		сангийн үйл ажиллагааны маягтын өөрчлөлтийн маягт, зааврыг боловсруулсан. - *МУҮНС-гийн Мэргэжлийн зөвлөлөөс Соёл урлагийн салбарын статистик мэдээний маягт боловсруулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2020-01-09-нд БСШУСЯ-ны сургалтад хамрагдан, маягтыг шинэчлэх, заавар, тайлбарыг боловсруулах ажлыг гүйцэтгэсэн ба УБХТНТНС, ХТНС-гуудын төлөөллийг оролцуулан 3-4 удаа хэлэлцүүлэн, яамны хэлэцүүлэг болон ажлын хэсэгт санал, холбогдох судалгаа, тайлбарыг өгч хамтран ажилласан.*
	Зарцуулсан хөрөнгө	*Зарцуулсан мөнгөн дүн, санхүүжилтийн эх үүсвэрийг бичнэ үү.*
	Хүрсэн түвшин	БСШУС-ын Сайдын 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А/181 дүгээр тушаалаар Соёл урлагийн салбарын захиргааны болон бүртгэлийн статистикийн мэдээллийн маягт болон маягт нөхөх зааврыг шинэчлэн баталсны дагуу Номын сангийн холбогдох 8 маягтын дагуу байгууллагын 2019 оны статистик мэдээг ЗГХА, Соёл Урлагийн газар, Нийслэлийн Соёл урлайгийн газарт өгсөн.
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний номын сан

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээ мэдээллийг түгээх, тэдэнд зориулсан соёл танин мэдэхүй, соён гэгээрүүлэх, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн ажлуудыг дараах байдлаар зохион байгуулан ажиллаа.

3.1 Хүрээлэн буй орчны тогтвортой хөгжил

3.1.1. Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон хөгжлийн үзүүлэлтээр зүүн хойд Азийн бүс нутагт жишиг хот болно.

Тус номын сангаас “Мод тарих үндэсний өдөр”-өөр номын сангийн өмнөх талбай дахь ногоон байгууламжид нөхөн тарилт хийж, цэвэрлэгээ арчилгаа хийсэн.

3.1.4. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах “Утаагүй хот 2030” төсөл хэрэгжүүлж, хүрэх үр дүнг тодорхойлно.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 дугаар захирамжаар, 2019 оны “Түүхий нүүрсний тээвэрлэлт хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”, “Нийслэл дүүргийн онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”-ийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09:00 цагаас 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цаг хүртэл, 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 09:00 цаг хүртэл, Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн захирал Д.Индрагийн удирдлага дор давхардсан тоогоор 28 хүнтэй ажлын хэсэг 24 цагийн хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэж Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд ажиллаж байгаа шуурхай штабын жижүүрүүдтэй 09:30, 12:30, 18:30, 22:30 цагуудад холбогдож, сайжруулсан түлшний хангамжийн мэдээллийг авч нийлүүлэлт дээр анхаарч ажилласан. “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийн байранд тус номын сангийн Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн эрхлэгч Б.Санжаасүрэн, програмист О.Цог, захирал Д.Индра ажилласан бол тус номын сангийн 22 албан хаагчид 5 хэсэгт хуваагдан Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн түлшний дундын цэгүүд, борлуулалтын цэгүүдэд биечлэн хяналт тавьж ажилласан.

3.2.6. Иргэдэд экологийн боловсрол олгож, амьдралын зөв дадлыг төлөвшүүлнэ.

Тус номын сангаас иргэдэд экологийн боловсрол олгох үүднээс дахин загварчлах Хуванцараар ээмэг хийх, Хаягдал хувцас ашиглан ариун цэврийн хэрэглэл хийх, Хуванцараар хүзүүний зүүлт хийх, Хаягдал шил чимэглэх, Хаягдал сэтгүүлийн цаасаар энгэрийн зүүлт хийх, Даавууны өөдсөөр аяганы суурь хийх, Даавууны өөдсөөр утасны гэр хийх, Ундааны бөглөөгөөр хөлийн гишгүүр хийх, Цоорхой хувцасыг хатгамлаар нөхөх, Эмний хаягдал шилээр үнэртүүлэгчний сав хийх, Хаягдал даавуугаар чихмэл тоглоом хийх, Хаягдал савхаар цүнх хийх, Хаягдал цаасаар сагс сүлжих, Хаягдал даавуугаар ханын чимэглэл хийх зэрэг 15

удаагийн сургалт танхимаар явагдаж нийт 137 хүнийг хамруулллаа. Уг сургалтыг зохион байгуулснаар байгаль экологи дахь хог, хаягдлыг бууруулах, иргэдийг зөв хэрэглээнд сургах ач холбогдолтой юм.



4.1.17. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Эрдмийн аялал" аян зохион байгуулж, Шинжлэх ухааны Академийн харьяа хүрээлэн, номын сан, музей, түүхийн дурсгалт газар, орон нутгийн байгууллага, үндэсний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах аяллыг тогтмол зохион байгуулна.

- Ерөнхий боловсролын 2, 5, 45, 50, 93, 112-р дунд сургууль,
- Хос уянга сургууль
- Хэнтий аймгийн ЕБС-ийн 12 сурагч, Налайх дүүргийн ЕБС-ийн 34 сурагч нийт 200 гаруй сурагч хүүхэд багачуудад төв болон салбар номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, уншигчаар бүртгэн, уншсан номынхоо талаар саналаа солилцож тэмдэглэл хөтлөх арга ажиллагааны талаар тойм яриа зохион явууллаа.

4.3. Соёл, урлаг

4.3.1. Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Иргэдийн оролцоотой Хотын соёл" олон нийтийн аяныг өрнүүлнэ.

Хөл хорио тогтоосон байгаа эл үед тус номын сангаас хүүхэд багачууддаа зориулан цахим хуудаснаа Үлгэрийн цаг буланг хөтлөн явуулж 20 гаруй үлгэрийг хүүхэд багачууддаа уншин танилцуулж мөн ухаалаг гар утасны цэнэглэгчийг хэрхэн хийх вэ, Генийн шинжлэх ухаан - коронависрусын тухай, Интернетийг хэрхэн ашиглах вэ, Электрон багаж, хэрэгслийг ашиглах арга зүй, техник, Шинжлэх ухааны тухай бидний мэддэггүй ба мэддэг зүйлс, Дахин загварчилсан хувцас,Дахин загварчлах нь Лего Майнд Сторм зэрэг сэдвүүдээр 23 удаа 498 минутын бичлэг хийж номын сангийн фэйж хуудсаараа дамжуулан олон нийтийн сүлжээгээр хүргэсэн.

4.3.2 Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн цахим хэлбэрт шилжүүлж, алслагдсан дүүргүүдийн Соёлын ордны номын сангийн хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ.

Тус номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн цахим хэлбэрт шилжүүлэх, номын баяжилт хийх ажлын хүрээнд 2020 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 100,000,000 төгрөгийн номын баяжилт хийхээр шийдвэрлэн Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер зарлагдан номын баяжилтаар "Монсудар паблишн" ХХК шалгарч 92,234,882 төгрөгийн 3470 ширхэг шинэ номыг хүлээн авч, төв болон салбар номын сангуудад фондын баяжилт хийсэн. 2020 оны байдлаар нийтдээ 1197 нэрийн 2033 ширхэг 38,605,337 төгрөгийн хэвлэмэл номоор фондын бүрдүүлэлт хийсэн байна. Үүнээс 280 нэрийн 808 ширхэг 9,607,200 төгрөгийн номыг бэлэг хандиваар 3 нэрийн 40 ширхэг 600,000 төгрөгийн номыг худалдаагаар, 209 нэрийн 222 ширхэг 3,837,328 төгрөгийн номыг төлбөрөөр, 705 нэрийн 963 ширхэг 24,560,809 төгрөгийн номыг тендерээр тус тус бүрдүүлэн авч, 2033ш номонд техник ажиллагаа хийж, мэдээллийг электрон каталогт оруулан, 2001ш RFID-ийн баркодон tag-ыг хэвлэн идэвхжүүлж наасан байна.

100,000,000 төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлхээр шийдвэрлэн Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер зарлагдан номын баяжилтаар "Монсудар паблишн" ХХК, тоног төхөөрөмж нийлүүлэх тендэрт "Оолинк" ХХК тус тус шалгаран бол 93,540,000 төгрөгийн 13 нэр төрлийн тоног төхөөрөмжүүдийг гэрээнд заасан үзүүлэлтийн дагуу тус тус бүрэн нийлүүлж дууссан.



1. Сервер компьютер Dell R740 1 ширхэг

2. Суурин компьютер Dell Optiplex 3070 20 ширхэг

3. Сүлжээний свитч 1 ширхэг /48 оролттой/

4. Интернетийн хамгаалах төхөөрөмж 1ширхэг

5. Хадгалах төхөөрөмж 1 ширхэг

6. Led дэлгэц



4.5 Хүүхэд, гэр бүлийн хөгжил

4.5.10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд “Би хариуцлагатай аав ээж” аяныг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Төв болон салбар номын сангийн хүүхдийн уншлагын танхимын номын санчид харьяа дүүргийн ГБХЗГ-тай байнга хамтран ажилладаг. Ковид 19 цар тахлын нөхцөл байдлын улмаас нийтийг хамарсан үйл ажиллагааг зогсоосон тул манай байгууллагаас уншигч эцэг эхчүүд болон хүүхдүүдэд зориулсан соёл танин мэдэхүйн ажлыг байгууллагын пейж хуудас, веб сайтаар дамжуулан цахимаар эрчимтэй хүргэж ажиллалаа. Үүнд бүтээлч орон зайн төвийн сургалт, видео контент – 17 удаа, хүүхдийн уншлагын танхимаас зохион явуулах уулзалт, үлгэрийн цаг – 25 удаа, Д. Нацагдоржийн шагналт зохиолч, уншигчийн уулзалт,Live “Номын сангийн зочин” ярилцлага – 19 удаа, Монголчуудын хэрэглэж байсан бичиг үсгийн цахим номзүй – 5 удаа, Зуны амралтаар унших номууд цуврал ном зүй – 7 удаа, Ном унших дадал, цаг үеийн шинж чанартай мэдээллийн шинж чанартай 62 постыг тус тус хүргэн ажилласан.

4.8 Нийгмийн халамж

4.8.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын барилга байгууламж нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, дэд бүтэц, ээлтэй орчин бүрдсэн эсэхэд хийгдсэн үнэлгээний дагуу хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Төв номын санд байрладаг харааны бэрхшээлтэй иргэдийн номын санд “Хүртээмжтэй технологиор дамжуулан, хараагүй хүмүүсийн мэдээлэл хүртэх боломжийг нэмэгдүүлэх” зорилт бүхий CANADA сан, хараагүй хүмүүсийн инноваци хөгжил ТББ-тай хамтран “Харааны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадваржуулах нь” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төслийн хүрээнд иж бүрэн компьютер 4 ширхэг, цахим брайль төхөөрөмж 4 ширхэг, дэйзи цахим ном тоглуулагч 4 ширхэг, сканер 2 ширхэг, утасгүй сүлжээний төхөөрөмж 2 ширхэг, чихэвч 4 ширхэг PC яригч 4 ширхэг, ширээ 4 ширхэг, сандал 4 ширхэг зэрэг эд хөрөнгийг авч уншлага үйлчилгээнд нэвтрүүлэв.

Мөн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой технологийн сургалтуудыг харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх танхимын номын санч болон харааны бэрхшээлтэй иргэдэд тус тус зохион байгуулсан. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан 90 нэрийн номыг E-PUB хүртээмжтэй форматаар тусгай хэрэгцээт боловсролын шаардлагад тохируулан бүрдүүлж үйлчилгээнд нэвтрүүлсэн. Мөн хараагүйчүүдэд үйлчлэх танхимын орох хаалга, ариун цэврийн өрөөнд засвар хийн тав тухтай үйлчлүүлэх боломжоор хангасан.

5.1 Оновчтой бүтэц, хариуцлагатай албан хаагч

5.1.7. Авилга албан тушаалын гэмт хэрэг, зөрчилд тавих олон нийтийн хяналтыг сайжруулна.

Авилгатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн тэргүүлэх нэгэн чиглэл нь авилгын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авилгын нийгэмд учруулах хор аюулыг олон нийтэд ухуулан таниулах, иргэдийг авилгатай тэмцэх арга барилд сургах, энэ төрлийн үйл ажиллагаанд татан оролцуулах юм. Энэхүү чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс авилгын эсрэг сургалт, сурталчилгаа, олон нийтийг хамарсан арга хэмжээг өмнөхөөс шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж байна. Үүний нэг нь авилгыг мэдээлэх 110 дугаарын хэлбэртэй номын булангаар дамжуулан авилгын тухай хууль тогтоомж, мэдээ мэдээлэл дамжуулж эхэлсэн.

Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр улс орон даяар уламжлагдан зохион байгууллагддаг “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-үүдээр Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас цахимаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

<u>Монголчуудын үсэг бичгийн видео товчоон, номзүй</u>

Монголчуудын эртний бичиг үсэг болох Вагиндра, Хэвтээ дөрвөлжин үсэг, Али-Гали, Дөрвөлжин үсэг, Уйгаржин монгол бичиг тэдгээрийн үүсэл гарал, холбогдох ном зохиол, судалгааны бүтээл, дээрх бичиг үсгийн талаар судалсан эрдэмтэн судлаачид, түүх дурсгалын талаар видео бичлэгүүдийг олон нийтэд цувралаар хүргэсэн.

<u>Уулзалт, сургалт, лайв</u>

Хэл бичгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Ууганбаатар “Хэрхэн сайхан бичигтэй болох вэ?” лайв уулзалт хийн зөв сайхан бичих суртгалт явууллаа.

<u>Үзэсгэлэн</u>

Мөн “Монгол бичиг бидний бахархал, Монголчуудын бичиг үсгийн түүх” зэрэг монгол бичгийн гайхамшгийг харуулсан уран бичлэгийн зургийн хамт 20ш ном 19ш хэвлэмэл материалаар үзэсгэлэн гаргасан.

“Үндэсний бичиг үсэг” сэдэвт үзэсгэлэн үзэсгэлэнг 10ш ном, 10ш хэвлэмэл материал, 14ш бүтээлээр гаргаж сурталчилсан.

Үндэсний бичиг үсгийн баяр арга хэмжээнд нийт 14ш бүтээл, 30ш ном, 29ш хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн гаргаж, цахимаар нийт 3612 хүн үзсэн байна.

2. Монгол Улсад Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын шийдвэрээр “Дэлхийн номын өдөр”-ийг 2018 оны 04 сарын 20-ны өдрөөс 25-ны өдрүүдэд улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхээр болсон.

Тус өдрийг тохиолдуулан тус номын сангаас Хүүхдийн зохиолч О.Сундуйтай хүүхдийн уншлагын танхимын номын санчид хамтран “Хүүхдийг хэрхэн номонд дуртай болгох вэ” сэдэвт уулзалтыг цахимаар, Бужинд тохиолдсон явдлууд-1, 2, 3, 4 номын зохиогч Б.Индра, Хачин бодлууд номын зохиолч М.Цогтхун нарыг урьж номын санчид “Бүтээлч багачууд” нэврүүлэг бэлтгэн уншигчдад танилцуулсан.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн хүрээнд жил бүр “Номын баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг. Эл зарлигийн хүрээнд тус номын сангаас дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

Соёлын гавъяат зүтгэлтэн зохиолч, эрдэмтэн Л.Дашнямтай уулзалт зохион байгуулж, уулзалтын төгсгөлд 2020 оны Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэнг шалгаруулсан.

4. Нийслэлийн Засаг даргын 2012 он “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/606 дугаар захирамж

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1348 жиргээ илгээгдэж, 465 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 39576, үүнээс гадна АСМТ 18547, ХУД 1162 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.

5. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Мэдээллийн аюулгүй байдлын журам” А/477 дугаар захирамж

Мэдээллийн системийг холбогдох стандартын дагуу зохион байгуулж ажилладаг бөгөөд номын сангийн үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй мэдээлэл, шилэн дансны мэдээллийг нийтэд ub.pl.gov.mn, UB Public Library.Facebook цахим хуудсанд тухай бүрт байршуулж байна.

Байгууллага дотооддоо захирлын тушаал, үүрэг даалгавар, ажилтан, албан хаагчдын хувийн хэрэг, өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүдийг ажилчдын дотоод Facebook page болон дотоод сүлжээгээр мэдээллэдэг.

Номын сангийн нийт байр талбайн 10 хүртэлх хувь буюу үндсэн фонд болон Серверийн өрөө хаалттай бүсэд тооцогддог. Үндсэн номын фонд, серверийн өрөөнд зөвхөн эрх бүхий албан тушаалтан нэвтрэх эрхтэй бөгөөд аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажилладаг.

Ашиглагдаж байгаа бүх комьютер техник хэрэгслийг мэдээллийн ажилтнууд бүртгэлжүүлж, засвар үйлчилгээ, шинэ програм хангамж нэмэгдэх бүрт програмист болон хариуцагч ажилтан нар гарын үсэг зурж баталгаажуулдаг.

Мэдээллийн системийг хууль бус халдлагаас хамгаалах галт хана ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, илрүүлэх зориулалтаар хамгаалалт, хяналтын техникийн систем, зориулалтын програм хангамжинд байнга хяналт тавьж ажиллаж байна.

6. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж

<u>Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт</u>

<u>http://koha.pl.ub.gov.mn</u> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2019 оны 12 дугаар сарын 25-аас 2020 оны 12 дугаар сарын 08-нийг хүртэлх хугацаанд 129546 хэрэглэгч зочилж /visits/, 295992 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 85,7% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 14,3% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсан хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.

Country	Acquisition: Users		New Users		Sessions	
	99,329	% of Total: 100.00% (99,329)	99,281	% of Total: 100.10% (99,182)	129,546	% of Total: 100.00% (129,546)
1. Mongolia	92,649	(93.05%)	92,503	(93.17%)	121,626	(93.89%)
2. United States	1,121	(1.13%)	1,096	(1.10%)	1,254	(0.97%)
3. South Korea	911	(0.91%)	898	(0.90%)	1,084	(0.84%)
4. Japan	765	(0.77%)	756	(0.76%)	896	(0.69%)
5. (not set)	718	(0.72%)	707	(0.71%)	772	(0.60%)
6. Australia	417	(0.42%)	411	(0.41%)	433	(0.33%)
7. China	413	(0.41%)	408	(0.41%)	466	(0.36%)
8. Russia	380	(0.38%)	377	(0.38%)	456	(0.35%)
9. Germany	282	(0.28%)	276	(0.28%)	332	(0.26%)
10. United Kingdom	165	(0.17%)	154	(0.16%)	198	(0.15%)

<u>Вэб хуудас</u>

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн вэб <u>http://www.pl.ub.gov.mn</u> -ийн агуулгыг шинэчлэн сайжруулахад анхаарч ажилласан. Jetpack програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг 2019 оны 12 дугаар сарын 25-аас 2020 оны 12 дугаар сарын 08-ний хүртэлх хугацаанд тайлагнан гаргахад 22185 хэрэглэгч зочилж, 76897 хуудасны мэдээллийг үзжээ.

СТАТИСТИК

237933

- Visit Today : 48
- Visit Yesterday : 206
- This Month : 3474
- This Year : 76897
- Total Visit : 237933
- Who's Online : 1



7. Нийслэлийн Засаг даргын 2015 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай" А/633 дугаар захирамж

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн 16, шинээр болон эгүүлэн томилогдсон 8, шилжин ажилласан 9 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

8. Нийслэлийн Засаг даргын 2017 оны "Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай" А/252 дугаар захирамж

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 199 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 195, цаасан суурьтай 4 албан бичиг ирснийг бүртгэсэн. 193 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хааж, 6 албан бичиг судалж буй төлөвтэй байна.

Тайлант хугацаанд Edoc системээр нийт явуулсан 151 албан бичгийг бүртгэсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 143, систем ашиглагдаггүй 8 байгууллага руу албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн.

Систем ашиглалтын зөрчилтэй 2, хяналтын зөрчилтэй 7 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад 12 удаа танилцуулж ажилласан.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Уншлага үйлчилгээ

Номын сангийн хэмжээнд тайлант хугацаанд бүтээгдэхүүн нийлүүлэлтийг "хүснэгт 1"-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Бүртгэлтэй уншигч	19300	8975	46,5%
2	Иргэсэд	119700	35798	29,9%
3	Ном олголт	299250	81593	27,2%
4	**НИЙТ ДҮН**	**438250**	126366	28,8%

Уншлага үйлчилгээний төлөвлөгөөт үзүүлэлтүүд 27,2%-46,5%-ийн биелэлттэй байгаа бөгөөд тайлант хугацааны төлөвлөгөөт үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 2

Он		2019			2020		
№	Үйлчилгээ нэр	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**
1	Бүртгэлтэй уншигч	19300	14728	76,3%	19300	8975	46,5%
2	Иргэсэд	119700	101400	84,7%	119700	35798	29,9%
3	Ном олголт	299250	241957	80,8%	299250	81593	27,2%

<u>Тайлбар</u>

1. Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын улмаас Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот хурлын шийдвэрээр соёлын байгууллагуудын

үйл ажиллагааг хааснаар манай байгууллага уншлага үйлчилгээ авалгүй дотооддоо цахимаар ажиллах ажиллаж эхэлсэн. Нийслэлийн засаг даргын 2020 оны “Хүн амын нийгэм-соёлын үйлчилгээ, эдийн засгын талаар авах зарим арга хэмжээний тухай” А/841 дүгээр захирамжийн дагуу 2020 оны 06 дугаар сарын 23-аас 2020 оны 11 дүгээр сарын 10-ийг хүртэл 4 сар гаруй хугацаанд уншигч, үйлчлүүлэгч авч ажилласан. Иймд өмнө жилийн мөн үеийнхтэй харицуулхад уншлага, үйлчилгээ буурсан үзүүлэлттэй гарсан байна.

2. Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд 5 удаагийн тооллого /Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан, төв номын сангийн уншлагын А танхим/ хийгдсэн.

3. Тус номын сангийн 2020 оны тайлангийн хугацаанд салбар номын сангуудад RFID /цахим номын сан/ технологийг нэвтрүүлэн ажилласан бөгөөд тус номын сангийн нийтийн уншлагын “А”, “Б” танхим, хүүхдийн уншлагын танхим, ном зүйн фондын ном, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудын нийтийн болон хүүхдийн уншлагын танхимын нийтдээ 111,852 номонд RFID-ийн tag-ыг суулгаж идэвхжүүллээ. Мөн 109,851 ширхэг номын мэдээллийг Коха програмын электрон каталогт засвар хийж, ном зүйн стандартыг хангаж ажиллалаа.





3.2. Гэрээр ном олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд уншигч хэрэглэгчдэд **81593** ном хэвлэл олгож үйлчилснээс 6409 ширхэг номыг гэрээр олгож үйлчилсэн байна.



3.3. Солилцоо болон зөөврийн үйлчилгээ

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу **10** удаа **911** ширхэг номоор үйлчилгээ үзүүллээ.

- ХУД-ийн 120-р цэргийн ангитай 44 номоор 2 удаа
- Оюунлаг төрийн албан хаагч аяны хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 50 албан хаагчид уншигчийн үнэмлэх нээлгэн 127 номоор 3 удаа
- ХУД-ийн 13 хороонд байрлах зэвсэгт хүчний 120-р цэргийн ангитай хамтарч 15 ширхэг номоор 1 удаа
- ХУД-ийн байрлах зэвсэгт хүчний 126-р цэргийн ангитай хамтарч 20 ширхэг номоор 1 удаа зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байна.
- Сэлэнгэ аймгийн Хушаат сумын соёлын төвийн номын санд хүргэлтээр 60 номоор 1 удаа
- ХУД-ийн 16-р хороонд нийт 22 ажилтан албан хаагчидад 40 ширхэг номоор зөөврийн үйлчилгээ үзүүлсэн.
- Идэр Их сургууль 7 нэрийн 106 ширхэг номоор нийт 3 удаа
- Сүхбаатар дүүргийн 45-р сургууль, “Сант” сургуулийн 7 дугаар 150 ширхэг номоор 2 удаа
- Хилийн цэргийн 151-р ангийн номын санчтай 17 ш 1 удаа тус тус хийж 59 удаа уншлага үйлчилгээнд гарган уншуулж, уншигчдын эрэлт хэрэгцээг цаг алдалгүй хангаан үйлчилж ирлээ.
- СХД-н ЕБ-н 107 дугаар сургуультай 29 номоор 1 удаа
- СХД дэх шинээр байгуулагдсан номын сантай 60 ширхэг номоор тус тус зөөвөр хийж ажиллсан байна.

Номын сан хоорондын ном солилцоогоор:

7 удаа **193** номоор номын сан хооронд түр солилцоо хийжээ.

- Ирээдүй цогцолбор 86 дугаар сургуультай 68 ширхэг номоор солилцоо,
- “Ном хөтөлбөр”-ийн хүрээнд Идэр их сургуультай зөөврийн номын сангийн гэрээ байгуулан 46 ширхэг номоор 1 удаа,
- Багануур дүүргийн Соёлын ордны номын сантай 54 номоор 2 удаа,
- Номын солилцоог “Өргөө” амаржих газрын номын сантай 25 ш номоор 2 удаа, СХД-ийн Өнөр хороололын 15 дугаар хороонд шинээр нээгдсэн номын санд мэргэжил аргазүйн зөвлөлгөө өгч,номын солилцооны үйлчилгээ үзүүлэх зэргээр хамтарч ажилласан байна.



3.4. Интернет үйлчилгээ

Төв номын сан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргүүдэд тус бүрт уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернэтийн үйлчилгээг үнэ төлбөргүй, харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерийг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон.

Тайлангийн хугацаанд Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудын интернетыг Ситинэт ХХК-ны 2Mbps dedicated хурдаар шилэн кабелын гэрээ байгуулсан.

Үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 97,38 Mbps, дунджаар 3,37 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 66,96 Mbps, дунджаар 395,65 Kbps хүрсэн байна.



Утасгүй Интернэтийн сүлжээ

Утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 45.40 Mbps, дунджаар 10.2 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 25.79 Mbps, дунджаар 128.37 Kbps хүрсэн байна.



Америкийн Соёл Мэдээллийн Төв, Хөтөлбөрийн өрөөний Утасгүй Интернэтийн сүлжээ

Утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж /download/ байгаа хурд хамгийн ихдээ 79.28 Mbps, дунджаар 1.02 Mbps, түгээж /upload/ байгаа хурд хамгийн ихдээ 54.28 Mbps, дунджаар 134.74 Kbps хүрсэн байна.



Хан-Уул дүүрэг дэх салбарын Үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 72.21 Mbps, дунджаар 685.85 Kbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 17.45 Mbps, дунджаар 70.60 Kbps хүрсэн байна.



3.5. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

2020 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 1197 нэрийн 2033 ширхэг 38,605,337 төгрөгийн хэвлэмэл номоор фондын бүрдүүлэлт хийсэн байна. 280 нэрийн 808 ширхэг 9,607,200 төгрөгийн номыг бэлэг хандиваар, 3 нэрийн 40 ширхэг 600,000 төгрөгийн номыг худалдаагаар, 209 нэрийн 222 ширхэг 3,837,328 төгрөгийн номыг төлбөрөөр, 705 нэрийн 963 ширхэг 24,560,809 төгрөгийн номыг тендерээр тус тус бүрдүүлэн авч, 2033ш номонд техник ажиллагаа хийж, 1197 нэрийн 2033ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 2001ш

RFID-ийн баркодон tag-ыг хэвлэн идэвхжүүлж наасан байна. Мөн АСМТ-ийн 131 нэрийн 138 ширхэг гадаад номонд техник ажиллагаа хийж, номын мэдээллийг электрон каталогт оруулан, баркод хэвлэж наасан байна. Дээрх худалдаа болон бэлэг хандив, тендерээр авсан бүх номыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүллээ.

Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, энэ онд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 21 нэр төрлийн 3,901,600 төгрөгийн хэвлэл захиалсан байна.

Мөн урагдаж гэмтсэн нийт 554ш ном хэвлэлийг сэлбэн зассан байна. Төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 305 нэгж, байгууллагын албаны бичиг баримтуудыг 38 нэгж болгон хавтасласан байна. Хотын төв номын санд үнэлгээ тогтоогоогүй байсан 1884 ширхэг судар номонд үнэлгээ тогтоож, данс бүртгэлжүүллээ.

Лавлагаа, номзүйн үйлчилгээ

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны цахим болон утсаар, амаар нийт **2396** удаа лавлагаа өгсөн байна.



Номзүй

- Ковид-19 буюу коронавирусын халдвар ихссэнтэй холбогдуулан “Вирусын чиглээлээр уншвал зохих номууд”-ын жагсаалтыг гаргаж нийгмийн сүлжээгээр олон нийтэд түгээлээ.
- Зотеро программыг ашиглан Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Засгийн газрын мэдээ, Монголын мэдээ, Үнэн, Үндэсний шуудан зэрэг сонингууд дээр ‘’Covid -19’’-ын тухай 1-4 сар хүртэл гарсан 1500 орчим мэдээллийг түүвэрлэж номзүй хийсэн байна.
- Мөн С.Буяннэмэх судлалаар эрдмийн зэрэг хамгаалахаар ажиллаж буй Л.Амаржаргаланд С.Буяннэмэхийн номзүйг илгээсэн.
- Гоёл чимэглэлийн зүйлтэй холбоотой номууд,
- Хэвлэл мэдээллийн суурь боловсрол,
- МАХН-ын их хурлын тухай ном хэвлэлийн жагсаалт
- Монгол Улсын баатар Ц.Олзвойн тухай бүтээлийн жагсаалт,
- Гоёл чимэглэлийн зүйлтэй холбоотой номууд,
- Хэвлэл мэдээллийн суурь боловсрол,
- МАХН-ын их хурлын тухай ном хэвлэлийн жагсаалтыг тус тус гаргасан.

Мэдээлэл номзүйн ажлын хүрээнд “Жаран цагаан хонь”, “Ногоон нүдэн лам”, “Гүйж яваа эмэгтэй”, “Хүн шувуу”, “Ухаантай хүүхдийн ухаалаг ном”, "Хөвгүүдий унших сонгодог зохиолууд", "Хорвоотой танилцсан түүх", “Бөөгийн домог”, “Судасны чимээ”, “Могой цэцэг”, “Шүгдэн”, “Сахиуст хангайн нууц”, “Дүрсгүй жаалын өдрийн тэмдэглэл”, “Дуу чимээ”, “Өнгө

дүрс", "Үгс", "Манай дэлхий", "Сурагчийн нэвтэрхий толь", "Дэлхийн 365 нээлт", "Паулын гудамжны хөвгүүд" зэрэг 20 гаруй номын мэдээллийг номын сангийн пэйж болон вэб хуудсаар дамжуулан уншигчдад танилцууллаа.

3.1.6. Ном хэвлэл сэлбэн засах

Урагдаж гэмтсэн нийт **1744 ш** номыг хэвлэлтийн анхны жинхэнэ хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан байна. Үүнд:

- Сэлбэн засагч 554 ш ном
- Төв номын сан 76 ш ном
- ЧД дэх салбар номын сан 734 ш ном
- ХУД дэх салбар номын сан 270 ш ном
- БЗД дэх салбар номын сан 30 ш ном
- СХД дэх салбар номын сан 80 ш ном тус тус сэлбэн зассан байна.

Төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 305 нэгж, байгууллагын албаны бичиг баримтуудыг 38 нэгж болгон хавтасласан байна.

3.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ

Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ

2020 онд 950 ирцэд 1424 номыг олгож үйлчилсэн байна. Үүнээс танхимаар 121, гэрээр 1245 (цахим олголт), солилцоогоор 58 номыг тус тус олгож үйлчилсэн байна.

Дэлхийн номын баяраар Ж.Уэтерфордын "Монголын их хатдын нууц товчоо" номоор идэвхтэн уншигч А.Сайханцэцэгтэй (LIVE), Үндэсний номын баяраар "Хэл, соёл оюун санааны тусгаар тогтнол" сэдвийн дор СУИС-ийн Радио, телевиз медиа урлагийн сургуулийн сэтгүүлчийн 4-р дамжааны оюутан Ч.Очиррэнчинтэй Төрийн соёрхолт, СГЗ, ардын уран зохиолч Бавуугийн Лхагвасүрэнгийн уран бүтээлээр "Номын далайд хамтдаа аялъя" сэдэвт уулзалтыг тус тус зохион байгуулсан байна. Уулзалтанд 667 хүн онлайнаар, холбогдсон.

Тээврийн цагдаагийн албатай хамтарч "Замын хөдөлгөөний дүрэм"-ийг брайль болон томруулсан форматаар хэвлэж сурталчилсан. Мөн "Дөрвөн бэрх - Шагайн мэргэ" тайлбарыг брайлиар хэвлэн гаргаж сурталчилсан.



Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан DAISY төв

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан (Daisy) стандартад нийцүүлэн E-PUB 90 ширхэг цахим ном бүтээсэн.

Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний албан ёсны facebook хуудсанд 50 удаагийн мэдээ мэдээлэл оруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн “youtube” сувагт 50 удаагийн дүрстэй мэдээлэл оруулсан байна.

Монгол хэлний ярьдаг програм суулгах, тохируулах 26 удаагийн заавар зөвлөлгөө, NVDA дэлгэц уншигч компьютерийн програм ашиглах заавын талаар 19 удаагийн зөвлөмж, цахим брайль төхөөрөмж ашиглах 20 удаагийн зөвлөмж, цахим ном тоглуулагчийг ашиглах 15 удаагийн зөвлөмж буюу 2020 онд нийт 80 мэдээлэл харилцааны технологийн зөвлөмжийг шууд болон онлайнаар өгч үйлчилсэн.

“Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний албан ёсны facebook хуудсанд 50 удаагийн мэдээ мэдээлэл оруулсан.

Харааны бэрхшээлтэй иргэдэд 78 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Утсаар 72, е mail-ээр 6 удаа тус тус өгсөн байна.

“Туслагч технологийн ганцаарчилсан сургалт”-ын 8 удаа зохион явуулсан. Мөн "Туслагч технологийн сургалт”-ыг 2 удаа нийтэд зохион байгуулж, нийт 70 хүн хамрагдсан. Үүнд:

- МУИС-ийн багш нарт “Онлайн хичээл”-ийн төслийн сургалт - 10 багш
- БШУЯаман дээр Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн 60 багш нарт 3 өдрийн сургалт



NVDA дэлгэц уншигч программын олон улсын хувилбарыг судалж, программын 4 удаагийн шинэчлэлтэнд монгол хэлний орчуулга хийсэн. Мөн Innonation нэвтрүүлэг, НҮБ-ын Хүн амын сангаас зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтанд тус тус оролцож, цахим брайль төхөөрөмж танилцуулж, нийгмийн инновацийн талаар санал өгсөн. ICT Expo 2020 мэдээлэл технологийн үзэсгэлэнд оролцож ярьдаг программын танилцуулга хийсэн. Mongolian Library Update 2020-д Номын сан - Инноваци хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр оролцсон.

3.1.8. Мэргэжил арга зүйн үйлчилгээ

Улаанбаатар хотод болон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй номын сангийн албан хаагчдад 17 удаагийн сургалт, үйл ажиллагааг танхимаар болон цахимаар явуулж 500 гаруй хүнийг хамруулсан. Эдгээрийг тоймлон үзвэл:

- Отгонтэнгэр Их сургуулийн номын санчидад Олон нийтэд үйлчлэх тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох, номзүйч О.Долгорсүрэн нар номзүйн "Зотеро програмын тухай" арга зүйн зөвлөгөөг байгууллага дээр нь очиж өгсөн.
- Монгол Япон төвийн номын санчидад Коха программын уншигч бүртгэл, үүдний хяналт, ном олголт, буцаалтын талаар Бүртгэл мэдээллийн ажилтан Б.Мөнхзул, угтах үйлчилгээний ажилтан Г.Ариунзаяа, Ахлах номын санч Ө.Бадамсэд, номын санч Д.Сарантуяа, Олон нийтэд үйлчлэх тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох нар танилцуулж, мэдээлэл өгсөн.
- Увс аймгийн номын сангийн номын санч, каталогич, фондоч Н.Уранчимэгт арга зүйн зөвлөгөө өгч номын сангийн үйл ажиллагаагаа танилцуулсан.
- СУИС-ийн Соёлын сургуульд Номын санч, мэдээллийн ажилтан мэргэжлээр сурч буй Н.Ариунтунгалаг, Н.Солонго нарын дадлага ажлыг амжилттай удирдан, арга зүйгээр ханган ажилласан.
- Тус номын сангийн 40 жилийн ойд зориулан Онол практикийн бага хурлыг зохион байгуулж, мэргэжлийн 80 гаруй номын санч, мэдээллийг ажилтанг хамруулан мэдээлэл зөвлөгөө хүргэсэн.

3.2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

3.2.1. Сар бүрийн сүүлийн 7 хоногийн Мягмар гараг бүрийн Дотоод ажлын өдрүүдэд номын сангийн ажилтнууддаа зориулсан сургалт, уулзалт, тэмцээн зохион байгуулж ажилласан. Тухайлбал:

- Захирал Д.Индра “Номын сангийн стандарт” сэдвээр
- Ном бүрдүүлэх тусгай үйлчилгээний тасгийн эрхлэгч З.Төгсжаргал “Номын хадгалалт, хамгаалалт - Номын ариутгал” болон Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн хийх” талаар
- Олон нийтэд үйлчлэх тасгийн АСМТ-өөс Номын санчдыг чадавхижуулах “Хаягдалгүй хэрэглээ-Хотын соёл” сэдэвт дахин загварчлах сургалт зэргийг тус тус явуулсан. Тус сургалтаар хуванцараар ээмэг, хүзүүний зүүлт хийх, хаягдал шил чимэглэх, хаягдал сэтгүүлийн цаасаар энгэрийн зүүлт хийх, даавууны өөдсөөр аяганы суурь хийх, даавууны өөдсөөр утасны гэр хийх, ундааны бөглөөгөөр хөлийн гишгүүр хийх, цоорхой хувцас хатгамлаар нөхөх, эмний хаягдал шилээр үнэртүүлэгчний сав хийх, хаягдал даавуугаар чихмэл тоглоом хийх, хаягдал савхаар цүнх хийх, хаягдал цаасаар сагс сүлжихийг нийт 60 гаруй албан хаачидад заасан.

3.2.2. Тус номын санд мэргэжил шаардсан албан тушаалд ажиллаж байгаа 48 албан хаагчдаас 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

3.2.3. Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 45,7% буюу 33 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, 18 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан. Ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

Мөн нийт албан хаагчийг томуу, томуу төст өвчлөл, тоосны харшлаас сэргийлэх, дархлаажуулах зорилгоор витаминжуулалтын аянг зохион байгууллаа.

3.3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Тайлант хугацаанд 15 өргөдөл ирснийг бүртгэлийн дэвтэрт болон UB ERP цахим системд бүртгэн 100 хувь барагдуулж ажилласан.

Ирсэн өргөдлийг агуулгаар нь авч үзвэл:

Цалинтай чөлөө 1, Ажлаас чөлөөлөгдөх 1, Тэтгэмж, буцалтгүй тусламж 5, Цалингүй чөлөө 5, Ажилдаа эргэн орох 1, Шилжиж ажиллах 1, Дэвшин ажиллах 1

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 3 удаа гаргаж НЗДТГазар руу хүргүүлж ажилласан.

Дөрөв. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Үйл ажиллагааны ил тод байдал:

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай **42** холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаараа мэдээлсэн.



Номын сангийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэх батлах тухай” А/01 дүгээр тушаалыг, үйлчилгээ авахад шаардах баримт бичгийн жагсаалт болон холбогдох мэдээллийг хамт ойлгомжтой байдлаар цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан байгаа. Номын сангийн тухай хууль, Номын сангийн үйлчилгээний журмыг уншигчдад ойлгомжтой байдлаар зурган болон видео бичлэгээр хийж вэб сайт, мэдээллийн самбар, нийгмийн сүлжээ, номын сангийн үүдэнд байрлах дэлгэцээр тус тус сурталчиллаа.

Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

4.2. Хүний нөөцийн ил тод байдал:

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг тухай бүр байршуулан шинэчилж байгаа.

Тайлант хугацаанд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

Тав. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Соёл, олон нийтийн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Үүнд:

№	Үйл ажиллагааны нэр	2020	
		Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Уулзалт лекц	22	2216
2	Уралдаан, тэмцээн	4	79
3	Сургалт	10	372
4	Чанга уншлага	2	48
5	Кино үдэш хөтөлбөр	13	168
9	Зөвлөмж яриа	5	3240
10	Номын үзэсгэлэн	3	1500
	Нийт	**87**	**7623**

Эдгээрээс тоймлон үзвэл: **Уулзалт, лекцийн чиглэлээр:**

- Улаанбаатар хотын хотын нийтийн төв номын сангаас сар бүр Д.Нацагдоржийн шагналт зохиолчидтой “Уулзалт, өдөрлөг” зохион байгуулдаг бөгөөд СГЗ зохиолч, сэтгүүлч Ү.Хүрэлбаатар, СГЗ зохиолч, эрдэмтэн Л.Дашням нарыг урин оролцууллаа.
- Дэлхийн номын өдрийг тохиолдуулан хүүхдийн уншлагын танхимын номын санчид хүүхдийн зохиолч О.Сундуйтай хамтран “Хүүхдийг хэрхэн номонд дуртай болгох вэ” сэдэвт уулзалтыг цахимаар хийсэн.
- Мөн Дэлхийн номын өдрийг тохиолдуулан “Бүжинд тохиолдсон явдлууд-1, 2, 3, 4” номын зохиогч Б.Индра, “Хачин бодлууд” номын зохиолч М.Цогтхун нарыг “Бүтээлч багачууд” нэврүүлэгтээ урьж оролцууллаа. Уг булангаар 33 дугаар сургуулийн сурагч Ш.Мандарваа уншигч багачуудад маань зориулан "Сохор номин" шүлгийг уран уншлаа.
- Хүүхдийн зохиолч Н.Мандалтай хийсэн “Номын амт” улзалтанд Атланта сургуулийн 3б ангийн нийт 24 сурагч, багш нар хүрэлцэн ирж оролцлоо.
- Идэр Их Сургууль болон СУИС-ийн Медиа Урлагийн Сургуулийн 40 гаруй оюутнуудыг хамруулсан номын уулзалт ярилцлагыг зохион байгуулсан.



Америкийн соёл мэдээллийн төвөөс:

“Америкийн тухай ярилцъя” цуврал лекц дараах 5 сэдвээр явагдлаа.

- Таротын картууд ба арга замууд дэлхийн хэмжээнд цар хүрээг хэрхэн хөгжүүлэх тухай
- Америкийн хөгжмийн цувралаас
- АНУ-н соёлын хадгалалт Монголд
- Америкийн үндэстнүүд: Бүс нутгийн түүхүүд өөр үнэт зүйлд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Айова дахь Кавказууд хэрхэн ажилладаг талаар зэрэг лекцүүд тус тус зохион байгуулагдаж 156 хүн хамрагдлаа.

“Америкийн тухай ярилцъя” цуврал лекцийг танхимаар зохион байгуулахаас гадна Фэйсбүүк лайваар дараах 4 сэдвээр хийж хүргэсэн.

- Акедеми авардс шагналын тухай
- Голдсборо хотын түүх, Хойд Каролина
- Америкийн пароди буюу инээдмийн түүх

- Хөөрхөн төрхний талаарх түүний үүсэл гарал зэрэг лайвыг тус тус хийж 1580 хүнд хүргэлээ.

Монгол судлалын чиглэлээр 3 удаагийн лекц зохион байгуулж 130 хүнийг хамрууллаа.

- “Үлэг гүрвэлийн өсөлт”
- “Монгол орны малчин, тариаланчдын ирээдүйн талаар”
- Мэдээллийн түүхүүдээс самбар руу: Дата эрдэмтдийн туршлага Монгол дахь”

Уралдаан тэмцээн:

- Үндэсний бичиг үсгийн баярыг угтан “Сайхан бичигтэн” уралдааныг цахимаар зохион байгуулж 15 материал хүлээн авч эхний 3 байрыг шалгаруулаа.
- Мөн А.Цэрэнчулууны “Нөөшийн лаазнаас гарч ирсэн Конрад хүү” номын хэлэлцүүлгийг зохион явуулж, нийт уншигчдын дунд Book Quiz уралдааныг зарлаж 18 уншигчийг хамруулсан тэмцээнийг зохион явуулсан.



- Нийслэл хот үүсгэн байгуулагдсаны 381 жилийн ойд зориулж ”Ногоон улаанбаатар” гар зургийн уралдаанд 5-р сургуулийн Ж.Бадамцэцэг багштай 4б ангийн 18 сурагч идэвхтэй оролцлоо. Мөн

“Миний Улаанбаатар хот” зохион бичлэгийн уралдаан зохион байгуулж ЧД-ийн 50-р сургуулийн Болорчимэг багштай 5а ангийн 28 сурагч оролцлоо.










Сургалт:

- Англи хэлний ярианы клуб 2 удаа зохион байгуулагдаж 98 хүн хамрагдсан

- Англи хэлний багш нарт зориулагдсан англи хэлний заах арга зүйн сургалт 2 удаа явагдаж 44 хүн хамрагдсан.

- Англи хэлний илтгэлийн клуб 4 удаа зохион байгуулагдаж 174 хүн хамрагдсан

- Лего тоглоомын хөтөлбөр 18 удаа явагдаж 23 хүүхэд хамрагдсан.
- Дахин загварчилах сургалт 3 удаа танхимаар зохион байгуулагдсан. Үүнд:
  - Хуванцараар ээмэг хийх сургалт 1 удаа 5 хүн
  - Хаягдал хувцас ашиглан ариун цэврийн хэрэглэл хийх 1 удаа 12 хүн
  - Хуванцараар хүзүүний зүүлт хийх 1 удаа 16 хүн тус тус хамрагдлаа.

Чанга уншлага:

- Сайн дурын ажилтан М. Нинжинтэй хамтран 5-р ангийн нийт 16 сурагчдад Малала Юсуфзайгийн "Малалагийн шидэт харандаа", "Сурах эрхийн төлөө" зэрэг номнуудаар номын тухай ярилцлага хийж, Малала охины тухай богино хэмжээний баримтат кино үзүүлж чанга уншлага хийв. К.Ямадагийн "Бэрхшээл гэж юу вэ" номын танилцуулга хийв.
- Сант сургуулийн Ю.Шижиртуяа багштай 6б ангийн 32 сурагчдад зохиолч Б.Уранболорын "Би өөрөө зохиолч болно" номын танилцуулга болон зохиолчтой уулзалт хийн чанга уншлага хийв.

Кино үдэш:

Кино үдэш хөтөлбөр 13 удаа зохион байгуулагдаж 168 хүнийг хамруулаа.

Зөвлөмж яриа:

- Бага насны хүүхдийн хөгжил судлаач Л.Дэлгэрмаатай хамтран “Бага насны хүүхдийн хүмүүжил, хөгжил” сэдвээр эцэг эхчүүдэд зориулан лайваар зөвлөмж өглөө.
- Монголын Хүүхдийн зохиолчдын холбооны тэргүүн Н. Энхтайваныг урьж Бага насны хүүхдэд уран зохиолын ном уншуулах тухай лайваар зөвлөмж, ярилцлага хийлээ.



- АНУ-ын Төрийн департаментын үүсгэн байгуулсан Фулбрайт оюутны хөтөлбөр 2021-2022-ын талаарх яриа зөвлөмж

- Флекс -2020 хөтөлбөрийн танилцуулга, шалгаруулалтын талаарх яриа зөвлөмж 2 удаа 40 оролцогч

- Монголын ЛГБТ төвөөс зохион байгуулсан “Найзууд болцгооё “яриа зөвлөмж

“Номын сангийн зочны ярилцлага” буланд:

- Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханы “Соёлт хүн төрөлхтөн оршин байгаа цагт ном зохиол унших соёл байсаар байна гэдэгт би огтхон ч эргэлздэггүй”
- МУИС-ийн Номын сангийн захирал Д.Цэрэнгийн “Олон жилийн дараа эргээд харахад ном их уншдаг байсан хүүхдүүд илүү зөв хандлагатай, ертөнцийг үзэх үзэл нь зөв тогтсон, бусдын хайрыг татсан, бусдыг хайрлаж чаддаг хүмүүс болон төлөвшсөн харагддаг”
- Тагтаа хэвлэлийн газрын үүсгэн байгуулагч, орчуулагч Б.Баясгалангийн “Уншигч байна гэдэг давын өмнө цүнхэндээ байнга нэг номтой явахыг л хэлнэ, өөр сүйдтэй жор байхгүй”
- Орчуулагч Б.Баярсайханы “Ном болгон хүнд шинэ ертөнцийг нээж өгдөг”
- Түүхийн ухааны доктор Б.Баатархүүгийн “Өнөөдөр залуучууд цахим орчноос мэдээлэл их авдаг болж, тэр дундаа үнэн зөв эсэх нь эргэлзээтэй элдэв янзын бохир мэдээллээр тархиа цэнэглэж байгаад тун харамсдаг”
- МУИС-ийн Ази судлалын тэнхимийн багш, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн салбарын эрхлэгч Ц.Цэрэндоржийн “Бүхий л эрдэм мэдлэгийн суурь бол бичиг үсэг, ном унших түлхүүр нь ч бичиг үсэг”
- МУИС, Антропологи-археологийн тэнхимийн багш Ж.Лхагвадэмчигийн “Ном уншихын утга учир, үнэ цэнэ нь үнэн зөв, цэгцтэй мэдлэгтэй болох, тэр хэмжээгээр өөрийн үзэл бодолтой, задлан шинжлэх, шүүмжлэлт сэтгэхүйтэй болох, мэдэж ухаарсны хэмжээгээр өөрт болон өрөөлд тустай байхад оршино”
- СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэн, захирал Ш.Эрдэнэцэцэгийн “Ном бол Монгол түмний хэдэн мянганы туршид бүтээсэн соёлын үнэт зүйлийг хадгалж ирсэн бөгөөд цаашид сэргээх, уламжлуулах гол түлхүүр нь”
- Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн Баянзүрх салбарын эрхлэгч М.Отгонбаярын “Миний амьдралд үлгэрийн номууд маш чухал нөлөө үзүүлсэн”
- СУИС-ийн Соёлын сургуулийн Соёл судлалын судалгаа, сургалтын профессорын багийн багш Б.Мөнхбадралын “Хувь хүний сонирхлоос үл хамаараад эх орны түүх, хэл, соёл, газар нутаг, уул усны талаар ерөнхий мэдлэгтэй болох нь хүн бүрт маш чухал. Тэндээс хувь хүний, нийгмийн бүр үндэсний үнэт зүйл бүрэлдэн тогтоно”
- АНУ-ын Оолстэйт даатгалын компанийн МТ-гийн салбарт ахлах инженер Ш.Баатарын “Өнгөрснийг сануулж, өөрт байхгүй мэдлэгийг хайрлаж байдаг номд ямагт талархаж явдаг”,
- Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ-ын үүсгэн байгуулагч, Зөвлөх, Австрали улсын Мелбурний Их сургуульд хөгжил судлалаар магистрант Б.Золзаяагийн “Нэг дуртай зохиолч гэхээс илүү үнэт зүйл, үзэл санаа нийцэх шинэ үеийн сэтгэгчдийг сонирхож уншиж байна”,
- Монгол Улсын Их Сургуульд ахлах багш, хэл бичгийн ухааны доктор Д.Нямдоржийн “Уран зохиолын сайн ном унших нэг насанд олон амьдрах боломж”,
- “Тагтаа” паблишингийн Орчуулагч, редактор Мө.Батбаярын “Ном унших зүгээр л их зугаатай зүйл”,

- ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн багш Г.Мөнх-Эрдэнийн “Ямар ч үед Чингис хааны дүр л сайхан даа. Монгол хүн бүрийн хувьд ийм байгаасай”,
- встралийн Эзэмшлийн Хамгийн том IT компани болох RackCorp-ийн Глобал ПР захирал О.Оюунцэцэгийн “Гэртээ ажлын ширээ, номын сантай, хуучны номын цуглуулгатай байх нь дэлхийн хамгийн сайхан тансаглал юм”,
- Нийслэл Масс Медиа ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Золбоотын “Хамгийн зөв, оновчтой хариултууд ихэнх тохиолдолд номд л оршдог”,
- Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Урлагийн түүхч, ЭША Д.Гоомаралын “Оюун ухаан оршин бус байдаг гагцхүү хүн өөрөө түүнийг олж авах ёстой бол ном уншихын утга нь үүнийг хэмээн боддог”,
- trends.mn сайтын эрхлэгч, нийтлэлч Б.Болор-Эрдэний “Урам зориг, ухаарал хоёр заримдаа эсрэг тэсрэг байдаг”,
- Номын соёл ертөнч ТББ-ын тэргүүн Б.Сувдын “Гэрийн номын сан хүний хөгжилд чухал нөлөө үзүүлдэг” зэрэг 20 ярилцлагыг хийж, вэб сайтад нийтлэн олон нийтэд түгээлээ.



Номын үзэсгэлэн:

Нийт **30** гаруй үзэсгэлэнг **359** ном **115** хэвлэмэл хуудсаар гаргаж 1500-аад хүн үзэж сонирхсон байна.

- “Ханиад томуунаас сэргийлье" үзэсгэлэнг 3ш ном, 6ш зөвлөмжөөр 12 хүн үзсэн
- Утгын чимэг 2019 наадмын тэргүүн байрын шагналт, Төрийн соёрхолт Д.Норовын намтар болон зохиол бүтээлийн тэргүүн байрын 8ш ном, 45 хүн үзсэн
- “Хэрээний нулимс” өгүүллэгийн хэсгээс 2ш хэвлэмэл хуудас, 30 хүн үзсэн
- “Хүүхдийн танин мэдэхүйн ном” үзэсгэлэнг 12 ш номоор, 20 хүн үзсэн
- “Хотын соёл хувь хүний соёлоос” сэдэвт үзэсгэлэнг 1978-2012оны 10ш ном, 4ш хэвлэмэл хуудсаар, 85 хүн үзсэн
- Аз жаргалтай-утаагүй Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд утааны тухай болон сайжруулсан түлш түүний хэрэглээний тухай үзэсгэлэнг 12ш номоор, 30 хүн үзсэн
- Нийслэлийн 2020 оны нэг хот – нэг стандарт аяны хүрээнд дураараа бишээ дүрмээрээ, та замын хөдөлгөөнд соёлтой оролцоно уу ? үзэсгэлэнг 28ш номоор, 28 хүн үзсэн
- “Дэлхийн бүжгийн өдөрт” сэдэвт үзэсгэлэнг 10 ном 2 хэвлэмэл хуудас, 15 хүн үзсэн
- “Дэлхийн номын баярын өдрийг” тохиолдуулан ковид 19 улмаас гэртээ байгаа хүмүүсийг уриалан Гэр гэртээ номоо уншья цахим үзэсгэлэнг 11 номоор 87 хүн үзсэн
- Оросын алдарт зохиолч Ф.М.Достоевскийн монгол, орос хэл дээр хэвлэгдсэн 10ш ном, Зохиолчийн намтар,уран бүтээлийн тухай 3ш хэвлэмэл хуудсаар, 40 хүн үзсэн

- Үндэсний бичиг үсгийн баярын өдрөөр "Монгол бичиг бидний бахархал, Монголчуудын бичиг үсгийн түүх" монгол бичгийн гайхамшгийг харуулсан уран бичлэгийн зургийн хамт үзэсгэлэнг 20ш ном, 19 ш хэвлэмэл материалаар, 60 хүн үзсэн
- "Монгол бичиг үсгийн баяр 2020" үзэсгэлэнг 22ш ном, 10ш зурмал материал, 8ш хэвлэмэл хуудсаар, 55 хүн үзсэн
- Дэлхийн гэр бүлийн өдөрт 11ш номоор, 86 хүн үзсэн,
- "Монголын агаарын тээврийн баярт зориулан 17ш ном, 3ш хэвлэмэл материалаар, 20 хүн үзсэн
- Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан "Монголын түүхийн домогт хатад" сэдэвт үзэсгэлэнг 17ш номоор 90 хүн үзэж танилцсан байна.
- Эрдмийн баярт зориулан "Ухаан далай номоос эхтэй" 9ш номоор 15 хүн үзсэн
- "Хүүхэд залуусын оюунлаг сэтгэлгээг хөгжүүлэх "Багачуудын заавал унших номууд" 10ш ном,3ш хэвлэмэл хуудсаар 23 хүн
- Хүүхдийн зохиолч Н.Мандалын намтар, зохиол бүтээл болох 11ш номоор 35 хүн
- Хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье" сэдэвт 9 ш хэвлэмэл хуудсаар, Үнд: "Хүчирхийлэл гэж юу вэ? "Гэр бүлийн хүчирхийлэл", "Хүчирхийлэлд өртсөн бол хаана хандах вэ? зөвлөмжөөр үзэсгэлэн гаргаж сурталчилсан.
- Багш нарын өдөрт зориулан сурган хүмүүжүүлэхийн 12ш номоор 58 хүн үзсэн
- Шинэ номын үзэсгэлэн 2 удаа 28ш номоор 3ш хэвлэмэл номын тойм хуудсаар 100 хүн үзсэн
- Л.Ванганы 100 жилийн ойд: Намтар, уран бүтээл, 6 ш номоор 92 хүн үзсэн
- Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 381 жилийн ойд зориулан тус номын сангаас "Улаанбаатар хотын түүхийн холбогдолтой 11ш ном, "Улаанбаатар хотын түүхээс" 6 ш хэвлэмэл хуудсаар 135 хүн үзсэн
- Уншигчдын хүсэлтээр Жүжгийн зохиолч Д.Намдагийн товч намтар, 6ш номоор, 144 хүн үзсэн
- Уншигчдын хүсэлтээр Төрийн шагналт, зохиолч Ч.Лодойдамбын товч намтар, 6ш номоор 105 хүн үзсэн
- 1."Миний Улаанбаатар" сэдэвт "Эртнээс-энэ үеийг хүртэлх фото зургийн үзэсгэлэн 21 ширхэг фото зургаар
- 2."Инээмсэглэлтэй Улаанбаатар" сэдэвчилсэн номын үзэсгэлэн 25 ширхэг боть номоор
- 3."Нийслэлийн иргэн бүр үйлдвэрлэгч байя" мэдээллийн үзэсгэлэн 8 ширхэг зурагт хуудас,5 ширхэг боть номоор
- 4.Хүүхдийн уншлагын танхимд: "Нийслэлийн өдөрт"мэдээллийн болон номын үзэсгэлэн 8 ширхэг зурагт хуудас,24 ширхэг боть номоор тус тус гаргасан байна.
- Хичээлийн шинэ жилд зориулан 27 ш номоор мөн "Үндэсний номын баяр"-т зориулан 24 ш номоор тус тус сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж нийт 1500 гаруй хүн үзэж сонирхсон байна.

Үзэсгэлэн худалдаа:

"Улаанбаатар номын баяр 2020" үсэсгэлэн худалдаа 2020.06.05-аас 2020.06.07-ний хооронд "Гэртээ хүсэснээрээ уншъя" уриан дор зохион байгуулагдаж тус үзэсгэлэнд манай номын сан дараах хөтөлбөрийн дагуу оролцлоо.

2020.05.06-нд

1. "Бага насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон номыг хэрхэн сонгох вэ?" сэдэвт цахим уулзалт ярилцлага.

2. “Хүүхдийн уншвал зохих 11ш ном” үзэсгэлэн
3. ”Дөрвөн бэрхтэй уншлага” танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн,
4. Хуучин номын худалдаа
5. Номын сангийн уншигчийн карт нээх үйлчилгээ үзүүлсэн бол

2020.06.06-нд

1. Насанд хүрэгчдэд зориулсан “Таны уншвал зохих 15 ш ном” үзэсгэлэн
1. 1946-1959 оны уран зохиолын 22ш номын үзэсгэлэн
2. Хуучин номын худалдаа
3. Номын сангийн уншигчийн карт нээх үйлчилгээ

2020.06.07-нд

1. Maker space, Америк мэдээллийн төвийн үйл ажиллагааны талаар сурталчлан танилцуулах
2. Гадаад хэл дээрх насанд хүрэгчид болон хүүхдэд зориулсан 45ш номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

			Өмнөх улирал	Хагас жилд		Жилийн эцэс	
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.
4	3.6.1. Батлагдсан төсвийг оновчтой зүйл заалтаар нь зарцуулах	Чанар	Тогтмол	Тогтмол	Төсвийг оновчтой зарцуулсан		Төсвийг оновчтой зарцуулж байна. 2019 оны Аудитын шалгалтаар зөрчилгүй гарсан.
2	3.6.2. Санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь гаргаж өгөх	Чанар	Тогтмол	тогтмол	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, шилэн дансны мэдээ, нийгмийн даатгалын тайланг улиралд татварын тайланг цахим болон цаасаар хуулинд заасан хугацаанд нь өгсөн		Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, шилэн дансны мэдээ, нийгмийн даатгалын тайланг улиралд татварын тайланг цахим болон цаасаар хуулинд заасан хугацаанд нь өгсөн
3	3.6.3. Нэг уншлагын танхимд иж бүрэн засвар, тохижилт хийх.	Чанар	-	1	1	-	-
4	3.6.4. Эд хөрөнгийн ээлжит болон	Чанар		1	Тогтмол	2	2

	ээлжит бус тооллого тооцоог үнэ зөв хийх						

16. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ

Гүйцэтгэлийн зорилт №3.7. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах
Төлөвлөлтийн уялдаа: “Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн 7-р зүйл “ Үйл ажиллагааны ил тод байдал” заалт, “Номын сангийн тухай хууль”-ийн 6.2.7, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дзрэм”, БСШУСЯамны Дотоод аудитын хорооны 2019 оны 8-р сарын 19 ны өдрийн 4-р тогтоолыг байгууллагад хэрэгжүүлэх

<table>
<tr><td>№65</td><td colspan="14">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="14">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.7.1-р арга хэмжээ: “Байгууллагын дотоод аудитын 2020 оны төлөвлөгөө”-г гарган албажуулж, хагас жилээр тайлан гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="13">Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, БСШУСЯамны Дотоод аудитын хорооны 2019 оны 8-р сарын 19-ны өдрийн 4-р тогтоол</td></tr>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Сар</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td><td>8</td><td>9</td><td>10</td><td>11</td><td>12</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="13">Цалин</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="13">2019 онд Дотоод аудитын тайланг нийт 2 удаа гаргасан.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="13">Жилийн албажуулсан төлөвлөгөө, дотоод аудитын үйл ажиллагаа, албан тоотоор явуулж буй тайлан, түүний бүрдэл, баримтжуулалт</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="13">Төлөвлөгөөний дагуу хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж, дүгнэлт хийж, тайлан гарган, байгууллагын цахим хуудсанд байршуулна</td></tr>
<tr><td>Хэрэгжилт</td><td colspan="13">1-р хагас жилд:
- Байгууллагын дотоод аудитын 2020 оны төлөвлөгөөг баталж албажуулсан..
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дотоод Аудитын Хорооны 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 4 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод аудит хийх удирдамж, хяналтын хуудасны загварыг шинээр гаргаж, захирлаар батлуулан албажуулсан.
2-р хагас жилд:
Хүүхдийн төв номын сангийн Дотоод Аудитын үйл ажиллагааны тайланг хагас жилээр болон жилийн эцсээр гарган албажуулахад бэлтгэж байна.</td></tr>
</table>

	Зарцуулсан хөрөнгө	Цалин
	Хүрсэн түвшин	Байгууллагын дотоод аудитын 2020 оны тайланг гарган 12-р сард багтаан Соёлын Яамны “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар”-т файлаар болон албан бичгээр явуулахаар бэлтгэж байна
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		Хангалттай

№66	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин												
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.7.2.-р арга хэмжээ: Төлөвлөгөөний дагуу “Байгууллагын дотоод хяналт”-ын комиссын ажлын хэрэгжилтийг хангах, комиссын гишүүдэд ажлын хуваарилалт хийх.												
	Төлөвлөлтийн уялдаа:	Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, БСШУСЯ-ны Дотоод аудитын хорооны 2019 оны 8-р сарын 19-ны өдрийн 4-р тогтоол											
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	*Хэрэгжих хугацаа*	Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Шаардагдах хөрөнгө	Цалин											
	Суурь түвшин	Арга хэмжээ хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга.											
	Шалгуур үзүүлэлт	Жилийн албажуулсан төлөвлөгөө, дотоод аудитын үйл ажиллагаа, албан тоотоор явуулж буй тайлан, түүний бүрдэл, баримтжуулалт											
	Хүрэх түвшин	2 удаа											
Арга хэмжээний хэрэгжилт	*Хэрэгжилт*	Комиссын гишүүдэд гүйцэтгэх ажлын хуваарилалт хийж, танилцуулсан.											
	Зарцуулсан хөрөнгө	Цалин											
	Хүрсэн түвшин	Хүүхдийн төв номын сангийн нягтлан бодогчоор түр хугацаагаар ажиллаж байсан Э.Батбаатарын 1-р улирлын цалин бодолтонд дотоод аудитын комиссын гишүүн Г.Оюунтунгалагийн хамт хяналт хийж, илэрсэн зөрчлийг 4-р сарын цалин бодолтонд тусгаж арилгасан. Комиссын гишүүдийн хийж гүйцэтгэсэн ажлуудыг нэгтгэн Дотоод хяналтын тайланг бэлтгэж байна.											
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		Хангалттай											

№67	*Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин*

<table>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="14">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.7.3- р арга хэмжээ: Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг албажуулан цахим хуудсанд байршуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="13">“Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн 7-р зүйл
Номын сангийн тухай хууль”-ийн 6.2.7
Хүүхдийн төв номын сангийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө №3.7.1</td></tr>
<tr><td rowspan="5">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Сар</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td><td>8</td><td>9</td><td>10</td><td>11</td><td>12</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="13">-</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="13">1 удаа</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="13">Жилийн албажуулан төлөвлөгөө болон хэлтсийн улирал тутмын тайлангуудын цахим хуудас дахь контент</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="13">1 удаа</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="13">Монгол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын2019 оны 47 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргаж албажуулсан.
• 2019 оны 8-р сараас эхлэн манай вэб хуудас “Интернетийн хамгаалалтгүй болж deceptive site ahead буюу “Хуурамч сайт” алдааг зааж эхэлсэн. Иймээс цаашид үүлэн технологид суурилсан вэб сайтыг шинээр хийлгэн өмнөх мэдээллийг хөрвүүлж, хөгжүүлэх шаардлагатай болоод байна. Зардлыг жил бүр байгууллагын төсвийн төсөлд суулгаж өгч байсан боловч, тухайн оны төсвийн хуваарь батлагдан ирэхэд уг зардлыг тусгаж өгдөггүй хасч баталсан байдаг.
Энэхүү шалтгааны улмаас байгууллагын вэб хуудас одоо ажиллахгүй байгаагаас, фэйсбүүк хуудсаараа нийтэд мэдээлэл өгч байна.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="13"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="13">ХТНС-гийн хаалттай группд 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байршуулан ажилтнуудад мэдээлэл өгсөн.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="13">Хангалтгүй</td></tr>
</table>

Гүйцэтгэлийн зорилт № 3.7.1-ийн үр дүн: Дотоод аудитын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, байгууллагыг эрсдэлийн удирдлагаар хангах

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			2019 он	Хагас жилд		Жилийн эцэст	
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.
1	3.7.1. “Байгууллагын дотоод аудитын 2020 оны төлөвлөгөө”-г гарган албажуулж, хагас жилээр тайлан гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулах	Хяналтын Тоо чанар	БСШУСЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт байгууллагын дотоод аудитын 2019 оны тайланг файлаар болон албан бичгээр илгээсэн	Дотоод аудитын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эрсдэлийн удирдлагаар хангана.	Байгууллагын дотоод аудитын 2020 оны эхний хагас жилийн тайланг БСШУСЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт файлаар болон албан бичгээр явуулахаар бэлтгэж байна.	Дотоод аудитын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эрсдэлийн удирдлагаар хангана.	Байгууллагын дотоод аудитын 2020 оны эхний хагас жилийн тайланг СЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт файлаар болон албан бичгээр явуулахаар бэлтгэж байна.
2	3.7.2.Төлөвлөгөөний дагуу “Байгууллагын дотоод хяналт”-ын комиссын ажлын хэрэгжилтийг хангах, комиссын гишүүдэд ажлын хуваарилалт хийх.	тоо	1	Комиссын гишүүдэд эхний хагас жилд хийж гүйцэтгэх ажлын хуваарилалт хийж, танилцуулсан		1	.
3	3.7.3. Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг албажуулан цахим хуудсанд байршуулах	хяналт	1	1 Байгууллагын хаалтай группд 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байршуулан ажилтнуудад мэдээлэл өгсөн.			

Хавсралт №1.

Хүүхдийн төв номын сангийн ажилтан албан хаагчдын мэргэшүүлэх сургалтын 2020 оны жилийн тайлан

Байгууллагын зүгээс ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтанд хамрагдах нөхцөл бололцоог нь тогтмол хангаж ажиллаж ирсэн.

Хүүхдийн төв номын сангийн шинэ, залуу номын санчдыг ажлын байран дээр нь дагалдуулан сургах, мэргэшүүлэх сургалтыг зохион явуулдаг. Шинэ ажилтан А. Итгэл, залуу ажилтан Б. Сувдмаа, К, Тамаша, О. Цэвэлсүрэн, Номундарь, Б. Бямбадулам нарыг номын сан Б. Аръяа, Г. Буянцэцэг, Г. Дарьсүрэн, Б. Хажидмаа, З. Алтанцэцэг нарт дагалдуулан ажлын байран дээр суралцуулж байна. Мөн аргазүй Л. Батболор, ном ангилагч ажиллагч С. Адъяаням, каталогч д. Жавзанпагма нараас зөвлөгөө авч мэргэшиж байна.

1. Нийт ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:
   - Номын баярыг угтаж 9-р сарын 17-нд “Номын санч – Ном, соёл, мэдээллийн хөтөч” сэдвээр байгууллагынхаа нийт ажилтнуудад сургалт зохион байгуулав. Тус сургалтанд байгууллагын 32 хүн хамрагдсан. Сургалтаар өнөө үеийн хэрэглэгчийн хэрэгцээ, номын сан, номын санчийн мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэхэд номын санчдад тавигдаж буй шаардлага, өөрчлөлт, цаашдын чиг хандлагын талаар захирал Д.Оюунбилэг мэдээлэл өгч, чөлөөт ярилцлага өрнүүлсэн.



- 10-р сарын 20 нд Төрийн албаны тухай хууль-ийн шинэчилэн найруулгыг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын Засгийн Газрын 38 р тогтоолоор батлагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, боловсруулж батлах, ажлын гүйцэтгэлийн, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын даргын 47-р тогтоолын хавсралтуудын дагуу Хүүхдийн Төв Номын Сангийн Захиргааны Зөвлөл, байгууллагын “Үнэлгээний баг” –аас нийт ажилтан албан хаагчдадаа “Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, үнэлгээ” сэдэвт сургалт зохион байгуулж, мэдээлэл аргачлал өгсөн. https://tinyurl.com/y3rhr6uq
- Номын санч Б. Сувдмаа Герман хэлний сургалтын А1.1, А2 сургалтуудад хамрагдаж амжилттай төгссөн.
- Номын санч Б. Бямбадулам РЦНК-ийн орос хэлний багш Отгонмандахын удирдлаган дор Орос хэлний анхан шатны хичээлийг амжилттай дуусгасан.
- Монголын Номын Сангийн Холбооноос （Mongolian Library Association）5-р сард цахимаар зохион явуулсан 4 удаагийн сургалтанд хэлтсийн эрхлэгч Г. Буянцэцэг, С. Тунгалаг, Г. Дарьсүрэн, Б. Аръяа нар хамрагдсан.
- Компьютерийн инженер Т. Билэгбаяр “Ehlel” академийн програм хангамжийн ангид суралцан компьютерийн дотоод сүлжээний мэдлэгээ дээшлүүлсэн.
- “Library ubdate-2020” зөвлөгөөнд Захирал Д. Оюунбилэг, хэлтсийн эрхлэгч Г. Буянцэцэг, номын санч Б. Бямбадулам, К. Тамаша, О. Цэвэлсүрэн нар оролцсон.

2. Ажилтнууд мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд

Арга зүйч Л.Батболор:

- “Movie maker” программ ашиглаж видео эвлүүлэг хийж сурсан

Ном зүйч С.Тунгалаг:

- Хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгоход баримтлах уран бүтээлийн жагсаалтын дагуу судалгаа хийж 6-10 насны хүүхдийн нас сэтгэхүйд тохирох богино өгүүллэгийн ном хэвлүүлэхээр бэлтгэсэн байна.

Каталогч Д.Жавзанпагма:

- Монгол бичгийн дүрмийг гүнзгийрүүлэн судалж, унших чадвараа ахиулан 2 ном уншив. Үүнд:
  Шагж. Монгол бичгийн дөт зам.- 1991
  Нямбуу. Монгол бичгийн зөв бичих дүрмийн үзүүлэн таниулах

Сан хөмрөгч З. Алтанцэцэг:

- Монгол бичгийн бүх үсгийг нүдэлж, уншлагаа сайжруулж байна.
- *Номын санч А. Итгэл:*
- LIB4U програмыг судалж, өдөр тутамдаа хэрэглэж байна.
- Уншигчдад зориулан “Номын тойм яриа” бэлтгэж хийсэн.
- Хувийн мэдлэгээ дээшлүүлэн Англи хэл болон монгол бичгийг бие даан судалж байна.

Номын санч Б. Бямбадулам:

- Ном ангилагч Адъяанямын заавраар номтой ажиллах техник ажиллагааны арга барилаа сайжруулж, 2 тавиур номонд тамга дарж ялтас наасан.
- Номонд тамга дарахдаа бичиг, зураг, үсэг гэх мэт гол мэдээллүүдийг харгалзан далдлахгүйгээр цэвэрхэн тамгалж сурах техник ажиллагаанд суралцсан.

Номын санч К. Тамаша:

- Номын сангийн ББК, DDC ангилалын мэдлэгээ дээшлүүлсэн.
- Их мэдэх танхимд байгаа CD – г төрөлжүүлж ангилан, баркодыг шинэчлэх ажлын хийсэн.

Номын санч Б. Сувдмаа:

- Герман хэлний 40ш шинэ номыг цавуутай хавтсаар цэвэр үзэмжтэй хавтаслаж ашиглалтын хугацааг нэмэгдүүлсэн.
- Герман хэл дээрх нийт 56ш шинэ ном, хэвлэмэл бус материалыг электрон каталогт оруулж, номын агуулгад тохирох түлхүүр үгийг герман хэлээр бичсэн.
- Шинэ номыг данслах ажлыг бие даан гүйцэтгэсэн.
- Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн шинэчлэгдсэн загварын дагуу танхимын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, тайлан гаргасан.

Хавсралт №2.

Хүүхдийн төв номын сангийн ажилтан албан хаагчийн
нийгмийн баталгааг хангах 2020 оны тайлан

№	Төлөвлөгөөт ажил	Биелэлт
1	Уншлагын хэлтсийн номын санчдыг ажлын нормын хувцсаар хангах	Нийт 16 ажилтныг нормын хувцсаар хангаж ажилласан. Үүнд: • Уншлага үйлчилгээний хэлтсийн 10 номын санч • Мэдээлэл техник аргазүйн хэлтсийн 2 каталогч, • Фонд хадгаламж хамгаалалтын хэлтсийн 2 фондоч, • Захиргаа аж ахуйн хэлтсийн 2 үйлчлэгч
2	Нийт ажилтан албан хаагчдыг ажлын байран дээрээ сэтгэл ханамжтай тав тухтай байх нөхцөлөөр хангах	Хагас жилд: • Ажилтнуудын цайны өрөөг тохижуулан үдийн цайгаа уух орчинг бүрдүүлсэн. • Бүртгэлийн номын санчийн ажлын байрыг томруулж, ажиллах нөхцөлийг нь сайжруулсан.

		Жилий эцэст: Ажилтнуудын ажлын байрны сэтгэл ханамжийг дээшлүүлэх ажлын хүрээнд Гёте институтын хөрөнгө оруулалтаар - Бүртгэлийн номын санчийн ажиллах нөхцөлийг нь сайжруулан цонхонд нь туузан хөшиг хийсэн. - Ажилтнуудын ажлын хэрэгцээ шаардлагын дагуу 4 шинэ принтер авсан.
3	Цалинг сард 2 удаа тогтмол, хоол унааны мөнгийг цаг тухайд нь олгох	- Ажилтнуудын цалин, хоол унааны мөнгийг сард 2 удаа бодож олгож байна.
4	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт орохыг дэмжиж 1 өдрийн цалинтай чөлөө олгоно.	- 2020 оны 2-р сард дэлхий нийтийг хамарсан “COVID-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтан албан хаагчдын дархлааг дэмжих, хүүхэд гэр бүлдээ тавих анхаарлыг сайжруулах зорилгоор, мөн ариутгал халдваргүйжүүлэлт хийхтэй холбогдуулан нийт албан хаагчдад 1-2 өдрийн цалинтай чөлөөг олгосон. - 2020 оны 03-р сарын 10-наас 06-р сарын 23 ныг хүртэл Улсын хэмжээний өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд жирэмсэн, 0-12 насны хүүхэдтэй болон , ахмад настай 10 албан хаагчийг гэрээсээ ажиллах боломж нөхцөлөөр хангаж ажилласан. - Ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байгаа бусад албан хаагчдын ажлын цагийг нь Даваа-Баасан гарагт 10.00-16.00 хүртэл богиносгосон цагаар ажиллуулсан.
4	Ажилтан албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэж, хууль тогтоомжинд заасны дагуу урамшуулал олгох.	**1-р хагас жилд:** Ажилтан албан хаагчдын 2019 оны сүүлийн хагас жилийн ажлын үр дүнг дүгнэн 2020 оны эхний хагас жилийн турш 5 ажилтанд 15-25%-ийн цалингийн нэмэгдэл олгосон. - 2020 оны 1 дүгээр улирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэж 29 ажилтанд 20-40%-ийн нэмэгдэл олгосон. **2-р хагас жилд:** 2020 оны эхний хагас жилийн ажлын үр дүнг дүгнэн 5 ажилтанд сүүлийн хагас жилийн турш 15-25%-ийн нэмэгдэл олгосон. - 2020 оны 1, 2,3-р дугаар улирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэж 32 ажилтанд 20-40%-ийн цалингийн нэмэгдэл олгосон
5	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	- Ном сэргээн засварлагч Б. Эрдэнэцэцэгт, ном бүрдүүлэгч Ч. Энхтуяа нарт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг олгосон.

Дэлхий нийтийг хамарсан “COVID-19” цар тахлын хүрээнд

<table>
<tr><td>№1</td><td colspan="14">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="14">Дэлхий нийтийг хамарсан “Covid-19” цар тахлын улмаас хорио цээрийн дэглэм тогтоосон цаг үед уншигч, хэрэглэгчдэд зориулан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тайлан</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="13">Улсын онцгой комиссын тогтоол, Эрүүл мэндийн яамны зөвлөмж</td></tr>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Сар</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td><td>8</td><td>9</td><td>10</td><td>11</td><td>12</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="13">-</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="13">Уншигч, хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхэд бэлтгэж, ажлын байранд ариутгал, халдваргүүжилт хийх</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="13">“ Covid-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.</td></tr>
<tr><td>Хэрэгжилт</td><td colspan="13">Хорио цээрийн дэглэм тогтоосон цаг үед хийх ажлын төлөвлөгөөг гарган ажилласан.</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="13">100%</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="13">Хангалттай</td></tr>
</table>

<table>
<tr><td>№2</td><td colspan="14">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="14">Өндөржүүлсэн бэлэн байдлын үед соёл, урлагийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэл хангагдсан өнөөгийн байдлын талаарх мэдээлэл</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="13">Улсын комиссын тогтоол, Эрүүл мэндийн яамны зөвлөмж</td></tr>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Сар</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td><td>8</td><td>9</td><td>10</td><td>11</td><td>12</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="13">-</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="13">Уншигч хэрэглэгчдийг хүлээн авч үйлчлэх</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="13">Уншлагын танхимаар болон гэрээр ном олгож үйлчлэх</td></tr>
<tr><td>Хэрэгжилт</td><td colspan="13">Хорио цээрийн үед тогтоосон дэглэм буюу Эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмжийг баримтлан ажиллана.</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="13">Хорио цээрийн үед тогтоосон дэглэм буюу Эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмжийг баримтлан ажилласан.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="13">Хангалттай</td></tr>
</table>

<table>
<tr><td>№3</td><td>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хүрсэн түвшин</td></tr>
<tr><td></td><td>Танхимуудад хийгдсэн бусад ажил</td></tr>
</table>

Арга хэмжээний нэр, дугаар	*Төлөвлөлтийн уялдаа:*	БСШУСЯ, СЯ,Улсын онцгой комиссын тогтоол, Эрүүл мэндийн яамны зөвлөмж
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	*Хэрэгжих хугацаа*	*Сар* 1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12
	Шаардагдах хөрөнгө	820.000
	Суурь түвшин	Сар бүрийн 3 дахь 7 хоногийн Пүрэв гаригт их цэвэрлэгээ хийдэг.
	Шалгуур үзүүлэлт	Цэвэрлэгээ үйлчилгээний чанар
	Хэрэгжилт	“COVID-19” тэй холбоотойгоор 1 сарын 30 , 2 сарын 1,2 нд Агуулах 2 сарын 4-10 өдрүүдэд Монгол номын сан хөмрөгийг 2 сарын 11-14 өдрүүдэд Төвд фонд 2 сарын 17-19 өдрүүдэд Европ фонд 2 сарын 20-нд “Утгын оньс” танхим 2 сарын 27-28 өдрүүдэд Нийтийн эзэмшлийн талбайд их цэвэрлэгээ хийсэн. - 85000 гаруй номыг арчиж цэвэрлэсэн. - Номын сангийн бүх өрөө танхим нийт танхим, сан хөмрөг, нийтийн эзэмшлийн талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг 3 удаа; - Их цэвэрлэгээг 3 удаа; - Ном ариутгалыг тогтмол хийж ирлээ. - Өндөржүүлсэн бэлэн байдал, хорио цээрийн дэглэмийн үед хариуцлагатай жижүүрийг захиргааны гишүүд 4-5 удаа, ажилтнууд 2-3 удаа хийсэн. - Номын санд гаднаас орж ирж байгаа уншигчдын халууныг үзэж тэмдэглэх, маск зүүхийг шаардах, гарыг тогтмол ариутгах зэрэг ажлуудыг хийж байна.
	Зарцуулсан хөрөнгө	820.000
	Хүрсэн түвшин	Ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж ажилласан.
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		Хангалттай

Хавсралт

Хүүхдийн төв номын сангийн
2020 оны цахим ажлын тайлан

Дэлхий нийтэд шинэ төрлийн коронавирус /Covid-19/ тархаж хөл хорио тогтоосонтой холбогдуулан Хүүхдийн төв номын сангийн хамт олон Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрүүд болон Соёлын яамны 2020 оны 11-р сарын 13 ны өдрийн 2/725 дугаар албан тоотын дагуу байгууллагын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулсан.

Цахимаар ажиллах энэ хугацаанд Хүүхдийн төв номын сангийн хамт олон 1172 цахим контентийг хийж 1242272 гаруй хэрэглэгчдэд хүрч ажилласан. Энэ хугацаанд электрон каталогийн 2717 номонд редакци хийж гүйцэтгэсэн.

2020 оны эхний хагас жилд 0-12 нас хүртэлх хүүхэдтэй эхчүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, эрсдэлт бүлгийн ажилтнуудад цахимаар ажиллах боломж бүрдүүлэн ажилласан. Гэрээсээ цахимаар ажилласан албан хаагчид дараах чиглэлээр ажилласан. Үүнд:

- Сургуулийн өмнөх, сургуулийн бага, дунд насны хүүхэд багачуудад зориулсан гадаад, дотоодын үе үеийн хүүхдийн зохиолчдийн үлгэр, өгүүллэг, танин мэдэхүйн 765 материалыг шивж пэйж хуудсанд байршуулсан.
- Үлгэрээр 5 видео контент хийсэн.
- Уншлагын танхим бүр 2019 оны хамгийн их уншлаганд гарсан ном зохиолыг сурталчилсан.
- Тэгш ой нь тохиосон Л.Ванган, Д.Цэвэгмид, Б.Ринчен, Л.Түдэв, Д.Маам, С.Санжаагончиг, С.Дашдооров, Ч.Аръяасүрэн, Д.Хүү, нарын уран бүтээлүүдийн сурталчилгааг цахим орчинд сурталчилсан

Хүүхдийн Төв номын сангийн цахим сурталчилгааг Архангай, Төв аймгийн номын сан, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Ховд аймгийн Дарви сумын соёлын төвүүд өөрсдийн пэйж хуудсанд байршуулж нутгийн иргэддээ цахим уншлагыг хүргэж байгаагаа мэдэгдсэн.

2020 оны 11-р сарын 12-ны өдрөөс эхэлсэн хорио цээрийн үед цахим орчинд 200 гаруй контентыг байршуулан 300,000 гаруй хэрэглэгчдэд хүргэсэн. Энэ хугацаанд дараах ажлууд хийгдсэн.

1. “Талын Монгол” телевизээр Хүүхдийн төв номын сангийн тухай “Номын өргөө” нэвтрүүлэг 3 удаа цацагдсан.





2. Хүүхдийн төв номын сангийн пэйж хуудсанд хорио цээрийн дэглэмийн энэ үед сургуулийн өмнөх болон бага дунд ангийн хүүхэд, багачуудад зориулан цувралаар 46 ардын аман зохиолыг оруулсан.



3. Соёлын яамнаас уриалж буй “Цахим орчинд соёл түгээе-Би хариуцлагатай иргэн” аянд Хүүхдийн төв ном сангийн хамт олон, тэргүүний уншигчид, хамтран ажилладаг хүүхдийн уран бүтээлчид тасралтгүй нэгдэж лайв болон видео бичлэгүүдийг Соёлын яамны болон байгууллагын пэйж хуудсанд байршуулан сурталчилсан. Үүнд:

- Хүүхдийн төв номын сангийн хэлтсийн эрхлэгч С. Тунгалаг
- 2018 оны Мөрөөдөл танхимын шилдэг уншигч “Нацагдорж тэмдэгтэн” Э.Энхриймаа
- Хөгжмийн зохиолч С. Батболд
- Хүүхдийн зохиолч О. Сундуй
- Хүүхдийн зохиолч, залуу уран бүтээлч Б. Ганчимэг
- Хүүхдийн зохиолч, сэтгэл судлаач А. Найгалмаа







4. Соёлын яамнаас уриалж буй “Цахим орчинд соёл түгээе-Би хариуцлагатай иргэн” аянд Хүүхдийн төв номын сангийн 41 уншигч нэгдэж үеийн найз нараа чөлөөт цагаараа ном унших, хорио цээрийн дэглэмээ баримталж хувийн ариун цэврээ сахихыг уриалсан.

5. Хүүхдийн төв номын сангийн Өрнө дахины танхим, Австралийн соёл мэдээлийн төвийн хамтран хэрэгжүүлж байгаа Австралийн сарын аяны “Боловсролын_долоо_ хоног” –ын хүрээнд Австралийн тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах, IELTS-ын шалгалтанд хэрхэн бэлдэх, мөн аяны хүрээнд зарлагдсан зургийн уралдаан, зохион бичлэгийн уралдаануудын талаарх мэдээллийг оруулсан.



6. Хүүхдийн төв номын сангаас уриалж буй “Гэр бүлээрээ цахимаар хүссэн номоо уншиж оюуны дархлаагаа дэмжицгээе” аяны хүрээнд Хүүхдийн төв номын сангийн электрон

каталогоос цахим хэлбэрээр унших боломжтой 50 номыг пэйж хуудсаар дамжуулан сурталчилсан.



7. Хорио хорио цээрийн дэглэмийн үед бяцхан уншигчдадаа зориулсан аудио хэлбэрээр 7 үлгэрийг пэйж хуудсандаа оруулсан





8. Мөн энэ хугацаанд 0 гаруй танин мэдэхүйн цуврал мэдээллүүдийг хүргэсэн байна.

9. Электрон каталогт 2717 номонд редакц хийсэн.

Цахим уншлагаар хамгийн их хандалт авсан контент

Д/д	Номын нэр	Хандалтын тоо
1	“Цахим орчинд соёл түгээе-Би хариуцлагатай иргэн” аяны хүрээнд Хүүхдийн зохиолч О. Сундуй “ Уран зохиолын нууцад нэвтрэх нь”	36400
3	Монгол ардын үлгэр "Хоёр сайн морь	34218
4	Еврей ардын ухаант үлгэрүүд: Азарган тахиа ханхүү	21200
2	“Соёлын яамнас уриалж буй цахим ертөнцөд соёл түгээе”	7421



	Талын Монгол ТВ "Номын өргөө" нэвт...	Лайв контент	Ардын аман зохиол	Австралийн сарын аян	Цахим номын сурталчилгаа	Уншигчдийн мэндчилгээ	Аудио үлгэр	Танин мэдэхүй цувралууд	НИЙТ
Контентийн тоо	3	7	794	6	43	60	10	249	1172
Контент		156102	238134	26647	131524	84617	357054	248194	1,242,

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

АГУУЛГА:

1. **Ерөнхий мэдээлэл**
   - 1.1. Эрхэм зорилго
   - 1.2. Нийтийн номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл
2. **Сан хөмрөг, Каталог**
   - 2.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал
   - 2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт
   - 2.3. Каталоги зохион байгуулалт
3. **Үйлчилгээ**
   - 3.1. Уншлагын танхим
   - 3.2. “Их мэдэх” танхим
   - 3.3. “Эко” уншлагын танхим
   - 3.4. Ангийн уншлага
   - 3.5. “Боролдой үлгэр унших” цаг
   - 3.6. Номын үзэсгэлэн
   - 3.7. Лавлагаа мэдээлэл
   - 3.8. Мэргэжил арга зүйн ажил
   - 3.9. Цахим үйлчилгээ

4.Соёл олон нийтийн ажил

5. Хүний нөөц

6.Технологи

7.Төсөв, Орлого, Зардал

8.Бусад ажил

Тайлбар:

Архангай аймгийн нийтийн номын сангийн 2020оны жилийн эцсийн тайланг дээрх 8 бүлэгт хуваан тайлагнасан болно.

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Эрхэм зорилго

Аймгийн нийт иргэдийг мэдээллээр хангах соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийг хадгалах, хамгаалах, уламжлалт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, дэлхий нийтийн жишигт нийцсэн орчин үеийн мэдээллийн технологитой "Олон нийтийн мэдээллийн төв"-ийг бий болгож орчин үеийн үйлчилгээг ашиглан мэдээллийн чөлөөт урсгалыг хөгжүүлэн хүн амын ном, хэвлэл, мэдээллийн хангамжийг сайжруулах нь манай номын сангийн эрхэм зорилго юм.

1.2 Нийтийн номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Аймгийн нийтийн номын сан нь 1945 онд , Хүүхдийн номын сан нь 1987 онд тус тус байгуулагдсан бөгөөд шинээр Хүүхдийн номын ордоны барилга нь 2013 онд, нийтийн номын сангийн барилга нь 2017 онд тус тус ашиглалтанд орсон. Нийтийн номын сан нь нийт 348 м2 талбайтай,Хүүхдийн номын ордон нь 648 м2 талбайтай,орон тооны 9 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийтийн номын сан нь:

- Захирлын өрөө
- VIP өрөө
- Үндсэн фонд
- Тогтмол хэвлэлийн фонд
- Лавлагаа номзүйн фонд
- Нийтийн уншлагын танхим 1
- Нийтийн уншлагын танхим 2
- Зөөврийн номын сан
- Ажилчдын гал тогоо
- Жижүүрийн өрөө

Хүүхдийн номын ордон нь:

- Хүүхдийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхимын фонд
- Гэр бүлийн танхим
- "Их мэдэх" танхим /бага насны хүүхэд зориулсан/
- Монгол бичгийн болон Англи номын фонд /танхим /
- Эко танхим
- Интернет танхим гэсэн танхимуудаас бүрдэлтэй
- Нягтлан бодогчийн өрөө
- Архивын өрөө

Цахим хаягууд:library.ar.gov.mn вэб сайт болон Архангай –Нийтийн номын сан facebook page,ar_library@yahoo.comимайл хаяг, гэсэн нийтийн номын сангийн электрон каталогийн хаяг .

Цагийн хуваарь: Даваа-Баасан гаригт ,Өглөө 9:00-13:00, 14:00-18:00 цаг
Байгуулагын утасны дугаар :70333248, 70332353
Номын сангийн захирал: О.Мөнхтуяа

ХОЁР. САН ХӨМРӨГ , КАТАЛОГ
2.1 САН ХӨМРӨГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Тус номын сан нь орон нутгийн онцлог,уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсвийн болон хандивын журмаар фондоо бүрдүүлж байна.

Номын сангийн фондод 2020 онд 134 ширхэг 2,110,500 төгрөгний номоор баяжилт хийсэн бөгөөд Үндэсний номын сангаас хандиваар ирсэн 32 нэр төрлийн 97 ширхэг 1,463,700 төгрөгний номыг хүлээн авч уншлагын танхимуудад хуваарьласан бөгөөд Мөн "Аз хур" номын дэлгүүрээс хандивласан 115 ширхэг 1,800,000 төгрөгний номын сумдад хуваарьласан.

2.2 САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

1. Уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангахгүй болсон хуудас салсан, урагдаж гэмтсэн 1691 ширхэг номыг сэлбэн засч, 2019 болон 2020 оны 31 нэгж сонин, 15 нэгж сэтгүүлийг үдэж хавтаслан тогтмол хэвлэлийн фондод архивласан.

2. Хүүхдийн номын ордны 600 гаруй монголын уран зохиолын номын тоосыг арчиж, шинжлэх ухааны салбараар байрлуулж хаяг ялгагч хийв.

3.Тогтмол хэвлэлийн фондод 6 ширхэг номын тавиур байрлуулж, түүх, хөдөө аж ахуй, гүн ухаан, сурган хүмүүжүүлэх салбарын номыг шинжлэх ухааны салбараар цэгцлэн байрлуулж, шинэ хаяг ялгагч хийв.

4. Үндсэн фондын шинээр дансалсан номын тоосыг арчиж, шинжлэх ухааны салбараар тавиурт байрлуулсан.

Жилд 4 удаа их цэвэрлэгээ хийж номыг тоосыг арчин ариутгал халдваргүйжүүлэлтийн үйлчилгээг "Мэргэн Насан " ХХК –аар 2 удаа ариутгалын бодис цацуулж хортон шавж, хөгц мөөгөнцрөөс хамгаалсан.

2.3 КАТАЛОГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Номын сангийн электрон каталогийн үүлэн технологит суурьласан Koha програмыг худалдан авч үйлчилгээндээ нэвтрүүлж байна. Одоогоор 13833 нэр төрлийн 43665 ширхэг номыг электрон каталогит оруулаад байгаа бөгөөд хүүхдийн уншлагын танхим, нийтийн

уншлагын танхим, тогтмол хэвлэлийн фондын номыг электрон каталогт бүрэн оруулж дуусгасан. Одоо үндсэн фондын 74000 гаруу номыг шивж эхлээд ажиллаж байна. 2021 ондоо багтаан тус танхимын номыг электрон каталогт бүрэн оруулж дуусгахаар төлөвлөсөн байгаа.

ГУРАВ.ҮЙЛЧИЛГЭЭ.
3.1. Уншлагын танхим

2020 онд Covid-19 буюу короно вирусын цар тахал гарсантай холбогдуулан онц байдал зарлаж нийтийн хөл хорио тогтоосонтой холбогдуулан аймгийн Нийтийн номын сан 2-8 сар, 11 саруудад уншлага, үйлчилгээ зохион байгуулаагүй бөгөөд заал танхимаар үйлчлүүлэгсдийг хоорондын зай барих зорилгоор нэг ширээнд нэг хүн суулгах зэрэг арга хэмжээг авч ажилласан тул үйлчлүүлэгчдийн тоо төлөвлөгөөндөө хүрээгүй болно. Мөн олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглосон тул СОНА-ыг цахим хэлбээр зохион байгуулж байсан.

Нийтийн номын сан нь 2020 оны жилийн эцсийн байдлаар 897 уншигч шинээр бүртгэж, 3603 ирэгсдэд 8695 ном, 1350 сэтгүүл, сонин хэвлэлээр үйлчилсэн байна. Үүнээс:

1. **Нийтийн уншлагын танхимд:** Нийт 220 уншигч шинээр бүртгэж 7383 иргэсдэд 2477 ном, 680 сонин, сэтгүүл, хэвлэлээр үйлчилсэн байна.
2.**Хүүхдийн уншлагын танхимд:** Нийт 443 уншигч шинээр бүртгэж 3741 иргэсдэд 5042 номоор үйлчилсэн байна.
3.**Зөөврийн номын санд:** Иргэд, олон нийтэд номын сангийн үйлчилгээг тэгш хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлэх, номын сангаас гадуурх уншигч, хэрэглэгчдийн хүрээг өргөжүүлэх зорилгоор тусгайд нь зөөврийн номын санч ажиллуулан аймгийн ЗДТГ, Эрдэнэбулган сумын ЗДТГ, БСУГ, Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Газар, Татварын Хэлтэс, Мэргэжлийн Хяналтын Газар, Онцгой Байдлын Газар, Цагдаагийн Газар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газар, Шүүхийн Тамгийн Газар, Ахмадын Хороо, Статистикийн Газар, Төрийн сангийн хэлтэс, "Ард" даатгал, БОАЖГ, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, "Тана Арцат" эмнэлэг, Олон нийтийн өмчийн газар, ГХБХБГ зэрэг 23 байгууллагад тусгайд нь зөөврийн номын санч ажиллуулан зөөврийн номын сангийн гэрээний дагуу ном хэвлэлийн үйлчилгээ хүргэн ажиллаж нийт 108 уншигч шинээр бүртгэж 588 уншигчдад 1259 номоор үйлчилсэн.

4.**Гэрээр ном олголт:**126 уншигч шинээр бүртгэж 773 иргэсдэд/давхардсан тоогоор/1102ном, 670 сонин, сэтгүүл, хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчилсэн байна.
5.**Явуулын номын сангийн үйлчилгээ:** 04-р сарын 28-30-ны өдрүүдэд зорилтот бүлгийн 15 өрхөд 30 ширхэг номоор үйлчиллээ.

3.2. "ИХ МЭДЭХ" ТАНХИМ

Цэцэрлэгийн 3-5 насны хүүхдийн "Их мэдэх" танхимаар 225 хүүхэд эцэг, эх, асран хамгаалагчийн хамтаар222 номоор үйлчлүүлж, үлгэр сонсох "Боролдойн цаг"-т хамрагдлаа.

3.3."ЭКО" УНШЛАГЫН ТАНХИМ

Байгальд ээлтэй хүүхэд төлөвшүүлэх зорилго бүхий "Эко" танхимаар Эрдэнэбулган сумын ЕБС-иудын бага, дунд, ахлах бүлгийн 220 сурагч, бусад иргэдэд үйлчилгээ үзүүлж, байгаль, экологийн талаар танин мэдэхүйн мэдлэг, мэдээлэл олгох үйлчилгээ үзүүллээ.

3.4."АНГИЙН УНШЛАГА"

Эрдэнэбулган сумын "Эрдэм" ахлах сургуулийн 6а, 7а, 8а анги, 3-р сургуулийн Б.Банзрагч багштай 9б анги, 4-р сургуулийн М.Баярбат багштай 8а ангийн 24 сурагч, нийт 150 иргэсэдэд, 360 номоор үйлчлүүлж, ангийн уншлагад хамрагдлаа.

3.5."БОРОЛДОЙ" ҮЛГЭР УНШИХ ЦАГ

БСШУС-ын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон Архангай аймгийн Засаг даргын хооронд 2017 онд засгийн чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний “Үлгэрийн цаг” үлгэр унших тогтмол цагтай болгох гэрээний заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хүүхдийн уншлагын танхим нь “Их мэдэх” танхимаар үйлчлүүлсэн болон сонирхсон хүүхдүүдтэй “Боролдой” үлгэр унших цагт “Их мэдэх” танхимаар ирсэн 15 хүүхэд эцэг, эх, асран хамгаалагчийн хамтаар оролцсон.

3.6.НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

2019 онд нийт 18 удаагийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг эдийн засаг, анагаах ухаан, техникийн шинжлэх ухаан, монголын уран зохиол, гадаадын уран зохиол, байгаль экологи, түүхэн ном болон бусад сэдвийн 1007 ш номоор гаргасан байна.

Нийтийн уншлагын танхимд: 6 удаагийн сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 440номоор гаргаж уншигчдад сурталчилан танилцуулсан. Үүнд:

1. Монголын болон гадаадын уран зохиолын 55 номоор үзэсгэлэн гаргаж, уншлагын танхим, гэрээр олгон үйлчиллээ.
2. А. “Монгол улсын түүх” сэдэвт 80 ширхэг номын үзэсгэлэн гаргаж, гэрээр ном олгон үйлчиллээ.
3. 3. Шинэ номын үзэсгэлэнг 45 ширхэг номоор гаргаж, гэрээр ном олгон үйлчилсэн.
4. 4.Монголын түүх, ёс заншлын 130 ширхэг номын үзэсгэлэн
5. Уран зохиолын 65 ширхэг шинэ номын үзэсгэлэн
6. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 70 ширхэг шинэ номын үзэсгэлэн

Хүүхдийн уншлагын танхимд: 6 удаагийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 311 ширхэг номоор гаргаж уншигчдад сурталчилан танилцууллаа. Үүнд:

1. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн танин мэдэхүйн цуврал, нэвтэрхий толь, лавлагааны чиглэлийн 40 номоор үзэсгэлэн гаргаж, чөлөөт сонголтоор уншлага зохион байгууллаа.
2. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн монголын болон дэлхийн хүүхдийн уран зохиолын шилдэг 50 номоор үзэсгэлэн гаргаж, чөлөөт сонголтоор гэрээр олгон үйлчиллээ.
3. Хичээлийн шинэ жилийн нээлтэд зориулан хүүхдийн уншлагын танхимд хүүхдэд зориулсан 40 ширхэг шинэ номын үзэсгэлэнг тус бүр гаргалаа.
4. Хичээлийн шинэ жилд зориулан хүүхдийн уншлагын танхимд гадаадын болон

монголын хүүхдэд зориулсан 63 ширхэг шинэ номын үзэсгэлэн
5. Монгол ардын аман зохиолын 50 ширхэг шинэ номын үзэсгэлэн
6. “Орон орны үлгэрийн ертөнцөөр аялацгаая” сэдэвт 68 ширхэг номын үзэсгэлэн

Эко танхимд: 2 УДААГИЙН НИЙТ 45 Ш НОМООР үзэсгэлэнг гаргаж иргэд олон нийтэд сурталчилсан.Үүнд:

1. “Эко” танхимд байгаль шинжлэлийн 22 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж, уншигчдад нээлттэй сурталчиллаа.
2. “Эко” танхимд байгаль шинжлэлийн 25 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж, гэрээр олгон үйлчиллээ.

Соёлын цаг: Соёлын цаг арга хэмжээгээр 6 цэцэрлэг, 2 сургууль дээр шинэ хүүхдийн ном, уран зохиолын ном нийт 256 ш номоор үзэсгэлэн гаргасан.

3.7. ЛАВЛАГАА , МЭДЭЭЛЭЛ

“Архангайн үнэн” сонины 1956-1998 он, “Пионерийн үнэн” сонины 1976-1989, “Номын үнэн” сонины 1959-1965 “Архангайн амьдрал сонины 2005-2018 он, “Дээж мэдээ” сонины 1999-2004 он, “Архангайн толь” сонины 2010-2018 он, “Үнэн” сонины 1987-1988 он, Архангайн амьдрал 2005-2018 он, Өдрийн сонин 2008,2012,2016 он, “Дээж мэдээ” сонины 1999-2002 он, нийт 165 нэгж сонинг тогтмол хэвлэлийн фондоос гаргаж, уншигчдын хэрэгцээт мэдээллийг шүүж, лавлагаа - мэдээллийн үйлчилгээ хүргэн ажиллаа.

Цахимаар 5 уншигчдад лавлагаа- мэдээлэл өгч үйлчиллээ.

3.8. МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН АЖИЛ

1. Үндэсний номын сангаас хандиваар ирсэн болон 2019 онд худалдан авсан 52 нэр төрлийн 105 ширхэг номонд техник ажиллагаа хийж, уншлагын танхимуудад хуваарилав.

2. Үндсэн фондын нийт 3895 нэр төрлийн 11740 ширхэг номыг шинэчилсэн нэг бүрчилсэн бүртгэлд стандартын дагуу бүртгэж, дансаллаа.

3. Төр эрх, хууль цаазын шинжлэх ухааны 1207 нэр төрлийн номыг номын сан-ном зүйн ангиллаар ангиллав.

4. Хүүхдийн номын ордны 4000 номыг шинэчилсэн нэг бүрчилсэн бүртгэлд хуулж, тулган шинэчлэн хуулсан.

5. Нийтийн уншлагын танхимын номын фондын хаалтыг авч, чөлөөт сонголттой үйлчилгээ үзүүлэхэд бэлэн болсон.

3.9. ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн хугацаанд “Цахим орчинд соёл түгээе!” уриан дор цахимаар хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Үүнд:

1.”Номын баяр-2020” арга хэмжээний хүрээнд зохиогдсон уралдаанд оролцогчдын өгүүллэг, шторкыг номын сангийн page хуудсанд цувралаар нийтлэх
2. СГЗ С. Жүншийн “Зуун зуун дамжих 108 домог” номыг цахимаар уншигчдад хүргэх
3. СГЗ, зохиол, сэтгүүлч Г. Жамцын уран бүтээлээс цахимаар уншигчдад хүргэх
4. Г. Жамцын “Тавилан” романаар уншигчдын online уулзалт-хэлэлцүүлэг хийх
5. Миний хамгийн сүүлд уншсан ном “Challenge” цахимаар зохион байгуулах

ДӨРӨВ. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

1. Дэлхийн номын өдөр Аймгийн Нийтийн номын сангаас 04 сарын 09-30 -ны өдрүүдэд “Дэлхийн номын өдөр буюу Зохиогчийн эрхийн өдөр”-ийг тохиолдуулан “Өөрийгөө асааж бусдыг гэрэлтүүл” уриатай богино өгүүллэгийг урнаар унших уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаанд оролцогчид өөрсдийн сонгосон богино өгүүллэгийг урнаар уншин бичлэг хийж номын сангийн пэйж хуудсанд нийтлүүлсэн бөгөөд олон нийтийн санал асуулгаар дүнг гаргалаа.

Тус уралдаанд насанд хүрэгчдийн ангилалд 12 хүн оролцсоноос тэргүүн байрыг Цахир сумын оролцогч Г.Хажидсүрэн , дэд байрыг Эрдэнэбулган сумын 2-р сургуулийн багш М.Анхзаяа, хүүхэд насны анилалд тэргүүн байрыг 2- сургуулийн 12а ангийн сурагч А. Дэмбэрэлдодов, дэд байрыг Лаборатори 1-р сургуулийн 9а ангийн сурагч Г. Даянжалбуу, 3-р байрыг Лаборатори 1-р сургуулийн 12р ангийн сурагч Ц.Цэнгэл нар тус бүр эзэлсэн.

2. “Монголын нууц товчоо – Монголчуудын амьдралд” хэлэлцүүлгийн “БЭХИ ЦОЛТОН” НҮТББ-тай хамтран Архангай аймагт зохион байгуулахаар төлөвлөн удирдамж боловсруулж байгууллага иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна. Тус уралдааны зорилго нь Монголын нууц товчоо судраас амьдрахуйн ухааныг таних, суралцах, эх хэл, түүх соёл, өв уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, бахархах, хөгжүүлэх, орон нутгийн онцлог соёлын контент бий болгох зорилгоор боловсрол соёл урлагийн байгууллагын нийт албан хаагчдын эх хэл , түүхийн тухай мэдлэг боловсролыг дээшлүүлэх, баталгаажуулах, суралцуулах, судалгаа хийлгэхэд оршиж байгаа.

3. Номын баяр – 2020

09.01-10.28-ны хооронд “Номын баяр-2020” арга хэмжээг зохион байгуулж байна. Тус арга хэмжээний нээлтийг аймгийн Биеийн тамир, спортын газар 09 сарын 19-нд зохион байгуулсан бөгөөд нийт 2000 гаруй иргэд хамрагдлаа. Номын баярын хүрээнд Нийтийн номын сангаас “Нөхдөдөө өгөх бидний зөвлөгөө ШТОРК” бэлтгэх уралдаан, “Ногоон дэлхий бидний ирээдүй” гар зургийн уралдаан, “Монгол хүн ба номын хэрэглээ” илтгэлийн уралдаануудыг Мэргэшсэн нягтлан бодогчдын Архангай дахь салбар, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар ивээн тэтгэж зохион явуулж байна.

4. Соёлын цаг -2020

МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/43 тоот тушаалаар батлагдсан “Соёлын цаг” нөлөөллийн аяны нээлтийг 09-р сарын 28-нд

аймгийн Нийтийн номын сан, Музей, Хөгжимт драмын театр хамтран аймгийн Биеийн тамир, спортын газар зохион байгууллаа. 2 сарын аяны хүрээнд “Соёлын цаг” нөлөөллийн арга хэмжээг Эрдэнэбулган сумын VIII, XI дүгээр цэцэрлэг, III, V дугаар сургууль, Ихтамир, Хотонт, Батцэнгэл сумдад тус бүр хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.

5.Соёлын цаг – 8-р цэцэрлэг

09.23-нд Эрдэнэбулган сумын VIII дугаар цэцэрлэгийн хүүхэд, багачууд, багш ажиллагсдад “Соёлын цаг” арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үеэр ХДТ-ын урлагийн тоглолт, Музейн монгол гэр барих талаар

зааварчилгаа, Нийтийн номын сангаас хүүхдийн номын үзэсгэлэн гарган, хөгжөөнт тоглоом тоглуулж соёлын үйлчилгээг нийт 50 гаруй хүнд хүргэлээ.

6.Соёлын цаг – Цэцэрлэг, сургуулиуд

МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/43 тоот тушаалаар батлагдсан “Соёлын цаг” нөлөөллийн 2 сарын аяны хүрээнд аймгийн Нийтийн номын сан, Музей, Хөгжимт драмын театр хамтран 09-р сарын 28, 10-р сарын 5,6-ны өдрүүдэд Эрдэнэбулган сумын II, IV, XI дүгээр

цэцэрлэг, V дугаар сургууль, Ихтамир сумын цэцэрлэг, ЕБС, Соёлын төвд тус бүр зохион байгуулж, нийт 1058 хүүхэд, 125 насанд хүрэгчид хамрагдаж, соёлын үйлчилгээ хүртлээ.

7. МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны “Номын баярын өдөр тэмдэглэх” тухай 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/43 тоот тушаалаар батлагдсан “Соёлын цаг” нөлөөллийн 2 сарын аяны хүрээнд Нийтийн номын сангийн Face хуудас-Архангай-Нийтийн номын сан сайтад ЕБС-ийн Ахлах, дунд насны ангиллын “Ногоон дэлхий -Бидний ирээдүй” гар зургийн уралдаанд 56, бага насны ангиллын “Нөхдөдөө өгөх бидний зөвлөгөө” covid-19 вирусын халдвараас сэргийлэх зөвлөмж-Шторкийн уралдаанд нийт 16 цэцэрлэг, сургуулийн 300 гаруй хүүхэд багачууд оролцсноос цахим орчинд олон нийтийн оролцоотой шүүж, шилдгүүдийг шалгарууллаа.

ТАВ. ХҮНИЙ НӨӨЦ:

Сургалт, семинарт хамрагдсан байдал

1. 01-р сарын 18-19-ний өдрүүдэд номын сангийн автоматжуулалтын “Koha”программын сургалтанд номын санчид хамрагдлаа.
2. 03-р сарын 09-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Monkohaпрограмын сургалтанд мэдээлэл-технологийн ажилтан Б. Ариунзаяа хамрагдсан.

3. Улаанбаатар хотод Номын сангийн консерциумаас жил бүл уламжлал болгон зохион явуулдаг 5 хоногийн сургалт, семенар, спортын арга хэмжээнд Архангай аймгийн

Нийтийн номын сангаас 4 албан хаагч, цэцэрлэг сумын 1 номын санч хамрагдсан.

ЗУРГАА.ТЕХНОЛОГИ

6.1. Электрон каталог:Номын сангийн электрон каталогийн үүлэн технологит суурьласан Koha програмыг худалдан авч үйлчилгээндээ нэвтрүүлж байна. Одоогоор 11018 нэр төрлийн 38461 ширхэг номыг электрон каталогит оруулаад байгаа бөгөөд хүүхдийн уншлагын танхим, нийтийн уншлагын танхимын номыг бүрэн оруулж дуусгасан.

2. Мөн Нийтийн болон хүүхдийн уншлагын танхимд дохиолол хамгааллын хаалга суурилуулан чөлөөт сонголттой уншлага үйлчилгээг үзүүлэхэд бэлтгэн бүх номыг электрон каталогит оруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

6.2. Цахим мэдээлэл: Аймгийн Нийтийн номын сангийн албан ёсны хаяг болох **Архангай-Нийтийн номын сан** Facebook page хуудсанд үйл ажиллагаанийхаа талаарх мэдээллээ тогтмол шинэчлэн байрлуулж иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэн ажилладаг. 2020 онд нийт 33 удаагийн мэдээ мэдээллээр шинэчлэсэн байна. Үүнд:

1. Номын сангийн ахмад уншигчийн талаарх мэдээлэл,
2. Гэрээр ном олгох үйлчилгээний тухай
3. Онцгой байдлыг үеийн талаар авах арга хэмжээ, сэрэмжлүүлэг
4.Цахим номын сангууд
5. Цахимаар унших хүүхдийн зохиолоос
6. Ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай
7. Уралдааны удирдамж
8. Уралдаанд ирсэн 20 гаруй бүтээлүүдийг нийтлэв
9.Уралдааны шалгаруулалт
10.Монголын нууц товчоо-Монголчуудын амьдралд хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл
11. Номын баярын хүрээнд зохион байгуулсан уралдааны бүтээлүүд
12. Цахим номын сангийн үйлчилгээний тухай мэдээлэл
13. Зөвлөгөө, сэрэмжлүүлэг,
14. СГЗ, зохиолч, сэтгүүлч Г.Жамцын “Тавилан ” түүхэн романыг цувралаар
15. СГЗ, зохиолч С.Жүнш “Зуун зуун дамжих 108 домог” номыг цувралаар зэрэг нийт 33 удаагийн нийтлэл оруулсан байна.

6.3. Байгууллагын аюулгүй байдал:

Аймгийн Нийтийн номын сан нь 24 цагийн 2 харуул хамгаалалтын ажилтантай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд галын дохиолол, дотор гадна хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгч дохиолол байрлуулж байгууллагын гадна талбайд гэрэлтүүлэг хийж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Мөн 2 уншлагын танхимд соронзон долгионоор мэдрэгч дохиолол хамгааллын төхөөрөмж байрлуулан чөлөөт сонголттой уншлага явуулахад бэлэн болсон бөгөөд ном алдагдахаас сэргийлэн ажиллаж байна.

Долоо. ТӨСӨВ, ОРЛОГО, ЗАРДАЛ:

2020 оны тайлангийн жилд орон нутгийн төсвөөс 231,662.0 мян төгрөгөөр санхүүжиж, үндсэн үйл ажиллагааны орлогоор төлөвлөгөөнд тусгагдсан 100.0 мян.төгрөг төвлөрүүлэн 231,762.0 мян.төгрөгт багтаан үйл ажиллагаа явуулсан.

Найм.БУСАД АЖИЛ:

1. Нийтийн номын сангийн 2019 оны бичиг баримтуудыг стандартын дагуу цэгцлэн, үдэж хавтаслав.
2. Ажилтан бүр 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлууллаа.
3. “Тамирын жавар-2020” мөсний баярын арга хэмжээнд хамт олноороо идэвхитэй оролцсон.

4. Нийтийн номын сан, Хүүхдийн номын ордны бүх өрөө, танхимуудад төлөвлөгөөт их цэвэрлээг 4 удаа хийж гүйцэтгэсэн.
5. Шинэ Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, тэдний дархлааг сэргээх, сэтгэл зүйн байдлыг дэмжих зорилгоор өдөрт 2 удаа ариутгагч бодисоор өрөө, танхимуудад цэвэрлэгээ хийж, амны хаалт, гар ариутгагч болон бусад зүйлсийг байгууллагаас хանган, орчны болон хүний нөөцийн аюулгүй байдлыг хანган ажилаж байна.
6. Хөдөлгөөн мэдрэгч дуут дохиолол эвдэрснийг засч, гамшгаас хамгаалах, аюулгүй байдлыг хангаж, хэвийн ажиллагаанд оруулсан.
7. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан аймгийн онцгой комиссоос гаргасан хуваарийн дагуу 2-р сарын 23,24, 3-р сарын 5-ны өдрүүдэд Наранбулаг, Цагаан даваа, Цагаан даваны пост дээр аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн Хяналтын газрын бие бүрэлдэхүүний хамт хөдөлгөөнт эргүүлд номын санч Б. Шинэхорго оролцсон.

8. “COVID-19” вирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 03-р сарын 19-ны өдөр “Мэргэн Насан” ХХК-аар номын сангийн бүх өрөө, тасалгаа, танхим, фондуудад ариутгал хийлгэлээ.

9. Нийтийн уншлагын танхимын орчин нөхцлийг сайжруулах зорилгоор 32 ш сандалд суудлын бүрээс шинээр хийлээ.

10. Өдөр бүр хлораминтай усаар чийгтэй цэвэрлэгээ хийж, маскаа тогтмол зүүн ажлын байрны ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахин ажиллаж байна.

11. Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний албан даалгаврын биелэлтийн тайлан, байгууллагын жилийн ерөнхий үнэлгээний дагуу хийх ажлын төлөвлөгөө зэргийг батлуулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

12. Онгоны аманд гарсан түймрийн голомтод 5-р сарын 08-11-ний өдрүүдэд ажилласан бөгөөд байгууллагын нийт ажилчдаас хоол хүнс, шатахууны дэмжлэг үзүүлсэн.

13. Үндсэн фондын номын 10 тавиурыг шинээр угсарч байрлуулав.

14. Өдөр бүр хлораминтай усаар чийгтэй цэвэрлэгээ хийж, маскаа тогтмол зүүн ажлын байрны ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахин ажиллаж байгаа бөгөөд уншигч-үйлчлүүлэгч бүр маскаа тогтмол хэрэглэж, гараа ариутган үйлчилгээ авч байна.

15. Хүүхдийн номын ордны интернет танхим болон Зөөврийн номын санчийн өрөөнд засвар хийж будаж тохижуулсан.

16. 10-ны өдөр буюу “Мод тарих үндэсний өдөр”-өөр байгууллага хамт олноороо 10 ширхэг мод тарьсан.

17. 10 сарын10-ны өдөр буюу бүх нийтийн их цэвэрлэгээний өдөр Музейн баруун талд байрлах хуучин гандангийн туурийг цэвэрлэж, хогийг ачуулсан.

18. 10 сарын 20-ны өдөр байгууллагын гадна талбайн цасыг арилгаж, цэвэрлэв.

19. 11 сарын 03-нд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/206 тоот удирдамжийн дагуу аймгийн Нийтийн номын сангийн “Соёлын тухай”, “Соёлын өвийг

хамгаалах тухай", "Төрийн хяналт шалгалт хийх тухай", "Номын сангийн тухай" хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журмын хэрэгжилт, Номын сангийн бүртгэл хамгаалалтыг шалгах хяналтын хуудас-д тусгагдсан 54 асуултын дагуу шалгалт хийсэн.

19. УОК-ын 2020 оны 11-р сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоол дагуу коронавирусг халдвар /covid-19/цар тахлаас байгууллагын ажиллагсдыг урьдчилан сэргийлэх, тэдний дархлааг дэмжих амин дэм, маскаар хангав.

20. Гамшгийн хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн хугацаанд Эрдэнэбулган сумын хөдөлгөөнт эргүүлд бүх ажиллагсад 1 удаа, аймгийн хяналтын постонд номын санч Б. Шинэхорго 4 удаа гарсан.

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САН

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго:

Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **“Мэдээллийн нээлттэй төв ”** болох.

1.2. Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Тус номын сан 1949 онд байгуулагдсан. 2014 онд шинэ байранд орж, нэг ээлжинд 180 хүнийг хүлээн авч ном уншуулах чадвартай 5 уншлагын танхимтай болсон. Насанд хүрэгчдийн танхим, Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын 1-р танхим/1-4 анги/, хүүхдийн уншлагын 2-р танхим /5-7 анги/, бяцхан уншигчдын танхим / цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулагдсан/. Танхимууд бүгд чөлөөт сонголттой. Нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 03-р сарын 09-ний өдрийн 37 тоот тогтоолоор аймгийн нийтийн номын санг зохиолч, яруу найрагч Б.Ахтаны нэрэмжит болгов. Өлгий сумын бүх БДС-ийн захиралаар гэрээ байгуулж, 5 хоногийн график гарган, сурагчдыг номын санд бүрэн хамруулж байна.

Цахим хаяг: Б.Ахтаны нэрэмжит төв номын сан
Өвлийн цагийн хуваарь: Даваа-Баасан гаригт, Өглөө 8:00-12:00, Орой 13:00-19:00 цаг
Бямба 10.00-15.00 цаг
Зуны цагийн хуваарь: Даваа-Баасан гаригт, Өглөө 9:00-12:00, Орой 13:00-19:00 цаг
Байгууллагын утасны дугаар: 70422504
Номын сангийн захриал Д.Алтангүл

2. Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт

2.1. Номын сангийн хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт, байрлуулалт, эргэлтийн байдал.

2020 онд 151ш номыг 2290625 төгрөгөөр худалдаагаар, 343ш номыг 1849100 төгрөгөөр бэлэг хандиваар нийт 494ш номыг тус тус бүрдүүлэн авч, электрон каталогт оруулан, 494 ш баркод хэвлэсэн байна. Бүрдүүлэлтээр авсан бүх номыг нэгдсэн болон нэгбүрчилсэн бүртгэлд авч, уншлагын танхимуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүллээ. Тогтмол хэвлэлийн захиалгыг хийж, дугаар ирэлтэнд хяналт тавьж, 2020 онд номын сангийн хэмжээнд 19 нэрийн 64 төрлийн 740850 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна. Бүрдүүлэлтээр авсан ном хэвлэлийг фонд, уншлагын танхимуудад үсэг дараалллаар болон төрөл ангиар нь байрлуулав. Монгол Улсын Үндэсний номын сангаас эрхлэн гаргасан “Номын санч” сэтгүүлийн 2019 оны №02, 2020 оны №01 дугаруудыг нийт 13 сумуудын соёлын төвийн номын санд жагсаалт үйлдэн хүргүүлээд байна.

Аймгийн Шүүх байгууулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан номын санд хууль зүйн фондонд 1100 гаруй ном хандивлах үйл ажиллагаа зохион байгуулагдав.

Сан хөмрөгийн төрөл	Тоо ширхэг	Үнэ
Сан хөмрөг нийт	68264	159051364
Хэвлэмэл ном	65606	149830264
Сонин сэтгүүл	2508	8996100
Хэвлэмэл бус	150	225000

Бүрдүүлэлт	Тоо ширхэг	Үнэ
Шинээр нэмэгдсэн нийт	638	4810075
Шинээр нэмэгдсэн ном	494	4139725
Шинээр нэмэгдсэн сонин сэтгүүл	144	670350

Хийгдсэн ажил	Тоо
Электрон каталогт бүртгэгдсэн ном	65606
Электрон каталогт шинээр нэмэгдсэн ном	494

2.2. 2020 оны фонд бүрдүүлэлтэд судалгаа хийж, фондын эргэлтийг харьцуулан судалсан. Энэхүү судалгаагаар шинээр худалдан авсан ном хэвлэл нь, уншигч, хэрэглэгчдийн аман болон бичгээр лавласан, татгалзалд бүртгэгдсэн ном хэвлэлээр сан хөмрөг баяжигдаж, оновчтойгоор бүрдүүлэлт хийгдэв.



2.3. Монгол фондын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, ариутгал халдваргүйжүүлэлтийн байдал.

Номын сангийн орчны стандартыг мөрдлөг болгон номын фондын байрны дулаан, чийгшлийг фондын номын санчид өдөр бүр хянаж, тэмдэглэл хөтөлж байна. Мөн фондын номын дулаан чийгшлийг хэмжэх төхөөрөмжийг СХЗГазарт шалгуулж, баталгаажуулалт хийлгэн ажиллаж байна.

-1-р улиралд чийгшил 25%, дулаан 18,2

-2-р улиралд чийгшил 28,6%, дулаан 18,8

-3-р улиралд чийгшил 32,4%,дулаан 18,0

-4-рулиралдчийгшил 31,1%, дулаан 19,3 байгаа нь номын сангийн фондын хадгалалтын дулаан хэвийн, харьцангуй чийгшил нь бага байна.

2020 онд “Уншлагын танхим”, “Хүүхдийн 1-р танхим ”, “Гэрээр ном олгох танхим” танхимуудад ээлжит бус болон ажил хүлээлцэх тооллогыг хийж гүйцэтгэсэн.

2020 оны 1-р сард насанд хүрэгчдийн уншлагын танхимын номын санч өндөр насны тэтгэвэрт гарсан тул ээлжит бус тооллого хийсэн. Тооллогоор 2143 ширхэг хэвлэмэл бүтээгдэхүүн байхаас 1963 ширхэг хэвлэлийн бүтээгдэхүүн тооллогдож, 180 ширхэг ном тооллогдоогүй дутсан. Тооллогыг нэгбүрчилсэн дансаар монгол номын 1 данс, казак номын 1 данс, гадаад номын данс 1 нийт 3 дансанд “Тооллого” нүдэнд тэмдэглэсэн. Тооллогын тайланг захиргааны зөвлөлд илтгэж тайлагнасан. Захиргааны зөвлөл тооллогын комиссын эцсийн дүгнэлтийг үндэслэн энэ ондоо багтаан тооллогоор дутсан номуудыг төлж барагдуулах

үүрэг өгсний дагуу тооллогоор дутсан 180 номноос 172 ширхэг номыг орлуулж, 8 номыг номоор нь төлүүлсэн.

2020 оны 2 сард “Хүүхдийн 2-р танхим”-ын ажил хүлээлцүүлэх тооллого хийсэн. Тооллогоор 3342 ширхэг ном байхаас 3307 ширхэг ном тоологдож 35 ширхэг ном тооллогдоогүй дутсан. Тооллогыг мөн дансаар монгол 1, казак номын 1 данс “Тооллого” нүдэнд тэмдэглэсэн. Тооллогын дүнг захиргааны хуралд танилцуулж, дутсан 35 ш номын 5ш номыг номоор нь 30ш номыг орлуулан төлүүлж барагдуулав.

2020 оны 7 сард Гэрээр ном олгох танхимын номын санч Ном зүйчийн ажилд шилжин ажиллах болсон тул ээлжит бус тооллого хийсэн. Тооллогоор 4025 ширхэг ном тооллогдож, 200 ширхэг ном уншлагаар гарсан, дутсан 25ш номыг номоор нь төлсөн. Мөн тус танхимаас эргэлтгүй байгаа 2177ш номыг үндсэн фондонд шилжүүлэн ажиллаа.

Цар тахлын үед үндсэн монгол фонд, казак фондын номын тос шороог арчиж, үсэг дарааллаар болон төрөл ангиар нь байрлуулан

ажиллаа.

Сэлбэн засалт:

- Элэгдэж хуучирсан 250ш ном, 40ш сонин сэлбэн зассан. Үүнд: Хүүхдийн 1-р танхимаас 100, хүүхдийн 2-р танхим 12, ГНОТанхимаас 30, уншлагын танхимаас 11 ном сэлбэн засав. 1960-1990 оны “Үнэн”, 1980-1990 онуудын “Залуучуудын үнэн” сонингуудын сэлбэн засаж хавтаслав.

3.1. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.

3.1 Уншлага үйчилгээ.
2020 оны байдлаар **7551** уншигчдад шинээр карт нээж, **20596** ирэгсэдэд нийт 28147 уншигчдад **51393** ном олгон уншуулж, уншигчдын эрэлт хэрэгцээг ханган үйлчилэв.

Танхимууд / Үзүүлэлт	Уншлагын танхим	Гэрээр ном олгох танхим	Хүүхдийн 1-ртанхим	Хүүхдийн 2-ртанхим	Зөөврөөр	Цахимаар	Нийт
Уншигч	1200	1409	1251	1391	700		**5951**
Байнгын уншигч	1450	2100	2150	2000	1300		**9000**
Ирэгсэд	5100	4900	5100	6946	3650	3550	**25696**
Ном олголт	11400	10500	13221	12582	4180	1267	**53150**

3.2. Соёл олон нийтийн ажил
Манай номын сан нь номзүйн мэдээллийг боловсронгуй болгох үүднээс 30 удаа **842** ш номоор шинэ болон сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж, **1460** уншигч, иргэдийг уншлаганд хамруулж, 11 төрлийн соёл олон нийтийн ажлуудыг тогтмол зохион байгуулж байна.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн

Номын үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэнд дэлгэгдсэн номын тоо	Зориулалт
Ховор ном	**20**	**“Соёлын цаг” нөлөөлийн аян**
Хүүхдийн ном	**30**	
Бабалар сөзи	**120**	
Сонин сэтгүүл	**15**	
Хамгийн том ба жижиг ном	**14**	
Шинэ ном	**70**	
Шашны ном	**35**	
Зөөврийн ном	**45**	
Хууль зүйн ном	**25**	

Тэнгэрлэг эрчүүд	38	Цэргийн баяр
Абай 175 жыл	32	Абайн мэндэлсэний 175 ой
Шинэ номын цахим үзэсгэлэн	59	Дэлхийн номын өдөр, хүүхдийн баяр
Эх сайхан монгол хэл	35	Бичиг үсгийн баяр
Шинэ номын үзэсгэлэн, номын худалдаа	265	Номын баяр -2020
Монголын түүх Монгол бахархал	39	Монгол бахархалын өдөр
Нийт	842	

“Соёлын цаг” нөлөөллийн аян

“Соёлын цаг” нөлөөллийн аяныг үндэсний өв соёлоо эрхэмлэн дээдэлж, хайрлан хадгалж, хамгаалж, түгээн дэлгэрүүлэхэд зориулсан соёлын нөлөөллийн олон төрөл, хэлбэрийн үйл ажиллагааг ард иргэдэд үнэ төлбөргүй хүргэх зорилгоор 9-р сарын 01 нээс 11-р сарын 01 хүртэл зохион байгууллаа.

“Соёлын цаг” нөлөөллийн нээлтийг 09-р сарын 19 нд аймгийн төв төлбайд аймгийн ЗДТГ, ХДТ, Музейтей хамтарч зохион байгуулав. Нээлтийн үйл ажиллагааг аймгийн орлогч дарга Ш.Хабыл нээж, ЗДТГ-ын соёл хариуцсан мэргэжилтэн Б.Сагым , Б.Ахтаны нэрэмжит аймгийн төв номын сангийн захирал Д.Алтангул, Хурманханы нэрэмжит ХДТ-ын дарга Асылбек, музейн захирал А.Айшагүл нар мэндчилгээ дэвшүүлэв.

Нээлтийн үйл ажиллагаанд Б.Ахтаны нэрэмжит төв номын сангаас шинэ ном, ховор ном, соёлын өв, түүхийн холбогдолтой нийт 400 гаруй номын үзэсгэлэн гаргаж, “Хэрэглэгчийн судалгаа” авч ажиллав.

9-р сарын 28, 10-р сарын 15 ны өдөрүүдэд Бугат, Сагсай сумын ард иргэдэд шинэ номын үзэсгэлэн, ховор номын үзэсгэлэн, хуулийн номын үзэсгэлэн, шашны номын үзэсгэлэн, “Бабалар сөзи” номын үзэсгэлэн, хүүхдийн номын үзэсгэлэн, хуучин оны сонин сэтгүүлийн, хамгийн том, хамгийн жижиг номын, зөөврийн номын сан, номын худалдаа зэрэг нийт 10 гаруй төрлийн номын үзэсгэлэн гаргаж, номын санчдын бэлтгэсэн “Баавгай ба туулай” үлгэрийн баатрын дүрийн тоглолтыг сонирхуулж, "Хэрэглэгчдийн судалгаа” авч ажиллаа.

Түүнчилэн аймгийн 3,7,11,13,14, 21-р цэцэрлэгүүдээр очиж, хүүхэд багачуудад ном уншиж өгч, үлгэрийн дүрийн тоглолт, хүүхэлдэйн кино үзүүлж, хамтдаа дуулж, бүжиглэх зэрэг олон хөгжөөнт үйл ажиллагаануудыг амжилттай зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд нийт 850 гаруй хүүхэд багачууд хамрагдав.

“Дэлхийн номын өдөр-2020”

- НҮБ-ын Соёл урлагын хорооноос жил бүрийн дөрөвдүгээр сарын 23-ныг **“Дэлхийн номын өдөр”** болгохоор 1995 онд албан ёсоор зарласан билээ. Энэ жил шинэ төрлийн короновирусын халдвар /Covid-19/ -аас урьдчилан сэргийлэх зорилгоор “Дэлхийн номын өдөр-”ийг цахим орчинд тэмдэглэн өнгөрүүлэв. Үүнд:
- Чөлөөт уншлагын танхимаас “ХОВОРДСОН НОМ” сэдэвт үзэсгэлэн гаргаж, уншлагын танхимд шинээр ирсэн “БАБАЛАР СӨЗІ” 100 боть номыг уншигчдад цахим хуудасаар танилцуулан ажиллав.
-





Хүүхдийн нэгдүгээр уншлагын танхимын номын санч Х.Жанна бяцхан уншигчдад зориулан “Ёгт үлгэрүүд” номноос “Ховдог хулгана” үлгэрийг уншиж өгч сонирхуулав.
- Номын санд хадгалагдаж байгаа орон нутгаас хэвлэгдэн гарч байсан “Өркендеу” сонингийн 1955 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн №35 дугаарыг сурталчилав.
- Гэрээр ном олгох танхимаас дэлхийн алдарт зохиолч Александр Дюма-гий намтар уран бүтээлийг “Зохиолч ба Зохиол” самбарт сурталчилж , пэйж хуудасанд байрлуулав.

- Мөн гэрээр ном олгох танхимд уншигчдын дунд хамгийн эрэлттэй байгаа 90 номыг уншигчад танилцуулж үзэсгэлэн гаргав.

- Дэлхийн номын өдрөөр "ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ Д.НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН"-ээр гэрээр ном идэвхтэй уншсан боловсролын салбарт 30 дахь жилдээ ажиллаж байгаа, 5 дугаар бүрэн дунд сургуулийн бага ангийн багш Дөлденбайн Нургүл, Ж.Аргынбайн нэрэмжит 4 дүгээр бүрэн дунд сургуулийн 2 "А" ангийн сурагч Ержаны Айман нар тодорлоо.

- Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, үндэсний хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах зорилгоор **" Үндэсний бичиг үсгийн баяр-2020"** арга хэмжээг цахим орчинд тэмдэглэв.

Үүнд:

Өнгөрсөн одоо ирээдүйд 3 цагийн алтан бичвэр дээр түүхийн түүчээ оюун санааны тусгаар тогтнол оршин байхын тунхаг сүлд болсон үндэсний бичиг үсэг мину МОНГОЛ БИЧИГ, сод гайхамшигт СОЁМБО БИЧИГ, ДӨРВӨЛЖИН БИЧИГ, ТОД БИЧИГ, ВАГИНДРА БИЧИГ-ийн тухай товч танилцуулга хийж сурталчилав.



Эрин зууны түүхийг өртөөлсөн Монголчуудын эв нэгдэл, ур ухааны бэлгэдэл ГЭСЭР, ЖАНГАР, МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО, АЛТАН ТОВЧ, ЭРДЭНИЙН ЭРХ, ГАНЖУУР, ДАНЖУУР г.м нийт 60 гаруй номыг цахим орчинд үзэсгэлэн гаргалаа

.



Хүүхдийн баяр

Цар тахлын үед Хүүхдийн баярыг тохиолдуулан хүүхэд багачуудад зориулж “ Арван өдөр арван үлгэр” сэдэвээр монгол казак хэл дээр 10ш үлгэрийг 10 өдөр дараалан Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн пэйж хуудасанд байршуулан сурталчилав. Уг үлгэр 500 Like, 1000 share нийт 3000 дээш хүүхэд багачууд үзэж сонирхосон болно.

Номын баяр -2020

“Номын баяр” –ын арга хэмжээг жил бүр уламжлал болгон   "2012 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158 тоот зарлигийн хэрэгжилтийг хангах, хүүхэд багачууд, ард иргэдийг номтой нөхөрлөхөд уриалах зорилгоор Хязгаар үгүй – НОМ-сэтгэлгээний эрх чөлөө уриан дор 9-р сарын 18- 19 ний өдрүүдэд зохион байгуулав.

Номын баярын нээлтийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын соёл хариуцсан мэргэжилтэн Б.Сагым , Б.Ахтаны нэрэмжит аймгийн төв номын сангийн захирал Д.Алтангүл, Хурманханы нэрэмжит ХДТ-ын дарга Асылбек, ШШГГ-ын дарга Н.Батэрдэнэ, ахмад номын санч Т.Катя нар оролцож хүүхэд, залуучууд болон уншигч нарт баярын мэндчилгээ дэвшүүлэв.

Номын баярын хүрээнд номын худалдаа эрхлэгчид, гэрийн номын сантай иргэд, ном солилцоо, шинэ номын үзэсгэлэн, Өлгий сумын сургуулиудын тайлант үзэсгэлэн, төв номын сангийн номын санчдын “Ваавгай ба туулай” үлгэрийн дүрийн тоглолт, 7-р БДС-ийн 5 “а” ангийн сурагчдын “Хан мен үш үры” үлгэрийн дүрийн тоглолт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд,

багачуудад номын сангийн уншлагын танхимуудыг танилцуулах, “Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн” шагнал, Өлгий сумын бүх ЕБС-ийн 6-8 ангийн сурагчдын дунд онлайн шүлгийн уралдааны шагнал гардуулах үйл ажиллагаа зохион байгууллаа. Энэхүү номын баярын үйл ажиллагаанд 280 гаруй ард иргэд, хүүхэд багачууд хамрагдав.

- Номын санд байгууллага болон хувь хүмүүсээс ном хандивласан явдалд талархал илэрхийлж “Ном хандивлагчид”-ын уулзалт зохион байгууллаа. Үүнд: Шүүхийн тамгын газрын шүүгч С.Өмирбекийн санаачлагаар "Хууль зүйн булан", Х.Батырбекийн “Шашны булан” түүнчлэн С.Сайран, Т.Султан, Т.Хуан, Р.Асылбек, Б.Өмирбек, Т.Костёр, О.Бахыт нар өөрсдийн номын сан хөмрөгөөс тус тус ном хандивласан билээ.

- Өрх бүр “Гэрийн номын сантай болох” уриа гаргаж, айл өрхүүдийн “Гэрийн номын сан”-г уншигч олонд сурталчлан таниулах, номыг хайрлан дээдлэх, хэрхэн хадгалан хамгаалах зорилгоор энэхүү арга хэмжээг зохион байгуулав. Үүнд: Түүхч О.Хавсатор 2000 гаруй, зохиолч З.Рысбек 800 гаруй,Түүхийн ухааны доктор Б.Өмирбек 1500 гаруй номын сан хөмрөгтэй байна. Эдгээр гэрийн номын сангуудад үнэт ховор ном цөөнгүй байв.

- Түүх сонирхогчиддоо зориулж Монголчуудын үе үеийн түүх, аж амьдрал, зан заншил, ёс суртахуун, ахуйн онцлогийг харуулсан цахилан өнгөрсөн цагийн эртний үнэт түүхийн талаарх номын үзэсгэлэн, “Эх хэл-эх бичиг” сэдэвт номын үзэсгэлэн гаргав.

- Өлгий сумын бүх ЕБС-ийн 6-8 ангийн сурагчдын дунд онлайн шүлгийн уралдаан явуулав. Уралдаанд нийт 20 гаруй сурагчид оролцож, эхний 3 байрыг шагнан урамшуулав. 1-р байрыг Сагсай сумын 8 “а” ангийн сурагч Е.Ахдаулет, 2-р байрыг 3-р ЕБС-ийн 8 “а” ангийн сурагч Д.Хайруулла, 3-р байрыг Дарын цогцолбор сургуулийн 8 “б” ангийн сурагч Б. Ахмарал нар тодорлоо.



- Төв номын сангийн хүүхдийн танхимын номын санчид М.Назигүл, Х.Жаннна, фондоч Д.Өмиргүл нар хүүхэд багачуудад “Ваавгай ба Туулай” үлгэрийн баатрын дүрийн тоглолт хийж сонирхуулав.

- Номын сангаас жил бүр идэвхтэй ном уншиж, их зохиолч Д.Нацагдоржийн тэмдэгтэний болзолыг хангасан нийт 11 ард иргэд, хүүхэд багачуудыг “Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн”-ээр шалгаруулав.

Номын нээлтүүд :

Б.Ахтаны нэрэмжит аймгийн төв номын санд 2020 онд орон нутгийн болон гадаадын зохиогчдын нийт 5 удаа шинэ номын нээлт хийгдэв. Үүнд:

- БНКУлс Б.Даурен “Ұлттық спортшылар”
- Т.Таукей “Театр тарландары”
- Х.Батырбек “Монғолиядағы мешіттер”
- Н.Еженхан “Ханкелді шежіресі”
- Х.Хайсанай “Ардчилсан залуучууд

Уран уншлага:

Казахын ард түмний суут хүмүүн, их соён гэгээрүүлэг, яруу найрагч АбайХунанбайн мэндэлсний 175 жилийн ойн баярыг тохиолдуулан 2 төрлөөр уран уншлагын “ОНЛАЙН УРАЛДААН”-ыг 3 насны ангилалаар зохион явуулав.

Уг уралдаанд аймгийн төв, хөдөө сумууд болон Улаанбаатар хотоос нийт 260 гаруй хүүхэд оролцож, 23 хүүхдийг шагнан урамшуулав. Уг уралдаанд оролцсон хүүхдүүдийг Өлгий сумын ЗДТГ, МУ-ын Гавьяат багш Е.Дөрвөтхан, “Туран Ворлд” ХХК-ны захирал А.Ерболат нар ивээн тэтгэв.

Сургаал үг

Абай Хунанбайн “Сургааль үг”-ийн уран уншлагын уралдааныг дунд болонахлах ангийн сурагчдын дунд зохион явуулсан бөгөөд үүнд нийт 80 хүүхэд оролцож үүнээс 6 хүүхдийг мөнгөн болон үнэ бүхий зүйлээр шагнан урамшуулав.Уг уралдаанд Алтай, Сагсай, Булган, Ногооннур, Баяннуур, Алтанцөгц, Толбо сумуудаас хүүхдүүд идэвхтэй оролцов.

Шүлгийн уран уншлагын уралдаан

“Абайн шүлгүүдийг хэн уран унших вэ?” яруу найргийн уран уншлагын уралдааныг бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион явуулсан ба нийт 200 гаруй хүүхэд оролцож үүнээс 16 хүүхдийг мөнгөн болон үнэ бүхий зүйлээр шагнан урамшуулав.

Байгууллагууд “Номын булан” тай болов

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газрын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн №01/946 тоот хамтран ажиллах хүсэлтийн дагуу аймгийн төв номын сангаас актанд гаргасан хуучин номнуудаас 44 ширхэг 25.276 төгрөгний, хууль зүйн чиглэлийн шинэ ном, сэтгүүлээс 50 ширхэг нийт 94 ширхэг номыг тус байгууллагын номын сан хариуцсан ажилтан Дэслэгч Б.Бат-Эрдэнд хүлээлгэн өгч ажиллав. Ийнхүү төв номын сангийн зүгээс номын булан баяжуулж өгсөн явдал нь ШШГГ-ын хоригдлыг нийгэмшүүлэх, соён гэгээрүүлэх, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн байдал нь тогтворжуулах, цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх ажилд нь хувь нэмэр оруулж чадсан юм.

Бяцхан уншигчдын ном унших сэдлийг төрүүлэх, тав тухай орчинг бий болгох зорилгоор Хүүхдийн уншлагын танхимуудыг тохижуулан танхим бүр мэдээллийн самбартай болов.



НОМЫН САНГИЙН ДЭРГЭДЭХ ДУГУЙЛАН

Амралтын өдрүүдэд сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулагдсан “Мөрөөдөл” уран зургийн, “Домбор хөгжим” болон “Тогыз хумалах” тоглоомын дугуйлан номын сангийн байранд тогтмол явуулж байна.

3.4. Зөөврийн номын сангаар үйлчилгээ үзүүлсэн байдал

- Номын сангийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа алслагдсан, тусгай байгууламжид байгаа иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх, сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг Өлгий сумын ТГ, Цагдаагийн Газар, ШШГА, Нийгмийн даатгал, аймгийн Прокурор, Иргэний Бүртгэлийн Газар, Шүүх, Онцгой Байдал, Татварын Хэлтэс, Цэргийн 240-р анги, Цэргийн 165-р анги, ГХВХБГ, ГЕГ, Байгаль орчин, Тагнуулын Газар, Нэгдсэн эмнэлэгийн дотрын тасаг, Нийгмийн датгал зэрэг 16 байгууллага болон Сагсай, Бугат сумдын ард иргэд, сургууль, цэцэрлэгийн хүүхэд, багачуудад нийт 35 байгууллагад зөөврийн номын сангаар 3650 уншигч болон ирэгсэдэд 4180 ном *уншуулж үйлчилэв.*

Зөөврийн номын сан ажиллуулсан албан байгууллагууд

д/д	Хамтран ажиллах байгууллага	Хэдэн удаа хүргүүлсэн	Хүргүүлсэн номын тоо	Захиалсан номын тоо	Нийт уншсан номын тоо
1	Цагдаагийн газар	2	120	40	**150**
2	ШШГГазар	7	150	60	**250**
3	Нийгмийн даатгал	3	80	30	**110**
4	Байгаль орчин	1	50	20	**70**
5	Газрын харилцаа, хот байгуулалтын газар	2	100	40	**200**
6	Онцгой байдлын газар	2	90	30	**190**
7	Прокурор	2	40	25	**80**
8	Сагсай, Бугат сум	3	540	0	**690**
9	Шүүхийн тамгын газар	5	75	20	**100**
10	Зэвсэгт хүчний 331 р анги	2	40	40	**260**
11	Цэргийн 165-р анги	3	160	50	**310**
12	Барилгын цэргийн 360-р анги	4	210	100	**420**
13	Өлгий сум	2	110	70	**270**
14	Иргэний бүртгэл	1	100	60	**180**
15	Татварын хэлтэс	2	100	50	**200**
16	Нэгдсэн эмнэлгийн дотрын тасаг	2	100	40	**160**
17	Өлгий сумын 3,7,11,13,14, 21–р цэцэрлэгүүдийн “Бэлтгэл”, “Ахлах “Дунд” бүлэгүүдэд	8	240	240	**540**
	Нийт	51	2305	915	**4180**

3.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байдал.

Өлгий сумын 3,4,9-р багийн дарга болон ХХҮГ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа авч, ярьдаг ном, үлгэрийн ном, уран зохиолын номоор зөөврөөр ном уншуулж, номын баярын үеэр номын санг танилцуулан, гарын бэлэг гардуулж, хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.

3.5. “Гадны чөлөөт номын сан”

Гадны номын сан нь монгол, казах номоор бүрдсэн 160 гаруй номтой. Номонд хайртай, номыг шимтэн уншдаг хэн бүхэнд нээлттэй чөлөөт уншлага юм. Гадна чөлөөт номын санд зууны улиралд 210 уншигчдад 340 ном уншуулсан байна.

ДӨРӨВ. ЛАВЛАГАА, НОМ ЗҮЙН АЖИЛ

- Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны мессенжер,бичгээр, утсаар, амаар нийт 860 удаа лавлагаа өгсөн байна.
- Шинээр бүрдүүлсэн ном хэвлэлийг LIB-4U программын цахим каталогт бүртгэн нийт 494 ширхэг карт шинээр бичиж, 400 ширхэг хэвлэн холбогдох каталогуудад байрлуулсан.
- Электрон каталогийн хайлтын компьютерийг ажиллахад бэлтгэх, каталогийн шоголуудыг цэгцлэх ажлыг өдөр бүр хийж гүйцэтгэв.
- “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээ” сэтгүүлийг тогтмол авч лавлагааны фондоо баяжуулан ажиллаж байна.
- Шинэ номын мэдээ, нэрийн жагсаалт бэлтгэж уншигчдад цахимаар болон бэлнээр хүргэв. 400 гаруй хавтасны зургийг сканнердаж номын товч агуулга, бусад мэдээллүүдийг багтаасан 13 ширхэг номзүйн каталогуудыг хэвлүүлэн гаргав

- Тогтмол хэвлэлийн өгүүллийн төрөлжсөн картын санг “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийн 2019-2020 оны, “Зууны мэдээ” сонины 2020 оны бүх дугааруудыг шүүж, 90ш өгүүллээр баяжуулан үйлчилж байна.
- Аймгийн 80 жилийн ойд зориулж гаргасан “Баян-Өлгий аймгийн түүхэн товчоон”, “Үзэсгэлэнт Баян-Өлгий” номноос 150ш картын сан бичиж уншигчдын хүртээл болгов.



ЗУРГАА. МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

- Lib-4U праграммын PC VERION энгийн хувилварыг ашиглан дотоод сүлжээндээ холбогдон WiFi утасгүй интернетийг ашиглан явуулж үйлчилж байна.
- Сумдын соёлын төвийн номын сангуудын цахим программын нэгдсэн тайлангийн мэдээ, нэгдсэн каталогийн мэдээ, нөөц бэлдэх аргачлалын талаар номын санчдад заавар зөвлөгөө өгч, Monbiblio цахим программд оруулсан нэгдсэн тайлан, нэгдсэн каталогийн мэдээ, мэдээллийн сангийн нөөцийг бэлдэж цаг хугацаанд нь БСШУЯ-д хүргүүлж, Вэб сайтын хөгжүүлэх тал дээр анхаарч ажилласан. Мөн Буянт, Бугат, Улаанхус, Цэнгэл, Баяннуур сумуудын компьютеруудыг форматлаж, хэвийн үйл ажиллагаанд оруулсан.
- Номын сангийн бүх уншлагын танхимууд болон каридорд ном алдах эрсдэлээс хамгаалах зорилгоор камержуулалтын хянах дэлгэцийг тогтмол ажиллуулж байна. Камерийн бичлэг хийх төхөөрөмжүүд 7 хоногийн бичлэг хадлагдан ажиллаж байна.
- Иргэдэд үйл ажиллагаагаа цахимаар хүргэх зорилгоор Б.Ахтаны нэрэмжит төв номын цахим хуудасыг тогтмол ажиллуулж 2020 оны байдлаар номын сангийн үйл ажиллагааны талаар нийт 210 удааг мэдээ, мэдээлэл тавьж сурталчилсан.
- Б.Ахтаны нэрэмжит төв номын сан нь Орон нутгийн радио, “Дербес” TV, “Саян” TV, телевизтэй хамтран үйл ажиллагаагаа сурталчлан 14 удаагийн мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж байна.



ДОЛОО. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1. 2020 онд өгөгдсөн аргазүйн зөвлөгөөний бүртгэл хөтөлж, соёлын төвийн номын санч 13, сургуулийн номын санч 16, төв номын сангийн номын санч 5 нийт 34 номын санчдад арга зүйн зөвлөлгөө өгч ажиллав.

- ✓ Уншигч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж, санал асуулгыг нийт 105 оролцогчдоос авч, судалгааны үр дүнг нэгтгэн, цаашид ололт, дутагдлыг судлах, хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг төлөвлөн ажиллаж байна.
- ✓ Соёлын төвийн номын санчдын сумын номын ажлыг дүгнэх аргачлалын дагуу үйл ажиллагааг дүгнэж аймгийн ЗДТГ-д хүргүүлэн, эхний 3 байр эзэлсэн номын санчдыг "Өргөмжлөл" болон номоор шагнан урамшуулав.
- ✓ 2020 онд хөдөө сумын соёлын төвийн номын сан болон сургуулийн номын сангуудад биеэчлэн очиж, зөвлөн туслах, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 13 сумд төв номын сангаас ажлын хэсэг очиж 12 чиглэлд 21 хоног ажиллав. Ногооннур, Цагааннуур сумын соёлын төвийн номын санчдад 10 хоногийн даалгавар өгч, фондын бүх номыг ангилалын дагуу хэрхэн байрлуулахыг зааж, цаашид номын сангийн стандартыг баримталж ажиллахыг зөвлөн ажиллаа. Мөн ажлын хэсэг Цэнгэл, Булган сумын номын сангийн фондын номыг тавиураас нэгбүрчилэн буулгаж, шинээр төрөл анги болон үсэг дараалаар нь байрлуулан өгч ажиллав.

НАЙМ. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

8.1 Номын сангийн хүний нөөцийн өнөөгийн байдал, хангалт

Тус номын санд 3-аас дээш жил ажилласан, мэргэжил шаардсан 9 албан тушаалд одоо ажиллаж байгаа номын санчдын 8 нь буюу 97,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа. 2020 онд уншлагын танхимын 1 номын санч өндөр насны тэтгэвэрт гарч оронд нь "Номын санч-мэдээллийн ажилтан" мэргэжилтэй номын санчыг авч ажиллуулав. 2020 онд Соёлын Яамны "ЖУУХ БИЧИГ" –ээр үйлчилгээний ажилтан Т.Азат, Д.Хуатбек нар шагнагдсан бол Хүүхдийн 1-р танхимын номын санч аймгийн "Шилдэг номын санч"-аар, "Байгууллагын аварга"-аар номын

санч Х.Ермеш нар тус тус тодорч шагнагдав. Одоо ажиллаж байгаа ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

8.2. Байгууллагын дотоод хяналт, үнэлгээг сайжруулах, маркетинг, менежмент, хүний нөөцийн хангамж, ашиглалтыг боловсронгуй болгох.

- Номын сангийн захиргааны зөвлөлийн хурлыг сард 1 удаа, Номын сангийн зөвлөл улиралд 1 удаа, Арга зүйн зөвлөл улиралд нэг удаа хуралдаж, жилийн төлөвлөгөөнд тусгагдсан номын санчдын ур чадварын нэмэгдэл, амралт, гадаад, дотоодын сургалт семинарт хамруулах асуудалд дүн шинжилгээ хийж ажиллаж байна.
- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Аймгийн МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлтээр дунд эрсдэлтэй гарсантай холбоотой тусгай төлөвлөгөө гаргаж, 5 төрлийн дутагдалаас 3 үзүүлэлтийг бүрэн арилгаж ажиллсанаар “бага” эрсдэлтэй гэсэн үнэлгээ авсан.
- МУ-ын БСШУСЯ –ны 2020 оны 1-р сарын 28 ны өдрийн “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” албан тоотын хэрэгжилт, ЗД-ын А/44-р захирамж, А/02 албан даалгавар, МХГ-ын 01/59 дугаар мэдэгдэл, Цагдаагийн газрын 11-р шаардлагыг дагуу тусгай төлөвлөгөө гаргаж, тус тус хэрэгжүүлэн биелэлтийг хүргүүлэн ажиллав.
- Хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа болон байгууллагын ажиллагсадын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээнүүдийг ЗДТГ-ын хүний нөөц хариуцсан мэргэжилтэнд цаг хугацаанд хүргүүлээд байна.
- Ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг стандартын дагуу хөтөлж 46ш ирсэн бичиг, 30ш явуулсан бичиг, Өргөдөл гомдол 20ш, 2018, 2019 оны баримт бичигүүдийг хадагаламжийн нэгж үүсгэн архивлав.
- 2020 онд эд аж ахуй, техник тоног төхөөрөмжийн тооллогыг хийж, нэгтгэл хийж, картыг шинэчлэн ажилтнуудад хүлээлгэн өгсөн.

8.3. Хүний нөөцийг чадавхжуулсан байдал /сургалт, семинар/

- Соёлын Яамнаас зохион байгуулсан Орон нутгийн соёл, урлагийн салбарын удирдах албан тушаалтануудтай хийсэн цахим уулзалтанд идэвхтэй оролцож 3 асуултыг санал болгон оролцлоо.



- Нээлттэй Нийгэм Форумаас зохиогдсон “Шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сургалтад номын сангийн 5 албан хаагч оролцож “Сертификат” гардан авав.
- Ажлын байранд мэргэжил дээшлүүлэх тусгай төлөвлөгөө гаргаж, улирал бүр үндсэн хууль, номын сангийн тухай хууль, соёлын тухай хууль, “Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах аргазүй” сэдэвүүдээр сургалт зохион байгуулан ажиллав.

- Номын санчдын дунд “Номын сангийн анхан шатны бүртгэлүүдийн хөтлөлт” сэдэвт мэтгэлцээнийг 2 баг болгон зохион байгуулж, эхний байр шалгарсан багыг сарын цалингийн 10% -иар урамшуулав
- Залуу номын санчдын мэргэшүүлэх зорилгоор СУИС, Соёлын сургуульд элсүүлж номын сан-мэдээллийн ажилтан мэргэжлээр суралцах бололцоогоор хангаж, дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

Гадаад харилцаа

- Баян-Өлгий аймгийн Б.Ахтаны нэрэмжит номын сангийн захирал Д.Алтангүл БНКУлсын А.С.Пушкины нэрэмжит номын сантай хамтран хорио цээрийн дэглэмийн үед "Онлайн хэлэлцүүлэг" хийж, номын сангийн өнөөгийн байдал, цаашдаа хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов. Хэлэлцүүллэгийн үеэр Өскемен хотын С.Пушкины нэрэмжит хүүхдийн номын сангийн номын санч Х.Алтангадастай монголын зохиолчдын хүүхдийн номыг казак хэл дээр орчуулж, хэвлүүлэн гаргаж өгөх талаар ярилцав.

- Номын сангийн захирал Казахстан улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ж.Адилбаевтай уулзалт хийв. Тус уулзалтаар цаашид онцгой нөхцөл байдал дууссаны дараа бүхий л чиглэлд хамтран ажиллана гэдгээ илэрхийлэн, бяцхан уншигчдад 60ш үлгэрийн ярьдаг ном, зохиолын 20ш номыг тус тус хандивлав.

➢ БНКУлсын Үндэсний номын сантай "Онлайн уулзалт" хийж, номын сангийн арга зүйч болон аймгийн соёл хариуцсан мэргэжилтэн нар оролцож 2 талын номын сангийн үйл ажиллагаа туршлагын талаар мэдээлэл солилцов.

ЕС. ТӨСӨВ. САНХҮҮГИЙН АСУУДАЛ

- 2020 оны батлагдсан төсвийг сар бүрийн хуваарийн дагуу үр ашигтай зарцуулсан. Шилэн дансны хуулийн заалтуудыг мөрдөж санхүүгийн тайлан, мэдээ, балансыг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгсөн.
- Шилэн дансыг сар бүр цахимаар шивэлт хийн хэвлэж гарган олонд харагдах байдлаар мэдээллийн самбарт байршуулсан.

Төсөв санхүүгийн талаар:

2020онд 257.621.600төсөв батлагдаж үүнээс:

- Цалин-145.706.500
- НДШ-19.596.600
- Бичиг хэрэг-3.252.300
- Тээвэр /шатахуун/-5.198.500
- Ном хэвлэл-3.894.400
- Нормын хувцас-387.100
- Төвлөрүүлэн шилжүүлэв-3.968.700

АРАВ. БУСАД.

11.1. COVID-19 ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН

12. АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

МУ-ын БСШУСЯ-ны 2020 оны 1-р сарын 28 ны өдрийн “Халдварт өвчнөөсурьдчилан сэргийлэхтухай”албан тоотын хэрэгжилт, ЗД-ын А/44-р захирамж, А/02 албан даалгавар, МХГ-ын 01/59 дугаар мэдэгдэл, Цагдаагийн газрын 11-р шаардлагын дагуу тусгай төлөвлөгөө гаргаж, тус тус хэрэгжүүлэн биелэлтийг хүргүүлэн ажиллав.

- Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх,халдвар хамгааллыг нэмэгдүүлэх зорилгоорномынсангийн уншлагын танхимууд,үндсэн фонд, коридор болонажилтнуудынөрөө асалгаанд бүтэнжилд 2 удаа ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэлээ.

- Коронавирусынхалдвараас урьдчилан сэргийлэхзорилгоор зөөврөөр болон гэрээр олгосон номнуудыг ариутгаж, үүдэнд үйлчлүүлэгчдийн биеийн халууныг хэмжиж, бүртгэж оруулж байна. Хүүхэд багачуудад ном олгохдоо зөвхөн эцэг эх, асран хамгаалагчаар нь дамжуулан ном олгож байна.





Аймгийн ЗДТГ, Онцгой байдлын газарт өөрсдийн гараар оёсон дахин хэрэглэх боломжтой даавуун материалаар хийсэн 330 ширхэг амны хаалт хандивлав.

Цар тахлын үед үүрэг гүйцэтгэж байгаа цагдаа, эмч, Зооноз өвчин судлал, Онцгой байдал, Аймгийн шуурхай штабын албан хаагчдад халуун хоол, аарц, чацаргана, хүргэж сэтгэлийн дэм өгч ажиллав.

Баян-Өлгий аймгийн ИТХ, ЗДТГ, Өлгий сумын ИТХ, ЗДТГ-аас зохион байгуулсан **“Хоггүй Өлгий”** цэвэрлэгээний өдөр болон бүх нийтийн мод тарих ажилд номын сангийн ажилчид хувиарт газарт ажиллав.

Дүгнэлт

2020 онд хэдийгээр цар тахал дэгдсэн, хөл хорио тогтож, аж ахуйн нэгж, албан байгууллагууд нэг бус удаа үүд хаалгаа барьсан хүнд хэцүү жил болж өнгөрсөн ч номын сангийн хамт олон түүхт ойн баяр, Дэлхийн номын өдөр, Бичиг үсэгийн баяр, Хүүхдийн баяр зэрэг СОНА-ыг цахим орчинд тэмдэглэн, “Соёлын цаг” нөлөөллийн аян, Үндэсний номын баярыг өргөн хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж хүүхэд багачууд, ард иргэдийг өргөнөөр хамруулж чадсан.

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

1.Номын сангийн үйлчилгээ

1.1. Лавлагаа арга зүй, ном зүйн ажил.

Лавлагаа арга зүйн танхим, Баянхонгор фонд, бусад уншлагын танхимуудад түр шилжүүлгээр нийт 1671 уншигчдад үйлчилж, электрон каталогоос хайлт хийх заавар зөвлөгөөг 4195 уншигчдад өгч ажилласан. Цахим программын бүртгэл ашиглан 310 уншигчдад амаар, 38 уншигчдад утсаар, лавлагаа өгч, 101 уншигчдад цаасан каталог ашиглах зөвлөгөө өгөв. Уншигчдаас хэрэгцээтэй байгаа номуудыг татгалзлаар бүртгэн, шинэ номын захиалгад нийт 21 номыг бүртгүүлснээс 12 номыг худалдан авсан байна.

Тогтмол хэвлэлийн Zotero программд "Өнөөгийн Баянхонгор" сонины 2008-2020 оны 890 мэдээллийг шивж, Үндэсний номын сангийн тогтмол хэвлэлийн үндэсний нэгдсэн мэдээллийн санд илгээсэн.

Орон нутгийн картын сан: С.Мөнхтогтохын уран бүтээлээр картын санг баяжуулсан.

Орон нутгийн ном зүйн бүртгэл хийх: Хүүхдийн зохиолч Нацагдоржийн нэрэмжит шагналт Д.Содномдоржийн намтар уран бүтээлээр, "Өнөөгийн Баянхонгор" тогтмол хэвлэлийн 2020 оны ном зүй гаргаж сурталчлав.

Шинээр ирсэн номын картыг каталогт байрлуулах, редакц хийх: Орон нутгийн сонин сэтгүүлийн 160 ширхэг каталогийн картад, төрөл анги, үсэг дараалын 120 ширхэг картад тус тус редакц хийсэн.

Арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд:

Арга зүйн зөвлөгөөг батлагдсан удирдамжийн дагуу аймгийн төвийн 9 сургууль болон Баян-Овоо, Өлзийт, Эрдэнэцогт, Жинст, Богд, Бөмбөгөр сумдад өгч, үр дүнг тооцон, зөвлөн тусалж ажиллалаа. Шүүхийн номын санд арга зүйн зөвлөгөө өгч 1780 ширхэг номд техник ажиллагаа хийх зөвлөгөө өгсөн. Аймгийн төвийн номын сангуудад "Номын санд хөтлөгдөх маягт, бүртгэл хөтлөх аргачлал" сэдэвт сургалтын гарын авлагыг DVD дээр 8 хувь бэлтгэн тараасан. Бусад сум, сургуулийн номын сангуудад арга зүйн зөвлөгөөг цахимаар өгч ажилласан.

Үндэсний номын сангийн ном зүйн ажил үйлчилгээ хэрхэн явагдаж байгаа талаарх сургалтыг цахимаар 46 номын санчдад хүргэсэн.

Уншигчдад зориулан гаргасан гарын авлага: Нийт танхимуудаас "Амьдралын мөн чанар", "Ашиг сонирхлын тухай үндсэн ойлголт", "Хүүхэддээ хайртай хүн бүрт", "Сэтгэлгээний өөрчлөлтийн удирдлага", "Чулуун тоглоом", "12 жилээр цахим үзүүлэлт" гэх мэт 10 ширхэг гарын авлагыг гаргаж уншигчдад сурталчилсан.

1.2. Сан хөмрөгийн үйлчилгээ: Фондоос цахим үйлчилгээгээр 595 номыг уншлагын танхимууд, гэрээр ном олгох тасгаар олгож, өдөр тутмын хэвлэлээр 42 хүнд үйлчиллээ.

***Фонд баяжилт**:* Худалдаагаар 222 нэр төрлийн 247 ширхэг 4.005.200 төгрөгийн номоор, хандив бэлгээр 90 нэр төрлийн 153 ширхэг 2.041.940 төгрөгийн номоор, нийт 312 нэр төрлийн 400 ширхэг 6.047.140 төгрөгийн номоор фондыг баяжуулж, стандартын дагуу техник ажиллагаанд оруулж, уншигчдад үйлчлэн, өдөр тутмын хэвлэл "Зууны мэдээ", "Өдрийн сонин", "Хүмүүн бичиг", "Утга зохиол урлаг", "Өнөөгийн Баянхонгор" сонин, "Улирал ба зохиолч", "Номын санч", Like news, "Төрийн мэдээлэл" сэтгүүл гэх мэт 9нэр төрлийн хэвлэлийг жилд 391.800 төгрөгөөр захиалан авч уншигчдад үйлчиллээ. Хэвлэлүүдийг 31 нэгж болгон үдэж сонин сэтгүүлийн дансанд бүртгэж, сан хөмрөгт байрлуулав.

Урагдаж гэмтсэн **287** номыг сэргээн засварлан, бүртгэл хөтлөн, фонд эргэлтийн судалгааг улирал бүр гаргав.

Соёлын баримтат өвийн талаар: "Соёлын баримтат өвийг хадгалж хамгаалах" сэдвээр гарын авлага бэлтгэн гаргасан. Бүртгэл мэдээллийн санд нийт 67 ном бүртгэлтэй байгаа цаашид баяжуулна. Үнэт ховор 10 номыг стандартын дагуу сэргээн засварлаж, сан хөмрөгийн ариутгал 2 удаа хийсэн.

Номын сан хоорондын ном солилцоо: Баян-Өндөр, Заг, Баянлиг, Жаргалант, Эрдэнэцогт сум болон Номгон сургуулийн номын сантай ном солилцооны гэрээ байгуулж, 270 номоор солилцоо хийлээ.

Нүүдлийн номын сангийн үйлчилгээг Баян-Өндөр сумд 1 удаа 35 номоор, Баянлиг сумд 1 удаа 60 номоор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 9 удаа 242 номоор, Политехник коллежид 1 удаа 5 номоор, Баян-Ойт сургуульд 2 удаа 20 номоор, Номгон ахлах сургуульд 1 удаа 24 номоор тус тус нүүдлийн үйлчилгээг хүргэлээ.

Номын үзэсгэлэн: Шинэ номын үзэсгэлэнг 9 удаа 616 ном, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 14 удаа 560 номоор гаргаж, уншигчдад сурталчилсан.

1.3. Уншлага үйлчилгээ: Байнгын 1613 уншигчдад, 3996 ирцэд, 7218 ном олгож үйлчилсэн.

1.4. Сургалт: Номын сангийн Lib4u программыг орон нутгийн номын сангуудад нэвтрүүлэх ажлыг шинээр санаачлан, сургалтыг Волвес ХХК-тай хамтран зохион байгуулж, нийт 20 номын санчийг хамрууллаа. Сургалтын үр дүнд 19 сумын номын санчид сан хөмрөгийн номоо электрон каталогт оруулж, бар код уншигчийг номонд наан, формуляр, цаасан каталогийг шинэчлэн гаргах ажил 80 хувьтай хийгдэж байна.

"Соёлын ажилтан" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд 9 дүгээр сард АЗДТГ, Соёлын яам, Боловсрол соёл урлагийн газраас хамтран аймгийн "Соёлын салбарын уран бүтээлчид, соёлын ажилтнуудыг чадавхжуулах нь" сургалтыг хамтран зохион байгуулж, мэргэжлийн ажилтнууд бүгд хамрагдсан.

“Mongolian library update” сэдэвт номын санч мэдээллийн ажилтнуудын улсын VII зөвлөгөөн Улаанбаатар хотод 10 дугаар сард зохион байгуулагдаж, захирал Б.Түвшинчимэг, номын санч Б.Бүжидмаа нар оролцлоо.

Боловсрол соёл урлагийн газартай хамтран ЕБС-ийн номын санчдад мэргэжил дээшлүүлэх сургалтыг 11 дүгээр сард Бөмбөгөр сумд зохион байгуулж, нийт 23 номын санч хамрагдсан.

1.5.Соёл олон нийтийн ажил:

“Монгол ёс заншил” танин мэдэхүйн тэмцээнийг албан хаагчдын дунд Монголын уламжлалт тоглоом наадгай, зүйр цэцэн үг, хоол хүнс бэлтгэх зэрэг асуулт хариулт, оролцооны байдлаар зохион явууллаа. Түрүүлсэн эхний 3 багийг шалгаруулж дурсгалын зүйл, өргөмжлөл хадгалуулав.

Монгол цэргийн түүхт 99 жилийн ойн хүрээнд "Аавдаа хэлэх чин сэтгэлийн үг" захидлын уралдааныг 7 дахь жилдээ зохион явууллаа. Захидлын уралдааныг Өлзийт сумын уугуул,яруу найрагч, МУСТА Цэрэнпил агсны 90 насны ойтой уялдуулан зохион явуулж, түүний үр хүүхэд ивээн тэтгэж хамтран ажилласан. Захидлуудаа цахимаар хүлээн авч, шалгаруулав. Тэргүүн байрт Бууцагаан сумын харъяа МУБИС-ийн оюутан Гүрсэдийн Отгонцэцэг, Дэд байрт Номгон ахлах сургуулийн 12'3' бүлгийн сурагч Болормаа, Гутгаар байрт Бөмбөгөр сумын иргэн Ууганчимэг нар тус бүр шалгарсан. Шагналын санд 150.000 төгрөг зарцуулсан.

Хүүхдийн номын баярт зориулан уншигч хүүхдүүдийн дунд Дани улсын их зохиолч Х.К.Андерсены зохиол бүтээлээс сэдэвлэсэн "Гар зургийн уралдаан”-ыг зарласан. Уралдаанд нийт 11 сурагчийн бүтээл ирснээс Тэргүүн байрыг Соого сейкео сургуулийн 6а ангийн сурагч Гончигсумлаа, дэд байрыг Соого сейкео сургуулийн 6а ангийн сурагч Элбэгсайхан, Гутгаар байрыг Соого сейкео сургуулийн 5а ангийн сурагч Элбэгдорж нар эзэлж өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнууллаа.

“Дэлхийн номын баяр”-ын өдрөөр “Сэтгэлийн нартай Монгол” телевизийн нэвтрүүлгийг Хонгор телевизтэй хамтран бэлтгэж үзэгчдэд хүргэсэн. Телевизийн нэвтрүүлэгт Монголын Зохиолчдын холбооны гишүүн, яруу найрагч, ардын боловсролын тэргүүний ажилтан Д.Рагчаа, ахмад санхүүч н.Амгалан, ном зүйч Б.Должин нар оролцож, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Ш.Дулмаагийн намтар, уран бүтээл, Хонгор нутгийн яруу найрагч Д.Рагчаагийн шинэ уран бүтээл болон гэрийн номын сан, Монголын зохиолчдын холбооны гишүүн, яруу найрагч, ган үзэгтэн шагналт, хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан Д.Батдамбын гэрийн номын сангаас үзэгчдэд танилцуулж хүргэсэн. Нэвтрүүлгийг интернетээр 101 хүн үзсэн байна.

Дэлхийн яруу найргийн өдөрлөгийг интернет орчинд цахим хэлбэрээр зохион явуулсан. Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, Ардын уран зохиолч П.Бадарч,

Баацагаан сумын харьяат яруу найрагч П.Пүрэвсүрэн, Ардын уран зохиолч Т.Галсан, Галуут сумын харьяат, хэл зүйч Я.Цэвэл, Төрийн шагналт, Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав нарын намтар, уран бүтээлийн талаар бэлтгэн хүргэсэн. Мөн Баянхонгор аймгийн үзэсгэлэнт газруудыг цахимаар сурталчлан уншигчдад хүргэв.

"Номын баяр-2020" хүрээнд Азхур ХХК-тай хамтран "Номын 72%-ийн хямдрал"-тай худалдааг зохион байгууллаа. Энэхүү өдрийг угтаж орон нутгийн 19 сумын номын сангуудын дунд номыг шимтэн уншдаг хүн бүрийн оюуны хэрэгцээг хангах, номын ашиг тусыг олон нийтэд сурталчлан таниулах, нийгмийг соён гэгээрүүлэх, аймаг орон нутгийн хэмжээнд хувийн номын сантай айл өрхийн тоог нэмэгдүүлэх, гэр бүлээрээ уншигч болох, мэдээллийг хамгийн их олон нийтэд түгээсэн, олон номын худалдан авалт хийсэн номын санчийг шалгаруулах зорилгоор "Оюунлаг сум-Оюунлаг номын санч" шалгаруулах болзолт уралдааныг 8 сарын 28 –аас 9 сарын 06-ны хооронд зарласан. Уралдаанд 14 сумын номын сан идэвхтэй оролцож, Баян-Овоо сум 2.715.700 төгрөгийн 502 ширхэг номын худалдан авалт хийснээр тэргүүн байранд шалгарч Өргөмжлөл, 500.000 төгрөгийн ном худалдан авах эрхээр шагнагдлаа.

"Соёлын цаг" соён гэгээрүүлэх нөлөөллийн аяны нээлтийг Баганат талбайд зохион байгуулж, соёл урлагийн салбарын ажилтан, уран бүтээлчид оролцлоо. Тус аяны хүрээнд "Зохиолч уншигчдын уулзалт"-ыг аймгийн Зохиолчдын холбоотой хамтран явуулж, Төрийн соёрхолт Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч С.Оюун, Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч яруу найрагч Б.Хүрэлбаатар, "Болор цом"-ын эзэн, яруу найрагч, Өдрийн сонины албаны дарга Н.Гантулга, Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, Бодлого зохицуулалтын албаны дарга, яруу найрагч Н.Пүрэв, Монголын Зохиолчдын эвлэлийн болон Утга зохиолын төлөө шагналт, яруу найрагч Д.Доржготов нар оролцож уншигч иргэд, хүүхэд багачуудад уран бүтээлийн дээжээс өргөлөө. Уулзалтад 260 гаруй уншигч оролцов.

"Соёлын цаг" нөлөөллийн аяны үйл ажиллагааг соёлын байгууллагууд хамтран аймгийн төвийн 1-10 дугаар багуудын иргэд болон Баян-Овоо, Өлзийт, Эрдэнэцогт, Богд, Жинст, Бөмбөгөр сумын ард иргэдэд түгээж ажилласан. Манай байгууллагын зүгээс шинэ номын үзэсгэлэн гаргаж танилцуулах, "Алтан хонх", "АХА", "50 номын хожил" танин мэдэхүйн асуулт хариултын уралдааныг багийн иргэд, хүүхэд залууст хөтөлбөр, хуваарийн дагуу хүргэж ажилласан. "Алтан хонх" 8 удаа, АХА тэмцээнийг 11удаа, "50 номын хожил" уралдааныг 38 удаа тус тус зохион явуулж, нийт 1344 хүн хамрагдсан. Соёлын салбарын хэрэглэгчдийн судалгааг 111 хүнээс авсан.

"Өсвөрийн яруу найрагч-бид" яруу найргийн уралдааныг ахлах болон дунд ангийн сурагчдын дунд 7 дахь жилдээ зохион байгуулж, 24 залуу найрагч 3 шаттайгаар оролцлоо.Уралдааны шүүгчээр Баянхонгор аймгийн Зохиолчдын холбооны тэргүүн, Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүн Б.Жавзандулам, Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн, яруу найрагч С.Мөнхтогтох, Нийтийн номын сангийн захирал Б.Түвшинчимэг нар ажиллав.

Ахлах ангийн сурагчдаас тэргүүн байрт Баацагаан сум 11 ангийн сурагч Б.Лувсанпэрэнлэй, Дэд байрт Политехник коллежийн Ардын хөгжим-1 ангийн оюутан Ч.Чинболд, Гутгаар байрт Номгон ахлах сургуулийн 11 дүгээр ангийн сурагч А.Жадамба нар; дунд ангийн сурагчдын төрөлд Тэргүүн байрт Эрдэнэмандал ахлах сургуулийн 9В ангийн сурагч А.Баясгалан, дэд байрт Заг сумын 9 дүгээр ангийн сурагч Б.Оюунгэрэл, гутгаар байрт Баян-Өндөр сумын 8А ангийн сурагч Г.Дашчойжил нар тус тус шалгарч Өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнагдлаа. Заг, Баян-Өндөр, Бөмбөгөр сумын 3 сурагч ирэх жилийн яруу найргийн уралдаанд оролцох эрхийн бичгээр шагнуулав. Уралдааны төсөвт нийт 201800 төгрөг зарцуулсан.

Дээрх 12 төрлийн соёл олон нийтийн ажлыг давтагдсан тоогоор 82 удаа зохион байгуулж, 1819 хүн хамрагджээ. Төсөвт 567600 төгрөг зарцуулсан байна.

2.Мэдээллийн үйлчилгээ: Байгууллагын 14 компьютерын дотоод сүлжээ, LIB4U программийн хэвийн ажиллагааг хангаж, вирустсэн компьютерийг форматалж, цахим үйлчилгээ явуулан, facebook хуудсыг соёл олон нийтийн ажил, сургалт, Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэх анхааруулга, бусад мэдээ мэдээллээр тухай бүр баяжуулж, иргэдэд мэдээлж ажиллаа.

Байгууллагын үйл ажиллагаа, соёл олон нийтийн ажлын урилга, хөтөлбөр, өргөмжлөл, талархал зэрэг хэвлэлийн үйлчилгээг хийж байна.

Орон нутгийн номын сангийн цахим программын ашиглалтыг сайжруулан, хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

3.Удирдлагын ажил: Төрөөс баримтлах соёлын бодлого Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, номын сангийн стандарт, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаа.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажилчдын улирлын төлөвлөгөө, түүний биелэлтийг хянаж, хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж ажиллаа. Байгууллагын хамт олны хурал 9 удаа, захиргааны зөвлөл 2 удаа, баримт бичиг нягтлан шалгах комиссын хурал 2 удаа хуралдав.

Соёлын сайд С.Чулуун манай аймагт 10 сарын 13-нд айлчилж соёл, урлагийн байгууллагын ажилтнуудтай уулзаж, санал бодлоо солилцов.

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч, байгууллагын захиргаанаас сар шинийн баяраар байгууллагын 6 ахмадад хүндэтгэл үзүүлж байгууллагын захиргаанаас 180000 төгрөг, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр ажилчдын хүүхдүүдэд бэлэг бэлтгэн өгөхөд 180.000 төгрөг, ажилчдыг дархлаа дэмжих бүтээгдэхүүн амин дэмээр хангахад 85600 төгрөг, нийтийн уншлагын номын санч, гэрээр ном олгох танхимын номын санч нарт хамтын сангаас тус бүр 50.000 төгрөгийн тусламж үзүүлсэн гэх мэт нийт 545.600 төгрөг зарцуулсан байна.

Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, Монгол орны үзэсгэлэнт газруудаар аялахад зориулан байгууллагын төсөв болон хамт олны дундын сангаас 500.000 төгрөг зарцуулан Өвөрхангай аймгийн “Хүйсийн 8 нуур”, Баянхонгор аймгийн Их Богд уулын Оюу, Номин нуурын аялалд хамт олноороо аялсан.

Covid-19 цар тахлын үед ариутгал халдваргүйжүүлэлт хийх, цэвэрлэгээний материал авах, ажилчдын эрүүл мэндийг хамгаалахад гар ариутгагч, нэг удаагийн бээлий, амны хаалт авах зэрэгт 210000 төгрөг зарцууллаа.

Номын санч Ц.Сарантуяад ээлжийн амралтын хугацаанд төрсөн нутаг Увс аймаг явж амарсаны замын зардалд 120.000 төгрөг, мэдээллийн ажилтан М.Дондовжамцын ар гэрт 100.000 төгрөгийн тусламж үзүүлсэн.

Гэр хороололд амьдардаг 5 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлж нийт 450.000 төгрөг зарцууллаа.

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажил: Ирсэн бичиг 93, явсан бичиг 51, тушаал 26, түр олгосон 8 баримт байна. i-office программыг үйл ажиллагаандаа ашиглаж, байгууллага хоорнд харилцаж байна. Байгууллагад хандаж ирсэн 2 өргөдлийг бүртгэн удирдлагад танилцуулж хугацаанд нь шийдвэрлэсэн. Өргөдөл гомдлын жилийн мэдээг Боловсрол соёл урлагийн газарт хүргэлээ.

Нийт ажилтнуудаас 2019 оны баримт бичгүүдийг байгууллагын архивт бүртгэлээр хүлээн авч, баримтын бүртгэл гаргав.

Ажилчдаас ирүүлсэн санал болон өмнөх оны хөтлөх хэргийн жагсаалт, байгууллагын жилийн төлөвлөгөөний дагуу 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан хэлэлцлээ.

“Цахим архив-Баянхонгор” хөтөлбөрийн хүрээнд байгууллагын байнга хадгалах 2017 оны 50 хадгаламжийн нэгжийг иж бүрэн нягтлан шалгаж, цахим хэлбэрт оруулан, өгөгдлүүдийг шивж, 4 хувь дансны хамт Төрийн архивын тасагт хугацаанд нь шилжүүллээ. Цахим мэдээллийг 3 хувь DVD-д хуулж, 1 хувийг байгууллагад авч хадгалав.

Соёл урлагийн СУ мэдээг шинэ маягтаар гаргаж Боловсрол соёл урлагийн газарт хүргэж, бусад ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/717 дугаар тоот захирамж, байгууллагын захирлын 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/19 дүгээр тушаалын дагуу 2020 оны 11 дүгээр сарын 10-11-ний өдөр тэмдэг, баталгааны тэмдэг, албан хэвлэмэл хуудасны тооллогыг ажлын хэсгийн ахлагч Я.Гэрэлтуяа, гишүүн О.Наранцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Тэмдэг, дардасны тооллогыг маягт загварыг ашиглан байгууллагад ашиглаж буй 7 төрлийн тэмдэг, дардсуудыг тод дарж, чанарын үнэлгээ өгч тооллоо. Ажилтнууд хариуцсан

тэмдэг, дардсыг дүрэм журмын дагуу хэрэглэдэг, ашиглалт сайн, хадгалалт хамгаалалт сайн, цоожтой сав шүүгээнд хадгалж, хэрэглэж байна.

Хэвлэмэл хуудасны тооллогыг байгууллагад ашиглаж буй хэвлэмэл хуудасны 4 төрөл бүрээр, 2019-2020 оныг хамруулан одоо ашиглаж байгаа болон хүчингүй болсон хэвлэмэл хуудсыг нүд үзэн тоолж шалгалаа. 2019-2020 онд захиалан авсан хэвлэмэл хуудасны төлбөрийг байгууллагаас шилжүүлсэн бөгөөд төлбөрийн өргүй байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчилсэн хуулийн талаарх 10 сарын 19-нд
Архивын ерөнхий газраас явуулсан онлайн сургалтад оролцов.
Хуулийг ажилтан албан хаагчдад танилцуулсан.

5.Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын хүрээнд: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журмыг мөрдөн ажиллаж байна. Оффисийн ажилтны ажлын байранд эрсдэлийн үнэлгээг хийсэн. Ажлын байранд covid-19 халдвараас урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах тухай Хөдөлмөр, нийгмийг хамгааллын сайдын 2020 оны А/80 дугаар тушаалаар батлагдсан зөвлөмжийг нийт ажилтнуудад танилцуулан, дагаж мөрдөж байна.

Уншигч үйлчлүүлэгчдэд амны хаалт зүүх, бээлий өмсөх, гэрээр авч уншсан номоо цэвэрхэн, гамтай унших зэрэг заавар зөвлөгөөг тогтмол өгч, анхааруулга, санамжийг коридор, танхимууд, мэдээллийн самбарт байршуулсан. Гэрээр гарсан номуудыг буцаан авах үед ариутгалын уусмалаар арчиж, тусгай тавиурт байрлуулан 3-5 хоногийн дараагаар уншигчдад олгож байна. Ном авч буй уншигчтай 2 метрийн зайнаас харьцах, олон уншигч цуглахгүй байх зэрэг зохицуулалтыг хийсэн. Ажилтнууд гараа тогтмол савандаж угааж, амны хаалт зүүж, бээлий өмсөж хэвшсэн.

Нийт ажилтнуудад халдварт өвчний үед өөрсдийгөө хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлж ажиллах талаар Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнээс мэдээлэл авч, гарын авлага санамжийг өрөө танхимуудад байрлуулан ажилласан.

6.Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Гамшгаас хамгаалах орон тооны бус зөвлөлийн ажилтнууд 5 зорилт бүхий төлөвлөгөө гаргаж, захирлаар батлуулан, хамт олонд танилцуулан ажиллаж байна.

7.Авлигатай тэмцэх ажлын хүрээнд: Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж батлуулсан. Албан хаагчдын хариуцсан ажил үүргийн хуваарь болон албан хаагчдын ёс зүйн дүрмийг гаргаж иргэд олон нийтэд нээлттэй ил тод байршуулсан. “Ашиг сонирхлын зөрчилдөөний үндсэн ойлголт” сэдвээр хэрэглэгчдэд зориулсан гарын авлага гаргав. Авлигын тандалтын судалгааг албан хаагчдаас авч, Хууль эрх зүйн хэлтэст нэгтгэн хүргэв.

Авилгатай тэмцэх газраас олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахад зориулан богино хэмжээний видео, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарын утасны

сурталчилгааны шторк, богино долгионы радио, зөвлөгөө, мэдээлэл Авилгын эсрэг хууль сурталчилсан талаар бэлтгэсэн материалуудын дагуу манай байгууллага нь ажилтан албан хаагчид болон уншигч ард иргэд, хүүхэд залуучуудад сурталчилгааны материал тус бүр 25, нийт 150 ширхэг материал тарааж, видео шторкуудыг байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулан сурталчилсан. Мөн Номын сангийн "Мэдээллийн самбар" болон өрөө, танхим, коридорт сурталчилгааны зурагт хуудас, электрон самбараар видео шторкуудыг тогтмол байршуулан ажиллаж байна.

8. Хүүхэд хамгааллын ажлын хүрээнд: Бага насны хүүхэдтэй албан хаагчдыг хүүхдээ харах, асрах боломжоор хангах, цалинтай чөлөө олгох, хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, "Охидоо хамгаалъя" аяны уриалгыг даган хэрэгжүүлэх гэх мэт хүүхдэд чиглэсэн зөвлөмж, ажил арга хэмжээг хамт олондоо сурталчлан таниулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

9.Цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын ажил: Үйлчлэгч, харуулын албан тушаалын тодорхойлолт, цэвэрлэгээний хуваарийн дагуу ажлыг чанартай хийж гүйцэтгэсэн. Гадна орчны цэвэрлэгээ, зүлэг цэцгийн үр суулгаж арчлан ургуулах, цахилгаан, сантехникийн жижиг гэмтлүүдийг засаж, сэлбэн ажиллав.

Ээлж гараатай үед байгууллагын гадна, доторх үүдний хэсгийн шат довжоог цэвэрлэж, ажилчдын цагийг үнэн зөв бүртгэж ажилласан.

"Ажлын хэрэгцээний автомашин ашиглах, хэрэглэх" журмыг мөрдөн ажиллаж, автын үзлэг оношлогоонд хамруулж, автомашины аюулгүй байдлыг хангажажилласан.

Сумын засаг даргын захирамж болон бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн хүрээнд Угалз багийн нутаг дэвсгэр дэх цементэн авто замын зүүн талын ойн зурвас, аймгийн хойд хэсгээрх ногоон зурвас дахь байгууллагын хуваарьт талбайд ойр орчмын хогийг цэвэрлэн, тариалсан 20 ширхэг хайлаас модыг усаллаа. Хамт олноор голын зах болон Самбартай хөтөл орчмын хог хаягдлыг цэвэрлэв.

10.Санхүү, бүртгэлийн ажил:Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэр, Соёлын яам, Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан журам, шийдвэрийг хэрэгжүүлэн, санхүү бүртгэлийн тайланг цаг тухайд нь гаргаж, шилэн данс, төсвийн мэдээллийн самбараар дамжуулж иргэд, уншигчдад санхүүгийн ил тод байдлыг мэдээлж, 2019 оны санхүүгийн аудитын тайлангаар "ИТГЭМЖЛЭЛ" авсан.

Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны баримтын маягтын дагуу 13 нэр төрлийн баримтыг шинэчлэн хөтөлж ажилласан.

Тод сод од ХХК, Д.Амгалан, Бүрд ээж ХХК, Монгол шуудан ХХК, Ник ХХК, Л.Амаржаргал ХХК, Смарт старт ХХК, Интерном ХХК, Б.Болормаа ХХК, Майхан цахир ХХК зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, бараа үйлчилгээ авч байна.

11. Шинэ бүтээлч ажил: Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасагт номын булан байгуулж өгөх ажлыг хамт олноороо санаачлан, эмчлүүлж буй хүүхдүүдэд зориулсан 250 гаруй шинэ ном, 100000 төгрөгийн өртөг бүхий номын тавиур хийж өгч, Хүүхдийн тасагт байрлуулан хүлээлгэж өгсөн.

Уншигчдад зориулж Lib4u программын үүлэн технологийг ашиглан ном хайх хайлтын компьютерт шинээр тавиур хийж коридорт байрлуулсан. Төсөвт 100000 төгрөг зарцуулсан.

"Соёлын цаг" нөлөөллийн арга хэмжээний хүрээнд аймгийн цагдаагийн газрын дэргэдэх "Жаргалтай амьдрал" төвд 200.000 төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг номыг хандивласан.

"Гэр бүлийн номын сан" төслийг Дэлхийн зөн-Баянхонгор олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж эхэлсэн. Хүүхдийг номоор дамжуулан хөгжүүлэх, төлөвшүүлэх, ярих, бичих, зурах чадварыг хөгжүүлэх, оюун ухаан, сэтгэхүй хөгжүүлэх, эцэг эхчүүдийн хүүхдэдээ гаргах цаг завыг нэмэгдүүлэх, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгох зорилготой уг төсөлд аймгийн төвийн 3-11 насны хүүхэдтэй 9 багийн 45 өрх хамрагдаж, Нийтийн номын сангаас зохион явуулж буй төрөл бүрийн сургалт, уралдаан тэмцээнд оролцож, "Номын багц"-уудыг гэрээр авч судалж, хүүхдээ хөгжүүлэхээс гадна эцэг эхчүүд өөрсдөө хөгжих боломжтой болсон. Төслийг Дэлхийн зөн-Баянхонгор олон улсын байгууллагаас дэмжиж 8 сая гаруй төгрөгийн ном, сэтгэхүй хөгжүүлэх тоглоом, номын тавиур, ширээ сандал, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, ая тухтай орчин бүрдүүлж хамтран ажиллаж байна.

"Гэр бүлийн номын сан" төслийн нээлтийг 10 сарын 05-нд Хүүхдийн уншлагын танхимд зохион явуулж, Дэлхийн зөн-Баянхонгор олон улсын байгууллагын хөгжүүлэгч чиглүүлэгч С.Чимгээ, АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн Оюунбаатар, төсөлд хамрагдах өрхүүдийн хүүхэд, эцэг эхчүүдийн төлөөлөл 90 гаруй хүн оролцлоо. Энэ хүрээнд эцэг эхчүүдийн дунд "50 номын хожил", хүүхдүүдийн дунд үндэсний оньсон тоглоом, сэтгэхүй хөгжүүлэх тоглоом эвлүүлэх уралдааныг тус тус явуулсан.

Төслийн хүрээнд "Миний мэдэх шүлэг" шүлгийн уралдааныг 6-8 настай хүүхдүүдийн дунд цахим орчинд зохион байгуулан нийт 35 хүүхэд оролцож, уншсан шүлгийн бичлэгээ "Баянхонгор Нийтийн номын сан" фэйсбүүк хаягаар илгээж, хамгийн олон like, share авсан хүүхдүүдийг шалгарууллаа. Тэргүүн байрт, Соого сейкео сургуулийн 1Б анги Г.Сэржханд /951 like,31569 share/, дэд байрт Баацагаан сум 1Б анги Г.Амин-Эрдэнэ /359like, 19293share/, гутгаар байрт Соого сейкео сургууль 1А анги Ц.Индра /268like, 18538share/ нар тус тус шалгарсан. Шагналын санд 213300 төгрөгийн үнэ бүхий ном, хичээлийн хэрэгсэл зарцуулсан.

Мөн "Миний хайртай зохиолын баатар" цахим зургийн уралдааныг 9-11 насны хүүхдүүдийн дунд зарлаж, 41 хүүхэд зурсан зургаа "Баянхонгор Нийтийн номын сан" фэйсбүүк хаягаар илгээх болон биечлэн авчирч өгч оролцов. Тэргүүн байрт Бууцагаан сумын 4а ангийн сурагч Б.Дүүрэнжаргал, дэд байрт Соого Сейкео сургуулийн 4а ангийн сурагч С.Номин-Эрдэнэ, гутгаар байрт Галуут сумын 6а ангийн сурагч Ц.Маргад, тусгай байрт Соого Сейкео

сургуулийн 4Б ангийн сурагч Ёндонсамбуу, Номундалай сургуулийн 6г ангийн сурагч Г.Сувдансондор нар тус тус шалгарлаа.

12. Төлөвлөгөөнөөс бусад цаг үеийн ажил: Аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх аян зарлах тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/01 дугаар захирамжийн хүрээнд "Ууж биш уншиж нэгдэцгээе!!!" уриатайгаар хамт олноор тус аянд нэгдэж, хуулийг хэрэгжүүлж байна. Хамт олны хурлаар хэлэлцэн архидан согтуурахтай тэмцэх ажлын төлөвлөгөө гаргаж, хариуцах ажилтныг сонгон томилсон. Удирдамжид заасан 6 чиглэлийн дагуу төлөвлөгөө гаргаж, ажилчдын сахилга хариуцлага дээшлэх, ажлын байранд архи согтууруулах ундаа огт хэрэглэхгүй байх, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх, уншигчдад үлгэр дуурайлал болох, үүрэг хариуцлагаа биелүүлэн ажиллах зэрэг олон зүйлүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гадаадад байгаа монголчуудад амны хаалт хандивлах ажилд хамт олноороо оролцож, 50 ширхэг амны хаалтыг бэлтгэн Гэр бүл хүүхэд залуучуудын газарт хүлээлгэн өгөв.

Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор "Сархдаас сална аа хө" соён гэгээрүүлэх нөлөөллийн аян аймгийн хэмжээнд 2020 оны 08 сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 20 хүртэл 2 сарын хугацаанд зохион байгуулагдаж, нээлтийн ажиллагаанд хамт олноор оролцов.

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргаж байгаа Засгийн газар, Улсын онцгой комисс, мэргэжлийн байгууллагын шийдвэрийг хариуцлагатайгаар даган биелүүлж ажилласан. Албан хаагчид 11 дүгээр сарын 19, 23, 27, 12 дугаар сарын 1, 5-нд тус тус нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон
сууц, гудамжны айл өрхүүдийг хянах хяналтын эргүүлд гарч ажилласан.

Захирал Б.Түвшинчимэг 2 дугаар сарын 28-нд 8 дугаар цэг буюу засмал замын эцэст 24 цагаар, 11 дүгээр сарын 24, 28-нд 7 дугаар цэгт 24 цагаар тус тус эргүүлд гарч ажилласан.

Бага насны хүүхэдтэй албан хаагчдыг хүүхдээ харах, асрах боломжоор хангах, цалинтай чөлөө олгох, хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хорогдуулсан цагаар ажиллуулан хүүхдэд чиглэсэн зөвлөмж, ажил арга хэмжээг хамт олондоо сурталчлан таниулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, дэмжих зорилгоор нэг наст малыг малчдаас байгууллагууд нэр дээрээ худалдан авч тэжээх, онд оруулах тухай аймгийн Засаг даргын уриалгыг дэмжиж 50 ширхэг борлон авч, тэжээж байна.

Дүгнэлт:

Дэлхийн улс орнуудад коронавирусийн халдвар гарч, манай улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамнаас ард иргэддээ анхааруулга, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг байнга өгч ажиллаж байна. Энэхүү урьдчилан сэргийлэх зөвлөмжийг байгууллага дээрээ хэрэгжүүлэн албан хаагчдын ажлын цагийг богиносгох зохицуулалт хийх, өрөө, уншлагын танхимуудад ариутгал халдваргүйжүүлэлт хийх, ном ариутгах, ажилчдыг дархлаа дэмжих бүтээгдэхүүн амин дэмээр хангах, уншигчдыг цахимаар ном унших болон танхимаар ном унших, гэрээр ном олгох үйлчилгээг зөвлөмжтэй уялдуулан зохион байгууллаа.

Уншигчдын дунд зохион байгуулах сургалт, дугуйлан, олон нийтийн ажлыг цуцалж, зарим соёлын ажлыг онлайн хэлбэрээр зохион явууллаа. “Ээждээ бичих захидал”захидлын уралдаан, Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан явуулдаг монгол бичгийн сайхан бичигтэн шалгаруулах уралдаан, монгол бичгээр хэн хурдан унших вэ уралдаан, “Үлгэрийн цаг” хүүхдүүдэд зориулсан уншлага, “Ном эрдэм” аяны хүрээнд явагддаг олон нийтийн ажлууд, “Хүрэн морь” яруу найргийн уралдаан зэрэг ажлууд коронавирусын нөхцөл байдалтай холбоотойгоор зохион явагдаагүй.

Коронавирусын цар тахлын өвчлөл ихсэж, нийт иргэд хөл хорионы дэглэм барьж байгаа энэ үед уншигч иргэд, хүүхэд багачуудын дунд интернет ашиглан цахим орчинд явуулж болох зураг, шүлгийн уралдаан, цахим ном уншлага, үлгэр сонсох челленж өрнүүлэх зэрэг соёлын үйлчилгээг явуулж эхлээд байна.

Цаашид уншигчид, хүүхэд багачууд, иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх, соёл олон нийтийн ажлыг цахим орчинд зохион байгуулж байх талаар төлөвлөн ажиллах болно.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН О.БАЙГАЛ
ХЯНАСАН:
ЗАХИРАЛ Б.ТҮВШИНЧИМЭГ

БУЛГАН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ

Уншигч: 1460 үүнээс байнгын 1021, шинэ 502

Ирэгсэд: 7720

Ном олголт: **12143** үүнээс ном- 10097**,** хэвлэмэл бус материал буюу цахим ном- 410, сонин-1993, сэтгүүл-17 байна.

Уншигч, ирэгсэд заал танхим бүрээр дэлгэрэнгүйг дор хүснэгтээр харуулав.

2020 он уншигч, ирэгсэд

					Уншигчдын ангилал										Боловсрол						Насны ангилал						Хүйс						үүдэл, зөөвө	
Он сар өдөр	Заал танхимууд	Бүх уншигч	Байнгын	Шинэ	Ажилтан албан хаагч	Хувиараа хөдөлмөр	Бусад	Сургуулийн өмнөх нас	I-IV анги	V-VIII анги	IX-XI анги	Их дээд сургууль, коллеж	Мэргэжлийн боловсрол		Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд		18 нас хүртэлх	18-24 насны	25-35 насны	36-50 насны	51-ээс дээш насны		Эмэгтэй	Эрэгтэй		**Монгол**	**Гадаад**	Ирэгсэд	Уншигч	Ирэгсэд
Бүтэн жилээр 2020.12.21	НУТ	**492**	**305**	**187**	7	2	4		2	95	70	4	3	**187**	8	95	70	7	7	**187**	174	8	2	2	1	**187**	131	56	**187**	**187**		**2546**		
	ХУТ	**264**	**256**	**71**					24	47				71	53	18				71	71					71	43	28	71	71		**947**		50
	Салбар	**487**	**332**	**155**	5				63	87				**155**	150				5	**155**	150			3	2	**155**	74	81	**155**	**155**		**1618**		705
	ГНО	**217**	**128**	**89**	55	8	26							**89**		1	12	10	66	**89**		12	19	48	10	**89**	61	28	**89**	**89**		**2609**	67	406
	Фонд																																	401
Дүн		**1460**	**1021**	**502**	67	10	30	0	89	229	70	4	3	**502**	211	114	82	17	78	**502**	395	20	21	53	13	**502**	309	193	**502**	**502**		**7720**	**67**	**1562**

Ном олголтыг заал танхим бүрээр дэлгэрэнгүйг дор хүснэгтээр харуулав.

2020 он ном олголт

					Шинжлэх ухаанаар ангилсан байдал																			Хэлээр нь ангилсан			Тогтмол хэвлэл		
Он сар өдөр	Заал танхим	Бүх олгосон	Ном	Хэвлэмэл бус материал ба цах ном	Байгалийн шинжлэл	Техник	Хөдөө аж ахуй	Анагаах ухаан	Социологи, статистик, хүн ам	Түүх	Эдийн засаг	Улс төр	Төр эрх, хууль цааз	Цэргийн ш/у	Соёл,ш/у, боловсрол	Хэл шинжлэл	Аман зохиол,утга зохиол судл	Уран зохиол	Урлаг	Шашин	Гүн ухаан	Сэтгэл судлал	Лавлах хэвлэл	Монгол	Орос	Англи	Сонин	Сэтгүүл	Нүүдэл
Бүтэн жил 2020.12.21	**НУТ**	**1095**	1440	388	69	39	10	14	7	72	1	6	10		39	115	25	364	60	10	40	35	179	1095			15		
	ХУТ	**1256**	1204	20	77					60					10	3	611	355			84		56	1243		3	15	17	10
	Салбар	**3022**	3022		5	1		17		119							1697	1106	33	3	41			3022					1560
	ГНО	**6770**	4805	2		2				6					1963	1	2585	2209	1				3	6770			1963		**2125**
	Фонд																												**231**
Дүн		**12143**	10471	410	151	42	10	31	7	257	1	6	10	0	2012	119	4918	4034	94	13	165	35	238	12130	0	3	1993	17	**3926**

2. ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

24 газарт 103 удаа 67 уншигч, 1562 иргэсдэд, 3926 номоор үйлчилсэн байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр дор оруулав.

НҮҮДЭЛ ЗӨӨВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2020.12.15

№	Байгууллагын нэр	Нэгж салбар	Хамтран ажилласан	Он,сар, өдөр	Уншигч	Иргэсэд	Ном олгопт
1	ХААМСҮТ	Фонд	ААМСҮТ-ийн номын сан	1.02		70	17
2	3-р сургуулийн номын с	Фонд	р сургуулийн номын са	1.22		108	62
3	ШШГАлба	Фонд		2.2		13	13
4	ШШГАлба	Фонд		4.03		21	10
5	ШШГАлба	Фонд		8.28		31	15
6	1-р цэцэрлэг дунд	Салбар				34	5
7	ахлах	Салбар	Цэцэрлэгийн багш нар	9.9		36	5
8	бэлтгэл	Салбар				40	5
9	ШШГГ	ГНО	Фонд	9 сар 11, 14, 28, 29	2	25	126
10	Аймгийн шүүх	ГНО	Фонд	9 сар 11, 25, 29 10 сар	20	29	115
11	АЗДТГ-ын Нийгмийн бо	ГНО		9 сар 14, 28, 10 сар 1	2	6	101
12	АЗДТГ-ын Хөрөнгө оруу	ГНО		9 сар 14, 28, 10 сар 1	2	8	101
13	1-р сургууль 3 В анги	ГНО	Ангийн багш нар	9 сар 11, 14, 25, 29	1	35	190
14	1-р сургууль 3 Г анги	ГНО	Ангийн багш нар	9 сар 11, 14, 25, 29	1	32	159
15	1-р сургууль 6 Б анги	ГНО	Ангийн багш нар	9 сар 11, 14, 28, 29	1	26	125
16	Улсын бүртгэлийн хэлтэ	ГНО		9 сар 11, 14, 28, 29	10	18	90
17	Мэргэжлийн хяналтын г	ГНО		9 сар 11, 25,	11	21	98
18	1-р сургууль 4 Б анги	ГНО	Ангийн багш	9 сар 11, 14, 28, 29	1	30	150
19	1-р сургууль 2 А анги	ГНО	ХҮТ, ангийн багш	9 сар 11, 14, 28, 29	1	35	175
20	1-р сургууль 2 В анги	ГНО	ХҮТ, ангийн багш	9 сар 11, 14, 28, 29	1	33	165
21	1-р сургууль 7 А анги	ГНО	Ангийн багш	9 сар 11, 14, 28, 29	1	25	125
22	1-р сургууль 3 Б анги	ГНО	Ангийн багш	9 сар 11, 14, 28, 29	1	31	155
23	1-р сургууль 9 Б анги	ГНО	Ангийн багш	9 сар 11, 14, 28, 29	1	28	190
24	Татварын хэлтэс	ГНО	Фонд	9 сар 25	11	24	
25	ШШГАлба	Фонд		9.17		21	10
26	2-р цэцэрлэг дунд	Салбар				24	5
27	ахлах	Салбар	Цэцэрлэгийн багш нар	9.18		40	5
28	бэлтгэл	Салбар				31	5
29	ЭӨЦС 5 Б анги	Салбар	Ангийн багш	9.24		26	80
30	ЭӨЦС 2 Б анги	Салбар	Ангийн багш			40	90
31	ЭӨЦС 4 А анги	Салбар	Ангийн багш	9.25		38	110
32	ЭӨЦС 5 Б анги	Салбар	Ангийн багш	9.28		25	80
33	ЭӨЦС 4 Б анги	Салбар	Ангийн багш	10.06		30	100
34	ЭӨЦС 5 Б анги	Салбар	Ангийн багш			26	80
35	ЭӨЦС 3 Б анги	Салбар	Ангийн багш	10.07		35	100
36	ШШГАлба	Фонд				25	15
37	ЭӨЦС 5 В анги	Салбар	Ангийн багш	10.08		30	90
38	ЭӨЦС 5 Б анги	Салбар	Ангийн багш			30	90
39	ЭӨЦС 5 Г анги	Салбар	Ангийн багш	10.09		30	100
40	ЭӨЦС 7 Б анги	Салбар	Ангийн багш	10.1		25	110
41	ЭӨЦС 4 А анги	Салбар	Ангийн багш	10.13		38	110
42	ЭӨЦС 4 Б анги	Салбар	Ангийн багш	10.16		30	100
43	3-р сургууль 5 А анги	Салбар	Ангийн багш	10.19		32	90
44	ШШГАлба	Фонд		10.19		24	14
45	3-р сургууль 3 А анги	Салбар	Ангийн багш	10.2		36	90
46	3-р сургууль 4 А анги	Салбар	Ангийн багш	10.21		29	110
47	3-р цэцэрлэг	Фонд	Эрхлэгч	10.3		24	31
48	3-р цэцэрлэг	ХҮТ	Цэцэрлэгийн багш			50	10
49	ШШГАлба	Фонд		11.04		26	16
50	3-р цэцэрлэг	Фонд	Эрхлэгч	11.1		24	12
	ДҮН				**67**	**1548**	**3850**

3. САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭЛТ

2020 онд нийт 142 нэр төрлийн 277 ширхэг 4.578.000 төгрөгний, үүнээс худалдаагаар 87 нэр төрлийн 205 ширхэг 4.053.200 төгрөгний, бэлэгээр 53 нэр төрлийн 72 ширхэг 524.800 төгрөгний ном, хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулсан

Фонд баяжилтийг шинжлэх ухаанаар сүүлийн 3 жилээр харьцуулан үзүүлбэл:



Фонд баяжилтийг нэр төрөл, тоо ширхэг, үнэ 5 жилээр харьцуулахад 2017 оноос хойш буурсан үзүүлэлт харагдаж байна. Шалтгаан нь ном хэвлэлийн үнэ жил бүр нэмэгдэж байна.

- Шинээр ирсэн 277 ширхэг ном, хэвлэлийг данс бүртгэлд тусгаж, 100% цахим каталогт оруулж анхан шатны техник ажиллагаа хийж заал танхимуудад хувиарлан уншлаганд гаргасан.
- Монгол тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд 2019 оны “Булганы мэдээ” сонины мэдээг оруулсан
- Програмд тогтмол хэвлэлийн үнэ оруулаагүй байсныг оруулж, 2019 оны сэтгүүлүүдийг програмд оруулсан.
- Солилцооны фондыг 80 ширхэг 220.310 төгрөгний номоор баяжуулж нийтдээ 385 ширхэг 1.266.490 төгрөгний үнэ бүхий номтой боллоо.
- Бэлтгэл фондыг 8 ширхэг 91.500 төгрөгний номоор баяжуулж нийтдээ 48 ширхэг 338.500 төгрөгний үнэ бүхий ном байна
- Аймгийн Засаг даргын тамгын газар, Хөдөө аж ахуйн газар, “Бэхи цолтон” ТББ, Нээлттэй нийгэм форум, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, иргэн О.Ууганчимэг, Б.Энхтөр, Г.Болормаа, зохиолч М.Уянсүх, Булган аймгийн зохиолч, яруу найрагчид, “Номын гэгээ” аяныг үүсгэн байгуулагч Хоролгарав, Сувддулам нар номын хандив өргөсөн байна.

Програмд ажилласан график мэдээ:



Номын сан ашиглаж байгаа Lib4U програмдаа шинэчлэл хийж шинэчлэгдсэн програмд шинэ ном хэвлэлээ оруулсан. Энэхүү шинэчлэлийг хийснээр цаг хугацаа орон зайнаас үл хамааран хаанаас ч манай цахим каталогт хандаж ном хайх боломжтой болсон. Манай цахим каталогийг bulgan.lib4u.net хаягаар хандаад гар утаснаас ч ашиглаж болно. Номын санчдын хувьд Lib4U програмын шинэчилсэн хувилбарыг ашиглаж байгаа бусад номын сангуудтай ном зүйн бичилт, каталогийн бүртгэлийг солилцоход нээлттэй болсон зэрэг давуу талтай.



4. САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Үндсэн болон ойрын фондод 2 удаа хортон шавьжны устгал, 2-3 удаа ном хэвлэлийн тоосыг арчиж механик аргаар ариутгал хийсэн.

НУТ, ХУТ, ГНО, Салбар номын сангийн ойрын фондуудын тооллого хийсэн.

Сэлбэн зассан ном:

Нийт 164 номыг сэлбэн зассан.

- Үндсэн фонд- 15
- Хүүхдийн уншлагын танхим-21
- Гэрээр ном олгох танхим-98
- Салбар номын сан- 30

5. ЛАВЛАГАА

Нийтдээ 1443 лавлагаа өгөгдсөн. Үүнээс амаар 351, бичгээр 32, утсаар 335, цахимаар 725 байна. Цах тахлын хорио цээрийн улмаас цахим болон утсаар өгөгдсөн лавлагаа мэдээлэл нэмэгдсэн. Лавлагаа заал танхим бүрээр дэлгэрэнгүйг дор харуулав.

- ✓ Хүүхдийн уншлагын танхим- 86 амаар 86
- ✓ Нийтийн уншлагын танхим- 33 амаар 25, цахимаар 8
- ✓ Гэрээр ном олгох танхим-211 амаар 70 , утсаар 25, цахимаар 116
- ✓ Үндсэн фонд- 8 бичгээр 8
- ✓ Салбар номын сан- 82, амаар 60, утсаар 22

- ✓ Арга зүйч-1023 амаар 110, бичгээр 24, утсаар 288, цахимаар 601 үүнээс номын санчдад 924 лавлагаа өгөгдсөн байна.



- ➢ “Дэлхийн Монголчууд MGL” радиогийн шууд эпирээр 3 удаа, Булганы мэдээ сонинд 1 удаа номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч номын сангийнхаа үйл ажиллагааг сурталчилсан
- ➢ Номын сангийн нүүр номд 112 удаа мэдээлэл оруулсан

6. ТАТГАЛЗАЛ:

Нийт 189 ном татгалзалд бүртгэгдсэн. Татгалзалд бүртгэгдсэн номноос бүрдүүлэлтээр 9 авсан.

- Хүүхдийн уншлагын танхим- 1
- Нийтийн уншлагын танхим- 16, хариулсан 4
- Гэрээр ном олгох танхим-121
- Салбар номын сан- 50 хариулсан 5
- Арга зүйч-1

7. МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙ

1. Тэшиг сум, ЭӨЦСургуулийн, АТНС-аас 1 номын санч УТНАДС-д эчнээгээр суралцан номын санчийн бакалавр зэрэгтэй эзэмшсэн
2. 2020 оны 3 сарын 20-27-ны өдрүүдэд Булган сумын Соёлын ордны номын сангийн бүртгэл хөтлөлт данс, Монбиблио програм, ном хэвлэлийн ангилал шинэчлэн сайжруулах ажилд ажлын 5 өдөр зөвлөн туслахаар ажиллаж 300 гаруй Монгол ном, 5000 гаруй гадаад номыг номыг шинжлэх ухаанаар ангилж Монгол номыг 100 % данс бүртгэлд тусгаж цахим каталогт оруулсан.
3. Мэргэжил арга зүйгээр зөвлөн туслах баг авч ажиллуулах хүсэлт ирүүлсэн сумын номын санчдад групээр дамжуулан “Номын сангуудын бүртгэл хөтлөлтийг сайжруулах”-д бэлтгэл ажлыг хангах талаар асуумж явуулж бэлтгэл ажлыг хангуулсан.

4. БСУГ-ын мэргэжилтэн О.Ууганчимэг, Музейн ажилтан Бат-Эрдэнэ нартай Бугат сумын номын санд очиж ажиллаж номын фондын эхний 2 тавиурын номыг нь шинжлэх ухаан, үсэг дараалаар ангилж цаашид үргэлжлүүлэх хийх арга техникийг номын санчид зааж мэргэжил арга зүйгээр зөвлөн тусалсан.
5. НУТ, ГНО, ХУТ, Салбар номын сангийн ойрын фондуудыг тоолсон
6. Номын санчдад амаар, утсаар, цахимаар, бичгээр нийтдээ 887 лавлагаа мэдээлэл өгсөн байна.
7. 6 сарын 10-нд ХААМСҮТ-ийн номын сангийн ангилал, дахин үнэлгээ, анхан шатны бүртгэл данс шинэчлэл, програм шинэчлэл дээр мэргэжил аргазүйгээр зөвлөн туслаж ажилласан.
8. Аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран сумдад мэргэжил арга зүйн зөвлөн туслахаар 7 сарын 22-24-ний өдрүүдэд Баян-Агт сумын номын сангийн дахин үнэлгээ, данс, ном зүйн бичилт, програмын шинэчлэл эхлүүллээ.

9. 7 сарын 27-29-ний өдрүүдэд Хангал сумын номын сангийн данс, ном зүйн бичилт, програмын шинэчлэл эхлүүлсэн
10. СУИС-ийн багш Т.Хайдавын нээсэн “Соёлын төвийн номын санчид” группд сумдын номын санчдаа нэмж оруулж орон нутгийн номын санчдаа мэдээлэл авах боломжийг нэмэгдүүллээ.
11. Аймгийн номын сангуудын аргазүйчдын групп дээр номын сангуудад тулгамдаж байгаа асуудлуудыг эрэмбэлж нэгтгэх санал оруулж анхан шатны бүртгэл хөтлөлтөд шинэчлэл хийх саналаа МҮНС-д явуулсан.
12. МҮНС-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу бүх номын санчдын e mail хаяг, утасны дугаарын мэдээллийг нэгтгэн хүргэсэн.
13. Сумдын номын сангуудын сан хөмрөгийн мэдээг нягтлангуудтай нь тулгаж номын санчдад санхүү данс бүртгэлийн зөрүүтэй байгаа мэдээллийг хүргэж засаж сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсөн. 17 сумын номын сангаас мэдээ авахад 3 номын сангийн фондын тоо ширхэг санхүүгийн дүнтэй тулж 14 номын сан зөрүүтэй гарсаныг засах арга хэмжээ авч ажиллаж байна
14. ХУТ-ын номын санчийн ажил хүлээлцэх номын тооллого хийсэн.
15. Орон нутгийн номын сангуудад тус бүрд нь хавтас нээж мэдээ тайланг хийхээр эхлүүлж Баян-Агт сумын сум, сургуулийн номын сангуудын мэдээллийг бэлтгэн хавтаст хийсэн.

8. НОМЗҮЙ

2019 оны тогтмол хэвлэлийг нэгжлэн дансанд авч програмд оруулсан.

2019 оны Булганы мэдээ сонины мэдээллүүдийг МҮНС-ийн тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд оруулсан.

Заал танхимууд шинэ номын мэдээг шинэ ном ирсэн тухай бүр гаргасан.

9. КАТАЛОГ

Lib4U программын шинэчлэл хийж цахим каталогийг интернэт байршуулж уншигчид интернэт ашиглаж байгаа бол цаг хугацаа орон зайнаас үл хамааран хаанаас ч манай номын сангийн каталогт хандан ном хайх боломжтой болсон.

10. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН, СУРТАЛЧИЛГАА

33 удаа 639 номоор үзэсгэлэн гаргаж 2298 хүн үзсэн. Дэлгэрэнгүйг дор оруулав.

2020 онд гаргасан номын үзэсгэлэн сурталчилгаа

2020.12.17

№	Номын үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэн гаргасан номын тоо	Он сар өдөр	Хаана	Үзсэн хүний тоо	Хариуцах эзэн
1	Үндсэн хуулийн өдөр	7	1.02-01-15	Салбар номын сан	35	Д.Долгормаа
2	Үндсэн хуулийн өдөр	24	1.02-01.20	НУТ	250	
3	Бэлгийн ном сурталчилгаа	1	1.23	Нүүр номд	32	Т.Мөнгөнтуяа
4	Шинэ номын мэдээ	22	1.23-3.1	НУТ	334	Б.Эрдэнэцацралт
5	Шинэ номын	10	03-5-03.20	Салбар номын сан	8	Д.Долгормаа
6	Хүүхдийн номын танилцуулга сурталчилгаа	1	4.01	Нүүр номд	22	Б.Отгончимэг
7	Сургамжит өгүүллэгээс	2	4.8	Нүүр номд	26	Б.Эрдэнэцацралт
8	Сургамжит өгүүллэгээс	2	4.13	Нүүр номд	11	
9	Бэлгийн ном сурталчилгаа	3	4.17	Нүүр номд	303	Т.Мөнгөнтуяа
10	Монголчуудын үсэг бичиг, үг хэллэгийн түүх гарлаас номын сурталчилгаа	1	5.5-5.8	Нүүр номд	68	Б.Эрдэнэцацралт
11	ЭЕШ-нд бэлтгэгчдэд	16	5.1	НУТ	132	Б.Эрдэнэцацралт
12	Үндэсний бичиг соёлын өдөрт	24	5.1	НУТ	35	Б.Эрдэнэцацралт, Г.Эрдэнэбулган
13	Дэлхийн номын баярт	52	5.19	ХУТ	27	Б.Отгончимэг
14	Эх үрсийн баярт	48	5.25	ХУТ	35	Б.Отгончимэг
15	Хүүхдийн номын цахим танилцуулга сурталчилгаа	42	5.28	Нүүр номд	44	Б.Отгончимэг
16	Хандивын номын сурталчилгаа	1	5.28	Нүүр номд	9	Т.Мөнгөнтуяа
17	Ж.Дашдондогийн зохиол сэдэвчилсэн	9	6.8	ХУТ	11	Б.Отгончимэг
18	Эрүүл мэндийн сэдэвчилсэн	16		НУТ	65	Б.Эрдэнэцацралт
19	Шинэ номын мэдээ	10		НУТ	260	Б.Эрдэнэцацралт
20	Соёлын цагаар номын үзэсгэлэн	80		ХЖТ	45	Г.Эрдэнэбулган
21	Хандивын номын сурталчилгаа	4	6.25	Нүүр номд	27	Т.Мөнгөнтуяа
22	Хандивын номын сурталчилгаа	10	7.27	Нүүр номд	74	Т.Мөнгөнтуяа
23	Шинэ номын мэдээ	15	09-12-10.01	Салбар номын сан	104	Д.Долгормаа
24	Шинэ номын мэдээ	39	9.1	Нүүр номд	13	Т.Мөнгөнтуяа
25	Шинэ номын мэдээ	22	9.22	Нүүр номд	19	Б.Эрдэнэцацралт
26	Шинэ номын мэдээ	35	9.23	Нүүр номд	38	Г.Энхбилэг
27	Бэлгийн ном сурталчилгаа	1	9.24	Нүүр номд	27	Т.Мөнгөнтуяа
28	Шинэ номын цахим үзэсгэлэн	13	10.10	Нүүр номд	32	Г.Энхбилэг
29	Хандивын номын сурталчилгаа	20	10.29	Нүүр номд	41	Т.Мөнгөнтуяа
30	Шинэ номын мэдээ	13	11.1	Нүүр номд	45	Г.Энхбилэг
31	Шинэ номын мэдээ	17	4.04	ХУТ	30	Ц.Одмаа
32	ХБИ-ийн сарын аян сэдэвчилсэн	63	11.06	Соёлын төвд	31	Г.Эрдэнэбулган
33	ХБИ-ийн өдөрт зориулсан сэдэвчилсэн	16	11.06	Соёлын төвд	65	Б.Эрдэнэцацралт
	ДҮН	**639**			**2298**	

11. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

11 сургалтанд 37 хүн хамрагдсан

Сургалтууд				
2020.12.17				
№	Сургалтууд	Зохион байгуулсан газар	Хугацаа	Оролцсон хүний тоо
1	Улаанбаатар хот Соёл урлагийн статистик мэдээний арга зүй сургалт	БСШУЯ	1.5	1
2	lib4u програмын цахим сургалт	АТНС	3.3	7
3	МНСХ-ноос зохион явуулсан Солонгосын Чонбукийн их сургуулийн докторант С.Хишигсүрэнгийн “Хэрэглэгч төвтэй үйлчилгээ” цахим сургалт	Цахимаар	4.1	2
4	4. “Сэдвийн түлхүүр үг” цахим сургалт	Цахимаар	5.1	1
5	Нийтийн номын сангийн үйл ажиллагааны загвар Ч.Мөнхчимэг	Цахимаар	5.3	2
6	Хэрэглэгч төвтэй үйлчилгээ М.Даваасүрэн	Цахимаар	5.12	3
7	Лавлагаа мэдээллийн үйлчилгээ	Цахимаар	5.18	1
8	Санхүү хүний нөөцийн сургалт	АЗДТ	5.18	2
9	Аймгийн НДГ-ын сургалт	Музей	5.2	8
10	Сан хөмрөг хөгжүүлэх бодлого М.Даваасүрэн цахим хичээл	Цахимаар	5.26	1
11	7. МНСК-иас жил бүр зохион байгуулдаг “Library update-2020” сургалт, спортын тэмцээнд оролцсон	ХЦИСургууль	9.23	9
Дүн				37

12. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ

33 соёл олон нийтийн ажилд 1082 хүн оролцож номын сангийн нүүр номд байрлуулсан СОНА-ын мэдээллийг 1411 хүн үзсэн.

Соёл олон түмний ажлын дэлгэрэнгүй мэдээллийг дор оруулллаа. Ажиллагсадын оролцсон олон нийтийн ажилд оролцсон тоог дээрх тоо мэдээнд оруулаагүй болно.

	СОНА-2020					
2020.12.17						
№	Зохион явуулсан ажил	Хамтран ажилласан байгууллага	Хэзээ	Зохион байгуулсан номын санчид	Оролцсон хүний тоо	цахимаар үзсэн хүний тоо
1	Цахим ном үнэгүй татах зөвлөмж		3.13	Б.Эрдэнэцацралт		31
2	Булган Төв номын сан танилцуулга live	МНСХолбоо М.Даваасүрэн	4.9	Т.Мөнгөнтуяа, Б.Эрдэнэцацралт	10	211
3	"Миний хайртай үлгэрийн баатар" цахим гар зургийн уралдаан		4.14-5.20	Г.Энхбилэг, Б.Эрдэнэцацралт	21	155
4	Хүүхдийн уншлагын танхим цахим уншлага		4.15	Б.Отгончимэг		35
5	Хүүхдийн баяр угтсан эможоор номын нэр таах уралдаан		4.15		29	11
6	"Булган аймгийн зохиолч, яруу найрагчдын ном бүтээл"-ийг сурталчилсан лайв		4.23	Т.Мөнгөнтуяа, Б.Эрдэнэцацралт	2	22
7	Хормогтой үлгэр уншлага цахимаар		5.4	Б.Отгончимэг	93	93
8	Салбар номын сангийн танилцуулга live		5.5	Т.Мөнгөнтуяа, Д.Долгормаа	2	68
9	Сургамжит өгүүллэг цахимаар		5.19	Б.Эрдэнэцацралт		6
10	Шүүхийн тамгын газар "Чанга шивнээ"	ШТГазар	5.21	Г.Энхбилэг, Б.Эрдэнэцацралт	14	
11	Хөгжөөнт тоглоом		5.21	Г.Энхбилэг	20	
12	ШШГГ чанга шивнээ			Г.Энхбилэг	11	
13	Хүүхдийн баяр угтсан эможоор номын нэр таах уралдаан		5.28	Б.Отгончимэг	21	39
14	Номын тэмдэглэл хөтлөхөд хэрэгтэй мэдээлэл		6.28	Б.Отгончимэг		11
15	"Үлгэр ярьж өгье" цахим уншлагын аян			Г.Энхбилэг	4	55
16	Өмнөговь аймгийн номын санчдад номын сан, орон нутгаа танилцуулах аялал		7.1	Номын санчид	10	106
17	"Шинэ номын баяр"		8.21	Д.Долгормаа, Б.Отгончимэг	24	90
18	"Олуулаа уншъя" ном уншлагын 14 хоногийн аян		9 сар	Д.Долгормаа, Б.Эрдэнэцацралт	657	
19	2-р цэцэрлэг чанга уншлага		9.8	Д.Долгормаа		79
20	Хань өгүүллэг цахимаар		9.9	Б.Эрдэнэцацралт		7
21	1-р цэцэрлэг чанга уншлага		9.9	Д.Долгормаа		39
22	Ном солилцох уриалга /цахимаар/		9.10-9.20	Т.Мөнгөнтуяа		48
23	"Ном бид 2" илтгэлийн уралдаан		9.17	Б.Эрдэнэцацралт, Т.Мөнгөнтуяа	4	71
24	ГБХЗГ-тай хамтран гудамжинд номын сан байрлуулж ном сонин тухай бүр байршуулдаг		9.18	Т.Мөнгөнтуяа	3	132
25	"Сайхан бичигтэн" Монгол бичгийн уралдаан		9.24	Б.Эрдэнэцацралт, Т.Мөнгөнтуяа	38	82
26	Соёлын цагийн үйл ажиллагаанд мэдээлэл сурталчилгаа		10.3	Г.Эрдэнэбулган	25	
27	2-р цэцэрлэгийн багш ажиллагсадын дунд АХА тэмцээн			Д.Долгормаа	16	
28	Уншигчдын чөлөөт цагт зориулан "БУАТНС" зэрэг үгийн сүлжээг зохиож нүүр номд оруулсан		11.3	Т.Мөнгөнтуяа, Д.Долгормаа		19
29	"ОУ-ын ХБИ-ийн эрхийн хамгаалах өдөр"-ийн нээлттэй өдөрлөгөөр мэдээлэл, номын үзэсгэлэн	ХХҮГазар	11.6	Г.Эрдэнэбулган	78	32
30	Уншигчдад зориулан цахим ном үнэгүй болон үнэтэй ашиглаж болох сайтуудын хаяг, мэдээллийг бэлтгэн нүүр номд оруулсан		11.6	Т.Мөнгөнтуяа		10
31	Уншигчдын чөлөөт цагт зориулан "НОМ" үгийн сүлжээг зохиож нүүр номд оруулсан		12.5	Т.Мөнгөнтуяа		17
32	Цахим ном үнэгүй татах хаяг, сайтуудын мэдээлэл		12.5	Т.Мөнгөнтуяа		12
33	Номын санчийн мэргэжил сурталчилах фото шторк		12.5	Т.Мөнгөнтуяа		141
	ДҮН				1082	1622

Өөрсдийн оролцсон олон нийтийн ажил					
2020.12.17					
№	Ажил үйлчилгээ	Хамтран ажилласан байгууллага	Хэзээ	Оролцсон хүний тоо	цахимаар мэдээлэл авсан хүний тоо
1	Олон нийтийн цас цэвэрлэгээ	Булган сум	1.17	8	63
2	Байгууллагын дотор их цэвэрлэгээ		2.27	9	56
3	Байгууллага дотор ариутгал, цэвэрлэгээ		3.13	9	74
4	Сумын Онцгой комисс-д хандив		3 сар	10	
5	Постонд гарч байгаа ОК-д 1 өдрийн хоол		4 сар	10	
6	Ном сэлбэн засалт,ариутгал халдваргүйжүүлэлт, үүдэнд жижүүр		3.16	9	225
7	Байгууллагын гаднах цэвэрлэгээ		3.31	7	41
8	Цэвэр орчин-Цэмцгэр Булган аян		4.28	5	13
9	Цэвэр орчин-Цэмцгэр Булган аян		9.1	5	56
10	Монголын номын санчдын спортын наадам		9.24-25	15	
11	НУТ-ын цонх дулаалга		10.1	3	10
12	Мод тарих өдөр		10.12	6	21
				96	559

- Монголын номын сангийн холбооны тэргүүн Төв номын сан, салбар номын сангийн танилцуулга лайв
- **"Миний дуртай үлгэрийн баатар"** сэдэвт гар зургийн цахим уралдаанд 14 хүүхдийн 21 бүтээл оролцож

  6-10 насны ангилалд:

  1-р байр: 3-р сургуулийн 4 А анги А.Цэенханд

  2-р байр: ЭӨЦС-ийн 5 А анги Б.Азбилэг

  3-р байр: Дашинчилэн сумын 3 А анги Баярмаа

  11-15 насны ангилалд:

  1-р байр: ЭӨСургуулийн 9 Б анги М.Мишээл

  2-р байр: 1-р сургуулийн 7 А анги Б.Хүслэн

  3-р байр: ЭӨЦС-ийн 5 Г анги Б.Хулан тус тус шалгарсан
- "Номын баяр -2020"-ын хүрээнд Нийтийн уншлагын танхимаас зохион явуулсан **"Ном бид хоёр"** илтгэлийн уралдаанд

  1-р байр: 1-р сургууль 11 В анги Б.Эрдэнэсувд

  2-р байр: 3-р сургууль 12 А анги Ж.Буяндэлгэр

  3-р байр: ЭӨЦС-ийн 10 В анги М.Эрдэнэт-Од нарын илтгэлүүд шалгарсан
- **"Миний гэрийн номын сан"-**г сурталчилах аян зохион байгуулж 3 өрхийн 56 номыг сурталчилсан.
- **"Үлгэр ярьж өгье"** цахим уншлагын аянд 2 сумын 4 хүүхэд оролцсон
- **"Сайхан бичигтэн"** уралдаанд 38 бүтээл оролцсоноос

1-р байр: Сайхан сумын 8 А анги Д.Бямбасүрэн

2-р байр: 3-р сургууль 8 А анги Б.Сүхбат

3-р байр: 1-р сургууль 7 А анги Ц.Эрдэнэбаяр нар шалгарсан

- Монголын номын сангуудын холбоо”-ны гүйцэтгэх захирал М.Даваасүрэнтэй хамтран МНСХ-ны групп дээр 4 сарын 9-нд “Булган аймгийн Төв номын сан”-ийн танилцуулга лайв
- 4 сарын 23-нд “Булган аймгийн зохиолч, яруу найрагчдын ном бүтээл”-ийг сурталчилсан лайв
- Хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох үйлчилгээний талаарх танилцуулга лайв
- Салбар номын сангийн танилцуулга лайвыг 5 сарын 5-нд хийж нүүр номд байршуулж сурталчилсан
- “Ном” цомд материал бэлтгэн явуулсан
- Өөрийн номын санд байхгүй цахим ном, өөр үнэгүй эх сурвалж, цахим номыг эрэлхийлж бусад номын сан, байгууллага, хувь хүмүүсээс татан авч цахим шуудангаар уншигчдад илгээж байна.
- “БЭХИ ЦОЛТОН” НҮТББ-ын “Монголын нууц товчоо” группд Төв номын санг оруулж уншигчдыг МНТ-ны бүлгээс өдөр бүр нэг бүлгийг унших боломжийг нээсэн
- СУИС-иас эрхлэн гаргадаг “Соёл урлагийн тайлбар толь” цувралын “Соёлын өв” ботид материал явуулсан.
- “БУАТНС”, “НОМ” зэрэг үгийн сүлжээнүүдийг зохион номын сангийн нүүр номоор дамжуулан уншигчдын дунд цахим уралдаан зарласан
- Номын санчийн тухай дуун дээр номын санчдын фото зургийн эвлүүлгийг хийж олон нийтийн сүлжээнд байрлуулж сурталчилсан
- 2-р цэцэрлэгийн ажиллагсадын дунд “АХА” танин мэдэхүйн тэмцээн
- “Library update-2020” сургалтын үеэр 2017, 2018, 2019 оны Номын сангийн салбарын “Онцлох 10 ажил”-д шалгарсан талаарх фото зургийн үзэсгэлэнд бүтээл бэлтгэн оролцсон. Сургалтанд АТНС-аас 4 номын санч 5 сумын номын санч өөрсдийн зардлаар хамрагдсан.
- Монголын номын санчдын спортын тэмцээн 2020 оны 9 сарын 24-25-ны өдрүүдэд Төв аймагт болж орон нутгийн номын санчидтай хамтарч баг бүрдүүлэн 8 төрөлд амжилттай оролцсон. Тус тэмцээнд Хангал, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Орхон, Бугат, Тэшиг сумдын номын санчид АТНС-ийн номын санчид нийт 18 номын санч оролцсон.

13. ШИНЭЛЭГ АЖИЛ

- Цахим сүлжээг ашиглан 5 удаа live буюу шууд бичлэг хийж номын сангийн үйл ажиллагааг сурталчилсан
- Уншигчдын чөлөөт цагт зориулж үгийн сүлжээнүүд зохиож цахимаар уралдаан зарласан
- Номын санчийн мэргэжил сурталчилах зорилгоор Номын санчийн тухай дууны аянд фото эвлүүлэг
- 3 сум 1 сургуулийн номын сангийн данс бүртгэл, програм, ном зүйн бичилт шинэчлэлийг эхлүүлсэн

14. ТӨСӨВ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

НУТ-ийн хойд талын цонхыг вакум болгож номын санчид өөрсдөө амалгааг хийсэн.

15. БУСАД АЖИЛ

- Ковид-19 өвчний хорио цээрийн дэглэмийн үеэр байгууллагын ажиллагсад ээлжээр үүдэнд жижүүрлэн үйлчүүлэгчдийг ариутгал халдваргүйжилтийн дэглэмийг сахиулан шаардлага тавьж гадуур олгогдсон номыг механик ариутгал хийсэн.
- Байгууллагын гаднах ойр орчмын талбайг 2 удаа ариутгалын бодисоор халдваргүйжүүлсэн
- Улирал бүр байгууллагын дотор гаднах их цэвэрлэгээг хийж Ковид-19 өвчний хорио цээрийн үед мэргэжлийн байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн дагуу тухай бүр ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн
- "Үндэсний мод тарих өдөр"-өөр байгууллагын ажиллагсад цэцэрлэгт хүрээлэнд хуваарьт газраа 5 мод тарьлаа
- Булган сумаас зохион байгуулсан бүх нийтийн хог цэвэрлэх, зэрлэг зулгаах ажилд бүх ажиллагсад оролцлоо
- Ковид-19 өвчний онцгой дэглэмийн үеэр 200 ширхэг амны хаалт оёж ажиллагсад болон сумын Онцгой комиссд хандивласан.
- Ажиллагадын хамт аймгийн Онцгой комисс болон сумын Онцгой комиссынхонд 2 удаа, аймгийн Онцгой комиссд 1 удаа 1 өдрийн хоолыг өгч тусламж үзүүлсэн
- Үйлчлэгч, манаачийг ажлын хувцасаар хангасан

16. ДҮГНЭЛТ

Үйлчилгээ талаас:

Халдварт Ковид-19 өвчний улмаас цахимаар үйлчлэх шаардлага их чухал байгаа тул техник тоног төхөөрөмж /хурдтай компьютер, скайнер, ном ариутгах төхөөрөмж, цахим ном зэргийг нэмэгдүүлж сайжруулалт хийх шаардлагтай байна.

Цаашид цахимаар үйлчилгээ үзүүлэх боломжийг өргөжүүлэх.

2020 онд халдварт цар тахлын улмаас нэлээдгүй хугацаанд хорио цээрийн дэглэмд шилжиж карантинд орж үйлчилгээг удаа дараа хааж байсны улмаас төлөвлөгөөнд тусгагдсан зарим олон нийтийн ажлууд цуцлагдсан, үйлчилгээнүүд багассан, үйлчлүүлэгчдийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Мэргэжил арга зүй талаас:

2018 онд Төв номын сантай хамтран 13 сумын 25 сум, сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцахад Номын сангууд анхан шатны бүртгэл хөтлөлт хангалтгүй байсан. 2019 онд БСУГ-аас "Орон нутгийн номын сангуудын бүртгэл хөтлөлтийг сайжруулах жил" болгон зарласан ч доривтой өөрчлөлт гаргаагүй. 2019 оны эцэст СУ тайлангийн үзүүлэлтийг гаргахад 14 сумын номын сангийн фондын тоо мэдээ санхүүгийн мэдээтэй зөрүүтэй гарч

байсан. 2020 онд аймгийн Мэргэжлийн Хяналтын газар, БСУГ-тай мэргэжил арга зүй талаас хамтарч энэ талаар бодит үр дүнд хүрэхээр ажиллаж Бугат, Баян-Агт, Хангал, Булган сум, ХААМСҮТ-ийн номын сангуудын данс бүртгэл, програм, ном зүйн бичилтийг шинэчлэх ажлыг эхлүүлсэн.

Боловсон хүчин, хүний нөөц талаас:

2020 онд Булган аймагт сумын 17, ЕБС-ын 20, МСҮТ, ХААМСҮТ-ийн 2, аймгийн Төв номын санд нийт 45 номын санч ажиллаж байгаагаас 13 номын санч буюу 30% нь мэргэжлийн номын санч байна. 2019 онд 3 номын санч эчнээгээр мэргэжил эзэмшсэн 2020 онд номын санч эчнээд суралцаж байна.. Мэргэжлийн бус номын санчид анхан шатны мэдлэг байхгүйгээс мэргэжлийн зүгээс юу хийхээ мэдэхгүй, ажилдаа анхаарлаа хандуулж ажиллах нь хангалтгүй байгааг анхаарч үйл ажиллагаанд удирдах дээд байгууллагууд хяналт тавьж эргэх холбоо, хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй байна.

Автоматжуулалт талаас:

АТНС нь “Lib4u” номын сангийн програм ашигладаг сумдын номын сангууд “Монбиблио” програм ашигладаг. Цахим мэдээллийн хэрэглээ, ашиглалт хурдацтай хөгжиж байгаа энэ үед номын сангуудын цахим төхөөрөмжийн хэрэглээг дэмжин сайжруулах шаардлагатай байгаа. Бүх номын сангууд нэг ижил програм ашиглах, интернэтэд бүрэн холбох, тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг асуудлуудыг шийдэх боломжуудыг нээж өгөх талаар цаашид төлөвлөгөөндөө тусган ажиллана.

17. **АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ХАГАС ЖИЛИЙН СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ФОТО ЗУРГУУДААС:** Булган номын сан нүүр номд оруулсан мэдээ мэдээллүүдээс







Зөөвөр, явуулын номын үйлчилгээ

Монголын номын санчдын спортын наадам

Монголын номын санчдын “Library update 2020” зөвлөгөөн

Сайхан бичгийн уралдааны бүтээлийн үзэсгэлэн





“Номын баяр 2020” арга хэмжээний хүрээнд

Мэргэжил арга зүйгээр зөвлөн туслах

Булган сумын номын санд

Хангал сумын номын санд

Баян-Агт сумын номын санд

Бугат
номын

сумын
санд

ХААМСУТ-

ийн

номын

санд

Салбар номын сангийн үйлчилгээ

Ном сэлбэн засалт

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн



Уншигчдаас ном хандивлах, бэлэглэх үйл ажиллагаа

“Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд

ТАЙЛАН БИЧСЭН: АРГА ЗҮЙЧ, НОМЗҮЙЧ Т.МӨНГӨНТУЯА

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОН ТОО БҮТЭЦ

Нийтийн номын сан нь 2020 онд удирдах-1,нягтлан бодогч-1, мэргэжлийн-10, аж ахуй үйлчилгээний-5 нийт 17 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн, Нийтийн номын сангийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг ханган биелүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжууд, УИХ, Засгийн газрын тогтоол, БСШУЯ-ны сайдын тушаал, заавар, зөвлөмжүүдэд үндэслэн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулж ирлээ.

2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. 2020 онд 972 шинэ уншигч бүртгэж, 8162 ирцэд 9807 ном олголт хийлээ.
2. Уншигч үйлчлүүлэгчдийг шинэ мэдээ мэдээллээр хангах зорилтын хүрээнд 167 удаа лавлагаа, 95 татгалзал өгөв.
3. Фондын номын эдэлгээг уртасгах зорилгоор 642 ширхэг номыг сэлбэн засаж уншлага үйлчилгээнд гаргалаа.
4. Сонин сэтгүүлийн уншлагын заалаар 68 сонин, 18 сэтгүүлээр уншигчдад үйлчилсэн байна.
5. Иргэд олон нийтэд хүрч ажиллах үүднээс зөөврийн номын санг гэрээний дагуу Шүүхийн Шийдвэр гүйцэтгэлийн албанд үйлчилгээ үзүүлэн нийт 45 ирцэд 84 ном олголт хийж ажиллаа.
6. Монгол ёс заншил, Шинэ номын үзэсгэлэн, Дэлхийн хүүхдийн номын өдрөөр англи номын үзэсгэлэн, Хүүхдийн номын үзэсгэлэн, Үндэсний бичиг үсгийн баяраар ховор номын үзэсгэлэн, Хичээлийн шинэ жил номын үзэсгэлэн, Номын баяр -2020 ажлын хүрээнд шинэ номын үзэсгэлэн, Нээлттэй хаалганы өдөрт ховор болон гадаад номын үзэсгэлэн, Соёлын цаг аяны хүрээнд хүүхдийн болон ховор номын үзэсгэлэн, Чингис хааны бахархалын өдөрт зориулсан номын үзэсгэлэн тус тус гарган байгууллагын цахим хаяганд байршууллаа.

Хөл хорио цээрийн үед уншлага үйлчилгээ хаасантай холбогдуулан цахим хаягаараа дамжуулан 50-70 нэр төрлийн үлгэр, сургамжит өгүүллэгүүд байршуулан цахим уншлагын үйлчилгээ үзүүллээ. 12 сарын 07-нд номын санд ирсэн хамгийн сүүлийн үеийн шинэ номоор Live хийж уншигчдад сурталчилж шинэ номын

Live мэдээг 954 хүн үзсэн байна.

Номын үзэсгэлэн



3. ФОНД, КАТАЛОГИ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2020 онд шинээр улсын төсвөөр 56 нэр төрлийн 773 ш 11150900 төгрөгийн шинэ ном, бэлэг хандиваар 21 нэр төрлийн 222 ш 2802300 төгрөгийн ном нийт 77 нэр төрлийн 995 ш 13953200 төгрөгийн шинэ номоор фонд баяжилт хийн уншлага үйлчилгээнд гарган уншигчдад үйлчилж байна. Фондын чийгшилт номын хадгалалтыг сайжруулан ажиллаж байна. 11-12 нэр төрлийн 448000 төгрөгийн сонин, сэтгүүл захиалан нэгж болгон үдэж уншлага үйлчилгээнд гарган уншигчдад үйлчилж байна. Манай аймаг хэвлэлийн хуудсанаа орон нутгийн картын санд Монголын мэдээ сонин -3 , Өдрийн сонин -2, Монголын үнэн сонин -1 материал түүвэрлэн баяжилт хийн байрлуулав. Соёлын гавьяат зүтгэлтэн С.Пүрэв, Р.Чулуун, Б.Дашзэвэг, Ч.Сонгино, Ч.Лодойдамба, М.Цэдэндорж нарын нэрэмжит шагналт зохиолч З.Гүнсэн, хүүхдийн зохиолч Ж.Дашдондог, зохиолч Д.Урианхай нарын амьдрал уран бүтээлээр бүртгэн мэдээлэх ном зүйн бүртгэл хийлээ. Говь-Алтай аймгаас төрөн гарсан төрийн соёрхолт, эрдэмтэд, гавьяатууд, хөдөлмөрийн баатруудын намтар судалгааг гаргаж Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүллээ.

4.СУРГАЛТ, АРГАЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Нийтийн номын сангийн захирал Э.Оюунгэрэл ахлагчтай номын сангийн баг 2020 оны 10-р сарын 19-26 хооронд Улаанбаатар хотод Үндэсний төв номын сан, УБ хотын номын сан, Хүүхдийн номын ордон, Төв аймгийн Нийтийн номын сангуудтай туршлага солилцон, Номын санч мэдээллийн ажилтаны 7-р зөвлөгөөн болон урлаг спортын наадамд оролцлоо.
Үндэсний номын сангийн арга зүйч Б.Сарандэлгэр байгууллагынхаа үйл ажиллагаа болон фонд тасгуудтай танилцуулав.

ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОНД

УБ ХОТЫН ТӨВ НОМЫН САН

“Mongolian library update” улсын зөвлөөнийг Монголын номын сангуудын консорциумоос 2014 оноос эхлэн жил бүр дотоодын номын сангууд болон номын санч, мэдээллийн ажилтнуудад тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, гарцыг эрэлхийлэх, дуу хоолойгоо нэгтгэх, асуудлыг шийдвэрлэх зорилгоор салбарынхаа төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирсэн түүхтэй. Энэ удаагийн “Mongolian library update-2020 “ улсын 7-р зөвлөгөөнийг Монгол Улсын Соёлын Яам, Монголын Номын сангуудын Консорциум, Дотоод хэргийн их сургуультай хамтран 2020 оны 10-р сарын 23-нд Дотоод хэргийн их сургуулийн төв номын санд зохион байгууллаа.

Номын санч, Мэдээллийн ажилтнуудын “Mongolian library update-2020 “ улсын 7-р зөвлөгөөнийг нээж Соёлын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Эрдэнэбат,Соёлын яамны Соёл гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэг, Дотоод хэргийн сургалт эрхэлсэн дэд захирал доктор Д.Эрдэнэбаатар, МНСК-ын гүйцэтгэх захирал Ч.Мөнх-Эрдэнэ нар үг хэллээ.



Нээлтийн үеэр Солонгосын KSLA Мэргэжлийн номын сан холбооны ерөнхийлөгч Oh Jeong Hoon цахимаар мэндчилгээ дэвшүүлж чуулганы үйл ажиллагаанд амжилт хүслээ. Зөвлөгөөнд хот хөдөөгийн 65 гаруй номын сангийн төлөөлөл болох 200 номын санч, мэдээллийн ажилтнууд оролцлоо. Мөн зөвлөгөөнд МУ-ын Үндэсний номын сан, УБ хотын төв номын сан, их дээд сургууль, мэргэжил сургалтын төв, ерөнхий боловсролын сургуулийн номын сан, хувийн хэвшлийн байгууллагын номын сан, орон нутгийн 19 нийтийн номын сангийн төлөөлөл оролцов. Мөн бусад холбогдох байгууллагын төлөөллүүдийг оролцуулснаараа онцлог боллоо.

Зөвлөгөөний үеэр МУ-ын Үндэсний номын сан, Хүүхдийн төв номын сан, УБ хотын төв номын сан, Удирдлагын академи, ШУТИС, СУИС, МУБИС-ийн номын сангаас үнэт ховор болон шинэ номын үзэсгэлэн гаргасны зэрэгцээ номын санд нэвтэрч буй шинэ техник технологийн үзэсгэлэн, Монголын номын сангийн салбарын 2019 оны “ОНЦЛОХ 10” номинацаар тус тус үзэсгэлэн гаргаж танилцууллаа. Энэ үеэр Интерном номын их дэлгүүр өөрийн номын үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Зөвлөгөөний 2-р хэсэг: Энэ хэсгийн зохион байгуулалтын онцлог бол зөвлөгөөнд оролцогчдын оролцоог хангах зорилгоор 5 сэдвийн хүрээнд панел хэлэлцүүлгийн хэлбэрээр зохион байгуулсан. Панел хэлэлцүүлэгийн сэдэв чиглүүлэгчид:

- Номын сангийн эрх зүйн орчин- Соёлын яам Б.Баяраа, АШУҮИС-ийн номын сан Т. Лувсаннямаа
- Хүний нөөц-мэргэжлийн үнэлэмж УБ хотын төв номын сан Д.Индра, Хүүхдийн төв номын сан Г.Буянцэцэг
- Номын сангийн мэдээллийн технологи- МУБИС-ийн номын сан Ж.Баатарсүрэн, ШУТИС-ийн номын сан О.Ариунжаргал
- Сургалт арга зүй хөгжил -Үндэсний номын сан Г.Гүнжинлхам, Б.Сарандэлгэр
- Бүтээлч санаачлага инноваци- УБ хотын төвномын сан М.Цэнгэл, МҮИС-ийн номын сан Б.Эрдэнэ

Хэлэлцүүлэгийн хэсэгт номын санч нар өөрсдийн санал бодлоо солилцон харилцан ярилцлаа.

Номын санчдын зөвлөгөөний үеэр зохион байгуулсан 5 салбар хэлэлцүүлгийн үр дүнг санал, зөвлөмжийг нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргэх юм. Энэ удаагийн зөвлөгөөн нь оролцогчдын идэвх оролцоог хангаж, зохион байгуулалтын хувьд илүү боловсронгуй, үр дүнтэй үйл ажиллагаа болсныг оролцсон номын санч нар талархлаа илэрхийллээ.

Монголын номын сангуудын албан хаагчдын дунд уламжлал болгон зохион байгуулдаг спортын таван төрөлт тэмцээн энэ жил Төв аймагт 10-р сарын 24-25-ны өдрүүдэд боллоо. Тус тэмцээн нь номын сангийн албан хаагчдыг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх, мэргэжлийн түвшинд харилцан туршлага солилцох болон хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм. Уг тэмцээнийг Төв аймгийн нийтийн номын сан болон аймгийн спортын холбоод, Монголын Номын сангуудын консорциум хамтран зохион байгуулсан бөгөөд албан хаагчид гар бөмбөг,сагсан бөмбөг, дартс, теннис, шатар гэсэн төрлөөр хурд хүч,авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Тэмцээний нээлт

Тэмцээн 2 өдөр амжилттай болж өндөрлөлөө. Нийлбэр дүнгээр тэргүүн байрт Үндэсний батлан хамгаалах их сургуулийн хамт олон, дэд байрт Төв аймгийн хамт олон, гуравдугаар байрт Орхон аймгийн баг тамирчид тус тус шалгарлаа. Нийтийн номын сангийн хамт олон Эмэгтэй, эрэгтэй холимог, Эмэгтэй дан төрлөөр гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцлоо. Теннисний тэмцээнд эмэгтэй төрөлд Дарив сумын номын санч М.Ганчимэг 3-р байрт шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулав .

5.СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

1. ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙН ӨДӨРТ:

Шинэ үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойн хүрээнд уншигч хүүхэд багачуудын дунд 1-р сарын 14-ны өдөр АХА тэмцээн, үндсэн хуулийг сурталчлах зорилгоор “Үндсэн хуулийг хэн сайн мэдэх вэ?” чөлөөт ярилцлага зэргийг зохион байгууллаа.

2.ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨРТ: 2020 оны 04-р сарын 17-22-нд

"Дэлхийн номын өдөр"-ийг угтаж ЕБС-ийн 9-12-р ангийн сурагчдын дунд "ЯРУУ НАЙРГИЙН ЦАХИМ УРАЛДААН", 10-12-р ангийн сурагчдын дунд "ХАЙРТАЙ ХҮМҮҮСЭЭ КОРОНА ВИРУСЭЭС ХАМГААЛЪЯ" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зарлаж дүгнэлээ.

Эдгээр цахим уралдаануудыг аймгийн БСУГ-ын Монгол хэл уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтэн болон "Алтайн хөх салхи" утга зохиолын бүлгэмийн зохиолч, яруу найрагчид шүүлээ. Нийт 25 сурагчдын шүлэг ирж шүүгчдийн өгсөн онооны дарааллаар шалгаруулав.

Тэргүүн байранд 3-р сургуулийн $10^{а}$ ангийн сурагч М.Сувд-Эрдэнэ, дэд байранд Тайшир сумын бүрэн дунд сургуулийн 12 ^{а} ангийн сурагч Г. Сүхбат, гутгаар байранд Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 11 ^{а} ангийн сурагч Е.Шүр нар шалгарлаа.

Шилдэг бүтээлийн эздийг 1-3-р байр эзлүүлэн өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав.

ШҮЛГИЙН УРАЛДААНД БАЙР ЭЗЭЛСЭН СУРАГЧИД

"ХАЙРТАЙ ХҮМҮҮСЭЭ КОРОНА ВИРУСЭЭС ХАМГААЛЪЯ" сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд 14 сурагчийн эсээ ирж, шүүгчдийн онооны дараалаар шалгаруулав.

Тэргүүн байранд Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн $11^{б}$ анийн сурагч А.Уртнасан, дэд байранд Есөнбулаг сумын улсын тэргүүний 1-р сургуулийн $12^{в}$ ангийн сурагч Б.Сэржмядаг, гутгаар байранд Чандмань сумын бүрэн дунд сургуулийн $12^{а}$ ангийн сурагч Р.Цэцэгбаяр нарын бүтээл шалгарлаа.

Шилдэг бүтээлийн эздийг 1-3-р байр эзлүүлэн өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

Говь-Алтай Нийтийн номын сан facebook хаяг дээрээ байршуулж олон нийтэд сурталчилав.

"ЭСЭЭ" БИЧЛЭГИЙН УРАЛДААНД БАЙР ЭЗЭЛСЭН СУРАГЧИД

3. ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР: 2020 оны 05 дугаар сарын 08-нд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 06 сарын 25-ны өдрийн 105-р зарлигийг хэрэгжүүлэх, ёс заншил өв уламжлалаа сурталчлах түгээн дэлгэрүүлэх зорилгоор Үндэсний бичиг үсгийн баярын өдрийг тохиолдуулж Монгол бичгийн "Уран бичлэг"-ийн уралдааныг аймгийн хэмжээнд насанд хүрэгчдийн дунд цахим хэлбэрээр зарлаж дүгнэлээ. Хөл хорио ариун цэврийн дэглэмийг баримталж бүтээлүүдийг Говь-Алтай Нийтийн номын сан facebook хаягаараа хүлээн авч цахимаар ирсэн бүтээлүүдийг мэргэжлийн шүүгчээр шүүлгэж байр эзлүүллээ. Уралдаанд 13 бүтээл ирснээс "Уран бичлэг"-ийн уралдааны тэргүүн байрыг

Есөнбулаг сумын 4-р сургуулийн Монгол хэл уран зохиолын багш Б.Баярмаа, дэд байрыг МУИС-ийн Монгол хэл уран зохиолын ангийн 4-р курсын оюутан Б.Дааваням, гутгаар байрыг Дэлгэр сумын Бүрэн дунд сургуулийн Монгол хэл уран зохиолын багш Л.Бадамгарав нар эзэллээ.Шагналыг Нийтийн номын сангийн захирал Э.Оюунгэрэл гардуулан өглөө.

Уралдааныхаа шагналт байр эзэлсэн бүтээлүүдийг цахимаар олон нийтэд сурталчиллаа. Мөн номын сангийнхаа сан хөмрөгт хадгалагдаж буй ховор хуучин судар номын үзэсгэлэн гаргалаа. Энэхүү үйл ажиллагааг Монгол телевиз болон Алтай радиогийн өргөн нэвтрүүлгийн сувгаар дамжуулан олон нийтэд мэдээллээ.

4. НОМЫН БАЯР: 2020 оны 09 дүгээр сарын 08-нд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158-р зарлигийн хэрэгжилтийг хангаж биелүүлэх, хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, оюунлаг Алтайчуудыг бий болгох зорилгоор аймгийн Нийтийн номын сан “Аз хур” ХХК-тай хамтарч 2020 оны 09 сарын 08-ны 09-22 цагийн хооронд аймгийн Спорт цогцолборт 20, 40, 72 хувийн хямдралтай номын үзэсгэлэн худалдаа, Нийтийн номын сангийн Хүүхдийн уншлагын танхимаас “Шинэ ном”-ын үзэсгэлэн, Үндсэн фонднoос “Ховор ном”-ын үзэсгэлэн гаргаж уншигчдад танилцууллаа.

“НОМЫН БАЯР-2020” арга хэмжээний нээлтэнд Аймгийн Засаг даргын орлогч Я.Эрхэмбаяр, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Алтайбаатар, Нийтийн номын сангийн дарга Э.Оюунгэрэл нар үг хэлж мэндчилгээ дэвшүүлэн нээлээ. Мөн Говь-Алтай аймгийн

зохиолчдын Алтайн хөх салхи нэгдлийн яруу найрагчид өөрсдийн уран бүтээлээс үзэгч түмэнд уншиж сонирхууллаа.

Энэ үеэр “Аз хур” ХХК-аас 18 сумын Соёлын төвийн номын сангуудад нийт 1,800,000 төгрөгийн номын хандив өргөж сумдын номын санч нарын төлөөлөл Баян-Уул, Бигэр, Дэлгэр сумдын номын санчдад гардуулан өглөө. Тус үзэсгэлэн худалдаанд аймгийн төвийн 2000 гаруй ард иргэд, уншигч хүүхдүүд хамрагдаж, 8,000,000 сая гаруй төгрөгийн ном хэвлэлийн худалдан авалт хийгдлээ.

Алтайчууд маань энэ өдөр өргөн сонголттой хямдралтай номоор үйлчлүүлж оюуны цангаагаа тайлсан сайхан арга хэмжээ боллоо.

Хөл хорио ариун цэврийн дэглэмийг баримтлан хүн бүрийн халууныг хэмжиж, амны хаалт зүүлгэж, гарыг нь ариутган оруулж мөн аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчид хяналт тавьж ажиллалаа.

Хүрэлцэн ирсэн сумдын төлөөлөлд тус бүр 100,000 төгрөгийн ном гардууллаа.

Хорио цээрийн дэглэмийг баримтлан үйлчлүүлэгчдийн халууныг үзэж, маск зүүлгэж, гарыг нь ариутган орууллаа.

Хүүхдийн уншлагын танхимын шинэ номоор үзэсгэлэн гаргалаа.

Үндсэн фондны “Ховор ном”-ын үзэсгэлэн

Үзэсгэлэн худалдааны үеэр

5. АХМАДЫН БАЯР: 2020 оны 09 дүгээр сарын 28-нд

Ахмадын баярын өдөрт зориулсан Ахмадад ээлтэй номын сан өдөрлөгийг зохион байгуулав. Тус өдөрлөгт 50 орчим ахмадууд оролцож номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээ сан хөмрөгтэй танилцав. Энэ арга хэмжээний үеэр сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэн гарган, Алтайн Хөх салхи уран бүтээлийн нэгдлийн зохиолч яруу найрагчтай уншигч зохиолчдын уулзалт хийлээ. Өдөрлөгт оролцсон хамгийн өндөр настай ахмадад гарын бэлэг гардуулав.

А
Б

АХМАДЫН БАЯРЫН
МЭНД ХҮРГЭЕ
ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ
ЭЭЖҮҮДЭД ТОХИРОХ БИЗНЕС САНААНУУД
ГЭРИЙН НӨХЦӨЛД НАРИЙН БООВ ХИЙЖ СУРАХ АРГА
ГЭР ОРОН АХУЙ АМЬДРАЛД ЧИНЬ
Б.ДУНГААМАА
ХҮҮХДИЙН ХУВЦАС
ГЭР АХУЙН ЛАВЛАХ
09 2020

6. СОЁЛЫН ЦАГ: 2020 оны 10-р сарын 29-нд

Соёлын цаг аяны хүрээнд шинэ номын болон ховор номын үзэсгэлэн гарган Индэрт, Баяншанд багийн иргэдийг хамруулж шинэ номын үзэсгэлэн гаргаж номын сангийн үйл ажиллагаатай танилцуулан 12 иргэдэд карт нээж номоор үйлчилсэн.

7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ӨДӨРТ: 2020 оны 12 дугаар сарын 11-нд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан шүлгийн уралдааны удирдамжийг Нийтийн номын сангийн Fasebook хаягт байршуулан 2020 оны 12 дугаар сарын 9-11-ны хооронд зарлан шүлгийг цахим болон бичвэр хэлбэрээр авч шалгаруулсан. Тус уралдаанд 15 шүлэг ирүүлсэнээс 1-р байр Ш.Ариунаа, 2-р байр Д.Нэргүй, 3-р байр М.Цамбацэрэн нар тус тус шалгарч Өргөмжлөл дурсгалын зүйлээр шагнав. Шүлгийн уралдааныг “Алтайн хөх салхи” бүлгэмийн яруу найрагчид шүүж явууллаа.

8. АЛТАЙН СОЁЛЫН ЦАГ: 2020 оны 12 дугаар сарын 9-нөөс

12-р сарын 9-нээс эхлэн Алтайн соёлын цаг аянд нэгдэж Говь-Алтай аймагт ажиллаж амьдарч байгаа зохиолч яруу найрагчдын уран бүтээлийг сурталчилах “Яруу найргийн цаг” Live-ийг орой бүрийн 20 цагаас хүргэж байна.Одоогоор 9 удаагийн дугаарыг хүргэж 9 яруу найрагчидтай уулзалт хийж 23750 хүн үзсэн байна.

6.ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Байгууллагын гадна талд: 1985 оны 8-р анги, 1987 оны 10-р ангийн нийт төгсөгчид өөрсдийн санаачлагаар байгууллагын гадна гэрэлтүүлэг,зүлэгжүүлэлт, сандал, хогийн сав хийж байрлуулан хүлээлгэж өглөө.

Хүүхдийн уншлагын танхимыг эрдэмтэн зохиолч Ч.Лодойдамбын зээ охин, Лодойдамба сангийн тэргүүн Л.Энхнасан 22,373,440 төгрөгийн хөрөнгө оруулалтаар иж бүрнээр тохижуулж хүлээлгэн өглөө.

Коридорт уншигчдад зориулан НҮБ-ын хүүхдийн сангийн ариун цэвэр,ус хангамж, эрүүл ахуйн хөтөлбөрөөс 400,0 төгрөгийн санхүүжилтээр ус цэвэршүүлэгч суурилуулж өглөө.

Өрөө, танхимуудад шинээр самбар, 1,2-р давхарт галын булан, хаягжуулалт хийн байршууллаа.





Бүх өрөө, танхимууд, фонд, коридорын цонхнуудад хөшиг хийлээ.




Үүдний өрөөнд уншигчдын хувцасны өлгүүр, Гэрээр ном олгох тасагт чөлөөт сонголтын номын тавиуруудыг хийлгэж байрлуулав.



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ:

Нийт 22134 уншигчдад 26100 ном олгож үйлчилсэн . Үүнээс:

Уншигч:

- Байнгын 9300 уншигч
- Цахимаар-10800 уншигч
- Шинээр 2034 уншигчдад карт нээж уншигчийн соронзон үнэмлэх олгосон.

Ном олголт:

- Танхимаар 11757 ширхэгном
- Гэрээр 1068ширхэг

Цахимаар -13275 ширхэг ном

1.1 ЗӨӨВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Номын санд биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй өндөр настай, өвчтэй, Хөгжлийн бэрхшээлтэй 48 уншигчид 125 ширхэг ном, хэвтрийн 5 иргэнд 91 ширхэг ном, Өндөр настан 329 Ахмадад 441ширхэг ном Нийт 382 уншигчдад657ширхэг ном хэвлэл олгож үйлчиллээ.

1.2. ХӨДӨӨГИЙН БАГИЙН ИРГЭДЭД НҮҮДЛИЙН НОМЫН САНГААР ҮЙЛЧЛЭХ:

Хөдөөгийн 4,5,6-р багийн иргэдэд нүүдлийн номын сангаар үйлчиллээ. 95 өрхийн 502 уншигчид 617 ширхэг ном олгож үйлчилсэн. 74 иргэнд шинээр карт нээж, үлгэрийн, танин мэдэхүй, уран зохиолын ном, сонин сэтгүүлийг уншуулж, Ном унших арга, Номын ашиг тус, Хүүхдээ хэрхэн номонд дуртай болгох вэ? Хүүхдээ ном уншуулж сургах шилдэг арга, зэрэг гарын авлага өгч мэдээллээр хангаж ажиллалаа.

1.3.ФОНДЫН САН ХӨМРӨГИЙГ ШИНЭ НОМ ХЭВЛЭЛЭЭР БАЯЖУУЛАХ, ЭЛЕКТРОН КАТАЛОГТ ОРУУЛАХ.

Номын фондын сан хөмрөгийг 83 нэр төрлийн 549 ширхэг 9.187.787 төгрөгийн ном хэвлэлээр баяжуулсан. Үүнээс:

- Төсвийн хөрөнгөөр 34 нэр төрлийн 166 ширхэг 374.700 төг
- Хандиваар 35 нэр төрлийн 139 ширхэг 827.607 төг
- Хөрөнгө оруулалтаар 14 нэр төрлийн 244 ширхэг 4.985.480 төг

1.4. АУДИО, СОНСДОГ НОМ БОЛОН ЦАХИМ НОМЫН ҮЙЛЧИЛГЭЭ:

Хөгжлийн бэрхшээлтэй 25 уншигчийн Дизи сонсдог төхөөрөмжинд 360 ширхэг ном суулгаж өгч уншуулсан.

1.5. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ:

- “Ном эрдэм 2 сарын аян зохион байгуулж Нийт 12000 уншигчдад 14000 ширхэг ном олгож үйлчилсэн.
- “Боржигидай хүү” хүүхдийн яруу найргийн цахим уралдаанд зохион байгуулсан Нийт 24 уншигч оролцсон.
- Үндэсний бичиг үсгийн баярыг угтаж “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО-МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛД” цахим хэлэцүүлэгийг соёл урлагийн

байгууллагууд болон гэр бүлүүдийн дунд зохион байгуулсан. Нийт 300 иргэн оролцсон. 1,2-р бүлгийн 104 зүйлийг 11000 уншигч уншиж хамрагдсан.

- "Хамгийн олон ном уншсан багш" цахим уралдаан зохион байгуулж Нийт 24 багш хамрагдсан.
- Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг цахимаар 42 удаа зохион байгуулж 2140 иргэн хамрагдсан.
- "Номын баяр" Нийт 615 уншигч хамрагдсан. Номын баярын хүрээнд "Номын булан байгуулах" уралдаанд 14 албан байгууллага оролцон номын булан байгуулсан.

  Номын булан байгуулсан байгууллагуудад очиж шторк бичлэг хийж өөрийн цахим хуудсаар уншигч иргэдэд сурталчилсан.
- "Миний уншсан ном" уралдааныг зохион байгуулж оролцогчдын өөрийн уншсан номын тухай цахим бичлэгийг олон нийтэд шторкоор хүргэсэн.
- **Хөгжлийн бэрхшээлтэй, Харааны, зорилтот бүлгийн хүүхдүүд иргэдийн дунд** "Номын сайн нөхөр" сарын аяныг зохион байгуулж 261 уншигчид 1160 ном олгож үйлчилсэн.
- Боржигидай сэцэн яруу найргийн наадам 24 яруу найрагч оролцож 200 үзэгч үзэж.
- Хүүхдийн зохиолч Г.Зоригт, Ж.Тунгалаг З.Билэгбаяр, Р. Батжаргал "АЛТАН НАМАР" зохиолч уншигчдын уулзалтыг зохион байгуулсан.

2. МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАХ:

Сумдын соёлын төвийн номын сангуудыг Мэргэжил арга зүй, Захиргааны удирдлагаар хангах төлөвлөгөөний дагуу Баянтал сумын соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, сургалт зохион байгуулж мэргэжил арга зүй, гарын авлагаар хангаж зөвлөгөөг өгч ажилласан. Үүнд:

- Номын сангийн салбарт баримталж буй журам, эрх зүйн баримтууд
- Шинэчлэгдсэн стандарт
- Лавлагаа ном зүйн бичилт
- Номын сангийн каталог түүний зохион байгуулалт сэдвээр сургалт зохион байгуулсан.

Номын санд хөтлөгддөг анхан шатны бүртгэл хөтлөлт ангилал ном зүйн бичилтийг шалгаж нэг бүрчилсэн бүртгэл нэгдсэн бүртгэл, өдөр тутмын бүртгэлийн алдааг засаж залруулан арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Мөн Номын сангийн Монбиблио программыг 2018 оноос хойш хөтлөгдөөгүй лиценз дууссан байсныг ярьж программ хэвийн ажиллагаанд оруулж өгсөн.

Сурагчдын

- *“*Унших чадварыг хөгжүүлэх арга барилууд*”*,
- *“*Унших арга барил*”*-ын
- Унших арга барил тухай ойлголт
- Унших арга барил буюу чадварыг хөгжүүлэх
- Уншлагын дараа юу хэрэгтэй вэ?
- Унших чадварыг хөгжүүлэхэд цахим орчинг ашиглах
- Номын санч Багш нар юу хийх хэрэгтэй вэ? Зэрэг гарын авлагуудыг боловсруулж өгсөн*.*

Номын сангийн шинэчлэгдсэн стандарт, Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын талаар чадавхижуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг бүх шатны номын санч нарт зохион байгуулсан.

3. НОМ ХЭВЛЭЛИЙГ ЦАХИМ ХУУДСААР БОЛОН ГАРЫН АВЛАГА ҮЗҮҮЛЭН ТАНИУЛАХ АРГААР СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ:

Сан хөмрөгийн ном хэвлэлийг Говьсүмбэр номын сангийн цахим хуудсаар өглөө бүр 8.30 д 10.00 11.50 14.00 15.00 16.30 цаг тус бүр тухайн цаг үеийн үйл ажиллагааны мэдээллүүдийг гарын авлага шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнгээр сурталчлан таниулсан.

Нийт 1330 мэдээллийг тавьж 13700 уншигч хандалт хийсэн байна.

Өмгөөлөгч сэтгүүлээс 60 материалыг Зотеро программд оруулж ном зүйн нэгдсэн лавлагаа мэдээллийн санд байршуулсан.

4. ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙГ КИРИЛЛ БОЛОН МОНГОЛ БИЧГЭЭР ХӨТӨЛДӨГ БОЛСОН БАЙХ, АЛБАН ХААГЧДАД СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ, БҮТЭЭЛЧ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЭВШҮҮЛЭХ.

Өглөө бүрийн 10 цагт зүйр цэцэн үг, уриалсан, сургамжит мэдээлэлүүдийг Монгол бичгээр оруулж хэвшсэн.

Албан хаагчдад монгол бичгийн сургалтыг явуулж нийтээрээ монгол бичигтэн болсон.

Соёл урлагийн ажилтны баярын өдрийн тохиолдуулан ажилчдын дунд танин мэдэхүйн цэнгээнт уралдаан зохион байгуулсан. Нийт 10 албан хаагч оролцсон.

Арга зүйч Д.Нарнай “үндэснийномын сан арга зүйн төв болох” нь

Ном-Зүйч Сан-Хөмрөгч А.Чимэгмааг Нийтийн номын сангийн ангилагч каталогч нарт зориулсан онлайн сургалтанд

Номын сан мэдээллийн ажилтан Т.Оюундэлгэр LIB4 программ болон комьютерийн дунд шатны сургалтанд

Монгол бичгийн сургалтанд 10 ажилтан хамрагдсан.

Нярав Ш.Түмэннаст архив бичиг хэргийн сургалт

Covid-19 Эрүүл мэндийн сургалт , “Хамт олны соёл” сургалт, Жолооч харуул хөтөчийн сургалт, үйлчилгээний соёл бариста, тогооч, гэх мэт Нийт 20 сургалтанд албан хаагчид тус бүр хамрагдсан.

Ажилчдын эрүүл хөдөлгөөн чөлөөт цагаа өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан нийтийн цэнгээнт бүжгийн “Хос эгшиглэн” бүжгийн холбоонд албан хаагчдыг элсүүлэн 4х4, 4х3 4х2 16тоот зэрэг бүжгийн хөдөлгөөний сургалтанд бүх албан хаагчдыг хамруулсан.

Өдөр тутмын идэвхтэй хөдөлгөөн 30х30 сарын аяны хүрээнд дасгал хөдөлгөөн сурах төлөвлөгөө боловсруулан сургалт зохион байгуулсан.

5. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД:

- "БОРЖИГИН ӨВ СОЁЛ,ГОВЬСҮМБЭР 25 ЖИЛ "ЦАГ ТООНЫ БИЧИГ
- "ХУЛГАНА ЖИЛИЙН ХУАНЛИ" ШИРЭЭНИЙ ЦАГЛАБАР

Энэхүү цаглабар нь Говьсүмбэр аймгийн ИТХурлаар батлагдсан есөн гайхамшигт газрын зурагтай, тухайн газар бүрт зориулагдсан "Боржигидай сэцэн" салбарын яруу найрагчдын шүлэгтэй хэвлэгдсэн.

- ЧОЙРЫН УУЛЫН САН" ТАНИЛЦУУЛГА НУГАЛБАР:

Тус нугалбарт Чойрын богд ууланд байдаг Цагаан дарь эх бурхан, Дагвасүндэл бурхан, Хүүхдийн цагаан овоо, Цагаан өвгөн буюу Цэрэндүг бурхны зурагтай, кириллээр бичсэн тарнитай, мөн Сэрдог номун гэгээн Чүлтэмжамцын зохиосон Чойрын уулын санг кириллээр бичигдсэн.

- ЦАЦ ХЭЛБЭРТЭЙ ГАР УТАСНЫ ТҮШЛЭГ ТАВИУР

- ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР зэргийг хийсэн.

Байгууллагын Уншлагын заал, Ойрын болон Үндсэн фонд ажилчдын өрөөнд
4 ширхэг 1,200,000 төг камер,

Номын фондын сан хөмрөгийг 83 нэр төрлийн 549 ш**ирхэг** 9.187.787төгрөгийн ном хэвлэлийг тус тус үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.

Ил тодын самбар болон байгууллагын вэб сайт шилэн дансанд мэдээллийг 12 удаа байршуулсан.

Уншлага үйлчилгээний үйл ажиллагаа ,Архивын стандартын хэрэгжилт, Няравын үйл ажиллагаа, Байгууллагын санхүүгийн ил тод байдал, Шилэн дансны мэдээлэл, Арга зүйн ажилд тус тус дотоод хяналт шалгалтыг хийсэн.

6. АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Ажилчин, албан хаагчдад унаа, хоолны зардалыг тухайн жилийн төсвийн хүрээнд хоолны зардалд өдөрт-1500 Унааны зардалд өдөрт-1500 төгрөг ажлын өдрөөр тооцон сар бүр олгож 4,284,000 төгрөг зарцуулсан.
- Номын сан мэдээллийн Ажилтан Т.Оюундэлгэрт тухайн албан тушаалын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан тул суралцах хугацааны албан тушаалын цалинг **.олгосон**
- Номын санч мэдээллийн ажилтан Б.Аасүрэн, М.Аюушжав нарт Хүүхэд төрүүлэхэд тус бүр 800**00**төгрөгний дэмжлэг үзүүлсэн.
- Шагнал урамшуулал, ур чадварын хэмжээг жилийн төсөвт багтаан ажилтан, албан хаагчдад урамшуулал, ур чадварын нэмэгдэлд 12.677.071 төгрөгийг олгосон.
- Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэлийг Захирал Б.Энхтөр , Арга зүйч Д. Нарнай, Ном зүйч-Сан хөмрөгч А.Чимэгмаа, нарт олгож байна.

- Албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлийг Захирал Б.Энхтөр, Арга зүйч Д.Нарнай, Нягтлан бодогч Ц.Цогзолмаа, Нярав-Архивч, үйлчлэгч Ш.Түмэннаст,Ном зүйч-Сан хөмрөгч А.Чимэгмаа, Харуул жолооч Ш.Отгоншагдар нарт олгож байна.

Тайлан бичсэн: **Арга зүйч Д.Нарнай**

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2020 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого шийдвэрийг Аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, БСШУС-ын сайдтай Аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтийг бүрэн биелүүлэх, номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, уншигчид бие даан боловсрол эзэмших, номын санг мэдээллийн төв болгон хөгжүүлэхэд ном тойрсон соёл танин мэдэхүйн олон арван ажил, арга хэмжээг зохион байгуулж, оюутан сурагчид, иргэд, уншигчдын оролцоог нэмэгдүүлэхийн төлөө бүхий л ажлаа чиглүүлэн цагийн нөхцөл байдалд тохируулан ажлын арга хэлбэрээ өөрчлөн /Ковид-19/, хамт олноо удирдан зохион байгуулж боломж бололцоо бүхний гаргалгааг олж номын сандаа таатай орчинг бүрдүүлж иргэд уншигчдынхаа хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор цахим орчин бүрдүүлэн ном хэвлэлээ сурталчилан амжилттай ажиллаж байна.

<u>НЭГ. УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЛААР.</u>

Аймгийн Төв номын сан нь Номын сангийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, БСШУСЯам, орон нутгийн засаг захиргаа, нутгийн удирдлагын байгууллагуудаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж БСШУСЯам, Үндэсний номын сан, номын сангуудын консерциум болон орон нутгийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавруудад хариуцлага санаачлагатай хандан хамтран ажиллаж ирэв.

Аймгийн төв номын сан нь 2020 онд 15 ажиллагсадтай, 2 салбар номын сантайгаар, орон нутгийн уншигч иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж байна.

2020 оны жилийн төсөв 344 704 700 төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл 346 950 900 төгрөг байна.

2020 оны 11-р сарын байдлаар

Утга	Төсөв	Гүйцэтгэл
Цалин хөлс	174 876 300	170 153 494
Нийгмийн даатгал	21 846 700	21 846 700
Байр ашиглалт	3 320100	2 176 803
Хангамж бараа	10 393 000	8 499 577
Ном хэвлэл	1 618 600	1 081 400
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	2 390 600	2 241 612

- ✓ Өөрийн үйл ажиллагааны орлого жилд ***360 000*** төгрөг батлагдсанаас байгууллагын үйл ажиллагаанаас ***360 000*** төгрөг орлогод оруулсан. Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын ЗГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.
- ✓ 2020 оны жилийн эцсийн байдлаар өр авлагагүй гарлаа.
- ✓ Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах үүднээс “Шилэн дансны болон төсөв санхүүгийн ил тод байдал” самбарыг цаасан болон цахим хэлбэрээр тогтмол ажиллуулж номын сангийн төсвийн нээлттэй байдлыг ханган ажиллаж байна.
- ✓ Төрийн байгууллагуудын нэгдсэн **Эйбл** программаас шаардлагатай мэдээ мэдээллийг тогтмол авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

<u>ХОЁР. ФОНД, БҮРДҮҮЛЭЛТ, КАТАЛОГИ</u>

Ном бүрдүүлэлтийг “Номын сангийн хууль” болон ном худалдан авах журмын дагуу татгалзлал, уншигчийн судалгааг үндэслэн номын худалдаа, зохиолч, уран бүтээлчид, ард иргэдийн хандив, тусламж зэргээр фондоо бүрдүүлж ирлээ.

2020 онд худалдаагаар 54 боть 1 081 400 төгрөг, хандиваар 171 боть 2505 780 төгрөгний ном хэвлэлээр фондоо бүрдүүллээ. Үүний ***615 600*** *төгрөгний* *10* нэр төрлийн тогтмол хэвлэлийн захиалга хийж, уншигчдын хүртээл болгоод байна.

Ном бүрдүүлэлтээр шинэ ном худалдан авсан мэдээ

д/д	Ямар журмаар авсан	Нэр төрөл	Боть	Бүгд үнэ
1	Худалдаагаар	4	44	465 800
2	Хандив тусламж	150	171	2 505 780
3	Тогтмол хэвлэл	6	10	615 600
	Нийт	**160**	**225**	**3 587 180**

“Хүмүүн бичиг”, “Засгийн газрын мэдээ”, “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонин, “Боловсрол судлал”, “Эрүүл мэнд”, “Төрийн мэдээлэл”, “Өрхийн үйлдвэрлэл” зэрэг сонин сэтгүүлийн **80 багцийг** тогтмол хэвлэлийн дансанд бүртгэн авч, үндсэн хөрөнгөнд бүртгэлээ.

2020 онд орос хэл дээрх ***5293 нэр*** төрлийн **5405 боть 3542 768** төгрөгний номыг фонднoос зөөвөрлөн, ариутган цэвэрлэж, нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэн номын сангийн Lib-4U программд 100% оруулж дуусгалаа. Үндсэн хөрөнгөнд нийтдээ 7909 нэр төрлийн 8120 боть 6304288 төгрөгний орос номыг бүртгэн оруулсан нь “Ковид-19” цар тахлын хөл хориотой байх үед ажлын цагийг үр ашигтай ашиглаж өөрсдийн нөөц боломцоог зөв хувиарлан ажиллалаа гэж үзэж байна.

<u>Тооллого:.</u>

БСШУ-ны сайдын 180, 441, Сангийн сайд, БСШУ-ны сайдын хамтарсан 357/406 тоот тушаалыг хэрэгжүүлэх “Комисс томилж тооллого хийх тухай” Аймгийн Төв номын сангийн захиралын 2020 оны дугаар сарын -ны тоот тушаалын дагуу салбар номын сангийн ойрын фондны тооллогыг номын нэг бүрчилсэн данс, бар кодоор 2020 оны 05-р сарын 24-ний өдрөөс эхлэн 2020 оны 06-р сарын 08-ны өдрийг хүртэл хийж нийт 8750 нэр төрлийн 11296 боть 43595423.86 төгрөгний номыг тоолж дутагдаж алдагдсан 38 нэр төрлийн 38 боть 186844 төгрөгний номын жагсаалтыг гарган, алдаж үрэгдүүлсэн номыг уншигчдаар нь номыг номоор нь буюу утга агуулгаар ижил төстэй номоор төлүүлэхээр боллоо.

<u>Ном сэлбэн засалт:</u>

Уншлага үйлчилгээнээс ирсэн 4924 хуудас бүхий 22 боть номыг сэлбэн зассанаас 92 хуудсыг скайнердаж нөхөн гаргаж, урагдсан-11 хуудас салсан-1521 хуудсыг нааж засварлан уншлагын танхимын фондонд хүлээлгэн өглөө.

- Номын сангийн 2018, 2019 оны 5642 хуудас бүхий 54 нэр төрлийн бичиг баримтуудыг үдэж хавтаслан, байнга, түр, 70 жил хадгалах данс бүртгэл хөтлөж архивт оруулав.
- Уншлагын танхимуудаас ирсэн 2018, 2019 оны 1514 дугаар бүхий сонин сэтгүүлийг 99 нэгж болгон үдэж, хаягжуулж наан архивт шилжүүлэв.

<u>ГУРАВ. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ:</u>

Аймгийн Төв номын сан нь уншлага үйлчилгээндээ ном хэвлэлээ тогтмол сурталчилж, шинэ номын жагсаалт гаргах, ном хэвлэлийн тойм хийх, ашигтай зөвлөмж материалуудыг хувилах, онлайн хэлбэрт байршуулах, мэдээллийг түгээх зэргээр уншигчдын эрэлт хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2020 онд уншлагын танхимаар 3265 байнгын уншигч, 19539 ирэгсдэд, 25684 боть ном олгож, Коронавирусын халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт уншигчдад 2020 оны 02-р сарын 05-наас 2020 оны 06-р сарын 01-ныг хүртэл мөн 11-р сарын

12-ноос 2020 оны 12-р сарын 10-ныг хүртэл үйлчилгээ үзүүлээгүй бөгөөд энэ хугацаанд цахим үйлчилгээгээр мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээж ирлээ.

Цахимаар 2100 мэдээллийг 155341 хандалт авч, 83544 хүн хуваалцсан байна.

Төлөвлөгөөт ажлыг хүснэгтээр харуулбал:

Ажил үйлчилгээ	***Төлөвлөгөө***	***Уншлагын танхимаар***	***Цахимаар***			***Бүгд***
			Мэдээ	Хандалт	Хуваалцсан	
Уншигч	1900	3265		155 341		158 606
ирц	30 000	19539			83 544	103 083
Ном олголт	32 500	25684	2100			27784
орлого	360 000	360 000				360 000

УОК-оос өгсөн үүрэг даалгаварын дагуу ажлын хувиарыг гарган цахим уншлагаар 2100 материалыг онлайн орчинд байршуулснаар **155 341** хүн үзэж **83 544** хүн мэдээллийг хуваалцсан байна.

Мэдээллийг сэдвээр харуулбал:

1.**Цахим уншлагад нэгдэцгээе!**:

- ✓ Хөөрхөн үлгэрүүд-Дөрвөн шумуул, Хөөрхөн үлгэрүүд-Сайн нөхөр, Хөөрхөн үлгэрүүд-Ууч сэтгэл, Хөөрхөн үлгэрүүд-Сарлаг гуай, Хөөрхөн үлгэрүүд-Барилдах дуртай мөндөл, Зуун нэгэн гөлөг, Үзэсгэлэнт гүнж, Бардам ишиг, Улаан малгайт, Хавар, Намар, Зоригтой үнэг, Амьтдын лавлах, Хармагны найз аа дайлсан нь, Тооройн байшин, Гоо сайханч үнэг, Өвгөн бүргэд, Хоёр найз, Цамаан зантай баавгай

2.**Дэлхийн шилдэг үлгэр** сэдвээр: Илбийн морь, Үзэсгэлэнт Василиса, Жек ба буурцгийн мод, Харамч бирман, Гурван алтан үстэй чөтгөр, Пиноккио, Бяцхан улаан малгайт, Залхуу муур, Алибаба ба 40 дээрэмчин, Жаргалтай ханхүү, Румпельштильцхэн, Загасчны шунахай эхнэр, Бяцхан янзага

3. Зохиолчийн долоо хоног

- ✓ Цэндийн Дамдинсүрэнгийн “Намтар уран бүтээл”, “Хоёр цагаан юм”, “Чемодантай Юм”, “Зугаацахаар мордсон нь”, “Буурал ижий минь”, “Монгол нутаг”,
- ✓ Их зохиолч Дашдоржийн Нацагдоржийн намтар уран бүтээл, "Дөрвөн улирал" хэмээх 4 бүлэг шүлгийн "НАМАР", "ЗУН", "Өвөл", "хавар" шүлэг

4. Монгол ардын үлгэр

Зэргэлдээ хоёр айл, Шагдар солиот мэргэн охин, Цуутын цагаагч гүү, Азтай_бадарчин зэрэг материалыг онлайн орчинд байршуулан уншигч, иргэдээ мэдээллээр ханган ажиллаж ирлээ.



2020-02-05 өдрөөс 2020-12-03 өдрийн байдлаар фэйсбүүк хуудасны хандалтын тоон үзүүлэлт

2020 оны цахим мэдээн тоон үзүүлэлт				
			2020.11.30.	
д/д	Байгууллагын нэр	Зурган мэдээ, мэдээлэл	Хандалт /хүмүүсийн/	Шэйр хийсэн тоо, /Давтамж/
1	Цахим уншлагад нэгдэцгээе!	140	10,899	7,000
2	Дэлхийн шилдэг үлгэрүүд	60	12,000	9,500
3	**"Ковид-19"**	485	35,340	9,062
4	**"Ковид-19" 11-р сар**	701	4,251	7,450
5	**Зохиолчын долоо хоног**	145	13,620	2,800
6	**Монгол ардын үлгэр**	150	15,670	15,727
7	**Дэлхийн номын өдөрт Дэлхийн алдартай 10 зохиолч**	26	6,754	3,800
8	**Үндэсний бичиг үсгийн өдөрт**	25	7,880	3,950
9	**Онч мэргэн үгс**	135	16,200	7,580
10	**Номын ач тус**	220	31,260	16,500
11	"Миний мэргэжил хамгийн сайхан" ярилцлага	1	150	39
12	Ахмад номын санч П.Бадамхандын хөдөлмөрийг үнэлж “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулсан нь	1	156	30
13	Ногоон нүдэн лам роман	1	631	74
14	Өдөр бүр ном уншаарай	5	250	23
15	Дарханчуудаа гэртээ байцгаая	5	280	9
	НИЙТ ДҮН	**2100**	**155,341**	**83,544**

Цахимаар 2100 мэдээ, мэдээллийг байршуулж, 155341 хүн хандалт хийж, 83544 хүн хуваалцсан байна.

<u>Гэрээр ном олголт:</u>

- Өндөр настан, номын санд суух боломжгүй нийт 157 уншигчдад 249 боть номыг гэрээр олгож үйлчлэв.

<u>Зөөврийн номын сан:</u> **8** удаа **305 боть** ном олгож үйлчиллээ.

- 13-р цэцэрлэгт 115 боть ном, 18-р цэцэрлэгт 35 боть номоор, ШШГГ-ын харъяа хаалттай хорих ангид 3 удаа 76 боть номоор, ШШГГ-ын 445-р нээлттэй хорих ангид 2 удаа, 100 боть, Нийгмийн даатгалын хэлтэст 31 нэр төрлийн 34 боть, Татварын хэлтэст 41 боть номуудыг тус тус олгож үйлчилсэн байна.

<u>Урилгат уншлага:</u> Номын сангийн үйл ажиллагааг сурталчилах хүүхэд бүрийн оюуны эрэлт хэрэгцээнд хөрөнгө оруулалт хийх зорилгоор **14** ангийн **585** сурагчдыг номын санд урьж номын сангаар үйлчлүүлэх, ном унших ач тусыг танилцуулж номын сангийн уншигчаар бүртгэн авлаа.Үүнд:

- 16-р сургуулийн Хорлоо багштай 8/в ангийн 28 сурагч, 16-р сургуулийн К. Карашаш багштай 5/б ангийн 38 сурагчид, 13-р ццэцрлэгийн ахлах бүлгийн 123 хүүхэд, 18-р цэцэрлэгийн дунд бүлгийн 32 хүүхэд, Шинэ алхам сургуулийн 5а ангийн 20 сурагч, 15-р сургуулийн Тэрбиш багштай 37 сурагч, Од цогцолбор сургуулийн Оюунчимэг багштай 9б ангийн 34 сурагч, Од цогцолбор сургуулийн 9в ангийн 37 сурагч, Од цогцолбор сургуулийн 7в 34 сурагч, ОИЦ сургуулийн 5-10-р ангийн 40 сурагч, 15-р сургуулийн 3д ангийн 46 сурагч, Од цогцолбор сургуулийн Буяндүүрэн багштай 10^3-р ангийн 32 сурагч, ОИЦ-ын 4 10-р ангийн 45 сурагчид, 15-р сургуулийн 8б ангийн 39 сурагчдыг номын санд урьж номын санг танилцуулж, цаасан болон электрон каталогоос хэрхэн номоо шүүж захиалгаа өгч үйлчлүүлэх

талаар зөвлөгөө өгч бүх уншигчдад ном уншуулан уншигчаар бүртгэн авч “Ном уншихын ач тус“ сэдвээр лекц хийж өглөө.

<u>ДӨРӨВ.СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ</u>

- Зохиолч уншигчийн уулзалт 2 удаа 450 гаруй хүн
- Уралдаан - 2 удаа 93 хүн
- Лекц - 4 удаа 75 албан хаагчид, номын санчдад ***нийт 8 удаа*** СТМА-уудыг зохион байгуулан 618 албан хаагчид, сурагчид, эрх нь хязгаарлагдсан хүмүүжигчид оролцсон байна.

Зохиолч-Уншигчдийн уулзалт 2 удаа нийт 450 гаруй хүн

- ✓ МЗЭ-ийн Утга зохиолын төлөө шагналт, зохиолч, нийтлэлч П.Амаржаргалтай уулзалт хийлээ. Уулзалтанд Шинэ алхам сургуулийн 5а ангийн сурагчид, номын сангийн уншигчид, Залуучууд театрын дэргэдэх Дионес агентлагийн сурагчид, залуучууд театрын жүжигчин Баттуяа, Төв номын сангийн номын санчид оролцлоо. Уулзалтанд нийт 50 гаруй хүн оролцлоо.
- ✓ Дархан хотын 59 жилийн ойг тохиолдуулан Төрийн шагналт, зохиолч, сэтгүүлч Б.Цэнддоо, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Д.Цэвээнгэрэлтэй Залуучууд театрын бага танхимд 12 цагаас уулзалт хийлээ. Уулзалтанд ЕБС, их дээд сургууль, зохиолчид, уншигчид нийт 400 гаруй хүн оролцлоо.

Баруун гараас:Төрийн шагналт, зохиолч, сэтгүүлч
Б.Цэнддоо,
МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Д.Цэвээнгэрэл, Аймгийн

Дархан хотын 59 жилийн ойг тохиолдуулан Төрийн шагналт, зохиолч, сэтгүүлч Б.Цэнддоо, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Д.Цэвээнгэрэлтэй Залуучууд театрын бага танхимд

<u>Лекц: 4 удаа 255 албан хаагч, мэдээллийн ажилтнууд оролцов.</u>

- ✓ "Тэд яаж Харвардад тэнцсэн бэ? Лекц Залуучууд театрын дугуй танхимд (150 хүн)
- ✓ Төв номын сангийн ажилтан, албан хаагчдад "Эрүүл мэнд" сэдвээр лекц уншуулав.
- ✓ Хонгор сумын ЗДТГ-ын хамт олон, Дархан сумын 3-р багийн иргэдэд "Угийн бичиг хөтлөх арга зам" сэдвээр лекц хийж 90 гаруй албан хаагч, иргэд оролцов.

<u>Уралдаан: 2 удаа, 93 уншигч, сурагчид оролцов.</u>

✓ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ШШГЕГ-ын харьяа хаалттай хорих 435-р ангитай хамтран "Ээждээ захидал бичээрэй" уралдааныг тус анги дээр зохион байгуулж эрх нь хязгаарлагдсан 20 гаруй хүмүүжигчид оролцож шилдэг 5 бүтээлд зохих шагнал урамшил өгч хамтран ажиллалаа.

✓ Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 99 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл баримтлалыг төлөвшүүлэх, үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх Аймгийн ЗД-ын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хanган ажиллах зорилгоор Дархан-Уул аймгийн ЕБС-ийн 8-12-р ангийн сурагчдын дунд цэрэг эх орны сэдэвт "Эссэ" бичлэг, шүлгийн уралдааныг Аймгийн ЗДТГ-ын Цэргийн Штаб, МЦНХ-ны Дархан-Уул аймаг дахь салбар холбоотой хамтран тус тус зохион байгуулан ахлах дунд ангийн сурагчдын дунд зарлан 73 материалыг онлайнаар хүлээн авч 10 хүүхдийг шалгаруулан өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

МОНГОЛ ЦЭРГИЙН 99 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ЕБС-ИЙН 8-12 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН ДУНД ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛСАН ЦЭРЭГ ЭХ ОРНЫ СЭДЭВТЭЙ ШҮЛЭГ, ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНД БАЙР ЭЗЭЛСЭН СУРАГЧДЫН НЭРС

2020.03.26

№	Сурагчдын нэрс	Нас, хүйс	Сургууль, анги, бүлэг	Шүлгийн нэр	Авсан оноо	Байр
ШҮЛЭГ						
1	Ууганбаярын Энхзул	эм	ОИЦ сургуулийн 11-2	Цэргийн гангараа	37	I
2	Батжаргалын Эрдэнэсүх	эр	1-р сургуулийн 12-б	Эх орон	32	II
3	Нямгэрэлийн Батболор	эм	ХИС-ийн 12-а	Бидний бахархал	30	III
4	Ганбатын Мөнхдалай	эр	Од цогцолбор 11-а	Эх орон	28	IV
5	Ернурын Ергенбек	эр	6-р сургуулийн 12-а	Цэрэг эрс	24	IV
ЭССЭ						
1	Отгонбаярын Жанлав	эр	16-р сургуулийн 11-а	Эх орны эр цэргүүд-Аравт	38	I

2	Отгонбаярын Ариунбаяр	эр	6-р сургуулийн 9-а	Цэрэг гэх үгний цаана цаглашгүй их амьдрал бий	34	II
3	Мөнгөнбаярын Амирлан	эм	Од цогцолбор 9-г	Загасан нүдэт цэрэг эрс	30	III
4	Батхүүгийн Золцэцэг	эм	4-р сургуулийн 12-а	Эр цэрэг үгүй бол эх орон эзгүйрнэ	27	IV
5	Мелсийн Мадина	эм	2-р сургуулийн 8-а	Монгол цэрэг	26	IV

Төв номын сангийн захирал Д.Цэрэндаваа, "Цэрэг эх орны сэдэвтэй шүлэг, эссэ бичлэгийн уралдаанд амжилттай оролцсон сурагчдын хамт

Соёл, урлагийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Сэргэлэн ажил байдалтай танилцаж, уралдааны шагнал гардуулав.

<u>Номын баяр:</u> Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг номын баярыг тохиолдуулан доорхи ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ШШГЕГын харъяа Хаалттай 435-р хорих ангид очиж номын сангийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөгөө өгч, тэргүүний уншигчаар шалгарсан нийгмийн ажилтан Ж.Уранчимэг, хүмүүжигч Л.Оюун-Эрдэнэ, болон "Ээждээ захидал бичээрэй" уралдаанд оролцсон хүмүүжигчдэд дурсгалын зүйл гардууллаа.

Тэргүүний уншигчийг шалгаруулав:

- 2019-2020 онд номын санд хамгийн их ном уншсан тэргүүний уншигч, анги хамт олныг шалгаруулллаа. Үүнд:

- ✓ Д.Сэлэнгэ-Этүгэн дээд сургуулийн 1-р курсийн оюутан 323 боть ном, 2.Г.Пүрэвээ-тэтгэвэрт 146 боть ном, 3.Х.Сүхбаатар-тэтгэвэрт 143 боть ном, 4. -ШШГЕГ-ын харъяа Хаалттай хорих 435-р ангийн нийгмийн ажилтан Ж.Уранчимэг 136 боть, 5.У.Авирмэд-тэтгэвэрт 107 боть ном, Залуучууд театрын жүжигчин Л.Хишигсүрэн 105 боть ном, 7.ОИЦ-ын 4-10 анги Т.Марал-Оюу 96 боть ном, 8.ШШГЕГ-ын харъяа Хаалттай хорих 435-р ангийн хүмүүжигч Л.Оюун-Эрдэнэ 83 боть ном уншиж 2020 оны "ШИЛДЭГ УНШИГЧ"-аар шалгарч Д.Нацагдорж тэмдэгээр шагнагдав.
- ✓ **Тэргүүний уншигч анги хамт олноор** Шинэ алхам сургуулийн Байгалмаа багштай 5а ангийн сурагчид номын сангаар тасралтгүй 3 жил уншигчаар бүртгүүлж, номын тэмдэглэлээ тогтмол хөтөлж ирсэн байна.
- ✓ **Байгууллагын дэргэдэх "ШИЛДЭГ НОМЫН САН"- гаар:**
  ШШГЕГ-ын харъяа Нээлттэй хорих 445-р ангийн номын сан шалгарлаа.
- ✓ Дархан хотын 59 жилийн ойг тохиолдуулан **"Шилдэг уншигч гэр бүл"-ээр 5 гэр** бүлийг шалгарууллаа. Үүнд:1.Д.Буяннэмэхийн гэр бүл 195 боть ном, 2.Д.Мягмарсүрэнгийн гэр бүл 144 боть ном, 3.Д.Энхболдын гэр бүл 108 боть ном, 4.Г.Мөнхбатын гэр бүл 95 боть ном, 5.П.Байгалмаагийн гэр бүл 64 боть ном уншиж шилдэг уншигч гэр бүлээр тус тус шалгарч өргөмжлөл, номын багцаар шагнагдлаа.
- ✓ **Хамгийн их уншигдсан "РЕКОРД НОМ-2020" шалгаруулав**:
- ➢ 2019-2020 онд хамгийн их уншигдсан 10 номын эхний байранд 1.Динза 418 уншигдад 699 удаа, Өлзийтөгс. Үзэхийн хязгаар 398 уншигчдад 601 удаа, 3.Гүрбадам. Биологи 253 уншигчдад 589 удаа, 4. Oxford-Англи-Монгол толь 229 уншигчдад 557 удаа, 5.Л.Кристен. Гүнжийн гоо сайхны сургууль 239 уншигчдад 476 удаа, 6. Ногун 211 уншигчдад 417 удаа, 7. Монгол Улсын түүх 171 уншигчдад 358 удаа, 8.А.Дэлгэржаргал. Цондоолой Цүндээлэй 170 уншигчдад 340 удаа, 9.Гастон Лерүкс. Дуурийн театрын хий үзэгдэл 169 уншигчдад 315 удаа, 10. Б.Мөнхчимэг. Солонгос хэлийг бие даан сурах 157 уншигчдад 306 удаа тус тус уншигдсан байна.

Ном солилцооны өдөр. 3 удаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн "Номын өдөртэй болох тухай" 33 дугаар тогтоол батлагдсаны дагуу сар бүрийн 17-ны өдрийг "НОМЫН ӨДӨР" болгон тэмдэглэж байхаар болсон. Энэ арга хэмжээний үеэр шинэ номын худалдаа, зохиолчийн гарын үсэгтэй номын худалдаа, иргэдийн дунд хуучин номын солилцоо, үлгэрийн баатруудтай хамт дурсгалын зургаа татуулах зэрэг үйл ажиллагаанууд сар бүрийн 17-нд уламжлал болон зохион байгуулагдаж ирсэн ба 2020 онд дараах ажлуудыг цахимаар сурталчилж байна.

- ➢ 2020 оны 1, 9, 10-р сарын 17-нд болсон ном солилцооны өдөрт ЕБС-ийн 5, 8, 10, 12-р ангийн сурагчид сурах бичгээ солилцон мөн номын санд гадаадын хөрөнгө оруулалттай Эйм, эйч Жи компаниас 20 гаруй боть ном хандивлалаа.
- ➢ Номын баярын өдрийг тохиолдуулан "Ном солилцооны өдөрт" од цогцолбор сургуулийн 8в ангийн 20 сурагч, Шинэ алхам сургуулийн Байгалмаа багштай 5а ангийн 20 сурагч, 15-р сургуулийн 8б ангийн 3 сурагч, идэвхитэн уншигчид оролцож ном солилцохоос гадна зарим уншсан номоо худалдлаа.

<u>Үндэсний бичиг үсгийн баяр-2020</u>:

- ✓ Жил бүрийн тавдугаар сарын эхний ням гарагийг үндэсний бичиг үсгийн баяр болгон тэмдэглэх тухай 2003 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105-р зарлиг, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-2", Аймгийн монгол хэл бичгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын өдрийг тохиолдуулан нийт 8 боть үнэт, ховор номын онлайн үзэсгэлэн гарган тайлбарыг дүрсжүүлэн нэвтрүүлэг хийн уншигчдын хүртээл болгов.Үүнд: Монголын нууц товчоо, Жангар, Хар бухын балгасны үйсэн дээрх бичиг, Монгол угсаатны хувцас, Чинад нууцын Монгол орон, Чингис хаан, Хубилай хаан, Монголчууд зэрэг номуудын сурталчилгааг видео хэлбэрээр-7 удаа, зурган хэлбэрээр - 5 удаа гаргаж, цахимд байршууллаа.

✓ БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-наас хандивласан “ГАНЖУУР, ДААНЖУУР” 390 боть их хөлгөн судрын талаар тайлбарлан нэвтрүүлэг бэлтгэн, **25** материалыг онлайн орчинд байршуулж, **7 880** хүн үзсэнээс **3 950** хүн мэдээллийг хуваалцсан байна.

✓ Дэлхийн гэр бүлийн өдөрт зориулсан сурталчилгаа зурган хэлбэрээр-33, "Зохиолчийн 7 хоног" видео хэлбэрээр-20, зурган хэлбэрээр-12, шүлгэн хэлбэрээр-25 удаа тус тус сурталчилж, мэдээллийг хуваалцсан **6000** хүн, таалагдсан **17244** хүнд мэдээлэл хүрсэн байна.

✓ Дэлхийн номын өдөрт зориулан Дэлхийн Шилдэг үлгэр- 15**,** Дэлхийн алдартай зохиолчийн намтар уран бүтээл, зохиолуудаар 18 удаа, материал бэлтгэн онлайн орчинд байршуулж, **4 500** хүн үзсэнээс **3 800 хүн** мэдээллийг хуваалцсан байна.

✓ Монголын уламжлалт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ШШГГ-ын албан хаагчдын дунд уламжлал болгон зохион явуулж буй “Дөрвөн бэрх” тэмцээнд оролцох багийн гишүүдэд “Монгол ёс заншлын тухай” ном хэвлэл, төлөвлөгөө боловсруулах аргачлал, болон монгол уламжлал сэдвээр асуулт хариултыг бэлтгэж өгсөн.



“Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдрийг тохиолдуулан Залуучууд театрын 1-рт давхарт “Уран бичлэг”-ийн үзэсгэлэн зохион байгуулав.

ТАВ.МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙН СУРГАЛТЫН ТАЛААР: 7 байгууллагын 11 номын санч хамрагдаж аргазүйн зөвлөгөө авсан байна.

✓ Шарын голын Соёлын төвийн номын санч Тамирт 2 удаа, ХИС, ТИС-ийн номын санчдад 2 удаа, ШШГЕГ-ын харъяа Нээлттэй хорих 435 1 удаа тус тус утсаар, Орхон сумын номын санч, 21-р сургуулийн номын санчдад биеэр 2 удаа, 11-р сургуулийн номын санч 1 удаа тус тус аргазүйн зөвлөгөө өглөө.

✓ Номын сангийн эрхзүй, номын сангийн фонд, ангилал, ном тодорхойлох, номзүй, уншлага үйлчилгээ, соёл танин мэдэхүйн ажил сэдвээр материал бэлтгэж мэдээллийн самбарыг шинэчиллээ.

✓ Арга зүйн нэгжийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2020 оны сургалтын төлөвлөгөө гаргаж батлуулав. 2020 онд Мэдээлэл хийх, Аргазүйн зөвлөгөө өгөх, ном солилцох өдөр, Соёл олон нийтийн ажил зэрэг ажлуудын хувиаруудыг хийлээ.

✓ Миний мэргэжил хамгийн сайхан ярилцлага хийж цахимд байршуулсан нь 150 хүн үзэж, 39 хүн сэтгэгдлээ хуваалцсан байна.

✓ Ахмад номын санч П.Бадамхандын хөдөлмөрийг үнэлж "Хүндэт дэвтэр"-т бичиж алдаршуулсан нь 156 хүн үзэж, 30 хүн сэтгэгдлээ хуваалцсан байна.

<u>Боловсон хүчнийг чадавхижуулах сургалт:</u>

6 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 12 албан хаагч хамрагдав.

1. 2020 онд зайны сургалтаар Хүмүүлэгийн их сургуулийн харьяа Эрдэм их Сургуулийн "Соёл судлал"-ын магистрыг-1 номын санч, СУИС-ийн Соёлын сургуулийн "Номын сан-Мэдээлэл зүйн" баклавраар -1 номын санч тус тус суралцаж төгслөө.

2. СУИС-ийн Соёлын сургуулийн "Номын сан-Мэдээлэл зүйн" ангид 1 оюутан суралцаж байна.

3. Хараагүй хүмүүсийн Инноваци хөгжлийн төв, Дархан-Уул аймгийн Төв номын сан, ХНО-той хамтран Харааны бэрхшээлтэй иргэд болон тэдний гэр бүлийнхэнд зориулсан цахим брайль төхөөрөмжүүд болон дэлгэж уншигч програмыг уншлагандаа ашиглах, чадамж эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтанд харааны бэрхшээлтэй 22 иргэн, захирал Д.Цэрэндаваа, ахлах номын санч Г.Нямцэнд, ХНО-ны мэдээллийн ажилтан Г.Гэрэл, О. Даваасүрэн нар хамрагдсан.

4. 2020 оны 05 дугаар сарын 15-ны 11.00 цагт МҮНС-гаас нийтийн номын санчдын дунд цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад сүлжээний инженер Х.Отгонбаяр, номзүйч Н.Солонго нар оролцлоо.

- Номын сангийн баримтыг төрөлжүүлэн ангилах;
- Ном зүйн бичилтийн стандартаар ном тодорхойлох;
- Нийтийн номын сангийн каталоги, картын сангийн зохион байгуулалтын онцлог;
- Электрон каталог LIB-4U программын талаар;
- Номын сангийн каталогт редакци хийх, сурталчилах ажил зэрэг сэдвүүдээр мэдээлэл авсан.

5.Монголын номын сангуудын консерциумаас Дотоод хэргийн их сургуулийн номын сантай хамтран зохион байгуулсан "Mongolian library update" номын санчдын зөвлөгөөнд Ахлах номын санч ЗАА-н нэгжийн дарга Г.Нямцэнд оролцов.

- Номын сангийн салбарын эрх зүйн орчин, шинэчлэл;
- Дээд боловсролын салбарт Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх бодлого;
- Номын сангийн салбарын эрх зүйн орчин, шинэчлэл;

6. Дархан-Уул аймгийн прокурын байгууллагаас зохион байгуулсан "Эцэг эхийн зөвлөлийг чадавхижуулах" сургалтанд Г.Нямцэнд, С.Энхцэцэг нар оролцлоо. 2020.11.08

<u>ЗУРГАА. ЛАВЛАГАА-НОМЗҮЙН АЖИЛ:</u>

✓ Шинэ номын мэдээг 7 удаа 350 боть номоор гаргаж, нийтийн уншлага үйлчилгээнд нэвтрүүлэн, цахимд байршуулан номоо сурталчилж байна.

✓ Эрдэмтэн мэргэдийн хэлсэн онч мэргэн үгсээс бэлтгэн уншигчдад өгөх "Оюуны чихэр"-т 500 гаруй үгсийг хэвлэн гаргаж уншигчдын хүртээл болгов.

<u>Лавлагаа:</u>

- Номын санд ирсэн уншигчдад амаар болон бичгээр 567 удаа лавлагаа өглөө.

<u>Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн</u>:

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг ***13 удаа***, ***424 боть*** номоор гаргаж сурталчилсан байна. Түүхт ой, тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан 11 удаа 360 боть номоор, шинэ номын үзэсгэлэнг 2 удаа 64 боть номоор тус тус гаргаж уншигчдын хүртээл болголоо.

✓ **Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг** Үндсэн хууль 62 боть ном, Залуу хүний заавал унших ном 38 боть, Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөрт- 51 боть ном, Монгол цэргийн өдөрт-26 боть, ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт-45 боть, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 99 жилийн ойд зориулж 36 боть, Усны өдөрт зориулж 32 боть, Гадаад хэл сурцгаая- 20 боть ном, Харилцааны соёл-15 боть ном, Үлгэрийн ертөнцөөр аялцгаая – 35 боть ном, Соёлын байгууллагуудын тайлангийн хуралд зориулж 2019 онд хийсэн ажлын тайлангууд

✓ **Шинэ номын үзэсгэлэнг** 3 удаа 160 нэр төрлийн 225 боть 3587 180 төгрөгний шинэ номыг хүлээн авч үзэсгэлэн гаргаж, фондын номуудаа сурталчиллаа.

Эчнээ уншигчдын материал: **5** удаа бэлтгэж 3 байгууллагад хүргүүлэн, уншлагын танхимаар 450 хүнд сурталчилав.

- ✓ “Харилцааны соёл”, “Охидын эрүүл ахуй”, “Ном уншихын ач тус”, “Залуу эмэгтэйн заавал унших ном” сэдвүүдээр

Татгалзлал: 51 боть номыг татгалзлалын дэвтэрт бүртгэн авч номын захиалгад оруууллаа. Үүнд:

✓ Чихэр эмэгтэй 147 хоног, Дээд айл, Харь хэлээр яригсад, Бүсгүй минь чи нүүрээ угаа, Амьдралд бэлэн үү, Тоомжиргүй амьдрах бяцхан урлаг, Нэг бүс нэг зам, Саятан хөрш,

✓ Цойлогсод, Амьсгал агаар болохуйд, Миний хуримын гэрч, Сүнсний томъёо, Ноён Бэхэн дуслын аялал, Бие даасан хүүхэд хэрхэн залуу ээж болох вэ?, Момо, Харизм, Цусаа худалдсан, Нэрийн дэлгүүрийн эмэгтэй, Эмсгүй эрс, Харри Поттер, Дүрсгүй жаалын өдрийн тэмдэглэл, Стрессээ удирдахуй гэх мэт номыг татгалзалд бүртгэж Дээд айл, Харь хэлээр яригсад, Бүсгүй минь чи нүүрээ угаа, Тоомжиргүй амьдрах бяцхан урлаг, номуудыг захиалан авч уншигчдын хэрэгцээг барагдууллаа.

ДОЛОО. МЭДЭЭЛЭЛ-ТЕХНОЛОГИ

Манай электрон каталогт одоогоор ***26611*** нэр төрлийн ***54 176*** боть, ***180 081 706*** төгрөгний ном, хэвлэлийн бүтээгдэхүүн бүртгэгдэн уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна. Номын сангийн үүлэн технологит суурилсан шинэ /lib4u/ программ хэвийн ажиллаж байна. darkhan.lib4u.net

Д/д	Хийж гүйцэтгэх ажлууд	Хэдэн удаа
1	**Техник хэрэгсэл**	**144**
2	**Мэдээлэл дамжуулалт**	**787**
3	**СТМАд оролцсон байдал**	**3**
4	**Фэйс бүүк хуудас**	**1275**
5	**Өнгөт хэвлэл /КОВИД-19/**	**270**
6	**И-Мэйл хаяг**	**98**
7	**Эйбли програм**	**270**
8	**Үйл ажиллагааны зураг авалт**	**150**
9	**Фэйс бүүк чат, пэйж хуудасын чат болон аман лавлага**	**2520**
10	**Вэйб сайт аймгийн Төв номын сан болон МУҮНС**	**375**
11	**Үйл ажиллагааны зурагт тайланг бусдад илгээх болон өнгөтөөр хэвлэх**	**2**
12	**Төв номын сангийн 2020 оны үйл ажиллагааны зурагт тайлан**	**Жилд 2 удаа**
13	**Утсаар асуулт хариулт, зөвлөгөө**	**510**
НИЙТ		**6406**

НАЙМ.ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАЛТ

2020 оны эхний хагас жилд 2 төсөл бичиж, Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүллээ.

- ✓ “Ажлын бүтээмж амжилтын үндэс” 10 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн, Аймгийн 60 жилийн ойг тохиолдуулан Дархан хотод ажиллаж амьдарч байсан зохиолч уран бүтээлчдийн “Яруу эгшгийн чуулган-2” уран бүтээлийн эмхэтгэл хэвлүүлэх 10 сая төгрөгийн төслүүдийг Аймгийн Хөрөнгө Оруулалт Хөгжлийн Бодлогын Хэлтэст хүргүүлэв.
- ✓ Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газарт ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ариутгалд хамруулж өгөх тухай /2020.02.27-ны 24 тоот/
- ✓ Соёлын Яамны номын сангийн мэргэжилтэн Б.Баяраад Номын сан, музейн барилгын төслийг бичиж явуулав.

ЕС. ТАЙЛАН, МЭДЭЭ ХҮРГЭЛТИЙН ТАЛААР:

***Санхүүгийн тайлан*,** Бараа материалын гүйлгээ, тогтмол гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн гүйлгээ, зардал хоорондын шилжүүлэг, сар, улирал бүрийн санхүүгийн тайлан, санхүүгийн сар бүрийн мэдээ, НД-ын тайлангуудыг сар бүрээр, худалдан авах ажиллагааны тайлан, татварын тайлангуудыг улирал бүрээр, орон нутгийн өмчийн тайлан, санхүүгийн тайланг хагас жилээр гаргаж, холбогдох газруудад хүргүүллээ.

Мэдээ, тайлан судалгаа:

- ✓ 2020 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан гаргаж, Аймгийн Засаг дарга С.Насанбатаар батлуулав.
- ✓ БСУГ-ын дарга Гантулгааар ахлуулсан ажлын хэсэгт 2019 онд хийсэн тайлангаа амжилттай хамгааллаа.
- ✓ Хүний нөөцийн онлайн судалгааг дахин хянаж, санхүүгийн бүртгэл тооцоог шивж оруулж дуусгавар болголоо.
- ✓ Арга зүйч Дя.Сарантуяатай хамт 2019 оны гүйцэтгэлийн тайланг гаргаж, Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд, Байгууллагын хяналт шинжилгээний тайланг аймгийн Хяналт шинжилгээ дотоод аудитын хэлтэст тус тус хүргүүллээ.
- ✓ Архигүй Монгол хүн” дэд хөтөлбөр, “Дарханы иргэд оюунлаг, авьяаслаг” дэд хөтөлбөрийн 4 жилийн тайлан, Сайд Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайлан, “Соёл урлаг бүтээлч үйлдвэрлэл түншлэл”-ийн тайлан, Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлангууд, Номын сангийн статистикийн НС-1, НС-2, НС-3, НС-4 маягтуудын тайлан, Төвлөрсөн номын сангийн ҮЭХ-ны 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, татвар, статистикийн тайлангууд, болон сар улирал, 7 хоногийн мэдээг цаг хугацаанд нь холбогдох газруудад өгч ирлээ.
- ✓ Дэлхийн номын өдрийн төлөвлөгөө, хийсэн ажлын тайланг БСШУСЯ-ны Соёл урлагийн газарт, Номын сангийн ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулж, төрийн захиргаа удирлагын хэлтэст, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2019 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тайлангуудыг гаргаж хавсралтаар хүргүүлэн ажиллав.

АРАВ. АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ТАЛААР:

- ✓ Байгууллагын хэмжээнд 2019 онд хөтлөгдөж дууссан баримт бичгүүдийг нэгж тасгаас хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт 54 нэр төрлийн баримтыг хүлээн авлаа.
- ✓ Байнга хадгалах-782 хуудастай 20 нэгж, Түр хадгалах-4723 хуудастай 31 нэгж, 70 жил хадгалах-137 хуудастай 3 нэгж, нийт 54 нэгж баримт үдэж, 5642 хуудас бичиг баримтуудыг гараар дугаарлан скайнердаж /JPG, PDF/ цахим сан үүсгэн ажиллав.

- ✓ Явсан бичиг-52, ирсэн бичиг-28, нийт 80 нэр төрлийн бичиг баримтыг бүртгэн авч 134 хуудсыг дугаарлан скайнердав.
- ✓ Захирлын тушаал А-8, Б-13, нийт 21 нэр төрлийн баримтыг бүртгэн авч 38 хуудсыг дугаарлан скайнердав.
- ✓ Канон-687 хуудас канондаж 34350 төгрөгийн орлого хийв. Мөн скайнер-нийт 5897 хуудас, принтер-1094 хуудас, шивэлт, эх бэлтгэл-195 хуудас, урилга, мэндчилгээ, өргөмжлөл, нийт-105ш

Эрхзүйн бичиг баримт боловсруулах талаар:

- ✓ Төв номын сангийн захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-гээ Дархан сумын ЗДТГ-ын эрхзүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Ариунтунгалагт танилцуулан баталгаажууллаа.
- ✓ Номын сангийн “Дотоод журам”-ыг хамт олноороо хэлэлцүүлж, захирлын тушаалаар батлуулав.

Судалгаа гаргалтын талаар:

2020 онд МҮНС, НБХ, БСУГ-дад холбогдох 20 гаруй судалгааг гаргаж, цахим хуудсаар илгээлээ.

- ✓ Төрийн байгууллагын нэгдсэн судалгаа гаргаж, lkhagvaa084560@gmail.com цахим хаягаар явуулав.
- ✓ Дархан-Уул Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, санхүүгийн хяналт, аудитын албанд судалгаа гаргаж, албан тоотоор хүргүүлэв.
- ✓ Албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгаа гаргаж, НБХэлтэст онлайнаар явуулав.
- ✓ Архивын ерөнхий газарт 2017, 2018, 2019 оны үйлчилгээний тоон мэдээг 2020.02.07-ны өдрийн 18 тоот албан бичгээр тус тус хүргүүлэв.
- ✓ Орон нутгийн сонингийн судалгаа гаргаж, СУИС-ийн харьяа Соёлын Дээд сургуульд хүргүүлэв.
- ✓ БСУГ-ын мэргэжилтэнд барилгын насжилтын болон урсгал засварын талаарх гурван барилгын судалгаа
- ✓ Аймгийн ОБК-оос гаргасан судалгаануудыг тухай бүрд нь гаргаж явууллаа.
- ✓ ЗГ-ын 382-р тогтоолын дагуу ажилтан, албан хаагчдын цалингийн судалгаа гаргаж нябод өгөв.
- ✓ Номын сангийн статистикийн шинэ маягтанд саналаа бичиж, БСУГ-ын мэргэжилтэн Г.Нарангэрэлд онлайнаар өгөв.
- ✓ Коронавирусийн халдварын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн хөл хорио тогтоосон үед Төв номын сангийн ажилтан албан хаагчдын эргүүл хийх хуваарь болон ажиллах цагийн хуваарийг тухай бүр нь өөрчилж, байгууллагын захирлаар батлуулан БСУГ-т хүргүүлэн ажиллаж ирлээ.

<u>Гэрээ байгуулж ажилласан талаар.</u>

- ✓ Нүүдлийн номын сангийн чиглэлээр ШШГЕГ-ын харьяа Дархан-Уул аймаг дахь нээлттэй хорих 445 дугаар анги болон Хаалттай 435-р анги, Аймгийн татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, ХУИС зэрэг газруудтай хамтран ажиллах гэрээ байгуулав.

<u>АРВАН НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД</u>

Засгийн Газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62-р тогтоолын хэрэгжилтийг хангах шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах бэлэн байдлыг хангах зорилгоор Дархан-Уул аймгийн Төв номын сангаас Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай БСШУС-яамны сайдын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/43 тушаал, Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 1-04/01 албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах ажлын тусгай төлөвлөгөө гарган ажиллалаа.

- ✓ Улсын онцгой комисс, Аймгийн онцгой комиссоос гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, байгууллага дээрээ ариутгал цэвэрлэгээг тогтмол хийж байгаа ба байгууллагынхаа ажилтан албан хаагчдад 4 удаагийн арга хэмжээгээр ариутгалын хэрэгсэл 905 250 төгрөгөөр авч өгсөн ба байгууллагын ҮЭ-ийн хорооноос 650,000 төгрөгийн агаар шүүгч, 50 000 төгрөгийн ус шүүгчийг ажилтнуудынхаа хэрэгцээнд авч өглөө.
- ✓ Аймгийн Онцгой комисс, БСУГ-ын баталсан хуваарийн дагуу 7 хоног бүрийн бямба, ням гарагуудад 5, 5 хүний бүрэлдэхүүнтэй машинт эргүүлийг 2020 оны 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар 14-нийг дуустал 6 дугаар багийн нутаг дэвсгэрт 17 удаа, 14 дүгээр багийн нутаг дэвсгэрт 8 удаа нийт 25 удаа зохион байгуулж 600 гаруй зөрчил дутагдлыг илрүүлэн зохих шаардлага тавьж үүрэг өгөн ажиллаж, цаг тухайд нь илтгэх хуудас, зурагт тайлангуудыг БСУГ-ын мэргэжилтнүүдэд, 6-р баг болон 14-р багийн Засаг дарга Цогзолмаа, нийгмийн ажилтан Номундарь /Харилцах утас-99219279/ нарт бичгээр болон цахимаар хүргүүлэн ажиллалаа.
- ✓ Энэ ажлын хүрээнд манай байгууллагын 15 ажилтан албан хаагчид тус бүр 10,000 төгрөг, нийт 150,000 төгрөгийн хандивыг цуглуулан Аймгийн Онцгой комисст хүлээлгэн өгөв.
- ✓ Монгол Улсын Засгийн Газраас шинэ төрлийн КОВИД-19 вирусын тохиолдлын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан халдварын тархалтаас сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, хорио цээрийн дэглэм тогтоож, ажилтан, албан хаагчдын ажлын цагийг богиносгох, гэрээсээ ажиллах, бөөгнөрөл үүсгэхгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээг 2020 оны 12 дугаар 01-ныг хүртэл авч хэрэгжүүлээд байна.
- ✓ Мөн “КОВИД-19” Цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр 2020 оны 02-р сарын 05-наас 2020 оны 06-р сарын 01 –ныг хүртэл, 2020 оны 11-р сарын 10-наас 12-р сарын 01 хүртэл тус тус хариуцлагатай жижүүрийн хуваарийг гарган Дархан сумын 6, 7, 8-р багийн нутаг дэвсгэр дээр эргүүл хийн мэдээ тайланг холбогдох газруудад тогтмол өгч дараахь ажлуудыг хийж ирлээ. Үүнд:
    1. Сурталчилгааны материалыг Дархан их дэлгүүр, Төв Номын сан, Салбар номын сангийн гадна талбай, Спортын ордон, Оточ манал эмнэлэг, Комфортын АТМ, Автобусны буудал, Монта 5-р байрны 3 орц, АЗЗА-ын газар, Аймгийн шүүх, Мишээл дэлгүүр, Hi mol дэлгүүрүүдийн гаднах самбарт 25 зар сурталчилгааны материал нааж сурталчилав.
    2. Сурталчилгааны материалыг Дархан хамгийн том зарын групп, Дархан зар, Дархан даяар зарлая, Дарханы авто зар, Дархан хотын зар, Үнэгүй зарын групп, Дарханы хамгийн том зарын групп–Дархан зар нийт 10586 гишүүдтэй 7 зарын группт байршууллаа.
    3. Амны хаалтаа зүүгээрэй ведио сурталчилгааг Nomiin san Darkhan Facebook хуудсанд байршууллаа.
    4. Хийсэн ажлын заримыг зургаар товч үзүүлбэл (Хавсралт хууд)

<u>АРВАН ХОЁР. ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД:</u>

1. Номын сан музейн цогцолбор барилгыг бариулах:
   А)Нийт хүчин чадал: Төрөлжсөн уншлагын танхимууд бүхий 200 хүний суудалтай, 120000 мянган боть номтой номын фондтой, музейн 911 дэсийн 1300 үзмэрийг дэглэж үзүүлэх танхимууд, 133 хүний суудалтай хурлын танхим.
   Б)Хэмжээ: Тэнхлэгээрээ 31х57.5м хэмжээтэй, 5928,29кв.метр ашигтай талбай бүхий зоорьтой 3 давхар барилга. Эзэлхүүн 25700,84м3
   В) Зориулалт: Соёлын үйлчилгээний барилга
   Г)Барилгажих талбай: 1,998 га
2. Орчин үеийн шаардлага хангасан техник тоног төхөөрөмжөөр хангагдах
3. Боловсон хүчнийг чадавхижуулах
4. Номын сангийн үндсэн фондны барилгын хэсэгчилсэн засварын ажлын зардал ***3 901 600*** төгрөг нэн шаардлагатай байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Эрхэм зорилго:

Соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийг хадгалж хамгаалах, ард иргэдэд ном соёлоор үйлчлэн тэдний оюуныг хөгжүүлэх, бүтээлч санаачлагыг өрнүүлэх, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, тав тухтай тохилог орчинг бүрдүүлэх, номын сангийн стандартыг ханган ажиллахад оршино.

1.2 Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Манай номын сан нь **1945** онд байгуулагдсан, нийт **13** хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Номын сан нь уншлагын 2 танхим, Соёмбо салбар уншлагын танхим, гэрээр ном олгох тасаг, үндсэн фонд, хэвлэлийн фонд, гэр бүлийн уншлагын танхим зэрэг танхимуудаар үйл ажиллагаагаа явуулдаг. Нийт 484$м^2$ талбайг номын сангийн үйлчилгээнд зориулан ашиглаж байна.

Номын сангийн албан ёсны имэйл хаяг: dg.library@yahoo.com

Цагийн хуваарь:

Насанд хүрэгчдийн уншлагын танхим:
Даваа-Лхагва 8^{00}-20^{00}, Пүрэв-Ням 8^{00}-17^{00}
Бусад тасаг танхим:
Даваа-Баасан 8^{00}-17^{00}

Байгууллагын утасны дугаар: 70522706

Номын сангийн захирал: А.Байгалмаа

2. САН ХӨМРӨГ, КАТАЛОГ

2.1 Сан хөмрөгийн өнөөгийн байдал

Орон нутгийн онцлог уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт **56284** ш номтой байна.

2.2 Сан хөмрөгийн бүрдүүлэлт

2020 оны фондын бүрдүүлэлтийг төсвийн санхүүжилтээр **8,193,500** төгрөгийн **415** ширхэг шинэ ном, хандив бэлгээр **330,000** төгрөгийн **47** ширхэг ном нийтдээ **8,523,500** төгрөгний **462**ш номоор сан хөмрөгийн баяжилтыг хийсэн. Мөн **8** нэр төрлийн **714900** төгрөгний хэвлэл захиалж иргэдийг өдөр тутмын мэдээ мэлээллээр ханган ажиллав.

Бүрдүүлэлт	Тоо ширхэг	Үнэ /төг/
Шинээр нэмэгдсэн нийт	462	8,523,500

Шинээр нэмэгдсэн ном	Шинэ ном-415 хандив-47	Шинэ ном – 8,193,500 Хандив - 330000
Шинээр нэмэгдсэн Сонин, сэтгүүл	8	714900

Хийгдсэн ажил	**Тоо хэмжээ**
Электрон каталогт бүртгэгдсэн нийт ном	56284
Электрон каталогт шинээр нэмэгдсэн ном	462
Электрон каталогт хийгдсэн хайлтын тоо	24476

2.3 Каталог зохион байгуулалт

Номын санд шинээр ирсэн 462 ширхэг номонд техник ажиллагаа хийж данс бүртгэлд тусган электрон католоогт бүрэн оруулж тасаг танхимуудад хуваарилан уншлага үйлчилгээнд гарган ажиллаж байна. Нийт номын сангийн хэмжээнд 56284 ширхэг номтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Үндсэн фонд, Гэрээр ном олгох тасгийн фонд, Хүүхдийн уншлагын танхимын фонд зэрэг фондуудын **319** ш номын ялгагч буюу хавчуургыг шинээр сольж байрлуулсан.

3. ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Уншлага үйлчилгээ:

Жилийн эцсийн байдлаар нийт 976 уншигч, 10182 ирцэд 10747 ном хэвлэл олгож үйлчиллээ. Энэхүү тоон үзүүлэлт нь зөвхөн Төв номын сангийн уншигч, ирц, ном олголтын тоо юм.

Үзүүлэлт	**Тоо, хэмжээ**
Аймгийн төвийн иргэдийн тоо	69386
Бүртгэлтэй уншигчийн тоо	976
Номын сангийн ирц	10182
Олгосон ном	10747

- Хөдөө орон нутаг болон алслагдсан айл өрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өндөр настан зэрэг номын санд ирэх боломжгүй хүмүүст номын сангийн үйлчилгээг хүргэх, ном хэвлэлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, уншигчдын хүрээг өргөжүүлэх зорилгоор зөөврийн номын сан болон “Номын багц” үйлчилгээг тогтмол ажиллуулж байна.
    - Зөөврийн номын сангаар **29** удаа, **337** иргэнд **1424ш** ном,

- “**Номын багц**” үйлчилгээ **45** иргэнд **321ш** ном

- Гэр бүлийн уншлагын танхимыг “Аз жаргалын өргөө” болгон тохижуулж уншигч хүүхдүүд болон гэр бүлээрээ ирж үйлчлүүлэх ая тухтай байх орчин бүрдүүлэн нийт 1500 хүүхэд, 25 гэр бүлийг хамруулан ажилласан байна. Мөн Хүүхдийн уншлагын танхим нь Баасан гариг бүрийг “Тоглоомын өдөр” болгон ажиллаж байна.

3.2 Номын үзэсгэлэн:

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 57 удаа 7220 номоор гаргаж үйлчилсэн.

4. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ:

ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР

Номын үзэсгэлэн болон дэлхийн номын өдрийн танилцуулга хийж, **“Эможи ашиглан номын нэр таах”** уралдаан, **“Ном таны амьдралд”** уншигчдын сэтгэгдэл зэргийг цахимаар зохион явуулж олон уншигч хүүхдүүд хамрагдсан. Мөн **“Номтой хамт сельфи”** уралдааныг зарлан нийт 22 бүтээл ирсэнээс шалгаруулан шагналыг гардуулан өгсөн.

“ХЯЗГААР ҮГҮЙ – НОМ, СЭТГЭЛГЭЭНИЙ ЭРХ ЧӨЛӨӨ”
ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР БОЛОН НОМЫН БАЯРЫН ӨДӨР

1. Номын баярыг 2020 оны 09 сарын 24-өөс 10 сарын 05-ны хооронд зохион байгуулахаар төлөвлөн ажиллав. Арга хэмжээний үеэр шинэ ном, ховор хуучин ном, сонин содон ном, 1970,1980-аад оны сонин сэтгүүлийн үзэсгэлэнгүүд гаргаж уншигч олондоо сонирхууллаа. Мөн энэ үеэр Тэргүүн уншигч-Д.Нацагдорж” тэмдэг 4 сурагчид, Шилдэг тэргүүний уншигч байгууллагаар ШШГГ-ын хамт олонг шалгаруулан шагналыг гардуулан өглөө. Уншигч сурагчдын дунд АХА тэмцээн зохион байгууллаа. Оролцсон хүний тоо- 150

2. Номын баярын хүрээнд Уншигч-Зохиогчийн уулзалтыг хүүхдийн зохиолч О.Сундуйтай онлайнаар зохион явуулж зохиолчийн зохиол бүтээлийг дэлгэж 9-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 5-6 насны бяцхан хүүхдүүдийг урьж харилцан ярилцаж, шүлэг уншлаа. Оролцсон хүүхдийн тоо -20

3. Монгол бичиг-Монгол бахархал” уралдааныг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд гэрийн даалгавар, цэвэр бичигтэн, хурдан уншлага, хөрвүүлэг гэсэн төрлүүдээр зохион байгууллаа. Оролцсон хүүхдийн тоо-28

4. Судартай аялал. Аймгийн ахмадын холбоотой хамтран аймгийн ахмад настангуудыг хамарсан Судартай аялалыг 6 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна. Энэ үеэр номын үндсэн фондонд хадгалагдаж байдаг үнэт ховор ном судруудыг дэлгэн танилцуулж, мөн иргэдээс ховор ном хандивлав. Мөн аймгийн гандан хийдээс судруудын талаар тайлбар хийж иргэдэд мэдээлэл өгсөн. Оролцсон хүний тоо-80

5. Танин мэдэхүйн уралдаант “50 номын хожил” тэмцээнийг ЕБС-ийн багш нарын дунд зохион байгууллаа. Энэхүү тэмцээнийг Н.Надмид агсны 95 жилийн ойд зориулан түүний төрөл төрөгсөд ивээн тэтгэж, тэд нар тухайн зохиогчийн талаар сэтгэгдэл дурсамжаа ярьж оролцлоо. Оролцсон хүний тоо- 37

6. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан номын баярт Номын санч Г.Цэндсүрэн, А.Гансүрэн нар оролцлоо.
7. Манай номын сан А.Эрдэнэ-Очирын нэрэмжит болсонтой холбогдуулан түүний зохиол бүтээлийг уншигч хүүхэд багачуудад сурталчилан таниулах зорилгоор "А.Эрдэнэ-Очирын шүлгийг хэн сайн унших вэ" уралдааныг зохион байгуулав. Уг уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

8. Н.Надмид агсны-95 жилийн ойн хүрээнд Цэцэрлэгийн багш нарын дунд уран бүтээлээр нь "Жүжигчилсэн дүрийн тоглолт" уралдааныг зарлаж 9 цэцэрлэг хамрагдаж 1,2,3-р байр болон шилдэг дүр бүтээсэн нэг багшийг шалгаруулан Н.Надмид агсны ар гэр ивээн тэтгэж шагнаж урамшуулсан.

9. Ойн хүрээнд тухайн зохиолчийн уран бүтээлийн үзэсгэлэн, намтар уран бүтээлийг цахимаар танилцуулж нийт 1000 гаруй хүн үзсэн.
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байранд хоригдож байгаа сэжигтэн, ялтан, яллагдагч нарын дунд **" Үрсийн зүрхний үг"** захидал бичих уралдааныг уламжлал болгон 6 дахь жилдээ зохион явуулав. Уралдаанд 18 хүн оролцсон.

ЦАХИМ АЖИЛ

1. Соёлын яамнаас уриалж буй **“Цахим орчинд соёл түгээе”** урианд нэгдэж дараах ажлуудыг зохион явууллаа.

2**. “Хүмүүний сэтгэлийг ариусгая”** уриан дор иргэд уншигчидтай 30 яруу найрагчийг цахимаар уулзуулсан.
3. Хүүхэд багачуудаа зориулан **“Үлгэрийн цаг”**-ийг үдэш бүрийн 19 цагт бяцхан уншигч нар уншиж сонордууллаа.
4. Номын санч - Мэдээллийн ажилтан Д.Алтанчимэг **“Хүүхдэд ном уншиж өгөх арга”** танилцуулгыг бэлтгэж хүргэсэн.

№	Цахимаар хийсэн ажил	Оролцсон хүний тоо	Like	Share	Сэтгэгдэл	Үзэлт
1	“Хүмүүний сэтгэлийг ариусгая”	30 яруу найрагч	930	321	374	16212
2	“Үлгэрийн цаг”	14 удаа 12 хүүхэд	476	111	119	5582
3	“Хүүхдэд ном уншиж өгөх арга”	1удаа	32	11	1	502

5. Үндсэн фондын эрхлэгч Г.Цэндсүрэн “Ховор хуучин номын танилцуулга хийсэн. Нийт 790 хүн үзсэн.
6. Онч сургаал үг, афоризмыг уншигчдад хүргэх зорилгоор 134 үгийг оруулж 3118 хүн үзэж сонирхсон.
7. Танин мэдэхүйн мэдээлэл 882 удаа оруулж 23014 хүн үзэж танилцсан.
8. Ном хэвлэлээ сурталчлан 350 номын мэдээлэл оруулж 3820 хүнд хүргэсэн.
9. Төрөл бүрийн сэдвээр слайд хийж видео танилцуулга бэлтгэн 7320 хүнд хүргэсэн.
10. Нутгийн зохиолчдын зохиол бүтээлийг сурталчлан таниулах зорилгоор 10 зохиолч яруу найрагч нартай хууч дурсамж хөөрөлдөн уран бүтээлээс нь уншигч олондоо хүргэсэн. Нийт 7800 хүнд хүрсэн.

11. Жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Миний сайхан ээж” уралдааныг цахимаар зарлаж шалгаруулсан.

12. Мөн хүүхэд багачуудын дунд “Түргэн хэллэг”-ийн уралдааныг зарлаж шалгаруулсан.

13. Хүүхдийн уншлагын танхимаас “Би үлгэр ярьж чадна” уралдааныг бага ангийн сурагчдын дунд зарлаж нийт 25 хүүхэд оролцон шагналыг гардуулан өгсөн.

СОЁМБО УНШЛАГЫН ТАНХИМ БОЛОН
AMERICAN CORNER

Англи хэлний сургалт

- ✓ Олон нийтэд нээлттэй болон байгууллагын ажилчдад зориулсан анхан, дунд шатны сургалт зарлан 309 иргэн хамрагдсан.

- ✓ Коронавирусын цар тахалтай холбоотойгоор ОУ-д хэрэгждэг МООС сургалтын хөтөлбөрийн бизнесийн болон хэвлэл мэдээллийн салбарын англи хэлний сургалтыг цахимаар явуулж байна. Хамрагдсан 93 иргэн.

- ✓ Америкийн мэдээллийн төвөөс www.dornogovipost.mn сайттай хамтран *Гэр бүлээрээ англиар ярьцгаая* цахим уралдаан зарлан дүгнэлээ. Нийт 20 хүн хамрагдлаа.

5. БУСАД АЖИЛ

- “Аз жаргалын өргөө” нэртэй танхимаа Аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөл зохион байгуулан 1000-н ээжийн хандиваар иж бүрэн засвар тохижилт хийж гэр бүл хүүхэд багачуудын оюуныг тэтгэх сайхан танхимтай болсон. Энэхүү танхимаар хүүхдүүд болон гэр бүлд чиглэгдсэн олон төрлийн арга хэмжээг амжилттай зохион байгуулсаны үр дүнд Аймгийн Хүүхэд Залуучууд гэр бүл хөгжлийн газраас “Шилдэг эцэг эхийн зөвлөл”-өөр шалгарч талархал мөнгөн шагналаар шагнагдсан.

- Дотоод санхүүжилтээр Захирал, Нягтлан бодогч, Гэрээр ном олгох тасаг, Үндсэн фонд зэрэг өрөө танхимуудыг засаж хулдаас дэвсгэр тавилга зэргийг шинэчилсэн.

- Манай байгууллага нь жил бүр нэгэн цаг үеийн манлайлал болж бид бүгдийн үлгэр дуурайлал болсон үе үеийн ахмад ажилтан өндөр настануудаа хүлээж авч уулздаг. Хамгийн бахархууштай нь удам дамжсан сайхан ээж охин 2 байдагт бид бүхэн баяртай байдаг.

- Аймгийн БОАЖГазраас 10 мод авч байгууллагынхаа үүдэнд тарьж ургуулсан.

- Байгууллагын хамт олны дунд “ Миний сайхан аав” сельфи зургийн уралдааныг зарлаж номын санч- мэдээллийн ажилтан Б.Батчимэгийн гэр бүл шалгарсан.

- Байгууллагын гадна талбайд Чөлөөт номын сан байршуулан ажиллуулж байна.

6. АРГА ЗҮЙН АЖИЛ:

- MNS 5271:2012 Номзүйн бичилт. Ерөнхий шаардлага стандартыг хэрэгжүүлэх, MNS ISO 4:2003 Мэдээлэл ба баримт бичиг. Гарчиг үг ба ном хэвлэлийн гарчгийн товчлол стандартыг хэрэгжүүлэх, MNS ISO 11799:2007 Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага зэрэг стандартын хэрэгжилтийг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.
- Сар бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гаригийг "Ном сэлбэн засах өдөр" болгон зарласантай холбогдуулан урагдаж гэмтсэн **1197** номонд стандартын дагуу сэлбэн засалт хийсэн.
- Улаанбаатар хотод болсон **"Номын санч мэдээллийн ажилтаны 7-р зөвөлгөөн"**-д арга зүйч Г.Баттогтох, Сүлжээний инженер Э.Цэндсүрэн нар хамрагдсан.
- "Номын санчдын бүсчилсэн сургалт"-ыг Өргөн, Эрдэнэ, Улаанбадрах сумдуудыг хамруулан шинээр номын сан байгуулагдаж байгаа Замын-Үүд суманд зохион байгуулсан. Төв номын сангийн арга зүйч Г.Баттогтох, үндсэн фондын эрхлэгч Г.Цэндсүрэн нар "Номын сан-Ном зүйн ангилал" "Анхан шатны бүртгэл хөтлөх аргачлал" зэрэг сэдвээр сургалт хийж хандиваар цугласан номуудад техник ажиллагаа болон ангилал зэргийг номын санч нартай хамтран хийж харилцан ярилцаж мэдэхгүй зүйлээ сурч маш өгөөжтэй сургалтыг зохион байгуулсан.

ЗАВХАН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга: Завхан аймгийн номын сан нь 1946 онд Гэгээрлийн хэлтсийн даргын 65 тоот тушаалаар аймгийн бага хурлын номын сан нэртэйгээр 500 номтойгоор 1 орон тоотой анх байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 109-р тогтоолоор төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн Б.Явуухулангийн нэрэмжит болон 75 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрхэм зорилго: Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт, өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **"Мэдээллийн нээлттэй"** төв болох

ХОЁР: НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус номын сан нь 2020 оны байдлаар 52629 ширхэг 121791468 төгрөгийн Монгол, Англи, Орос, Төвд хэл дээрх ном хэвлэлтэй бөгөөд Монгол номын фонд- 2, гадаад /орос/ номын фонд- 1, Гадаад /англи/ номын фонд -1 үйл ажиллагаагаа явуулж байна. Сан хөмрөгийн бүрдүүлэлтийг худалдаа, хандиваар бүрдүүлдэг бөгөөд ном хэвлэл худалдан авах журмаар бүрдүүлэн ажиллаж байна.

2020 онд 174 нэр төрлийн 299 ширхэг 5033200 төгрөгийн ном хэвлэлээр сан хөмрөгөө бүрдүүлснээс:

- Худалдаагаар 108 нэр төрлийн 161 ширхэг 2809,200 төгрөгөөр
- Хандиваар 65 нэр төрлийн 136 ширхэг 1473200 төгрөгөөр фондоо баяжуулан үндсэн фонд болон тасаг танхимуудад хүлээлгэн өгч ажилласан байна. 2020 онд Номын сангийн үндсэн фонд болон ойрын фондонд хадгалагдаж буй Уран зохиолын 10064 нэр төрлийн 20182 ширхэг номын ангилал, баркод,



формулярыг шинэчлэн фондын байрлалыг зөв болгон ажиллалаа.

Номын баяр 2020 үйл ажиллагааны хүрээнд Аз хур номын их дэлгүүртэй хамтран 20-72%-ийн хямдралтай номын худалдааг Улиастай, Тосонцэнгэл сумдад зохион байгуулан тус дэлгүүрээс сум бүрт 100,000 төгрөгийн 28 ширхэг номыг бүрдүүлэн нийтдээ 644 ширхэг 2300000 төгрөгийн ном хэвлэлээр фонд баяжилт хийн 23 сумдын уншигчдын эрэлт хэрэгцээг хханган ажиллалаа.

Уншлага үйлчилгээнд ашиглагдах боломжгүй болсон **190** ширхэг ном,сонин хэвлэлийг ангилан сэргээх засварлах ажлыг номын санч болон ном зүйч нар хамтран зохион байгуулж үйлчилгээнд гаргаад байна.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь Уншлага үйлчилгээний:

- Нийтийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэрээр ном олгох тасаг
- Англи хэлний сургалтын танхимаар үйлчилгээ явуулдаг бөгөөд

Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээс1868 уншигч 15706 ирэгсдэд 21662 ном олгож үйлчиллээ. Уншигч-49,1%-тай, ном олголт39,3%-тайгаар үйлчилгээ үзүүлсэн байна.

Уншлага үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс тасаг танхмын номын санч нар өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн ном уншлагын аянуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Энэ жил дараах уншлагын аянуудыг зохион байгуулж уншлага үйлчилгээгээ явууллаа. Үүнд:

Төв номын сангийн дэргэдэх Номын гүүр гадаад хэлний сургалтын танхим нь гадаад хэл дээрхи ном хэвлэл, сурах бичгийг ашиглах бодитой мэдээлэл олж авах, англи хэл сурах идэвх сонирхлыг нэмэгдүүлэх, түүнд нь дэмжлэг үзүүлэх, гадаад хэлний багш нарын сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор "ЧИХЭРТЭЙ УНШЛАГА"ном уншлагын 1 сарын аян зохион байгууллаа.Тус аянд Жавхлант цогцолбор сургуулийн 8-н бүлгийн нийт 280 суралцагчид, уншигч хүүхдүүд хамрагдан ном унших аяныг дэмжин оролцлоо.

Гэрээр ном олгох танхимаас "Богцтой уншлага" ном уншлагын аянг байнгын хамтарч ажилладаг албан байгууллагын ажилтан болон ЕБС-ын хүүхдүүд, цэцэрлэгүүдийн багачуудыг хамруулан зохион байгуулж ажиллалаа. Уг уншлагад 8-н байгууллагын 85 албан хаагчдад 941 ширхэг шинэ номоор богцтой уншлагын үйлчилгээ үзүүлж, зохиолын болон шүлгийн номын түүврээр үзэсгэлэн гаргаж, **125-**н уншигчдад шинээр карт нээж, гэрээр ном олголоо. Байгууллагын ажиллагсдын дунд "Орос орныг хэн сайн мэдэх вэ?" танин мэдэхүйн тэмцээн, АХА асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулж ажиллалаа. Мөн ЗООНОЗ өвчин

судлалын төвтэй хамтран албан хаагчдад “Хүүхдээ сонсох” ажлыг дэмжих зорилгоор хүүхдэд зориулсан үлгэрийн, шинжлэх ухаан, танин мэдэхүйн нийт 53 нэр төрлийн номоор үзэсгэлэн гаргаж тойм яриа хийж богцтой уншлага аянд хамрууллаа.

Хүүхдийн уншлагын танхимаас санаачлан Улиастай сумын ЕБС, СӨБ-ийн 5 бүлгийн нийт 180 уншигч хүүхдэд Чанга уншлагыг зохион байгуулж, хүүхдийн уншлагын танхимын үлгэрийн номоор чанга уншлага, тойм яриа хийж бяцхан уншигчдад сонордуулж харилцан ярилцаж, ойлгосон зүйлээ зургийн аргаар

илэрхийлэх,өөрийгөө нээж хөгжүүлэхэд нь ихээхэн дэмжлэг үзүүллэн ажиллалаа.

Ковид-19 цар тахлын үед номын сангийн уншлага үйлчилгээг уншигчдад хүргэх зорилгоор “Зөөврийн номын сангаар үйлчлэх болзолт уралдаан”-ыг ажилтнуудын дунд зарлан Улиастай суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагуудад зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн үйлчиллээ. Уг уралдаанд нийт 506 уншигчийг номын сангийн үйл ажиллагаанд татан оруулж 687 ширхэг номыг зөөврөөр өгч ажилласан байна.

Монгол Улсын засгийн газрын санаачилгаар Соёлын яам Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл урлагийн газар хамтран ард иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулах хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор“Соёлын цаг” нөлөөллийн аяныг “Танай багт- Таны дэргэд” уриатайгаар Улиастай сумын 6 багийн иргэд болон ЕБС-ийн 5 сургуулийн суралцагчдад 2020 оны 09 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл амжилттай зохион байгууллаа. Уг аяны хүрээнд Жинст баг, Товцог баг, Богдын гол, Чигэстэй, Жаргалант багуудад, Дэвшил, ЖЦС, ЧЭЛС-ийн суралцагчдад номын сангийн үйлчилгээг хүргэн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн, АХА тэмцээнүүдийг хамт олны хамт амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд ойролцоогоор 800 гаруй иргэд хамрагдсан байна.

ДӨРӨВ: КАТАЛОГ, ЛАВЛАГАА НОМЗҮЙН АЖИЛ

Каталог, картын сангийн зохион байгуулалт:

Монгол, Орос фондын номыг электрон каталогт бүртгэж дууссанаар номын сангийн бүх ном хэвлэлийг электрон каталогт 100 хувь орууллаа. Мөн 299ширхэг шинээр ирсэн номонд техник арга ажиллагаа хийн данс бүртгэлүүдэд тусган тасаг танхимууд хуваарилан уншлага үйлчилгээнд ашиглуулж байна.

Мөн ҮДК болон ТАК-т бүрэн редакц хийж 900 гаруй картын байрлалыг зөв болгож байрлуулан ажиллалаа.

Орон нутгийн картын санг Завхан нутгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагч эрдэмтдийн номоор баяжуулан уншигчдад лавлагаа өгөн ажиллаж байна.

LIB4U програмын онлайнд холбогдон уншигчдыг хаанаас ч номын сангийн ном хэвлэлийг харах, захиалах боломжийг олгон мэдээ мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хүргэн ажиллаж байна.

Ард иргэдээ сонсох өдрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан батлуулж Лхагва гариг бүрийг лавлагааны өдөр болгон 2020 оны 05 сарын 06-ны өдрөөс 07 сарыг дуустал уншигчдад лавлагаа өгч ажиллалаа. Энэ хугацаанд нийт 9 ажилтан лавлагаа мэдээллийн үйлчилгээнд ажилласан бөгөөд номын сангийн үйл ажиллагаа, уншлага үйлчилгээний талаар 287 лавлагааг өгч 61 уншигч сэтгэл ханамжийн судалгаа бөглөж номын санчийн зан харьцаа болон номын сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх саналуудыг ирүүлсэн байна.

Номзүйн ажил:

Zotero програмд 2019 онд Завхан сонингийн 2009-2015 оны өгүүллийг Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүлэлийн санд оруулах ажлыг гүйцэтгэж нийт 182 өгүүлэлийг оруулаад байна. 2021 онд Туяа сонины өгүүлэлийг оруулан ажиллахаар төлөвлөөд байна.





Б.Явуухулангийн 91 насны ойг угтан уншигчдад их найрагчийн намтар уран бүтээлийг сурталчилах зорилгоор түүний намтар номзүйг баяжуулан Номзүй мэдээллийн самбарт байршуулж ажиллалаа.

Мөн “Миний монгол- 2025” аяны хүрээнд Хэлний шинжлэх ухаан, Багш нарын баярыг угтан Сурган хүмүүжүүлэх ухаан, Лавлах хэвлэл сэдвүүдээр номын сангийн фондонд хадгалагдаж буй ном хэвлэлийг сурталчлах зорилгоор санамж өгөх номзүйн бүртгэл хийж уншигчдад лавлагаа өгч ажиллаж байна.





ЛАВЛАХ ХЭВЛЭЛ /Санамж өгөх номзүй/

1. Гансүх А.
"Манай дэлхий" цуврал Ази тив.- Улаанбаатар: Адмон ХХК, 2009. Б.1.- 63х.- ISBN 978-99929-0-765-7.
2. 500 асуулт, хариулт / Ред. Б. Галаарид; Орч. Ш. Даваадорж, Т. Баттулга.- Улаанбаатар: Урлах эрдэм, 1997.- 92х.
3. Мириам Штоппард
Аав хүүхэд төрүүлж болох уу?: Хүүхдийнхээ байнга шалгаадаг янз бүрийн асуултад эцэг эхчүүд хэрхэн хариулах вэ? / Ред. Д. Баттулга, А. Энхнаран; Орч. Л. Эрдэнэбилэг.- Улаанбаатар: АДМОН, <Хэвл.-н онгүй>.- 93х.
4. Ажил мэргэжлийн лавлах толь / Эмхт. Д.Нарангарав, Г.Оюунбилэг ба бус.- улаанбаатар: Бишрэлт тэнгэр ХҮ, 2014.- 478х.- ISBN 978-99973-862-3-6.
5. Айлын ном-2 / Эмхт. Ц. Далхаа; Ред. В. Дашбалжир.- Улаанбаатар: өнгөт хэвлэл, <Хэвл.-н онгүй>.- 32х.
6. Батчулуун Т.
Алдархаан сумын байгалийн үзэсгэлэнт газар нутгууд.- улаанбаатар: <Хэвл.-ийн газар байхгүй>, 2010.- 94х.
7. Батчулуун Т.
Алдархааны байгалийн урлан.- Улаанбаатар: <Хэвл.-ийн газар байхгүй>, 2015.- 168х.
8. Ихбаяр Л.
Амьдран хайрлахуйн өврийн ном.- Улаанбаатар: <Хэвл.-ийн газар байхгүй>, 2005.- 406х.
9. Сониуч хүүхдийн ширээний ном : Амьтны ертөнц / Ред. Н.Цэрэнбат; Орч.

ТАВ. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖИЛ

Сумдын номын сангуудын Монбиблио програмыг онлайнд холбуулан тэдний ажлыг шууд хянах боломж бүрдэж байгаа бөгөөд СУИС-ийн багш Т.Хайдавтай хамтран уг програмын тухай заавар зөвлөмжийг тухай бүр нь хүргэн ажиллаж байна. Мөн өөрийн байгууллагын LIB4U програмын хэвийн ажиллах нөхцлийг ханган Волвес компанийн инженер Гантулгаас утсаар болон фэйсбүүкээр заавар зөвлөгөө аван өөрийн ажилтнуудад програмын шинэчлэлт, програмд гарсан засвар үйлчилгээний талаар мэдээллийг тухай бүрт нь хүргэн ажиллаж байна.

Завхан аймгийн нийгэм эдийн засгийг 2021-2025 онд хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөнд Номын сангийн цахим сан хөмрөгийн эзлэх хувийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4 заалт бүхий санал хүргэгдээд байгаа бөгөөд тус асуудлыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар төлөөлөгчид хэлэлцэн шийдвэрлэнэ.

ЗУРГАА: АРГА ЗҮЙН АЖИЛ

Соёл урлагийн ажилтны өдрийн үйл ажиллагааны хүрээнд 2020 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр сумдын номын санчдад Номын сангийн каталог зохион байгуулалт, Анхан шатны бүртгэл хөтлөх аргачлал, Номын сангийн норм норматив, Номын сангийн үйлчилгээ, Ном сэлбэн засах арга, Номын сангийн фонд зохион байгуулалт, Угийн бичиг хөтлөх арга, СУ мэдээ хөтлөх заавар сэдвүүдээр Номзүйч М.Энхтүвшин, Фондчин Б.Энхцэцэг, Номын санч Э.Сарангэрэл, Ахмад багш А.Янжинхүү нар хичээл бэлтгэн зааж мөн Манлай соёлын төв уралдааны шалгуур үзүүлэлт нэгдсэн дүнг танилцууллаа. Номын санчдад тулгамдаж буй асуудал шинэ санал санаачлагын талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.

Сумдын номын санчдыг шинэ мэдээ мэдээллээр хангах зорилгоор Номын сан мэдээллийн байгууллагад мөрдөх стандарт шинэчлэгдсэнтэй холбогдуулан сумдын номын санчдад стандарт болон бусад журмуудыг эмхэтгэн гарын авлага бэлтгэн хүргүүллээ.





“Манлай соёлын төв” шалгаруулах болзолт уралдааны шалгуур үзүүлэлт, дүгнэх журмыг боловсруулан сар бүрийн мэдээ тайланг нэгтгэн БСУГ-т хүргүүлэн ажиллаж 9 сарын дундаж үнэлгээгээр эцсийн дүн мэдээг гарган тайланг хүргүүлэн ажиллалаа. Энэ арга хэмжээг зохион байгуулснаар номын санчдын ажлын бүтээмж нэмэгдэн шинэ санаачлага, бүтээлч ажлуудыг өрнүүлэн туршлага солилцон уншлага үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн нь харагдаж байна. Номын сангууд өмнөх жилүүдэд дунджаар 11000 гаруй уншигчдад 101000 гаруй ном хэвлэл олгож үйлчилдэг байсан ба уралдааны 9 сарын хугацаанд 13360 уншигчдад 69799 ном олгож үйлчилсэн нь уншигчийг даруй 2360-аар нэмэгдүүлж ажилласан байна.

Шинээр орсон номын санчдад анхан шатны мэдлэг олгох зорилгоор өөрийн номын санд 3 хоногийн хугацаанд дадлагажуулах сургалтыг зохион байгуулдаг ба 2020 онд Яруу, Эрдэнэхайрхан сумын шинээр орсон номын санчид сургалтанд хамрагдлаа.

Номын санчдад мэдээ мэдээллийг тасралтгүй хүргэх зорилгоор цахим сургалтуудыг зохион байгууллаа.





2020-05-07-ны өдөр Монбиблио програмын цахим хэлбэрийг хэрхэн ашиглах талаар мэдээлэл хүргэх Лайв хийчээлийг номын санчдын группт хийн ажиллалаа.

2020-05-25-ны өдөр Каталог зохион байгуулалт сэдвээр номын санчдад дадлага ажлын сургалтыг лайваар зааж хамтран каталогоо зохион байгуулан туршлага солилцон санал бодлыг нь сонслоо.

2020-12-07-ны өдөр шинэ СУ мэдээг хэрхэн бэлтгэх талаар лайвыг номын санчдад хүргэн ажиллалаа.

2020-05-07-ны өдөр Монбиблио програмын цахим хэлбэрийг хэрхэн ашиглах талаар мэдээлэл хүргэх Лайв хийчээлийг номын санчдын группт хийн ажиллалаа.

Мөн Сумдын номын санчдад мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь фэйсбүүк группт байрлуулах болон утсаар тогтмол хүргэн ажиллаж байна.

“Үндэсний бичиг үсгийн баяр – 2020” үйл ажиллагааны хүрээнд ЧЭЛС-ийн багш Э.Мөнгөнсувдтай хамтран Монгол бичгийн дунд шатны 3 цагийн видео хичээлийг бэлтгэн фэйсбүүк группт байршууллаа. Уг хичээлд 23 сумын номын санчид болон төв номын сангийн ажилтнууд хамрагдан монгол бичгийн мэдлэгээ сайжруулсан сургалт боллоо.









"Угийн бичиг хөтлөх арга, аргачлал, түүнийг хөтлөхийн ач холбогдол" сэдэвт сургалтыг Ахмад багш А.Янжинхүүтэй хамтран 23 сумдын

Соёлын төвийн эрхлэгч, номын санч нарт зохион байгуулаа. Сумын иргэд уншигчдад

ураг удамаа мэдэж угийн бичгээ үнэн зөв хөтөлж хойч үедээ өвлүүлэн үлдээх их өв соёлд туслах чиглүүлэхэд нь тухайн сумын соёлын бодлого, үйл ажиллагааг сурталчлан ажиллаж буй ажилтнуудад үр дүнтэй бөгөөд уншигчдын оюуны эрэлт хэрэгцээг хангахад нь ихээхэн ач холбогдолтой сургалтуудын нэг боллоо.

ДОЛОО: ХҮНИЙ НӨӨЦ

Манай номын сан нь захирал, нягтлан бодогч, ном зүйч, мэдээллийн технологич, мэдээллийн ажилтан, фондчин, номын санч-3, зөөврийн номын санч, үйлчлэгч сахиул гэсэн 11 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Эдгээр ажилтнуудаас Мэргэжлийн номын санч-4, Номын сангийн чиглэлээр Магистр хамгаалсан ажилтан – 3 ажилтан ажиллаж байгаа бөгөөд номын санчдыг мэргэшүүлэн сургах сургалтанд хамруулж чиглэл чиглэлээр нь туршлага судлуулсан дадлага ажлуудыг холбогдох газруудад хийлгэж кредит цагийн сургалтуудад номын санчдыг хамруулах шаардлага тулгарч байгаа.

Байгууллагын ажилтнуудын мэдлэг мэдээллийг тэлэх зорилгоор тухайн жилийн сургалтын хэрэгцээг тодорхойлон улирал бүр мэдлэг олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

Номын сангийн хуучин ном хэвлэлийг сэлбэн засварлах ажлыг мэргэжлийн түвшинд чанартай зохион байгуулах зорилгоор Хүүхдийн уншлагын танхимын номын санчийг Монголын үндэсний номын сангийн Мэдээлэл сургалт сурталчилгааны албаны ном сэлбэн засварлах тасагт сэлбэн засварлалтын сургалтанд 5 хоногийн хугацаагаар хамруулан улмаар энэ сургалтаа өөрийн ажилтнууд болон сумдын номын санчдад сургалт, дадлага хослуулан зааж ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулсан.Энэ үеэр нийт 190 гаруй ном хэвлэлийг дүрэм журмын дагуу сэлбэн засч уншлага үйлчилгээнд гаргаад байна.

Library update-2020 номын санчдын нэгдсэн зөвлөгөөнд номын сангийн захирал, номын санч нар хамрагдаж бусад аймгийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан туршлага хуримлуулан ажилтнуудад мэдээ мэдээллийг хүргэн ажилласан байна.

Мөн номын гүүр буюу Bookbridge төслөөс Баянхонгор аймагт зохион байгуулсан сургалтанд Гадаад ном хэвлэлийн тасгийн номын санчийн чадавхи бэхжүүлэх сургалтанд 3 хоногийн хугацаанд хамрагдлаа.

Аймгийн Төв номын сан, Онцгой байдлын газрын 43-р ангийн 2-р салаатай хамтран 2020 оны 10-р сарын 09-ны өдөр гал түймрийн аюулаас сэргийлэх, гал унтраах тархалтын сургалтыг төлөвлөгөөт хөтөлбөрийн дагуу номын сангийн ажиллагсад болон уншигчдад зохион байгууллаа.

Авран хамгаалах, гал түймрийн тархалтыг зогсоох үйл ажиллагааг Номын сангийн объект дээр түшиглэн зохион байгуулсан нь ажиллагсдад гал түймрээс урьдчилан сэргийлэх, онцгой объект дэх эд зүйлийг хамгаалах яаралтай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх зэрэгт нь хувь нэмрээ оруулсан үр дүнтэй сургалт боллоо.

Мөн ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сар бүр нэг ажилтан хариуцан ажилтнуудын хэрэгцээ шаардлага, тухайн сарын онцлогт тохируулан төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгууллаа.

Тухайлбал: Цагаан сарын баяраар Шагайн наадгай тэмцээн, Үндэсний бичиг үсгийн баяраар Монгол бичгийн уралдаан, Хаврын баяр үйл ажиллагааны хүрээнд Спортын тэмцээн уралдаануудыг бусад саруудад АХА тэмцээн, Алтан намар арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллалаа.

НАЙМ. СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Дорнын их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан түүний амьдрал уран бүтээлийн уншигчдад сурталчлан фэйж хуудсанд номын санд хадгалагдаж буй ном





хэвлэлүүдийг болон яруу найрагчийн шүлгээр бүтсэн дуунуудыг фэйж хуудсанд оруулан уншигчдад сурталчлан ажиллаж байна.

Орос хэлний төвийн багштай хамтран ЗООНОЗ-ын өвчин судалын төв, Стандарт хэмжил зүйн ажилтан, албан хаагч, тэдний хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн зохион байгуулж номын санд байгаа гадаад ном хэвлэлийг нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулж нийт 35 сурагчдыг хамруулллаа.

Гадаад сургалтын танхимыг түшиглэн явагдаж буй англи хэлний сургалтанд суралцаж байгаа хүүхдүүдийн дунд BOOKBRIDGE-н нэрэмжит англи хэлний бичгийн олимпиадыг зохион байгууллаа.Тус олимпиадад оролцогч хүүхдүүдийн англи хэлний түвшин бичих, ярих, сонсох,найруулах ур чадварыг нь хөгжүүлэх зорилгоор зохиойн байгуулагддаг тус олимпиадад нийт 48 суралцагчид хамрагдсан.

Хөгжлийн онцлогтой хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулсан номын сангийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд Хүүхдийн уншлагын танхимд долоо хоног бүрийн баасан гаригт үлгэр сонсох цаг өдрийн хүрээнд үлгэрийн кино, контентуудыг тогтмол үзүүлж

хэвшин хүүхдүүд өөрсдийн уншсан сонссон үлгэр,зохиолын дүр дүрслэлийг гаргуулан ярилцуулж үг таах,зохиогчийн бүтээл таах зэрэг тэмцээн уралдааныг танхимд нь зохион байгуулж СӨБ, ЕБС-ийн 72 уншигч хүүхдүүдийг хамрууллаа.

Үлгэрээр дамжуулан бага насны

хүүхдүүдэд эерэг зөв мэдээлэл өгч, уншлагын хурдыг нэмэгдүүлэх зорилгоор ЕБС-н бага бүлгийн суралцагчдын дунд Уншсан номоороо тэмдэглэл хөтлөх” 1 сарын аянг зохион байгууллаа. Уг уралдаанд 9 бүлгийн 343 суралцагчдыг хамруулллаа.

ЕБС-ийн ахлах бүлгийн суралцагчдад зориулан Ном уншихын ач тус танин мэдэхүй лекцийг ахлах бүлгийн суралцагчдад зориулан зохион байгууллаа. Уг лекцээр номын ариг гамтай унших, номоос эерэг зөв мэдээлэл олж авах, авсан мэдээллээ өөртөө хуримтлуулах,бусдад түгээх ном уншснаар хувь хүнд гарах өөрчлөлтийн талаар сурагчидтай ярилцан хэлэлцүүлэг өрнүүллээ. Тус лекцэнд 4-р сургуулийн 3 бүлгийн 65 суралцагчид хамрагдлаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан жил бүр "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Энэ жил “Босоо бичигтэн” сэдэвт хичээнгүй бичгийн уралдааныг ЕБС-иудын 9-12 дугаар сангийн суралцагчдын дунд зарлан 3 бүтээлийг шалгаруулан шагналыг Номын баяр 2020 үйл ажиллагааны үеэр гардуулан бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.



Дэлхийн номын өдрийг тохиолдуулан цахим мэдээллийн сүлжээ бусад технологийн дэвшлийг ашиглан ном хэвлэлийг суртчилах,түгээх ажлын хүрээнд .“Шинэ болон сэдэвчилсэн” 78 ширхэг номыг скайндан цахим сайтаар сурталчлах аяныг өрнүүллж танин мэдэхүй”, “Шинжлэх ухаан”-ны номыг түүвэрчлэн судалж цахим хуудсаар тойм яриа хийж /видео хэлбэрээр/ цахимаар суртачиллаа. Өөрийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 23 нэр төрлийн халдварт өвчин,түүний хор уршиг сэдэвт төрөл бүрийн вирусын чиглэлээр хэвлэгдэн гарсан анагаах ухааны ном, товхимолуудаар лавлагаа ном зүйн жагсаалт бэлтгэн цахим сайтаар олон нийтэд сурталчлан таниуллаа.

2020 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Номын баяр тэмдэглэх тухай 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ард иргэд, хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, ном эрдмийг сурталчлах, хүүхэд залуучуудын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Номын баяр-2020” үйл ажиллагааг “Хязгааргүй ном-сэтгэлгээний эрх чөлөө” уриан дор Хутагтын хүрээлэнд ЕБС,СӨБ-ийн сурагч, багш сурган хүмүүжүүлэгчид, хүүхдийн оролцооны байгууллагууд, идэвхтэн уншигчдын төлөөллөөс бүрдсэн 150 орчим иргэн хамруулан зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Төв номын сангаар үйлчлүүлэгч идэвхтэн уншигчдаа Б. Явуухулан тэмдгээр шагнаж урамшууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд оролцогчдыг идвэхжүүлэх зорилгоор Bookbridge номын гүүрийн гадаад хэлний танхимд суралцагчид оролцогчдод хөдөлгөөнт дасгалыг хийж сонирхууллаа.

- Улсын тэргүүний 1 дүгээр цэцэрлэгийн бага бүлгийн багш нар “Үлгэрийн баатрууд дуулж байна” сэдэвт жүжигчилсэн тоглолтыг зохион байгуулж хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад оньсого таавар,үлгэрийн баатруудындүрийн тоглолтыг таалгах уралдааныг зохион байгууллаа.

- ЧЭЛС-ийн Номч клубийн суралцагчид Болор цомын эзэн яруу найрагч Баттулгын “Монгол бичиг минь үү зээ” Дорнын их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн “Хүлэг минь, шүлэг минь” шүлгүүдээр нээлтэд хүрэлцэн ирсэн оролцогсдод мэндчилгээ дэвшүүллээ.

- Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн,ЕБС-ийн Монгол бичгийн багш нарын бийрэн болон таталган бичгийн бүтээлийн үзэсгэлэн, сурах бичгийн

солилцоо худалдаа болон хандивын хайрцаг аялууллаа.

/Номын баяр нээлтийн үйл ажиллагаа/

“Номын баяр-2020” арга хэмжээг ард нийтэд хүргэх зорилгоор Завхан сошиал ТВ-тэй хамтран уг арга хэмжээний мэдээг бэлтгэн Завхан аймгийн Фэйсбүүк группт байрлууллаа.

Bookbridge англи хэлний сургалтын танхимаас санаачлан орон нутагт ажиллаж амьдарч буй хэлний мэргэшсэн багштай нартай хамтарсан 3 сарын англи, хятад, солонгос хэлний хосолсон сургалтуудыг шат дараатай зохион байгуулж ажиллалаа. Тус сургалтуудад нийт 43 суралцагчид хамрагдсан бөгөөд сургалтын орлогын 20 хувийг гэрээний дагуу авч, нийт1 сая төгрөгийн оролгооруулан ажилласан байна.

9. ШИНЭЛЭГ САНАА, ТОХИЖИЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан төсөл хөтөлбөрийн байгууллагууд болон банкууд, төрийн бус байгууллагуудтай хамтран олон ажил зохион байгуулсаар ирсэн бөгөөд энэ жил НҮБ-ын хүүхдийн сан, Дэлхийн зөн монгол ОУБ-уудтай хамтран дараах төслүүдийг хэрэгжүүлэн уншлага үйлчилгээндээ нэвтрүүлээд байна. Нийт 12 сая төгрөгөөр тус танхимыг тохижуулан техник тоног төхөөрөмж,сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган ажиллаж байна.

Мөн манай байгууллага өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан хөгжлийн онцлогтой иргэд болон хүүхдэд үйлчлэх налуу шат, орох гарах гарцыг хамт олноороо хийж гүйцэтгэлээ.

Хүүхдийн уншлагын танхимын ширээ сандал, ойрын фондны номын тавиур 1988 оноос хойш шинэчлэгдээгүй удсан он удаан жил эдэлгээнд орсон учраас эвдрэл гэмтэл гарч уншигч багачууд сууж үйлчлүүлэхэд бэрхшээл тулгарч шаардалга хангахгүйд хүрсэн байсан бөгөөд Дэлхийн зөн монгол ОУБ-ын Завханхангай ОНХХ-т санал тавьсаны дагуу Хүүхдийн уншлагын танхимын номын тавиур, ширээ сандлыг уншигчдын нурууны өндөрт тохируулан орчин үеийн шаардлагад нийцүүлэн чөлөөт сонголт бүхий уншлагын танхим болгон тохижуууллаа. Мөн өвлийн улиралд уншигч сууж үйлчлүүлэхэд танхим нь барилгын дулаан алдалт ихтэй хүйтэн тохь тух муутай байдаг ба энэ асуудлыг шийдвэрлэн хүүхдийн уншлагын танхимд эко

халаагуур нийлүүлснээр уншигчид дулаан тохитой уншлагын танхимд ном унших, хичээлээ хийх боломж бүрдсэн байна./Хүүхдийн уншлагын танхим дараа нь/

Тус танхимыг тохижуулан нээлтийн үйл ажиллагааг 2020 оны 10 дугаар сарын өдөр зохион байгуулан Аймгийн Засаг Д.Батсайхан болон НБХ-ийн мэргэжилтнүүд болон БСУГ-ын мэргэжилтнүүд, Хүүхдийн оролцооны байгууллагууд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын ажилтнууд оролцон дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээний хүрээнд Завхан аймагт амьдардаг Хөгжлийн бэрхшээлтэй

хүүхүүдэд чиглэсэн тусгай хөтөлбөрт боловсруулж шат дараатай ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: Хөгжлийн онцлогтой хүүхэд, эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг Сэтгэл зүйч багш Ц. Лхагвасүрэн “Хөгжлийн онцлогтой хүүхэдтэй ажиллах, харилцах сэтгэлзүйн зарим асуудал, хүүхэд хамгааллын талаар” лекц уншлаа. ДЗМОУБ ажилтан О.Анхбаяр Хүүхдийн тусламжийн утас 108 талаарх мэдээлэл хүргэсэн. Нийт 70 гаруй эцэг эх , хүүхэд , багш ажилчид тус сургалтанд хамрагдлаа.

Мөн Завхан аймгийн урчуудын эвлэлийн тэргүүн М.Анхцэцэг “Өнгөний зохицлыг зургаар илэрхийлэх” техник сэтгэлгээг хөгжүүлэх сургалтыг хөгжлийн онлцогтой хүүхдүүдийн дунд зохион байгууллаа.

2-р цэцэрлэгийн багш Б.Ням-Очир “Бие бялдар оюун ухааныг хөгжүүлэх” хөдөлгөөнт дасгал хийж дархлааг дэмжин ажиллалаа.

10.БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Завхан аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлын хүрээнд “ЭКО ЗАВХАН” аяны хүрээнд төлөвлөгөө боловсруулан, байгууллагын даргаар батлуулан, төлөвлөгөөт ажлуудыг хийж байна.

Үүнд:

Номын сангийн ажилчдын өрөө тасалгаа, заал танхимуудад агаар цэвэршүүлэх цэцэг болон ногоон ургамалуудыг тарьж ургуулсан нь уншигч үйлчлүүлэгчдэд таатай байгаагаас гадна байгууллагын өнгө үзэмж сайжирсан ба

Одоогоор тасалгааны 13 нэр төрлийн 45 гаруй цэцэг үрслүүлэн тарьсан байна.

Хог хаягдлын хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах үүднээс, орчин тойрны 100 м талбайн хог хаягдалд цэвэрлэгээ хийж, идэвхтэй хандлагыг өрнүүлэн, хэрэгжилт үр дүнг тооцож, аймгийн Хот тохижуулах албатай гэрээ байгуулан хог хаягдлыг ачуулллалаа.Мөн байгууллагын дотор болон гадна хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын хогийн савтай хийж, зааврын дагуу холилгүй зөв ангилан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 03 сарын 17-ны өдрийн А/130 тоот захирамжийн "Ард иргэдээ сонсох аяны" захирамжийн хүрээнд долоо хоног бүрийн лхагва гариг бүрт номын сангаар үйлчлүүлэх иргэдийг тосч үйлчлэн санал хүсэлтийн хайрцаг ажлуулан иргэдээс ирсэн санал хүсэлтийг цаашдын үйлчилгээ арга хэмжээг сайжруулах, сэтгэл ханамжын судалгааг авч нэгтгэн ажилдаа тусган ажиллаж байна.

Цар тахлын үе дэхь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж аймгийн Засаг даргын захирамж гарсантай холбогдуулан төрийн албан хаагч нарыг тусгаарлагдсан иргэдийн хөл хорионы үеэр иргэдэд хяналт тавих эргүүлийн үүрэгт ажлыг гүйцэтгүүлэх ажлын хүрээнд Товцог,Өлзийт багуудад эргүүлийн хуваарь гарган мөрдүүлэн ажиллаж нийт 6 удаагийн эргүүлд 8 ажилтан гарч ажиллаа.Мөн цар тахалаас хамгаалах,танхим тасалгаа номын фондын өрөөнд ариутгал халдваргүйтгэл хийлгэх ажлыг улирал тутам Завхан ариусгал компианаар хийлгэж, ажиллагсад хуваарийн дагуу зал танхимуудад тогтмол их цэвэрлэгээг хийж үйлчилгээний байгууллагын орчны ариун цэвэр ахуйн дэглэмийг сахиулан ажиллахад анхааран ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь 2020 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг 100%-тай хийж гүйцэтгэснээс гадна ОУ-ын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн уншлага үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэн ажиллалаа.

Уншлага үйлчилгээний хувьд: Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээс1868 уншигч 15706 ирэгсдэд 21662 ном олгож үйлчиллээ. Уншигч-49,1%-тай, Ном олголт- 39,3%-тайгаар үйлчилгээ үзүүлсэн байна. Энэ жилийн тухайд уншлага үйлчилгээний хувь буурсан нь Ковид-19 цар тахлын үеэр уншлага үйлчилгээ тасалдсантай холбоотой байна. Сумдын тухайд 2019 оны 09 сараас эхэлсэн “Манлай соёлын төв” уралдаан зохион байгуулснаар номын санчдын идэвхи нэмэгдэн уншлага үйлчилгээний чанар нэмэгдэн өмнөх жилүүдтэй харьцуулахад өндөр хувьтай байгаа нь энэ уралдааны үр дүн сайн байгааг харуулж байна.

Арга зүйн ажлын хувьд: 2020 оны төлөвлөгөөт сургалтуудыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулан ажиллалаа. Цахимаар номын санчдыг сургах олон төрлийн сургалтуудыг зохион байгуулан зохих үр дүнд хүрч ажилласан байна. Энэ жил өөрийн байгууллагын ажилтнуудыг МҮНС болон бусад байгууллагуудаас туршлага судлуулах, практик дадлагуудыг авч мэргэшүүлэн ажиллалаа.

Соёл танин мэдэхүйн ажлын тухайд:2020 оны төлөвлөгөөнд орсон ажил үйлчилгээг Ковидын нөхцөл байдлаас шалтгаалж ихэвчлэн цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд уншигчдын оролцоо, үр дүн өмнөх жилүүдийнхээс бага хувьтай байна. Иймээс цаашид зарим нэг төрлийн ажлуудыг цахимаар зохион байгуулах,ном хэвлэлийг сурталчилах уншигчдын тоог нэмэгдүүлэн ажиллах шаардлагатай байна.

Шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажлын тухайд: 2020 онд төсөл хөтөлбөрийн 2 байгууллагад хүсэлт гаргаж төсөл бичиж хүргүүлсэний дагуу нийт 12 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлэн уншлага үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлээд байна. НҮБ-аас хэрэгжүүлсэн тоног төхөөрөмжийн төслийг хэрэгжүүлснээр СОНА-ыг зохион байгуулах, хөгжлийн онцлогтой иргэдэд үйлчлэх боломжийг нээж өгсөн бөгөөд зарим нэг үйлчилгээг шинээр нэвтэрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой үр дүнтэй төсөл арга хэмжээ байлаа. Тус төслийн хэрэгжилт, явцыг НҮБ-ын хүүхдийн сангийн холбогдох мэргэжилтнүүд газар дээр нь ирж танилцан төслийн хэргэжилтийг үр дүнтэй явагдаж байгаад талархалаа илэрхийллээ. Мөн Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас хэрэгжүүлсэн танхимын тохижилтын ажил уншигч багачуудыг тав тухтай, дулаан орчинд ном унших хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлсэн, орчин үеийн уншлагын танхимын орчин нөхцөлийг бүрдүүлсэн танхимын зохион байгуулалттай болсон нь уншигч хүүхдүүдийн сэтгэлд нийцсэн үр дүнгээ өгсөн ажил байлаа.

ОРХОН АЙМГИЙН НОМЫН ТӨВИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм зорилго. Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглан хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй ирэнийг төлөвшүүлэхэд оршино.

Зорилт 1: Аймгийн Засаг даргын тамгын газарт нийтийн уншлагын танхимыг өргөжүүлэн тохижуулах олон улсын номын сангийн үйлчилгээний түвшинд хүрсэн танхим болгох ажлын төсөл боловсруулах

2021 онд Номын төвийн нийтийн уншлагын танхимыг өргөжүүлэн засварын ажил хийх орон нутгийн нөөц хөрөнгөнөөс 49,0 сая гаргахаар батлагдсан байна

Зорилт 2: Мэргэжлийн бус номын санчдыг номын сангийн мэгэжил эзэмших эчнээ болон цахим сургалтанд хамруулан , мэргэжлийн номын санчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх

Номын төвийн номын санч Ч.Эрдэнэсувд нь Улаанбаатар хотын СУИС-ийн номын сангийн удирдлагаар магсистрантаар , мэргэжлийн бус номын санч Б.Даариймаа, Биндэръяа номын сангийн бакалавар, үйлчлэгч Мөнхтогтох номын сангийн мэргэжил эзэмшихээр суралцаж байна.

Нэг. Уншлага үйлчилгээ

2020 онд Номын төв нь 4 танхим, 1 салбар номын сангаар ном, сонин олгож үйлчлэн, гэрээр ном олгох, албан газар байгууллагуудаар нүүдлийн номын сан ажиллуулах зэрэг уншлагын үйлчилгээ хийж 2861 шинэ уншигчдад карт нээж 15203 байнгын ирэгсдэд 28086 ном олгож үйлчилсэн байна. 2020 онд цар тахлын улмаас танхимын үйлчилгээнээс гадна цахимаар танхимын номын санчид олон ажил зохион байгууллаа.

Номын төвийн 4 танхим 1 салбар номын сан, номзүй, уншлага үйлчилгээний албанаас Эрдэнэт хотын номын төв хуудсанд өгүүллэг,үлгэр, үлгэрийн цаг, монгол бичгээр бичсэн бичвэр, гадаадын зохиолчдын намтар, уран бүтээл, Номын цахим хэлэлцүүлэг 10 удаа, “Эрдэнэт хотын бахархалт зохиолчид” цахим видео 8 зохиолч, эрдэнэт хотын танилцуулга англи хэл дээр зэрэг нийт 63 төрлийн 995 удаагийн материал оруулсанаас 11956 хүнд таалагдаж 3102 хүн хуваалцаж 1723 хүн сэтгэгдэл үлдээн, 56846 хүн харсан үзүүлэлт харагдаж байна.

Гэр бүлийн уншлагын танхим, салбар номын сангаас уран зохиолын номыг 935 хүнд 1116 номыг олгож 763600 төгрөгийн орлоготой гэрээр ном олгон, 17 нэрийн сонин, 5 нэрийн сэтгүүл нийт 23 нэрийн тогтмол хэвлэл захиалан авч өдөр тутам уншуулж байна.

Гадаад хэлний танхим нь танхимын үйлчилгээний хугацаанд 7 хоног бүрийн Даваа, Мягмар, Баасан, Ням гаригуудад англи хэлний насанд хүрэгчдийн болон хүүхдийн , “Монглиш” хүүхдийн ярианы клуб, насанд хүрэгчдийн кино үзүүлэх, ярианы клуб ажиллуулан кино үзүүлэн

ярилцах, энэ оноос шинээр “Кореан speaking club”, “Chinese speaking club”, “Health club”, клубуудыг ажиллуулж 441 хүн хамрагдсан байна

ЦАХИМААР ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

	Танхимын нэр	Хэдэн төрөл удаа	Тандалт				Танхим Номын санч
			Like	Share	Comment	VIEWS	
1	Лавлагаа ном зүй	15төрөл 390 удаа	6883	1040	905	38215	Ч.Эрдэнэсувд
2	Хүүхдийн танхим	12төрөл 104удаа	689	360	176	1086	Б.Даариймаа Л.Гантуяа
3	Гадаад хэлний танхим	12төрөл 268удаа	3647	1508	437	15204	Биндэръяа Хишигмаа
4	Нийтийн танхим	22төрөл 119удаа	393	164	193	1003	Д.Мөнгөнцэцэг Д.Отгонцэцэг
5	Гэр бүл, гэрээр олголт	2төрөл 114удаа	96	12		760	Д.Уранчимэг Н.Ганболор
6	УҮА	3төрөл 15 удаа	245	18	12	578	Н.Отгонцагаан
	Нийт дүн	**63төрөл 995 удаа**	**11953**	**3102**	**1723**	**56846**	

<u>Хоёр: Ном зүйн үйлчилгээ</u>

Энэ онд нийт танхим номын санчид 5 төрлийн санамж өгөх ном зүй гаргасан байна. Нийтийн уншлагын танхимын номын санч Д.Отгонцэцэг, Төрийн шагналт, СГЗ зохиолч Ванганы 100 жилийн ойд намтар номзүй, Гүн ухаан сэтгэл судлалын номын санамж өгөх ном зүй, хүүхдийн уншлагын танхимын номын санч Б.Даариймаа, Л.Гантуяа нар Хүүхдийн зохиолч, О.Сундуй, А.Аръяасүрэн нарын уран бүтээлээр, ерөөл магтаалаар сургуулийн өмнөх боловсролыхонд зориулан санамж өгөх номзүй зэрэг ном зүйн бүтээлүүд гаргасан байна.

Номын сангийн лавлагаа болон мэдээлэл номзүйн үйлчилгээг зохион байгуулж, номын сан, номзүйн мэдлэгийг сурталчлан таниулах тал дээр анхааран ажиллаа. Төв номын сангийн лавлагааны бүрдүүлэлтэнд анхаарч, номзүйн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, Zotero программ дээр “Шинэ мэдээ” сонины 2009-2013 онуудын нийт 5 жилийн 430 мэдээг шүүж оруулаа.



Нийтийн уншлагын танхим нь лавлагааны дэвтэрийг G-Mail дээр хийн хөтлөж нийт 183 лавлагаа, Татгалзлын дэвтрээр 50 хүнээс татгалзал хүлээн авч урагдаж салсан 516 ном, 23 төрлийн сонин нааж хавтаслах ажил хийгдсэн байна.

Аймгийн музей болон соёлын төвүүдээс соёлын биет болон биет бус өвийн жагсаалтыг авч нэгтгэх ажлыг хийж байна. Одоогийн байдлаар дараах байгууллагуудад бүртгэлтэй соёлын өв тээгч хүмүүсийн бүртгэлийг хүлээн аваад байна. Уг бүртгэлээс үзэхэд хамгийн их биет бус соёлын өв тээгчийн бүртгэлтэй соёлын төв нь “Хүүхэд залуучуудын соёлын төв” байна.



Лавлагаа номзүйн үйлчилгээг нийт 111 уншигч, хэрэглэгчдэд үзүүлэн, ирсэн лавлагааны хүрээнд төрөл бүрийн номзүйг цаасаар болон цахимаар бэлдэн түгээсэн. Уншигч хэрэглэгчдийн судалж буй судалгааны ажилтай холбоотой ном, эх сурвалжуудыг санал болгон, үйлчилгээг тухай бүрт үзүүлж байна.





Ном сэлбэн засалт



2020 оны эхний хагас жилийн байдлаар Үндсэн хуулийн өдөр, Сар шинийн баяр, Сансрын нисэгчдийн өдөр, Наурызын баяр, Дэлхийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр зэрэг тэмдэглэлт өдөр баярыг угтсан үзэсгэлэн 68 удаа гарган 1460 номоор гарган шинэ

номоор 21 сэдэвчилсэн 16 шинэ номоор үзэсгэлэн гаргаж, алслагдсан баг, сургууль байгууллагуудаар зөөвөр 33 удаа 415 номоор 504 хүнд хүргэж үүнээс зорилтот бүлгийн иргэдэд 20 удаа 39 номоор 18 хүнд хүргэж үйлчилсэн байна.

Номын тоймыг 8 удаа 264 хүүхдэд, чанга уншлагыг 15 удаа, 466 хүүхдэд хийж, үлгэрийн цагийг 3 удаа 1134 хүнд хийсний 2 удаа 60 хүүхдэд гадаад хэлний танхимаас англи хэл дээр үлгэр сонсож ярилцах ажлыг хийж эхлээд байна.

Байгууллага, үйл ажиллагааны ажлаа сурталчлах ажлыг орон нутгийн хэвлэл мэдээлэл, цахимаар 123 удаа үүнээс орон нутгийн телевизээр 10 удаа, FM-ээр 2 удаа бусад цахимаар 105 удаагийн мэдээ мэдээлэл явагдсан байна.

Олон нийтийн цахим сүлжээгээр “Номын цахим хэлэлцүүлэг” нийт 10 удаа, “Эрдэнэтийн бахархалт зохиолчид” цувралыг мэдээллийн ажилтан А.Бахыт, номзүйч Ч.Эрдэнэсувд нар уран бүтээлчдийн мэдээллийг цуглуулан нэгтгэн бэлтгэж видео хэлбэрт оруулан, уран бүтээлийн “Гүн утга” нэгдлийн гишүүдийн яруу найргийн бичлэгийг цуврал болгон цахимаар нийт иргэдэд хүргэсэн

Монголын ба олон улсын томоохон тэмдэглэлт өдрүүдэд зориулан тухайн баяр, тэмдэглэлт өдрүүдийн тухай мэдээ, мэдээллийг цахимаар буюу “Эрдэнэт хот номын төв” хаягаар дамжуулан нийт иргэдэд хүргэсэн.

Номын төвийн 2020 оны үзэсгэлэн, зөөвөр, номын тойм,
чанга уншлага, үлгэрийн цаг, мэдээ мэдээллийн нэгтгэл

Танхим / Чиглэл	НУЗ	ХУЗ	Го/Гб	В/Гх	СНС	ЛНЗ	ДҮН
Үзэсгэлэн	13 удаа 542 ном	14 удаа 599 ном 237бүтээл	3 удаа 22 ном		6 удаа 129 ном	4 удаа 45 ном	**40 удаа** **1337 ном**
Зөөвөр	6 удаа 54 ном 33 хүн	4 удаа 150 ном 127 хүн	2 удаа 25 ном 20 хүн	3 удаа 46 ном 90 хүн	15 удаа 121 ном 149 хүн	3 удаа 19 ном 85 хүн	**33 удаа** **415 ном** **504 хүн**
Номын тойм			3 удаа 97 хүн	1 удаа 35 хүн	4 удаа 132 хүн		**8 удаа** **264 хүүхэд**
Чанга уншлага		4 удаа 116 хүн	5 удаа 184 хүн	3 удаа 55 хүн	3 удаа 111 хүн		**15 удаа** **466 хүүхэд**
Үлгэрийн цаг			6 удаа	3 удаа 47 хүн	1 удаа 21 хүн		**10 удаа** **68 хүүхэд**
Мэдээ мэдээлэл	11 удаа ТВ-1 FM-10	102 удаа FB-102 удаа	2 удаа ТВ-1 FM-1	2 удаа 2 ТВ	6 удаа FM-6		**123 удаа** **ТВ-4 удаа** **FM- 16 удаа** **FB-105 удаа**
Зорилтот бүлгийн хүмүүс	3 удаа 5 ном	16 удаа 32 ном			1 удаа 2 ном		**20 удаа** **39 ном**

НУЗ - Нийтийн уншлагын танхим

ХУЗ- Хүүхдийн уншлагын танхим

В/Гх- Виртуал-гадаад хэлний танхим

Го/ГБ- Гэр бүлийн танхим

ХХС- Хүний хөгжлийн салбар номын сан

СНС- Салбар номын сан

УҮА –Уншлага үйлчилгээний алба

Нэгтгэсэн УҮА-ны дарга Н.Отгонцгаан

Номын төвийн 2020 оны СОНА -ын нэгтгэл

Сэдэв / Танхим	**НУЗ**	**ХУЗ**	**Го/Гб**	**В/Гх**	**СНС**	**ЛНЗ**	**УҮА**	**ДҮН**
Óðàëäààí ãàð çóðàã		1						**1**
Àñóóëò õàðèóëòûí òýìöýýí ÀÕÀ	2			1				**3**
ÓÁÕóðàë, èëòãýë	1					2		**3**
Íîìûí áàÿð, òýìäýãëýëò ºäºð, Бичиг үсгийн баяр			1				1	**1**
Эссэ зохион бичлэг								
Уулзалт, ярилцлага лекц мэдээлэл	1	1		1				**3**
Нийт хийсэн ажлын тоо / Хүний тоо /	**4 удаа 87 хүн**	**2 удаа 252 хүн**	**1 удаа 45 хүн**	**2 удаа 111 хүн**		**2 удаа 88 хүн**	**1 удаа 300 хүн**	**12 удаа 883 хүн**
Нийт зардал	**393500 Бай-393,5**	**189500 Бай-144,5 Х/б- 45,0**	**20000 Б-20.0**	**Б-150,0 Х/б-60,0**			**2566,5 Бай ЗДТГ**	**3319500 Бай-3274,5 Х/б- 105,0**

НУЗ - Нийтийн уншлагын танхим

ХУЗ - Хүүхдийн уншлагын танхим

В/Гх - Виртуал-гадаад хэлний танхим

Го/ГБ - Гэр бүлийн танхим

СНС - Салбар номын сан

ЛНЗ -Лавлагаа номзүй

Дөрөв. Олон нийт хамтын ажиллагаа

Монгол улсын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ард иргэд, хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, эерэг хандлагыг бий болгох, ном хэвлэлийн салбарын үйл

ажиллагааг дэмжих, нийтийн уншлагыг дэмжин сурталчлах, зохиолчийг алдаршуулах, ажлыг аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсийн санхүүжүүлэн Номын төвөөс Амарын талбайд 2020 оны 09 сарын 25 ны өдөр зохион байгууллаа.

Номын баяраар Улаанбаатар хотоос “Өв орчин үе боловсролын хүрээлэнгээс гаргасан “Тэд яаж Харвардад тэнцсэн бэ” номын бүээлийн хамт олон, зохиолч Шуурайн Солонго, аймгийн зураач урчуудын холбооны уран бүтээлчид үзэсэглэн “Тод анир”, Гүн утга” нэгдлийн зохиолч уран бүтээлчид өөрсдийн номыг худалдаалах, Номын төвөөс илүү акталсан хуучин номын худалдаа зохион байгуулагдлаа.

Мөн номын баяраар нийтийн уншлагын танхимаас 9-12 ангийн сурагчдын дунд” Алтан хонх “ тэмцээн хийж нийт 40 хүүхэд хамрагдаж , гадаад хэлний танхимаас 6-7, 8-9 ангийн хүүхдүүдийн дунд англи хэл дээр АХА тэмцээнд 60 гаруй хүүхэд , хүүхдийн уншлагын танхимаас СӨБ, 1-2, 3-5 гэсэн насны ангиллаар гар зургийн уралдаан зохион байгуулж нийт 226 хүүхэд, гэр бүлийн танхимаас цэцэрлэгийн уншигчдад СТА Хүүхэд залуучуудын театрын жүжигчин Түвшинжаргалаар үлгэр яриулах зэрэг соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж нийт 300 гаруй хүүхэд хамрагдлаа.

Номын баяраар ЕБС-ийн 5 сургуулиас 4 ангийг “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” анги хамт олныг шалгаруулан шагнаж урамшуулан “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”-ээр болзлын дагуу 10 хүүхдийг шалгаруулан шалгарсан анги хамт олноороо Д.Нацагдоржийн “Пионерийн дуу”, “Миний хэнз хурга”, “Миний нутаг” зэрэг дуу шүлгийг ангиараа дуулж сонирхууллаа. Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх их үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж анги хамт олноор нь тэргүүний уншигч анги хамт олон болгосон 1 сургуулийн 5 ангийн багш Цээбурам, 4 сургуулийн багш О.Түмэндэмбэрэл, 14 сургуулийн багш Б.Лхагвасүрэн, 8 сургуулийн багш Б.Баяртүвшин багш нарын шагнаж урамшуулж хүүхэд багачуудын дунд тэмдэглэх үйлсэд багш сурагчдыг өргөн хүрээнд хамруулж тэдний дунд олон соёл олон нийтийн номын тухай ажлыг зохион байгуулсан 5 сургуулийн номын санч Ц.Оюунтуяа, 4 сургуулийн номын санч Нямханд нарыг шагнаж урамшууллаа.

Мөн номын баяраар аймгийн Засаг даргын орлогч Батжаргал, Түвшинжаргал БСУГ-ын дарга Бат-Амгалан нар урилгаар оролцож, СТА хөөмийч Саруултөгс “Жангар” туулийг хайлж үзүүллээ.

Сургалт, арга зүйн заавар зөвлөгөө:

Номын төвийн номын санч Ч.Эрдэнэсувд нь Улаанбаатар хотын СУИС-ийн номын сангийн удирдлагаар магсистрантаар , мэргэжлийн бус номын санч Б.Даариймаа, Биндэръяа номын сангийн бакалавар, үйлчлэгч Мөнхтогтох номын сангийн мэргэжил эзэмшихээр суралцаж байгууллагаас ҮЭ-ийн хамтын гэрээнд заасан заалтын дагуу ажлын цагийг хөнгөвчлөх ажлыг нь зохицуулан сургалтанд хамруулж байна.

Улаанбаатар хотод "Mongolian Library update-2020" сургалтанд дарга А.Уранчимэг, ҮҮА-ны дарга Н.Отгонцагаан нар оролцож Төв аймгаас зохион байгуулсан шилжин явах цомын төлөөх 6 төрлийн спортын тэмцээнд оролцож багаараа гуравдугаар байранд шалгарсан байна.

Номын төвийн уншлага үйлчилгээний албаны дарга Н.Отгонцагаан нэгдсэн бүртгэл хэрхэн хөтлөх талаар 4 сургуулийн номын санч Л.Долгормаад, Жаргалант сумын соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаанд хяналт хийж номын бүртгэлд дүгнэлт гаргасан. Аймгийн Онцгой байдлын газарт шинээр номын сан байгуулах талаар зөвлөмж өгч, номын сангийн бүртгэл судалгааг хэрхэн хөтлөх талаар заавар зөвлөгөө өглөө.

Фондын ажил, тооллого тооцоо

2020 онд улсын төсвөөр шинээр ном, сонин авах 4368,300 мянган төгрөгийн төсөв батлагдаж үүнээс номын сангийн фондын сан хөмрөгт шинээр 198 нэрийн 298 ширхэг 7710848 төгрөгийн ном шинээр нэмэгдсэнээс төсвөөр 129 нэрийн 186 ширхэг 5462000 төгрөгийн, хандиваар 63 нэрийн 100 ширхэг 2103848 төгрөгийн ном, заавал авах хувиар 6 нэриын 12 ширхэг 145000 төгрөгийн, 17 нэрийн 689100 төгрөгийн сонин, 5 нэрийн 300400 төгрөгийн сэтгүүл нийт 35 нэрийн 906000 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан авсан байна.

Дэнжийн салбар номын сан, Хүний хөгжлийн дэргэдэх салбар номын сан татан буугдаж аймгийн Хүүхдийн ордонд нэгдэн орсон учир салбар номын сангуудаас ирсэн 427 ширхэг 4643000 төгрөгийн номыг нөхөн бүрдүүлэлтээр программд оруулан техник ажил хийсэн байна.

Энэ онд байгууллагын хэмжээнд ээлжит бус номын тооллогыг салбар номын сан 2 удаа, Хүүхдийн танхим 3 удаа, гадаад хэлний танхим 1 удаа, гэр бүлийн уншлагын танхим 2 удаа хийж тооллогоор дутсан 60 гаруй ширхэг номыг номоор нь төлүүлэн номын санчдын хариуцлагыг өндөржүүлэх ажлыг хийсэн байна.

Хүний нөөц, судалгаа, дотоод ажил

2020 номын санч Д.Сувдаа, Ш.Гарамханад, үйлчлэгч Ц.Оюунчимэг нар өндөр насны тэтгэвэрт гарч Төрийн албаны тухай хуулийн 60.1 заалтын дагуу хөнгөлөлт 52.0 сая төгрөгийн тэтгэмж төсөвт суулган олгосон байна.

2020 оны Төрийн албан хаагчийн хүний нөөцийн нэгдсэн системийн судалгаа, соёл урлагийн ажиллагсдын хүний нөөц, тоног төхөөрөмж, уншлага үйлчилгээний чиглэлээр аймгийн Боловсрол соёл урлагийн газар , Үндэсний номын санд суралцсан.

1.Номын төвийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж жагсаалтанд байнга хадгалах 10, түр хадгалах 15, 70 жил хадгалах 3 хадгаламжийн нэгжийг батлуулсан байна. Манай байгууллага дээр одоогийн байдлаар 252 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

2.Тухайн онд гаднаас ирсэн бичиг 82-албан бичгийг хүлээн авсан байна.
Үүнээс: Захирамж-24, тогтоол4, даалгавар 2 хариутай бичиг-10, шууд бичиг 34, бичиг баримтыг хүлээн авч бүртгэлд оруулсан байна.Тухайн жилийн хугацаанд ирсэн хариутай бичгийн хариуг хугацаанд явуулсан байна.



3.Тухайн онд 63 албан бичгийг гадагш явулсан байна. Үүнээс:
Шууд бичиг 42, ажлын болон цалингийн тодорхойлолт 2, бусад19

4. Энэ оны үндсэн үйл ажиллагааны А тушаал 30 , Боловсон хүчний Б тушаал 4-ыг үйлдэж цаг хугацаанд цаг хугацаанд бүртгэлд оруулсан байна.

5.Өргөдөл гомдлын мэдээг бүртгэж архивын болон аймгийн өргөдөл гомдлын программд оруулан улирал бүр мэдээг өргөдөл гомдол мэдээ хариуцсан ажилтанд хүргүүлсэн. 70351111 утсаар гаргасан иргэний гомдлыг хүлээх авч хуулийн хугацаанд нь гомдлын хариуг хүргүүлэнэ ажилласан.

Санхүү, материаллаг баазыг бэхжүүлэх талаар

2020 онд 345,2 сая төгрөгийн төсвийн санхүүжилт авч ажилласан байна.

2019 онд Номын төвийн өөрийн орлогын 3700,0 мянган төгрөгийн Сангийн сайдын 74 дүгээр тушаалыг үндэслэн 3700,0 мянган төгрөгийн давсан орлогыг Номын баярын соёл танин мэдэхүйн ажлын шагнал урамшуулалд 3,0 сая төгрөг, Төв аймгийн Номын сангийн 6 төрлийн спортын уралдаан тэмцээнд 1,0 сая гаруй мянган төгрөгийг зарцуулан ажилласан байна.

Нийт ажиллагсдын цалингийн сан 222,2 сая төгрөгөөр батлагдсанаас үндсэн цалинд 145,1 сая төгрөг зарцуулж ур чадвар үр дүн-13,7 сая төгрөг, унаа хоолны зардалд 13,7 сая төгрөг , Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 хавсралтаар орон нутгийн нэмэгдэл 7.2 сая төгрөг, төрийн алба хаасан олон жилийн нэмэгдэл 27,5 сая тус тус олгосон байна. Мөн энэ онд ахмадын санг бий болгож цалингийн сангийн 2 хувь буюу 3926,2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Урсгал засвар 1800,0 мянган төгрөг батлагдсаныг байгууллагын дотор хана шат будах, цахилгааны монтаж шинэчлэх зэрэг ажил хийж гүйцэтгэлээ.

НОМЫН БАЯРЫН НЭЭЛТ

Амарын талбай дээр хийгдсэн СОНА-уудаас

Амарын талбайн номын худалдаа, зохиолч уншигчдын уулзалт

ТӨВ АЙМГИЙН СПОРТЫН ТЭМЦЭЭН

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Аймгийн төв номын сан нь уншигч иргэдэд мэдлэг мэдээлэл олж авах орон нутгийн оюуны хөгжлийн нээлттэй мэдээллийн төв болоход оршино.

АЛСЫН ХАРАА:

Номын сангийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийн технологийн шинэчлэл нэвтрүүлж, цахим электрон номын сангаар иргэдэд үйлчилнэ.

1.2. НОМЫН САНГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Манай номын сан нь 1946 онд байгуулагдсан. Нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. 2019 онд захирал 1, нягтлан бодогч 1, аргазүйч 1, сан хөмрөгч 1, номзүйч 1, номын санч мэдээллийн ажилтан 3, IT инженер 1, жолооч 1, жижүүр 1, үйлчлэгч 2 гэсэн орон тоотойгоор Боловсрол танхим , Хүүхдийн уншлагын танхим, Гэрээр ном олгох танхим , Хүүхдийн номын ордон , Интернэт танхим, Лавлагаа мэдээллийн танхимуудаар дамжуулан уншлага үйлчилгээ явуулан ажиллаж байна

Facebook хаяг : ӨВӨРХАНГАЙ ТӨВ НОМЫН САН

Номын сангийн албан ёсны имэйл хаяг: UVNOMIINSAN@GMAIL.COM

Ажиллах цагийн хуваарь: 09:00-18:00

Байгууллагын утасны дугаар: 70322613

Номын сангийн захирал: Л.Анхбаяр

2. САН ХӨМРӨГ, КАТАЛОГ

2.1 Сан хөмрөгийн өнөөгийн байдал

2020 онд 242 төрлийн 427 ширхэг номоор фондоо баяжууллаа. Үүнээс уран зохиолын ном 110 ширхэг, Түүхийн ном 51ш, Аман зохиолын ном 58 ширхэгээр фондоо баяжуулсан байна. Номын сангийн фондод байгаа ном хэвлэлийн бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалтанд анхааран ажиллаж, тавиур тус бүрийн номуудийг шинжлэх ухааны ангилалын дагуу байрлуулж, шинээр ирсэн номыг хүлээн авч фондын нэгдсэн бүртгэл, танхимуудын бүртгэлд бүртгэн танхимуудад хүлээлгэн өгч монголын уран зохиолын номуудыг үсэг дараалал дотор нь зохиолч зохиолчоор, зохиолчдыг үсэг дараалалаар нарийвчлан ангилаж байрлуулж цэгцлэв.

Фондоос Гэрээр ном олгох танхимд 1508 ном , Өргөө-2 гэрээр олгоход 500 ном, ирээдүй танхимд 29 ном, боловсрол танхимд 18, лавлагаанд 33 ном, өргөө 1-т 5 ширхэг нийт 2093 номыг түр шилжүүлэгээр шилжүүлэн уншигчдын захиалгын дагуу үйлчилсэн байна.

<u>2020 оны үзүүлэлт</u>

Фондын эргэлт $\text{ФЭ} = \frac{\text{НО} \quad 6299}{\text{НФ} \quad 48976} = 0{,}12$

Ном хангамж $\text{НХ} = \frac{\text{НФ} \quad 48976}{\text{У} \quad 835} = 58{,}6$

Ном уншилт $\text{НУ} = \frac{\text{НО} \quad 6299}{\text{У} \quad 835} = 7{,}5$

2020 онд 188,000 төгрөгийн өдөр тутмын 3 нэр төрлийн сонин, 2 нэр төрлийн сэтгүүл захиалан уншигчдад хүргэж байна. Захиалгийн дагуу сонин сэтгүүлийг шалган хүлээн авч бүртгэлийг тогтмол бүртгэж байна. Сонингуудыг хагас жилээр нь үдэн хавтаслаж фондонд хүлээлгэн өглөө.

“Баримтат өвийн хадгалалт хамгаалалтын сайжруулах ажлын хүрээнд Соёлын баримтат өвийн цаасан суурьтай дурсгалууд болох Жадамба судар /Бээжин барын ном/, Дүлба буюу Дулбагийн тайлбар судар /Сахил санваартны дүрэм/, Алтангэрэл судар, Банзрагч Таравчимбу /Нүгэл арилгах/ судруудыг Гандaнпунцоглин хийдийн лам нараар жаяг дэгийн дагуу болгон баринтаглуулан хаягжуулж, хуудас нь холилдсон Дулба сударыг хуудас

дараалалд оруулан засуулж , сударуудын нэрийг донторт бичүүлэн авч урагдаж гэмтсэн судрыг эвлүүлэн нааж янзаллаа.

2.2 Номын сангийн электрон каталогт 2020-12-31 –ний байдлаар 22226 төрлийн 48983 ширхэг ном бүртгэгдсэн байна. 418 уншигчийг программд бүртгэж уншигчийн үнэмлэхийг хэвлэлээ. Уншлага үйлчилгээнд гарч бар код хуучирч, кодгүй болсон 127 ширхэг номыг дахин коджуулж үйлчилгээнд гаргасан ба шинээр ирсэн 427 ном нь хавтасны зураг агуулгын тайлбартайгаар мэдээллийн санд тусгагдаж байна



2.3 КАТАЛОГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хийгдсэн ажил	Тоо хэмжээ
Электрон каталогт бүртгэгдсэн нийт ном	48983
Электрон каталогт шинээр нэмэгдсэн	427
Электрон каталогт редакц хийгдсэн ном зүйн бичлэгийн тоо	50
Электрон каталогт хийгдсэн хайлтын тоо	14150
Картан каталогт бүртгэгдсэн нийт	427

Номзүйн ажлын талаар:

“**Өврийн сайхан хангай ном хэвлэлийн хуудаснаа**” цахим ном зүйг Зотера программ дээр үргэлжлүүлэн хийж **“Улирал ба зохиолч “** сэтгүүлээс 129 ширхэг мэдээлэл, Өвөрхангайн элч сониноос 48 мэдээлэл нэмж оруулсан ба уншигчийн хүсэлтийн дагуу лавлагааг байнга өгч байна.

2. ҮЙЛЧИЛГЭЭ

2.1 УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Жилийн эцсийн байдлаар нийт 835 уншигч , 7298 ирэгсэдэд 6299 ном олгож уншигчдыг шинэ шилдэг ном сонин сэтгүүлээр ханган үйлчилж , оюуны хөгжлийн нээлттэй төв болох зорилгоо биелүүлэн ажиллаж байна. Аймгийн төв номын сан нь зөөврийн номын сангийн үйлчилгээг Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар , МСҮТөв, Мэргэд сургуульд үзүүлсэн ба нийт 185 ширхэг номоор үйлчиллээ. Мөн хүргэлтийн номын сангийн үйлчилгээг нэвтрүүлэн төв бараан захын худалдаачдад шинэ болон хүүхдийн уран зохиолын 105 ширхэг номоор үйлчлэн уншигчийн тоог нэмэгдүүлж номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн ажиллаа. Манай номын сан нь ном зүйн мэдээллийн үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс 26 удаа 1765 ширхэг шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж, танин мэдэхүйн ажлуудыг тогтмол зохион байгуулж байна.

№	Танхимын нэр	Үзэсгэлэн	Тоо ширхэг
1	Фонд	“Үндэсний бичиг үсгийн баяр”	143
2		Бурхан багшийн мэндэдсэн өдрөөр	40
3		Улсын баяр наадмаар	50
4		Номын сангийн гадна талбайд	30
5		хүүхдийн номоор үзэсгэлэн	50
6		Дэлхийн номын өдөрт зориулан “Дэлхийн шилдэг зохиол”	150
7		“Соёлын дархлааг дэмжих” ажлын хүрээнд Адууны соёл, Хурдан морьтой холбоотой номоор	80
8		Соёлийн цаг нөлөөлийн аяны хүрээнд Багийн төвийн урд талбай	200
9		МСҮТөв	200
10		ЗХ-ний 256-р ангид	200
11		Цахимаар Туулийн номын үзэсгэлэн	80
12			
13	Лавлагаа	Цахимаар шинэ номын үзэсгэлэн	15
14		Соёлийн цаг нөлөөлийн аяны хүрээнд Багийн төвийн урд талбай	30
15		МСҮТөв	30
16		ЗХ-ний 256-р ангид	30
17	Гэрээр ном олгох танхим	Соёлийн цаг нөлөөлийн аяны хүрээнд Багийн төвийн урд талбай	30
18		МСҮТөв	35
19		ЗХ-ний 256-р ангид	54
20		Дэлхийн номын өдөрт зориулан “Дэлхийн сонгодог зохиол”-ын номоор	65
		Цахимаар шинэ номын үзэсгэлэн 7 удаа	65
21	Хүүхдийн уншлагын танхим	Соёлийн цаг нөлөөлийн аяны хүрээнд Багийн төвийн урд талбай	31

22		МСҮТөв	31
23		ЗХ-ний 256-р ангид	31
24		Дэлхийн номын өдөрт зориулан “Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол”	35
25			
26	Хүүхдийн номын ордон	Дэлхийн номын өдөр	60
Нийт:		**26 удаа**	**1765**

Гэмтэж урагдсан номонд сэлбэн засалт хийж уншлаганд гарахад бэлэн болголоо.

№	Танхим	Сэлбэн засалт хийсэн номын тоо
1	Гэрээр ном олгох танхим	45
2	Хүүхдийн уншлагын танхим	38
3	Хүүхдийн номын өргөө 1	38
4	Хүүхдийн номын өргөө 2	40
5	Фонд	30
Нийт		191



<u>3.СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ</u> :

2020 оны жилийн эцсийн байдлаар төв номын сангаас зохион явуулсан соёл, олон нийтийн ажлууд:

3.1 <u>Дэлхийн номын өдөр</u>

Өвөрхангай аймгийн төв номын сан болон Хүүхдийн номын ордон нь “Дэлхийн номын өдөр”-ийг ***цахимаар тэмдэглэе*** уриан доор 2020 оны 04 дүгээр сарын 23,24-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ.

Тус өдрүүдээр Шинэ номын танилцуулга, Сонгодог болон шинэ, уран зохиолын номын үзэсгэлэнг цахимаар иргэд, уншигчдад суртчиллаа

Сонгодог зохиолын номын үзэсгэлэн

Шинэ номын танилцуулга

Шинэ болон салбар шинжлэх ухааны номын

үзэсгэлэн

Дэлхийн алдарт зохиолч Жюль Верний намтар, уран бүтээлээс танилцуулж “Усан доогуур 20000 бээр аялсан нь” зохиолоор уншигчидтай ярилцан сэтгэгдэлийг нь иргэдэд хүргэлээ.

Мөн Дэлхийн номын өдөрт зориулан **“Хүргэлтийн номын сан”**-гийн үйлчилгээг 04 дүгээр сарын 23-ны өдөр иргэд, уншигчдад хүргэлээ. Тус өдрөөр 12 уншигчдад 28 номоор үйлчилсэн болно.

“Танин мэдэхүйгээ сорьё” асуулт хариултын LIVE уралдааныг өөрийн цахим хуудсаараа дамжуулан иргэд уншигчдын дунд зохион явууллаа.

I байранд: Арвайхээр сумын иргэн М.Дөлгөөн

II байранд: Дэлхийн зөн олон улсын байгууллагын Өвөрхангай аймаг дахь төслийн зохицуулагч Б.Уганхүү**III байранд:** Өв.Хайрандулаан сумын Соёлын төвийн хөгжмийн багш Т.Батжаргал нар хамгийн олон асуултанд түрүүлж хариулан шалгаран номын сангаар үнэгүй үйлчлүүлэх эрхийн бичиг болон номоор шагнагдлаа.

3.2 Үндэсний бичиг үсгийн баяр

Үндэсний “Бичиг үсгийн баяр”-ыг тэмдэглэх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх, монгол бичгийг сурах, түгээн дэлгэрүүлэх, сурч эзэмших явдлыг хөхүүлэн дэмжих, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг Үндэсний “Бичиг үсгийн баяр”-ыг Өвөрхангай Аймгийн Төв номын сан 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр цахимаар тэмдэглэлээ.

1. VI-XII ангийн сурагчид болон насанд хүрэгчдийн дунд “Уран дүрс бичлэг”-ийн уралдаан, “Цэвэр бичигтэн” шалгаруулах уралдаан зохион байгуулах удирдамжийг ЕБСургууль, иргэдэд хүргэн ӨВӨРХАНГАЙ ТӨВ НОМЫН САН цахим хуудаснаа материалыг хүлээн авч 05 дугаар сарын 15-нд уралдаанд ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргалаа. Уралдааныг ЕБ-ийн 4 дүгээр сургуулийн багш Март, 2 дугаар сургуулийн багш Түгжсүрэн нар шүүж LIVE-аар шууд дамжууллаа.



Уралдаанд нийт 29 бүтээл ирсэнээс :

"Уран дүрс бичиг"-ийн уралдаанд

1-р байр: Мэргэд бага ангийн багш Л.Санжаасүрэн
2-р байр: Уянга сумын оролцогч Б. Бямбатогтох
3-р байр: Уянга сумын оролцогч Ганхуяг

Хичээнгүй сайхан бичиг / насанд хүрэгч/-ийн уралдаанд

1-р байр: Арвайхээр сумын 4-р сургуулийн бага ангийн багш Д.Нарантуяа
2-р байр: Арвайхээр сум мэргэд сургуулийн багш Б.Энх-Очир
3-р байр: Нарийн тээл сумын оролцогч Л.Загармаа

Хичээнгүй_сайхан_бичиг / хүүхэд/ - уралдаанд

1-р байр: Мэргэд сургуулийн сурагч Э.Хонгорзул
2-р байр: Бүрд сумын ЕБС-ийн 8а ангийн сурагч Э.Долгорсүрэн
3-р байр: Мэргэд сургуулийн 10а ангийн сурагч Т.Мөнгөнсор нар шалгарлаа.

Хүүхдийн ордны монгол бичгийн дугуйлангийн багш, эх бичиг судлаач А.Мөнхсамбуутай хамтран иргэд, хүүхэд багачуудад уран бичлэг, татлан бичих талаар зөвлөгөө мэдээлэл хүргэлээ.

Номын сангийн фондонд хадгалагдаж буй монгол бичгийн номоор үзэсгэлэн гаргаж видео бичлэг бэлтгэн цахимаар сурталчиллаа.

3.3 Номын баяр

Ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн нэрэмжит Өвөрхангай аймгийн төв номын сан нь номын баяр 2020 арга хэмжээний хүрээнд “Аз хур” номын дэлгүүртэй хамтран номын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж Сумдын соёлын төв болон ЕБС-ийн номын сангуудын дунд номын захиалга, ном худалдан авах болзолт уралдаан зохион байгуулж шалгаруулж урамшууллаа.

Хамгийн олон ном худалдан авсан номын санг урамшуудан 200000 төгрөгний номоор шагнасаныг хүлээн авч Мэргэд, 1-р сургууль, Төгрөгийн номын санд хүлээлгэн өгөв.

3.4 Соёлын цаг

МУ- ын Засгийн газар, Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газраас зохион байгуулсан “Соёлын цаг” нөлөөллийн аяны хүрээнд Аймгийн төв номын сан нь төлөвлөгөөний дагуу Аймгийн ЗДТГ, Засаг даргын дэргэдэх БСУГ - ын СУХ, аймгийн ХДТ, аймгийн Музейтэй хамтран үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг нөлөөллийн аянаар Өвөрхангай аймгаас төрөн гарсан зохиолчдын бүтээл болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн, танин мэдэхүйн уралдаант тэмцээнүүдийг зохион явуулж оролцогчдыг шагнаж урамшууллаа.

Аяны хүрээнд засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, соёл урлагын газраас авсан хэрэглэгчийн судалгааг аван тайланг БСУГазарт гарган өгсөн.

Өвөрхангай аймгийн төв номын сан нь **" Соёлын цаг"** арга хэмжээний хүрээнд 2020 оны 09-р сарын 22-нд гадаах тайлбайд шинэ болон сэдэвчилсэн, хүүхдийн номын /140 ширхэг ном/ үзэсгэлэн зохион байгуулсан ба тус өдрөөр уншигчийн карт үнэ төлбөргүй нээж гадаах уншлагыг зохион байгууллаа

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖ /2020-10-01/

Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллежид Өвөрхангай аймгаас төрөн гарсан зохиолчдын бүтээл болон хувь хүний хөгжлийн 160 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж сурагчдын дунд ардын аман зохиолоо хэн сайн мэдэх вэ ? тэмцээн зохион байгууллаа. Уг тэмцээнд 35 сурагч оролцсоноос барилгын ангийн 8г ангийн сурагч н.Энхболд тэргүүлж номоор шагнууллаа

“ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 256 ДУГААР АНГИ” /2020-10-08/

Зэвсэгт хүчний 256 дугаар ангид Өвөрхангай аймгаас төрөн гарсан зохиолчдын бүтээл болон шинэ номын /120 ш ном/ үзэсгэлэн гаргаж “50 номын уналт” танин мэдэхүйн тэмцээнийг зохион явууллаа. Уралдаанд албан хаагчдын 5 баг оролцсоноос ахлагч нарын баг хамгийн олон асуултанд хариулж амжилттай оролцон шилдэг уран зохиолын номоор шагнагдлаа .

Мөн 2,7 дугаар багийн цэцэрлэгт хүрээлэнд Өвөрхангай аймгаас төрөн гарсан зохиолчдын бүтээл болон шинэ 120ширхэг номоор номын үзэсгэлэн гаргалаа.

3.5 “Соёлын дархлааг дэмжих” жилийн хүрээнд

Номын санч мэдээллийн ажилтнууд цахим орчинд ардын аман зохиолын төрөл түүний тухай мэдээ мэдээллийг тогтмол байршуулж иргэдийг мэдээллээр хангаан нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна.Үүнд:

- Номын санч мэдээллийн ажилтан Б.Цэрэнпүрэв: Хүүхэд багачууд, эцэг эхчүүддээ зориулан хүүхдийн уншлагын танхимаас амьтдын, аж байдлын, ид шидэт, шог хошин, домог үлгэр, сургамжит өгүүллэгийг нийт **62** удаа суртчилан, танин мэдүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг цахим орчинд хийсэн ба ингэнд ботго авахуулах зан үйл, цуур хөгжмийн зэмсэгийн тухай материал бэлдэн уншигч иргэдэд таниулах, суртчилах, зорилгоор соёлын өв хөгжлийн дархлаа пайжид байршуулсан.
- Сан хөмрөгч С.Энхтогтох: Адууны соёл, Хурдан морьтой холбоотой 50 ширхэг номоор номын үзэсгэлэн гаргасан ба Зүйр цэцэн үг , Ертөнцийн гурав, хүүхэдтэй холбоотой зан заншилын талаарх мэдээллийг цахим орчинд байршуулсан. Үүнд: Хүүхэдтэй холбоотой уламжлалт ёс заншилаас цуврал болгон "Шинэ хүн", "Авсан ээж", "Өлгий", "Эхэс оршоох ёсон", "Угаалаг үйлдэх ёс", "Нэр өгөх ёс", "Хүүхдийг хамгаалах зан үйлүүд", "Шинэ хувцас өмсгөх ёс", "Бүүвэйлэх", "Хүүхэд домнох ёс", "Тушаа хайчлах ёс", " Ширгэлэх", "Даахь сэвлэг үргээх ёс", "Төрсөн өдөр мялаалгын баяр",” Хүүхэд хөхнөөс гаргах” зэрэг 20 оод мэдээлэл багтсан байна.
- IT инженер Л.Даваахүү: Сургамжит өгүүллэг, “Хангайн магтаал”, “Эсгийний ерөөл” гэх мэт 47 мэдээллийг цахим орчинд байршуулж суртчилсан.
- Номзүйч Б.Жаргал: Н.Багабанди ”Титэм үг” номноос 95 мэдээлэл Сургамжит өгүүллэгээс 8 мэдээлэл Х.Баасансүрэн. “Ухаарахуйн сургаал”-аас 5 мэдээлэл цахимаар хүргэсэн ба Zotera программ ашиглан туулийн мэдээлийн сан үүсгэж 88 мэдээлэл шивж орууллаа.

- Номын санч мэдээллийн ажилтан О.Долгормаа: Соёлын өв-хөгжлийн дархлаа” пэйж-д 6 удаа аман өвийн төрлөөр мэдээлэл оруулсан ба Арвайхээр сумын хэмжээнд аман өв/домог/-ийн цуглуулгын дэвтэр нээсэн
- Аргазүйч Д.Отгонболор:: “Монгол тууль” сэдвээр 13 удаа мэдээлэл
- Номын санч мэдээллийн ажилтан Д.Болортуяа: Монгол ардын үлгэрүүдээр Аудио үлгэр бэлтгэн соёлын өв хөгжлийн дархлаа пайжид байршуулсан ба “Шинэ номын мэдээлэл, өгүүллэгээр” 20 удаа мэдээлэл хийсэн байна.

Мөн номын санчид хамтран номын сангийн фондонд хадгалагдаж буй “Үнэт ховор ном судар”-ыг суртчилах богино хэмжээний видео танилцуулга, хүүхэд багачуудад уран бичлэг, татлан бичих талаар ярилцлагыг бэлтгэн “Соёлын өв хөгжлийн дархлаа” пайжид байршуулан иргэдэд хүргэсэн болно.

4. ХҮНИЙ НӨӨЦ

4.1 Арга зүйн ажлын хүрээнд:

Номын санч мэдээллийн ажилтнууд хариуцсан 3 сумдын номын санчидтай уялдаа холбоотой ажиллан мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь өгч, номын сангийн ангилал, Электрон каталоги зохион байгуулалт. Номзүйн бичилтээр ном тодорхойлох, Номын сангийн программ дээр хэрхэн ажиллах талаар соёлын төвийн номын санчид болон сургуулийн номын санчдад мэргэжлийн талаас зөвлөгөө өгч ажиллалаа.

4.2 сургалт, семнарь:

- Соёлын яамны агентлагын дарга Нацагдолгорт глиын сангийн үйл ажиллагааг танилцуулсан ба уншигчидтай ажиллах арга барилын талаар зөвлөгөө авсан.
- Бүтээлч үйлдвэрлэлийн инновацийн төвийн захирал Ж. Эрхэмтөгсийн “Монгол улсад соёлын инновац, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж, шийдэл” сертифкаттай үндэсний симнарт номын санчид оролцлоо
- Соёл урлаг, судлалын ухаан доктор Л. Оюунчимэг багшийн “Өөрчлөлтийг өөрдөөсөө эхлье” сургалтанд суусан.

4.3 2020 оны 12- р сарын 20 нд “Аман өвийн уламжлалын хадгалалт, хамгаалах зарим арга зам” эрдэм шинжилгээний цахим хуралд сан хөмрөгч С.Энхтогтох “Аман өвийг уламжлуулан хэвшүүлэх нь” сэдвээр, номын санч мэдээллийн ажилтан Б.Цэрэнпүрэв: “ Үлгэр түүнийг танин мэдэх, суртчилах, түгээн дэлгэрүүлэх арга зам” сэдвээр тус тус илтгэл бичиж амжилттай оролцсон.

5.БУСАД

6.1 “Соёлтой иргэн, цэвэр хот 2020” зорилтот жилийн хүрээнд Аймгийн төв номын сан нь гаднах өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор 2020 онд барилгын гадна талд пасад хийн барилгын дээврийг шинэчиллээ.

Ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн хөшөөг номын сангийн өмнөх талбайд шилжүүлэн байрлууллаа.

Байгууллагын гаднах ногоон байгууламжийн зэрлэг ургамлыг түүж шинээр 50 ширхэг улиас мод суулгалаа. Байгууллагын хайсны хаалгыг урд талд нь шинээр гаргаж явган хүний зам тавьлаа.

“Хүүхдийн номын ордон”-ы ногоон байгууламжийг хамгаалах зорилгоор 8 метр төмөр хайс, 10,5 метр гинжин хамгаалалт хийж ногоон зүлэг суулгасан ба хогийн сав байрлуулсан.

Номзүйч Жаргал, сан хөмрөгч С.Энхтогтохын санаачилгаар "Бүтээлч байж, орчиноо өөрчилье" аяныг байгууллага эхлүүлж самбарын тохижилтийг хийж гүйцэтгэлээ.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Иргэдэд номын сангийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, орчин үеийн мэдээлэлжсэн нийгмийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн соёл танин мэдэхүйн арга хэмжээнүүдээр дамжуулан тэднийг сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх зорилго тавин ажиллаа.

1. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Үзүү-лэлт	Хүүхдийн уншлагын танхим	Нийтийн уншлагын танхим	Гэрээр ном олгох танхим	Мэдээллийн төв	Сан хөмрөг	Зөөврөөр	Цахим	Нийт
Уншигч	828	378	275	138				**1619**
Ирэгсэд	1515	1432	3297	338	163	3940	6070	**16755**
Ном олголт	3870	1706	4140	122	859	4719	6070	**21486**

1.1. <u>Урилгат үйлчилгээ</u>

Сурагчдыг номын сангаар үйлчлүүлэх, номын санд ном унших соёлыг эзэмшүүлэх, номын сангийн үйлчилгээ үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор урилгат үйлчилгээнд 20 ангийн 569 хүүхдийг хамруулж 780 ширхэг ном олгож үйлчиллээ.
Бага дунд ангийн 14 бүлгийн 420 хүүхдэд 570 ном олгов.

1. I/06. 1-р сургууль 4А 25 ном 25 хүүхэд
2. I/08. 1-р сургууль 6А 30 ном 25 хүүхэд
3. I/22. 5-р сургууль 4В 30 ном 22 хүүхэд
4. X/05. 2-р сургууль 6а 32 ном 32 хүүхэд
5. X/06. 1-р сургууль 7д 49 ном 38 хүүхэд
6. X/07. 1-р сургууль 7а 36 ном 35 хүүхэд
7. X/08. 2-р сургууль 5а 31 ном 32 хүүхэд
8. X/09. 4-р сургууль 4б 36 ном 30 хүүхэд
9. X/16. 1-р сургууль 4г 68 ном 23 хүүхэд
10. X/27. 5-р сургууль 4б 38 ном 38 хүүхэд
11. X/28. 5-р сургууль 7в 29 ном 29 хүүхэд
12. X/28. 2-р сургууль 3в 49 ном 28 хүүхэд
13. X/02. 4-р сургууль 5в 54 ном 31 хүүхэд
14. X/03. 1-р сургууль 6б 63 ном 32 хүүхэд

Дунд болон ахлах ангийн 6 бүлгийн 149 сурагчдад 210 ном олгож үйлчлэв.

1. X/13 нд 7-р сургуулийн 10А анги 12 хүүхэд 24 ном
2. X/14 нд 2-р сургууль 8А анги 27хүүхэд 36 ном
3. X/28 7-р сургууль 8А анги 24 хүүхэд 32ном
4. XI/2 3-р сургууль 8В 34 хүүхэд 45 ном
5. XI/4 5-р сургууль 9Б 24 хүүхэд 33 ном
6. XI/10 5-р сургууль 9А 28 хүүхэд 40 ном

2. НҮҮДЛИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Номын сангийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий нүүдлийн номын сангийн үйлчилгээг 10 цэцэрлэг, 6 сургууль, Буянт хотхон зуслан, Политехникийн коллеж, 6 байгууллага, 2 суманд тус тус хүргэн ажиллав.

Цэцэрлэгүүд: */1130 ирцэд 1830 ном/*

1. I/21 2-р цэцэрлэгийн багш ажилчид хүүхэд багачуудад шинэ ном хэвлэлээ танилцуулан, үлгэр уншиж өгч номын яриа өрнүүлсэн.
2. I/21 24-р цэцэрлэгийн багш ажилчид хүүхэд багачуудад шинэ ном хэвлэлээ танилцуулан, үлгэр уншиж өгч номын яриа өрнүүлсэн.
3. I/22 23-р цэцэрлэгийн багш ажилчид хүүхэд багачуудад шинэ ном хэвлэлээ танилцуулан, үлгэр уншиж өгч номын яриа өрнүүллээ.
4. I/24-нд 1-р цэцэрлэгийн бэлтгэл, ахлах , дунд бүлгийн 85 хүүхэд, 6 багшид 182 ширхэг ном олгож уншлага, үйлчилгээг зохион байгуулж ажилсан. Хүүхдүүдэд "Үнэг хэрээ зараа гурав" үлгэрээр чанга уншлага хийлээ
5. X/28 Даланзадгадын 25-р цэцэрлэгийн хүүхдүүдэд номын танилцуулга, үлгэр уншин номын тухай санаа бодлоо солилцсон
6. X/28 Даланзадгадын 26-р цэцэрлэгийн хүүхэд багачууддаа үлгэрийн номын танилцуулга хийж, үлгэр уншиж өгч, нүүдлийн номын сангаар үйлчилсэн.
7. X/02 8-р цэцэрлэгт 162 ирэгсдэд 310 ном
8. X/06 4-р цэцэрлэг дээр 93 ирэгсдэд 170 ном
9. IX/23 9-р цэцэрлэгийн бэлтгэл, ахлах бүлгийн 94 хүүхэд, 6 багшид 188 ширхэг ном олгож уншлага, үйлчилгээг зохион байгуулж ажилласан.
10. X/1 11-р цэцэрлэгийн бэлтгэл, ахлах, дунд бүлгийн 193 хүүхэд, 11 багшид 386 ширхэг ном олгож уншлага, үйлчилгээг зохион байгуулж ажилласан.

Сургуулиуд: */ 1294 ирцэд 963 ном/*

1. VII/31 Буянт хотхон хүүхдийн зуслан дээр явуулын үйлчилгээгээр очиж уншлага үйлчилгээ үзүүлсэн нийт 43 хүүхэд, 6 багш 93 ширхэг номоор. "Миний зуслан" шүлэг зохиох тэмцээн зохион явуулсан.
2. X/5 2-р сургууль 195 хүүхэд 98 ном
3. X/6 1-р сургууль 200 хүүхэд 117 ном
4. X/7 4-р сургууль 190 хүүхэд 126 ном
5. X/9 7-р сургууль 150 хүүхэд 97 ном
6. X/27 5-р сургууль193 хүүхэд 112 ном
7. X/28 3-р сургууль 197 хүүхэд 110 ном

8. Политехникийн коллежийн оюутан сурагч, албан хаагчдад нийт 210 ном 120 ирцэд шинэ номоо танилцуулах, гэрээр ном олгох үйлчилгээг хүргэн ажиллалаа. Мөн өдөрлөгийн үеэр зохион байгуулсан танин мэдэхүйн АХА, ЭМОЖИ ТААВАР тэмцээнүүдийг зохион байгуулж Б.Тэмүүлэн,Э.Баатар нар манлайлан, номтой шагналын эзэд боллоо.

Байгууллагууд: */298 ирцэд 390 ном/ 6 байгууллага*

1. I/22 Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд явуулын номын сангийн үйлчилгээг үзүүллээ. Ном олголт 100 Ирэгсэд 40
2. I/23 Эрүүл мэндийн газарт явуулын номын сангийн үйлчилгээг үзүүллээ. Ном олголт 30 Ирэгсэд 20
3. II/18 0167-р ангийн алба хаагчдад явуулын номын сангийн үйлчилгээ үзүүллээ Ном олголт 130 Ирэгсэд 150
4. X/05 Явуулын номын сангийн үйлчилгээгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчдад уншлага үйлчилгээ үзүүллээ.Ном олголт 30 Ирэгсэд 25
5. X/06 Ахмадын хороонд шинэ номын мэдээ мэдээлэл хүргэн уншигчийн карт нээж, ном олгох үйлчилгээ үзүүллээ. Ном олголт 50 Ирэгсэд 33
6. X/06 Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хамт олонд номын сангийн үйл ажиллагааны тухай мэдээ мэдээлэл хүргэж, шинэ ном танилцуулах үйлчилгээ үзүүллээ.Ном олголт 50 Ирэгсэд 30

Сумд: */2 сум 168 ирцэд 236 ном/*

X/28 Ханхонгор сумын иргэдэд шинэ номын танилцуулга, уншлага үйлчилгээ, соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгууллаа. Ирц 75, ном олголт 50

XI/06 Цогтцэций сумын 93 хүүхэд, залуучуудад 186 ширхэг ном олгож уншлага, үйлчилгээг зохион байгуулж ажилласан.

Зөөврийн номын сан: Зөөврийн номын сангаар 6 байгууллагад нийт 29 удаа /558 ирцэд 570 ном олгож үйлчилсэн/

1. ШШГГазар /20удаа 459ш номоор 439 ирц/
2. Хөдөлмөр зуслан /1удаа 20ш номоор 20ирц/
3. 7-р багийн төв /1 удаа 21ш номоор 16ирц/
4. ЗӨС төв /4удаа 45ш номоор 32 ирц/
5. 0167-р анги /1удаа 15ш 19 ирц/
6. 0131-р анги /1удаа 10ш 32 ирц/

Хамтдаа уншъя аяны хүрээнд */217 гэр бүлийн 502 хүн 730 ширхэг ном/*

Уг аяны хүрээнд 3 ээлжээр 33 байгууллагад гэр бүлийн гишүүн бүр уншиж болохуйц номууд, хамтдаа чөлөөт цагийг өнгөрөөхөд зориулсан мэдээлэл сурталчилгаа, зурж будах материалууд бүхий хайрцгийг аялуулсан ба нийт 217 гэр бүлийн 502 хүн 730 ширхэг ном уншиж уг аянд хамрагдсан байна.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗАР

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗАР

3. СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Иргэдийн ном унших идэвхийг өрнүүлэх, номын сангийн үйл ажиллагаанд татан оролцуулах, иргэдийн соёлын түвшинг дээшлүүлэх зорилго бүхий соёл танин мэдэхүйн ажлуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.
Цар тахал, цаг үеийн нөхцөл байдалд тохируулсан цахим арга хэмжээнүүдийг мөн зохион байгуулж ажилласан.

3.1 <u>Тренди бүсгүй” номын цахим хэлэлцүүлэг /IV/29-V/04/</u>

Цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах зорилго тэмүүлэлтэй, оюунлаг, чадварлаг байхын зэрэгцээ гаднаасаа ч загварлаг, соёлтой, биеэ сайхан авч явдаг байхыг зааж зөвлөн чиглүүлэх Тренди бүсгүй номоор хэлэлцүүлгийг “Өмнөговь номын клуб” фэйсбүүк группын админ, 1-р сургуулийн монгол хэлний багш М.Ууганбаяртай хамтран зохион байгууллаа.
Хэлэлцүүлгийг номын 6 бүлгээр
T-ime Цаг хугацаа /10/
R-elationship Харилцаа /8/
E-ducation Боловсрол /9/
N-iceness Гоо, сайхан байдал /8/
D-iligence Дайчин чанар /8/
Y-oga Бясалгал, төвлөрөл, амьдралын мөн чанар/10/ нэртэй 6 өдрийн даалгавар гүйцэтгүүлэх байдлаар хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулсан. Давхардсан тоогоор 6 өдрийн хэлэлцүүлэгт 53 оролцогч даалгаваруудын гүйцэтгэлээ ирүүлж оролцлоо. Оролцогчид 13-32 настай охид, залуу бүсгүйчүүд байлаа.

1. 1-р сургуулийн Физикийн багш Б.Үүрдмандах
2. 2-р сургуулийн 10б ангийн сурагч Б.Зулсайхан
3. 1-р сургуулийн 9б ангийн сурагч Ц.Содномянжид
4. 2-р сургуулийн 10б ангийн сурагч Б.Зулсайхан
5. БОЭТөвийн шүдний эмч Д.Дивачимбу
6. Өглөөний клубын гишүүн Б.Жавхланчимэг нар 6 хэлэлцүүгийн шилдгээр, бүх хэлэлцүүлэгт хамгийн идэвхтэй байж шилдгийн шилдэг оролцогчоор 1-р сургуулийн Физикийн багш Б.Үүрдмандах шалгарч, номын зохиогч Т.Гүлдаурены шагналаар оролцогч 1-р сургуулийн 12а ангийн сурагч М.Азжаргал шагнууллаа.

Хэлэлцүүлгийн гол ач холбогдол :
Оролцогчдын хувьд:

Бүтээлч уншлагаар дамжуулан номын бүлэг тус бүрийг амьдралдаа хэрэгжүүлэх шинэ санааг дэвшүүлэхийн зэрэгцээ шинэ мэдлэг, шинэ хүсэл тэмүүллийг олж авч бусадтай хуваалцаж чадсан.Уншиж хөгжсөний төлөө урамшуулал авч цаашид унших урам авсан.
Бусад хэлэлцүүлгийг хөндлөнгөөс ажиглагч уншигчид, иргэдийн хувьд:

Бүтээлч уншлагын ач холбогдлыг таньж мэдэхийн зэрэгцээ ном унших ялангуяа Тренди бүсгүй номыг уншихсан гэсэн зорилго хүсэлтэй болж, уншсанаа бусадтай хуваалцах, номоор дамжуулан суралцах сэдэл, хүсэл тэмүүллийг бий болгосон. 6 удаагийн даалгавар, даалгаврын биелэлт, оролцогчдын болон хэлэлцүүлгийн шилдгүүдийн сэтгэгдэл зэргийн хүлээн авч үзсэн, хариу үйлдэл үзүүлсэн /reaction-424/ хүмүүсийн хандалтын тоо 9038.

3.2 <u>”Дэлхийн номын өдөр” арга хэмжээ /IV/23/</u>

Дэлхийн номын өдрийн хүрээнд хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх иргэдийн ном унших идэвхийг өрнүүлэх зорилгоор дараах ажил, арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Дэлхийн сонгодог 50 ном сурталчилах

“Дэлхийн сонгодог зохиол”-ын 50 ботиор үзэсгэлэн гаргаж цахимаар сурталчилж нийтэд танилцуууллаа.Ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэн,Т.Галсан нарын номын тухай шүлгүүдээр

зурагт мэндчилгээ бэлтгэн цахимаар уншигчиддаа хүргэлээ.

Номын азтан /цахим/ шалгаруууллаа.

Дэлхийн номын өдрөөр төрсөн өдөрт ном бэлэглэе, гэрийн номын сангийнхаа зургаар давалгаалъя уриалгын дор цахим азтан шалгаруулах постоор 46 хүний ном бэлэглэж буй болон гэрийн номын сангийн зургийг хүлээн авч3 азтан тодруулав.3-р сургуулийн 12-р ангийн сурагч Ц.Одонгоо, 1-р сургуулийн 6а ангийн сурагч Х. Мөнхзолбоо, Б. Жавхланчимэг нар номын азтанаар тодорлоо.

Зохиолч Б.Шүүдэрцэцэгтэй хийсэн цахим "Зохиолч-Уншигчдын уулзалт" арга хэмжээ

Зохиолч Б.Шүүдэрцэцэгтэй хийсэн цахим "Зохиолч-Уншигчдын уулзалт" \live\-ийг 11427 хүн үзсэн ба аймгаас оролцсон оролцогчдоос 2 хүнийг тодруулан зохиолчийн гарын үсэгтэй номоор урамшууллаа.

Энэ номыг уншаарай цахим уриалгыг өрнүүлсэн

Иргэдийн ном унших идэвхийг өрнүүлэх, уншсан номын мэдээллээ бусадтай хуваалцах, өөрийн уншдагаас бусад сэдвээр унших, ном солилцож унших зэрэг боломжуудыг олгох зорилгтой "ЭНЭ НОМЫГ УНШААРАЙ" цахим уриалгад олон нийтийг уриалан ажиллав.

3.1. <u>”Үндэсний бичиг үсгийн баяр” арга хэмжээ /V/8- V/11/</u>





МУ-ын Ерөнхийлөгчийн 2003 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн 105 дугаар зарлигийг хэрэгжүүлж үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх бичиг соёлын дурсгалыг сурталчлах, Монгол хэл бичгийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж иргэд болон өсвөр үеийнхэнд босоо монгол бичгээ эзэмших сэдэл тэмүүллийг бий болгох зорилгын хүрээнд 2020 оны 5 дугаар сарын 8-ны өдөрөөс 5-р сарын 11-ний өдөр бичиг үсгийн баярыг тэмдэглэн өнгөрүүллээ.

- 2016, 2019 оны “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ” монгол бичгийн хичээнгүй цэвэр бичгийн шилдэг бичвэрийн цахим үзэсгэлэнг гаргалаа.

- Өмнөговь аймгийн зохиолчдын уран бүтээлийн үзэсгэлэнг 53 ширхэг шүлэг, яруу найргийн номоор гаргаж сурталчилсан.
- Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байдаг Үнэт ховор номыг олон нийтэд таньж мэдүүлэх зорилгоор 45 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж live хийж, Говийн наран телевизээр танилцууллаа.
- “БИЧИГ СОЁЛ” номын үзэсгэлэнг 49 ширхэг монгол бичгийн сурах бичиг болон монгол бичгээр бичигдсэн хятад үлгэрийн номоор үзэсгэлэн гаргаж live хийж, Говийн наран телевизээр танилцуулсан.

3.2. ***<u>“БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ” монгол бичгийн уран бичвэрийн бүтээлийн уралдаан V/1- V/11</u>***

Үндэсний утга соёлын нандин өв болсон монгол бичгийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах сурталчлах, иргэдийн монгол бичгийг сурч эзэмших идэвхийг дэмжих зорилгоор Өмнөговь аймгийн ЕБСургуулиудын 10-12-р ангийн сурагчдын дунд Өмнөговь аймгийн сүлд дуу “Тэмээн сүргийн говь” дуунаас сэдэвлэсэн. Уг уралдаанд 22 оролцогч бүтээлээ ирүүлж оролцсон. Даланзадгад сумын 1-р сургууль /1 хүүхэд/, 3-р сургууль /1 хүүхэд/, 4-р сургууль /1 хүүхэд/, 5-р сургууль /2 хүүхэд/, Ханбогд /14 хүүхэд/, Цогт-Цэций сумын 1-р сургууль /2 хүүхэд/, Гурвантэс /1 хүүхэд/ сумдын хүүхдүүд идэвхтэй оролцлоо.

Уралдаанд бүтээлээ ирүүлсэн оролцогчдын бүтээлийг уран бичээч Г.Ганзориг шүүн шилдэг бүтээлүүдийг шалгаруууллаа. Үүнд:
I байр 1-р сургуулийн 11А ангийн сурагч О.Эрдэнэчимэг
II байр 5-р сургуулийн 10Б ангийн сурагч Х.Намуунбайгаль
III байр 5-р сургуулийн 10А ангийн сурагч Б.Эрхсаран
Тусгай байр Цогтцэций сумын 12А ангийн сурагч Б.Гийхнаран нар тус тус шалгарлаа.
Цахимаар уралдааны шилдэг бичвэрүүдийг сурталчлах, мэдээлэл сурталчилгааг 2839 хүн үзэж



3.3. <u>“Номтой манлайлал” нийгмийн салбарын агентлагуудын удирдлагууд, нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтнүүд, номын санчдын хэлэлцүүлэг. / V/22 /</u>

Төрийн албан хаагчдын ном унших идэвхийг өрнүүлэхэд агентлаг, байгууллагуудын удирдлагуудыг манлайлан ажиллахыг уриалах, номын сантай хамтран ажиллах хамтран зохион байгуулах үйл ажиллагаануудыг санал болгох танилцуулах зорилго бүхий хэлэлцүүлгийн 5-р сарын 22-нд зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт оролцогчдын тоо 20
Хэлэлцүүлгийн хүрээнд

- Миний анхны ном-Гүн сэтгэгдэл төрүүлсэн ном угталт
- Номын сангийн үйл ажиллагааны танилцуулга
- Говийн 10 домог номын танилцуулга видео
- “30 ном уншъя” тэмцээн

- Номын нэр-Эможи таав
арт тэмцээнийг тус тус зохион байгууллаа.

Үр дүн, үр нөлөө:

Удирдлагууд хамт олноо номтой нөхөрлөхөд уриалах, номын сантай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах, хамт олныг ном уншихад сэдэлжүүлэх манлайлагч болж ажиллана.

3.4. <u>“Номтой бэлэг” фэйсбүүк уралдаан /V/25-V/30/</u>

Хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан Мөндөөхэй-2 номын зохиогч С.Гантогтохтой хамтран уг номд орсон шүлгүүдээс цээжлэх уралдааныг ЕБСургуулиудын 1-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж шилдэг оролцогчдыг номтой бэлгээр урамшууллаа.

3.5. <u>"Хадгаламж өлсөхөөс эхэлнэ" номын хэлэлцүүлэг/VIII/26-IX/9/</u>

“Хөгжлийн ирээдүй оюунлаг залуучууд” хөтөлбөр, “Залуучуудын хөгжлийн сарын аян”-ы хүрээнд "Хадгаламж өлсөхөөс эхэлнэ" номын хэлэлцүүлгийг Даланзадгад сумын залуучуудын дунд 8-р сарын 26-ны өдрөөс 9-р сарын 9-ний хооронд 2 үе шаттай зохион байгууллаа.
1-р шат: “Хадгаламж өлсөхөөс эхэлнэ-Өрхийн санхүүгээ удирдах нь” илтгэлийг цаасан хэлбэрээр хүлээн авлаа.

Хэлэлцүүлгийн 2-р шатанд номынхоо үр шимийг хэдийнээ хүртэж хувийн болоод өрх гэр бүлийнхээ боловсрол, эрүүл мэнд, санхүү, амьдралын чанарт гарсан олон олон ахиц дэвшил, амжилтын туршлагаасаа хуваалцсан өвөрмөц илтгэлүүдээ оролцогчид маань биечлэн толилууллаа.

Хэлэлцүүлгийг <u>арга хэмжээг Номын сангийн дарга А.Одончимэг, Насан туршийн боловсролын багш Э.Амартүвшин, Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан менежер А.Гантулга нар шүүн явууллаа.</u> Уг хэлэлцүүлэгт Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Төрийн банкууд <u>дэмжин</u> хамтран ажиллаж нийт оролцогчдыг гарын бэлгээрээ урамшууллаа.

Хэлэлцүүлгийг Live хийж олон нийтэд хүргэсэн 1000 гаруй хүн үзэж, 28 шэйр хийгдсэн байна.

Хэлэлцүүлгийн 2-р шатны 10 шилдэг оролцогчдоос

1-р байр П.Нэргүй / 1-р сургуулийн биологийн багш/
2-р байр Б.Урантөгөлдөр / Түргэн тусламжийн эмч /
3-р байр М. Ууганбаяр / 1-р сургуулийн монгол хэлний багш/ тус тус шалгарлаа.

Дүгнэлт:



- "Хадгаламж өлсөхөөс эхлэнэ" номын уншигчид болох оролцогчдын 90% нь энэхүү номыг уншаад хуримтлал үүсгэх, зарлага, орлогодоо хяналт тавьж зорилготой хуримтлалыг бий болгожээ.
- Энгийн бүхэн агуу гэдэгчлэн энгийн юм шиг хирнээ гэр бүлийнхээ чихрийн хэрэглээг багасгаснаар хүүхдийнхээ шүдний эрүүл байдал, өрхийн орлогыг зөв зүйлд зарцуулах, жижиг зүйлээс том хэмнэлт гаргаж болно гэсэн санаа, хуримтлуулахад дадал, зуршил, тууштай байдал чухал байсныг илтгэлдээ дурдсан ээж П.Нэргүйн илтгэл шүүгчдийн хийгээд оролцогчдын сонирхлыг татаж байлаа.
- Ном зөвхөн мөнгийг хуримтлуулах ухаан бус залуу хүний унаж боссон амьдралын туршлага хийгээд хэрхэн тууштай байх, зорилготой байх, ирээдүйд тохиолдож болох төрөл бүрийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хувь хүн өөрийгөө мотивацлах ухаан багтсан гэдгийг оролцогч бүр дурдаж байлаа.

Хэлэлцүүлэг Залуусын хувийн болоод өрхийн санхүүгээ удирдаж залахад тус болох төдийгүй залуусыг ном унших, ном уншсанаар мэдлэг хэрхэн олж авдаг тэр нь хүмүүсийн амьдралыг хэрхэн өөрчилж, зөв тийш нь залж болдгийг таниулсан арга хэмжээ болж чадсан.

3.6. <u>"Номын баяр" арга хэмжээ / IX/26/</u>

3.7.

МУ-ын ерөнхийлөгчийн 2012оны "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, иргэд, хүүхэд, залуучуудыг номтой нөхөрлүүлэх, бүх нийтийн ном уншлагыг дэмжих зорилгоор Номын баярыг 9-р сарын 16-ны өдөр зохион байгууллаа.

Номын баярын нээлт

- Номын баярын арга хэмжээг нээж аймгийн Засаг Даргын орлогч Х.Батболд нээж үг хэллээ.
- ХЖТеатрын "Амжилт таны гарт" зохиолын баатрууд, ажил мэргэжлээр сэдэвлэсэн жүжигчилсэн тоглолт, урлагийн үзүүлбэрүүдээ толилууллаа.

- "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж" тэмдгийн болзол хангасан сурагчдад шагналыг гардууллаа. Уг шагналаар

1. О.Эрдэнэчимэг 1-р сургууль 12А анги
2. Б.Бат-Ялалт 1-р сургууль 6Б анги
3. Н.Нандин-Эрдэнэ 4-р сургууль 12А анги
4. Г.Мөнхжин 4-р сургууль 9А анги
5. Э.Хулан 2-р сургууль 8А анги
6. Б.Анужин 2-р сургууль 12Б анги
7. Х.Намуунаа 3-р сургууль 12Б
8. Ж.Амар 3-р сургууль 12Б
9. Б.Номин 7-р сургууль
10. Э.Эмүжин 7-р сургууль 8А
11. Н.Санчирмаа 5-р сургууль 8а
12. А.Анударь 5-р сургууль 12в нар шагнууллаа.

“Мөндөөлэй“ хүүхдийн цуврал номоо гаргаж хүүхэд, багачуудыг номтой нөхөрлүүлэх, ном уншлагыг түгээн дэлгэрүүлэхэд хамтран ажиллаж “Номтой бэлэг” арга хэмжээг 2 дахь жилдээ хамтран зохион байгуулсан С.Гантогтохыг “Номын элч-2020” шагналаар шагнаж урамшуулав.

“Хэн хамгийн олон шүлэг мэдэх вэ?” шүлгийн тэмцээнийг номын баярт оролцогчдын дунд зохион байгуулахад 8 шүлэг түгдрэлгүй уран яруу уншсан амжилтаар 4-р сургуулийн дадлагажигч багш Б.Жаргалмаа тэргүүллээ.***Номын үзэсгэлэн***

Шинэ номын үзэсгэлэн 32 ширхэг номоор, Түүхийн зурагт альбом, лавлах нэвтэрхий толь бүхий 21 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж номын баярт оролцогсдод үйлчилгээ үзүүллээ.

Номын баяр, Номтой нөхөрлөе хүрээ ашиглан зураг авахуулах үйлчилгээ

Номын баяр 2020, Хязгаар үгүй-Ном-Сэтгэлгээний эрх чөлөө уриа, Номтой нөхөрлөе зургийн хүрээнд номын баярт оролцогчдын зургийг авч үйлчиллээ.

“Гэр бүлийн шилдэг номын сангийн туршлага“ телевизийн нэвтрүүлэг

2019 онд зохион байгуулсан Гэр бүлийн шилдэг номын сан шалгаруулах уралдаанд “Хамгийн урт настай баялаг номын сан” төрөлд шалгарсан ахмад уншигч А.Цоож, Ш.Баттөмөр нарын номын сангаар нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевиз, Мэлмий сайтаар олон нийтэд хүргэж ажиллаа.

3.8. ***<u>“Зуны уншлага” шилдэг номын тэмдэглэл шалгаруулах уралдаан</u>***

Хүүхдийн бүтээлч уншлагыг дэмжиж урамшуулах, сурагчдыг чөлөөт цагаараа ном уншлагыг зуршил болгохыг уриалах зорилгоор зарласан уралдаанд зуны амралтаараа уншсан номын тэмдэглэл, хөтөлгөөгөө 6-12-р ангийн 25 сурагч ирүүлж оролцсоноос

- 1-р байр 7-р сургуулийн 8А ангийн сурагч Э.Эмүжин
- 2-р байр 3-р сургуулийн 7А ангийн сурагч М.Гэгээ
- 3-р байр 1-р сургуулийн 6А ангийнсурагчБ.Мишээл нар эзэллээ.

3.9. ***<u>“Шүлгийн марафон” 3 өдрийн шүлэг цээжлэх сорил</u>***

Шүлэг, яруу найргаар дамжуулан хүүхэд багачуудын авьяас, чадвар, ой тогтоолтыг хөгжүүлэх зорилго бүхий уг уралдаанд “Би монгол хүн”, “Тусгаар тогтнол”, “Говь” шүлгүүдийг 3 өдөр дараалан цээжилж оролцсон сурагчдаас 3 шүлгээ амжилттай цээжилж уран яруу уншсан байдлаар

- 1-р байр 1-р сургуулийн 9Б ангийнсурагчБ.Энхнаран
- 2-р байр 4-р сургуулийн 6А ангийнсурагч М.Ганбаатар
- 3-р байр 2-р сургуулийн 8А ангийнсурагч Э.Хулан нар тус тус шалгарлаа

Уг уралдааныг цахим хэлбэрээр эхлэн зохион байгуулж сүүлийн өдрийн шүлгийг хүүхдүүд биечлэн уншиж оролцлоо.

3.10. <u>“Мэдрэмжийн цуврал” номоор эцэг, эхчүүдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг/X/14/</u>

Эцэг, эхчүүдийг хүүхдүүдтэйгээ номоор дамжуулан харилцаа үүсгэж, бяцхан үрсийнхээ сэтгэл хөдлөлүүдийг таньж мэдэх, түүнийг хэрхэн ялгаж салган даван туулахад нь дэмжлэг туршлагатай болгох зорилгоор уг хэлэлцүүлгийг 1-р цэцэрлэгийн залуу эцэг, эхчүүдийн дунд зохион байгууллаа.

3.11. <u>“ХҮҮХДИЙН ШИЛДЭГ НОМ” номын хэлэлцүүлэг /X/27/</u>

ЕБСургуулиудын 12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан уг хэлэлцүүлэгт оролцсон сурагчид энэ цаг үед хүүхдүүдийн хамгийн их уншигддаг номууд, өөрт хамгийн их өгөөжөө өгч амьдрал, сурч хөгжихөд нь дэм болсон номуудаа сонгон илтгэл, танилцуулга хийлээ. Хэлэлцүүлэгт хамгийн бэлтгэл сайтай, идэвхтэй оролцсон 3 сурагчийг шалгаруулж шагнаж урамшууллаа. Үүнд:

- 1-р сургуулийн 12 В ангийн сурагч Г.Алтанцэцэг
- 1-р сургуулийн 12А ангийн сурагч О.Эрдэнэчимэг
- 1-р сургуулийн 12В ангийн сурагч Отгондүү нар тус тус шалгарлаа.

3.12. ***<u>“Алдартнуудын амжилтаас суралцъя” номын хэлэлцүүлэг /XI/06/</u>***

Залуучуудыг номоор дамжуулан дэлхийн болон Монголынхоо алдартай хүмүүсээс суралцсан туршлага, амжилтаа харилцан солилцох, суралцах боломжийг бий болгох зорилгоор Цогтцэций сумын уншигч залуучуудын дунд зохион байгууллаа.

Уг хэлэлцүүлэгт салбар салбарт ажилладаг 17 залуучууд оролцон өөрийн уншсан гүн

сэтгэгдэл төрүүлсэн, амьдрал, ажилдаа хэрэгжүүлж чадсан тийм номынхоо баатар болох алдартны амжилтанд хүрсэн түүх өөрт хэрхэн нөлөөлснийг илтгэл байдлаар танилцууллаа. Амжилттай оролцсон М.Мөнгөнхонх, Ц.Дөлгөөнмөрөн, О.Алдармөнх нарыг шагнаж урамшууллаа.

Хэлэлцүүлгийн өгөөж нь уншдаг залуучууд маань цаашид номын хэлэлцүүлгийг уламжлал болгон сумандаа ээлжлэн зохион байгуулж ажиллахаар санал гаргаад үлдсэн явдал байлаа.

3.13. ***<u>“Эерэг зуршлыг бий болгоё” өглөөний гайхамшиг цувралуудаар хийх номын хэлэлцүүлэг /XI/11/</u>***

Сэврэй сумын залуучуудын дунд залуучуудын ном уншлагыг дэмжих, номоос уншиж өөрт бий болгосон эерэг зуршил, хандлагын талаар харилцан туршлага хуваалцах, суралцах боломжийг олгох зорилготой уг хэлэлцүүлгийн хүрээнд илтгэлийн уралдаан зарлаад байна..

3.14. ***<u>“Монголын нууц товчоо” номын хэлэлцүүлэг /XI/21- XII/11/</u>***

Монголын нууц товчоог түгээн дэлгэрүүлэх, залуучуудыг эх түүх, нүүдэлчин соёл, зан заншлаасаа суралцан түүх, соёл өв уламжлалаа хүндэтгэсэн иргэн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх зорилготой уг хэлэлцүүлгийн хүрээнд

- "Монголын нууц товчоо-Өрх бүрт" фото зургийн цахим уралдаан
- "Монголын нууц товчоог тайлбарлахуй" цахим илтгэлийн уралдаануудыг зарлаад байна.

3.15. "Өрхийн номын сангаа цэгцэлж, ном унших челленж" /XI/21- XII/11/

Хөл хорионы дэглэм сахиж гэрээр байх цагаа ашиглан өрхийн номын сангаа эмхэлж цэгцлэн тэнд буй хайртай номуудаа дахин сөхөж унших буюу хэзээ нэгэн цагт уншина даа хэмээн хойш тавьсан номуудаа унших, өрхийн номын сангаа болон тэнд буй өөрийн хамгийн эрхэм нандин номуудаа танилцуулах уг челленжид одоогоор 18 гэр бүл номын сангаа танилцуулж оролцлоо.

4. САН ХӨМРӨГИЙН БАЯЖИЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

- 448 ширхэг монгол ном, сонин, сэтгүүлээр сан хөмрөгөө баяжуулсан байна. /Нийт 7,013,640 төгрөгийн/
  Үүнд:
  - Төсвийн хөрөнгөөр - 2,778,700 төгрөгийн 104 нэр төрлийн 142 ширхэг ном
  - Орон нутгийн төсвөөр - 2,500,000 төгрөгийн 41 нэр төрлийн 100 ширхэг ном
  - Бэлэг хандиваар ирсэн - 1,388,340 төгрөгийн 101 нэр төрлийн 174 ширхэг ном
  - Сонин сэтгүүл – 346,600 төгрөгийн 30 нэгж сонин, сэтгүүл
    /сонин – 13 сэтгүүл – 17/
- Хуудас салсан буюу урагдаж гэмтсэн 907 номонд сэлбэн засалт хийж ашиглалтыг уртасгах арга хэмжээ авч, ном хэвлэлийг ариутгах ажлыг тогтмол хийлээ. ариутгаж ажилласан.
- Сар бүрийн сүүлчийн 7 хоногийн 5 дахь өдөр тавиуруудын бүх номынхоо эмх цэгцэд анхаарч, чийгтэй цэвэрлэгээг хийж, өрөө тасалгааг ариутгаж ажиллав.
- Номын тооллогыг 2020 оны 2-р сарын 19-нд эхэлж 6-р сарын 12 хүртэл фонд, интернэт мэдээллийн төв, архивын ном, гэрээр ном олгох танхим, хүүхдийн уншлагын танхим, Нийтийн уншлагын танхимын номуудыг LIB4you программ болон номын нэг бүрчилсэн дансаар тоолж дууссан байна.

5. МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

Номын сангаас зохион байгуулсан арга хэмжээнүүдийг Монцамэ-1 удаа, Говь HD-3 удаа, ОНХА-5 удаа, Алтан говь-1,Говийн наран ТВ-1, Мэлмий сайтаар 1 удаа тус тус хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 12 удаа, байгууллагын нүүр ном хуудсаар 280 удаа мэдээ, мэдээлэл тавьж олон нийтэд үйлчилгээ үйл ажиллагаагаа сурталчилж ажиллав. 150 хүнд интернэт, компьютерийн үйлчилгээ үзүүлж мэдээлэл өгч ажиллав.

Сан хөмрөгийн хуучин ном хэвлэлийг сурталчлах, тэмдэглэлт өдрүүд, тодорхой сэдвийг хамарсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 37 удаа 1228 ширхэг номоор гарган 1449 хүнд, шинэ ном хэвлэлийг уншигчид олон нийтэд танилцуулах номын үзэсгэлэнг нийт 21 удаа 542 ширхэг номоор гарган 1545 уншигчдад танилцуулж ажиллаа.

<u>Шинэ номын үзэсгэлэн</u> /21 удаа 542 ширхэг номоор 1545 хүнд/

- Нийтийн уншлагын танхим -4 удаа 99 ширхэг номоор /133 хүнд/
- Гэрээр ном олгох танхим – 4 удаа 135 ширхэг номоор /165 хүнд/
- Хүүхдийн уншлагын танхимаас- 8 удаа 150 ширхэг номоор/1100 хүүхдэд/

- Сан хөмрөгөөс - 5 удаа 158 ширхэг номоор /147хүнд/

<u>Сэдэвчилсэн үзэсгэлэн</u> /37 удаа 1228 номоор 1449 хүнд /

Нийтийн уншлагын танхимаас 11удаа нийт 385 ширхэг номоор гаргаж 188 хүн үзэж сонирхсон

1. I/20. Гадаад хэл сурцгаая номын үзэсгэлэн / 35 ном 42 хүн /
2. II/24. Гэр бүлийн хайр, харилцаа, хандлага/22 ном /
3. III/17. Хоолны номын үзэсгэлэн / 32 ном /
4. IV/2. шилдэг яруу найргийн номын үзэсгэлэн/ 32 ном /
5. V/7. Мэргэжил бүхэн сайхан / 34 ном /
6. V/22. Хувь хүний хөгжил / 34 ном / 25 хүн
7. V/16. Өрхийн үйлдвэрлэл сэтгүүл 45 Сэтгүүл 10 хүн
8. VI сард Гадаадын уран зохиол -34 ном /27хүн /
9. VIII сард Эдийн засгийн номоор үзэсгэлэн гаргасан /35 ном / /19 хүн/
10. X/9. Bestseller номын үзэсгэлэн 48 ном /34 хүн /
11. X/26. Ахлах ангийн сурагчдын заавал унших номын үзэсгэлэн /34 ном 31 хүн/

Хүүхдийн уншлагын танхимаас 12 удаа 300 номоор үзэсгэлэн гаргаж 650 хүүхдэд танилцуулсан байна

1. I/09. Монгол ардын үлгэрүүд- 20ш номоор 42 хүүхэд үзэв.
2. II/03.Хүүхдэд зориулсан "танин мэдэхүйн" номоор 19 номоор 42 хүүхдэд.
3. V/10-VI/4. хүртэл Хүүхдийн баярт зориулж 20 номоор 35 хүүхэд.
4. V/15-VI/15. Д.Содномдоржийн уран бүтээлээс 35номоор 35 хүүхдэд.
5. IV/08-IV/15. Ардын аман зохиолоор 20 ном 70 хүүхэд
6. IV/15-V/15. Говийн 10 домог 30 ном 70 хүүхэд.
7. VII/07-VII/26. Монгол ардын үлгэрүүд 35 ном 30 хүүхдэд.
8. IX/10-IX/25. Таши цуврал номоор19н 30 хүүхдэд.
9. IX/20-X/20. Дэлхийн хүүхдийн сонгодог ботиуд. 40ном 40хүүхэд
10. IX/30-X/15. Монгол ардын шилдэг үлгэр цувралаас 45ном 22хүүхэд
11. X/20. Хүүхдүүд ээ үлгэрийн орноор аялцгаая 23 ном 154 хүүхэд
12. X/25-XI/02. Лавлах ботиуд 40 ном 42 хүүхэд

Гэрээр ном олгох танхимаас үзэсгэлэнг 5 удаа 196ш номоор гаргаж 142 хүн үзэж танилцсан

13. III/06. Бүсгүйчүүдэд зориулан 32ш номоор 26 хүн үзсэн
14. VI/02. Бяцхан уншигчиддаа зориулан 50ш номоор 28 хүн үзсэн
15. X/01. Хувь хүний хөгжлийн номоор 32ш номоор 26 хүн үзсэн
16. X/07. Жаргалтай гэр бүл сэдэвт 50ш номоор 32 хүн үзсэн
17. XI/02. Эрүүл мэндийн номоор 32ш номоор 30 хүн үзсэн

Үндсэн сан хөмрөгөөс 9 удаа үзэсгэлэнг 347 ширхэг номоор 469 хүн үзэж танилцсан.

1. II/14. "Монголчуудын эдийн соёл" сэдэвт номын үзэсгэлэн 32 ширхэг номоор /Үзсэн хүн-17/
2. III/6. "Мартын 8"-ны үзэсгэлэн 39 ширхэг номоор /Үзсэн хүн-36/
3. IV/16. "Дэлхийн сонгодог зохиол"-ын үзэсгэлэн 49 ширхэг номоор / Үзсэн хүн-211/
4. V/5. Бичиг үсгийн баяраар "Бичиг соёл" сэдэвт үзэсгэлэн 49 ширхэг номоор / Үзсэн хүн-106/
5. V/20. "Газар тариалан" сэдэвт үзэсгэлэн 55 номоор /Үзсэн хүн-20/
6. VI/02. Үнэт ховор 21 ширхэг зурган альбомын үзэсгэлэн / Үзсэн хүн-21/
7. VII/10. "Эрийн гурван наадам" сэдэвт номын үзэсгэлэнг 37 ширхэг номоор /Үзсэн хүн-18/
8. IX/11. "Угийн бичиг" сэдэвт номын үзэсгэлэн 30 ширхэг номоор / Үзсэн хүн-21/
9. IX/21. "Алтан намар" сэдэвт номын үзэсгэлэнг 35 ширхэг номоор /Үзсэн хүн-19/

6. КАТАЛОГИ, НОМЗҮЙ, ЛАВЛАГАА

- Уг онд хандив бэлгээр болон худалдаж авсан 421 ширхэг номонд падаан бичиж, иж бүрэн техник ажиллагаа хийж, нэгбүрчилсэн бүртгэл болон танхимуудын дансанд бичиж, программд оруулж, бар кодыг хэвлэж зал танхимуудад хуваарилан хүлээлгэн өгсөн.
- Танхимуудад аман лавлагааг нийт 187 удаа, цахим лавлагаа нийт 2133 удаа өгсөн ба татгалзалд 54 ном бүртгэж бүрдүүлэлт хийхэд анхаарч ажиллав.

Ном зүй

- Шинээр ирсэн номын мэдээллээр 2 удаа шинэ номын мэдээ бэлтгэн гаргаж танхимуудад байршуулан уншигчдад хүргэж ажиллав.
- Боловсролыг дэмжих жилийн хүрээнд Говийн мэдээ сонины 1957 оноос хойших дугааруудаас аймгийн боловсрол, багш нарын холбогдолтой нийлэлүүдээр орон нутгийн ном зүй бэлтгэн гаргав.
- 1983-2019 оны "БОЛОР ЦОМ" яруу найргийн наадмын тэргүүн шагналтнуудын шилдэг шүлгүүдээр он дарааллын ном зүй бэлтгэн уншигчдад хүргэв. Мөн цахимаар олон нийтэд танилцууллаа.
- Дэлхийн хүүхдийн зохиолч Ханс Христиан Андерсений бүтээлүүдээр бүртгэн мэдээлэх ном зүйг бэлтгэн гаргав.

7. СУРГАЛТ, АРГА ЗҮЙ

Зохион байгуулсан арга зүйн ажлууд

- Ноён,Ханбогд,Сэврэй,Ханхонгор,Цогт-Овоо,Баян-Овоо,Номгон,Цогтцэций сумын номын санчдад утсаар номын ангилал,тооллого, бүртгэлүүдийн талаар зөвлөгөө өгсөн.

- III/24-III/25. Номгон сумын Соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан номын тооллогыг эхлүүлж ажилд нь зөвлөн туслаж ажиллаа.
- V/04. Хүрмэн сумын соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж номын тооллогыг эхлүүлж ажилд нь туслан зөвлөж арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.
- IX/20. Ноён сумын шинэ соёлын төвийн нээлтэнд оролцож номын сангийн сан хөмрөгийн зохион байгуулалт, номын санчийн ажилд арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.
- X/28. Ханхонгор суманд "Номын баяр" арга хэмжээг хамтран зохион байгуулж арга зүйн тусламж үзүүллээ.
- XI/06. Цогтцэций сумын номын санчийн ажилд зөвлөн туслаж ажиллав.
- XI/11. Сэврэй сумын соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж номын санчийн ажилд нь туслан зөвлөж арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Дотоодын сургалт

Ажилтан ажиллагсдын ур чадвар, ажлын бүтээмж, ёс зүй, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2020 оны дотоодын сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж хүн бүрд сургалт зохион байгуулахыг даалган хэрэгжилтийг ханган ажиллаа.

1. I/8-нд ХШҮ-ний Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах сургалт /ХШҮДАХ-ийн дарга Ч.Сүрэнхорол/
2. I/9-нд Эрүүл мэндийн газраас Томуу, томуу төст өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? сургалт
3. I/16-нд Онцгой байдлын газраас Галын сургалт
4. I/16-нд Монгол банкнаас Ипотекийн зээлийн тухай сургалт /Шүрхүү
5. III/6-нд Цагдаагийн газар "Үгүй гэж хэлье" нөлөөллийн сургалт
6. IV/2-нд Номын сангийн хууль тогтоомж /Дарга А.Одончимэг/
7. IV/16-нд Угийн бичгийн сургалт /НТБТөвийн багш Ц.Амарсайхан/
8. IV/23-нд Багаар ажиллах арга зүй /ГБХЗХГазрын багш Б.Наранцэцэг/
9. V/5-нд "Гэр бүлийн үнэ цэн" сургалт /ГБХЗХГ Т.Золжаргал/
10. V/7-нд Эерэг хандлага /НТБТөвийн багш Г.Лувсандагва/
11. VI/11-нд Номын сангийн судалгааны аргууд /НУТ-ын номын санч Н.Даваажаргал/
12. VI/18-нд Номзүйн бичилтийн стандартаар ном тодорхойлох" /Т.Нямсүрэн/
13. VI/25-нд Соёл танин мэдэхүйн ажил хэрхэн зохиох вэ? /ГНОТ-ын номын санч М.Сувданцэцэг/
14. VI/30-нд Анхны тусламж /Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Цэцэгсүрэн/
15. IX/10-нд Байгууллагын ёс зүй онлайн сургалт
16. IX/24-нд Номын сангийн алсын хараа /ХУТ-ын номын санч А.Оюунгэрэл/
17. X/8-нд Номын сангийн стандарт /Мэргэжлийн хяналтын Соёлын байцаагч О.Уламцэцэг/

18. Х/28-нд Зөв, сайхан бичиг нь таны соёл /АБТАжилтан НТБТөвийн зөвлөх багш Ц.Амарсайхан/

Орон нутаг, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургалт зөвлөгөөн семинарт хамрагдсан байдал

- V/15-нд Үндэсний номын сангаас Нийтийн номын сангуудын ангилагч, каталогич нарт зориулсан онлайн сургалтанд хамт олноороо хамрагдсан.
- VII/4-VII/6-ний өдрүүдэд хамт олноороо Булган аймгийн Төв номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан ажиллав.
- IX/29- IX/30. Соёл урлагийн ажилтныг чадавхижуулах сургалтанд хамт олноороо хамрагдсан.

-Х/26. ХШҮ-ний сургалт, хэлэлцүүлэгт байгууллагын ХШҮхариуцсан ажилтан Т.Нямсүрэн хамрагдав.

-Х/23. MONGOLIAN LIBRARY UPDATE 2020 зөвлөгөөн, сургалтанд Номын сангийн дарга А.Одончимэг, Номын санч М.Сувданцэцэг хамрагдаж Дотоод хэргийн их сургуулийн шинэ номын сантай танилцаж, бусад номын сангуудын туршлагаас суралцлаа.

8. ӨРХ ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛУУД

Хамтдаа уншъя аян

Гэр бүлийн гишүүдийн цахим хэрэглээг багасгах, номоор дамжуулан амьд харилцааг нэмэгдүүлэх, бүтээлч уншлагыг өрнүүлэх зорилготой уг аяны хүрээнд 3 ээлжээр 33 байгууллагад гэр бүлийн гишүүн бүр уншиж болохуйц номууд, хамтдаа чөлөөт цагийг өнгөрөөхөд зориулсан мэдээлэл сурталчилгаа, зурж будах материалууд бүхий хайрцагийг аялуулсан. Аяны номын багц нийт 217 гэр бүлд хүрч, 502 хүн 730 ном уншиж уг аянд хамрагдсан байна.

Даланзадгад сумаас заавал хөгжих өрхөөр сонгогдсон Т.Тогтохсүрэнгийн гэр бүлтэй ажилласан байдал

Т.Тогтохсүрэн Нисэхийн 12-15-д оршин суудаг өрх толгойлсон эмэгтэй, ам бүл 5, 3-11насны 4 хүүхдийн хамт амьдардаг. Ингээд 7-р сард Тогтохсүрэнтэй уулзаж гэр бүлийн

амьжиргааг дээшлүүлэхэд бидний зүгээс хийж болох зүйлсийн талаар ярилцан цагт баригдахгүй ажил хийх боломжтой гэснээр бид Политехникийн коллежтай ярилцан оёдлын сургалтанд суулгахаар тохирч Тогтохсүрэнд хэлж цаг хугацааг хэлж өгсөн хэдий ч хөдөө явах болсон, хүүхэд харах хүнгүй гэх мэт шалтгаан хэлж сургалтанд хамрагдаагүй.

7-р сарын 27 нд сургалтанд хамруулахаар ярилцахаар очих үед гэрийн доторх тохижилт

Иймд бид Цэнгүүн говийн оёдолчин А.Янжинбилэгт хүсэлт тавьж Тогтохсүрэнд оёдол хийх талаар тэр дундаа монгол дээлний товч хадахыг зааж сурган гэрээр болон уг оёдолчинтой тохирон оёдол хийж мөнгө олох боломжийг гаргаж өгсөн.

Мөн хүүхдүүдийн ном уншиж хөгжихөд тус болох зорилгоор 20 ширхэг хүүхдийн танин

мэдэхүйн цуврал ном, үлгэрийн ном, сурах бичиг, зурагт хуанли өглөө.

Амьдрах орчинг нь тав тухтай болгох үүднээс гэрийнх нь эвдэрсэн тавилгуудыг засаж сайжруулж, гал тогооны шкафны шил хагарсаныг шинээр шиллэж, шилгүй байсан тоонны рамуудыг шиллэж хийж өглөө. Мөн гэрийг тохижуулж цэгцлэн мөлхөө тавилга худалдан авч өгж тохитой тухтай орчинд хийж бүтээж амьдрахыг зөвлөж урам хайрласан.

“Гэр бүлийн шилдэг номын сангийн туршлага“ телевизийн нэвтрүүлэг

2019 онд зохион байгуулсан Гэр бүлийн шилдэг номын сан шалгаруулах уралдаанд “Хамгийн урт настай баялаг номын сан” төрөлд шалгарсан ахмад уншигч А.Цоож, Ш.Баттөмөр нарын номын сангаар нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевиз, Мэлмий сайтаар олон нийтэд хүргэж ажиллаа.

“Өрхийн номын сангаа цэгцэлж, ном унших челленж” /XI/17- XII//

Хөл хорионы дэглэм сахиж гэрээр байх цагаа ашиглан өрхийн номын сангаа эмхэлж цэгцлэн тэнд буй хайртай номуудаа дахин сөхөж унших буюу хэзээ нэгэн цагт уншина даа хэмээн хойш тавьсан номуудаа унших, өрхийн номын сангаа болон тэнд буй өөрийн хамгийн эрхэм нандин номуудаа танилцуулах уг челленжид одоогоор 18 гэр бүл номын сангаа танилцуулаад байна.

Гэр бүлийн аянуудад хамрагдаж ажил, арга хэмжээ зохион байгуулав

Аз жаргалтай гэр бүл-Амжилтын үндэс” дарцагт аяныг 2020 оны 05-р сарын 01-ний өдөр хүлээн авч 9 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулсан.

Тухайлбал:

- Байгууллагын ажилчдын гэр бүлийн дэлгэрэнгүй судалгааг авч цаашид гарч болохуйц эрсдэлийг тооцоолж, түүнд тохирсон арга замыг тодорхойлсон.
- ГБХЗХГ-т хүсэлт тавьж **“Гэр бүлийн үнэ цэн”** сэдэвт сургалтыг зохион байгуулж хамт олноороо хамрагдаж гэр бүлийн талаарх эерэг хандлагад суралцсан.
- Үр хүүхдэдээ зөв үлгэр дуурайлал үзүүлж цахим орчны зохистой хэрэглээний талаар зурагт гарын авлагыг бэлтгэн ажилчдад тараав.
- Өөртөө дүгнэлт хийж, бусдаас суралцах зорилгоор манай хамт олон **“Ханьдаа зориулсан талархлын үгтэй”** захидал бичиж гэр бүлийнхэндээ хүргэсэн.
- Гэр бүлийн судалгаан дээр үндэслэн **“Манай гэр бүл”** хөгжлийн хөтөлбөрийн номыг сургуулийн насны хүүхэдтэй 7 гэр бүлд хүлээлгэн өгч ажиллуулсан.

9. БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛУУД

Боловсролыг дэмжих жилд зориулсан орон нутгийн ном зүй

Говийн мэдээ сонины 1957 оноос хойших дугааруудаас аймгийн боловсрол, багш нарын холбогдолтой нийтлэлүүдээр орон нутгийн ном зүй бэлтгэн гаргав.

“Ном миний амьдралд” аян

Боловсролыг дэмжих жилийн үйл ажиллагааны хүрээнд говь нутгийн уул усны гарал үүсэл, үүх түүхийг өгүүлсэн “Говийн 10 домог” номыг хүүхэд, залуучууд, олон нийтэд сурталчилан таниулах, түгээн дэлгэрүүлэх, ардын аман зохиолын өвөрмөц төрөл зүйл болсон домгоор дамжуулан хүүхдийн уран сэтгэмж, төсөөлөн бодох, уран яруу илэрхийлэх чадварыг хөгжүүлэх, иргэдийг ном уншихад уриалсан “Ном миний амьдралд” аяныг цахим хэлбэрээр зохион байгуулж дараах уралдаануудыг зохион байгууллаа.

<u>Говийн 10 домог шүлгийн уралдаан</u>

Говийн 10 домгийг хүүхэд багачууддаа түгээн дэлгэрүүлэх, домгоор дамжуулан хүүхдийн уран сэтгэмж, төсөөлөн бодох, уран яруу илэрхийлэх чадварыг хөгжүүлэх, нутаг орныхоо газар усаар бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилготой уг уралдааныг IV/20-V/20 хооронд зарлан зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулиудын 10-12-р ангийн сурагчдын дунд зарласан уг уралдаанд 20 сурагч оролцсоноос

I байр Даланзадгад сумын 2-р сургуулийн 12А ангийн сурагч Т.Тунгалагтуяа
II байр Ханбогд сумын 2-р сургуулийн 11А ангийн срагч Ц.Алтжин
II байр Даланзадгад сумын 1-р сургуулийн 12В ангийн сурагч М.Нандинболор
III Ханбогд сумын 1-р сургуулийн 11А ангийн сурагч Ц.Нандин-Эрдэнэ
III Даланзадгад сумын 2-р сургуулийн 10Б ангийн сурагч О.Ариунбилэг нар шалгарлаа.

<u>Говийн 10 домог зохион бичлэгийн уралдаан</u>

Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 7-9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулсан Говийн арван домог зохион бичлэгийн уралдааныг IV/20-V/20 хүртэл сарын хугацаатай зарлаж уг уралдаанд нийт 21 хүүхэд оролцсон. Тус уралдаанд сумдаас Баян-овоо сум идэвхтэй оролцлоо. Уралдааны сэдвүүдийг монгол хэл уран зохиолын багш Ц.Амарсайхан /НТБ/, тэргүүтэй шүүгчид шүүж дараах 5 байр эзлүүллээ.

1-р байр Баян-Овоо сумын ЕБС-ийн 8а ангийн сурагч Х.Золзаяа
2-р байр Даланзадгад сумын 1-р сургуулийн 8б ангийн сурагч Б.Энхнаран
2-р байр Манлай сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч М.Нандинцэцэг
3-р байр Баян-Овоо сумын ЕБС-ийн 8а ангийн сурагч Б.Тайвансайхан
3-р байр Ноён сумын ЕБС-ийн 7а ангийн сурагч М.Бадамсамбуу нар шалгарлаа.

<u>“Номтой нөхөрлөөрэй“ хүүхдэд хандсан захидлын уралдаан</u>

Эцэг эхчүүдийн номтой нөхөрлөсөн түүх, ном уншдаг туршлагыг хүүхдүүдэд хуваалцах , аав ээжүүдийн тусламжтайгаар хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх зорилгоор IV/20-V/10 хооронд зохион байгуулсан уг уралдаанд нийт 24 захидал ирснээс
1-р байр С.Эрдэнэсайхан / Цогтцэций сумын 27-р цэцэрлэгийн багш, /
2-р байр М. Цэцэгбадам / Ханхонгор сумын ЕБС –ийн бага ангийн багш /
Х.Туяа / Даланзадгад сумын ЕБ 5-р сургуулийн багш /
3-р байр Б. Болор-Эрдэнэ / Даланзадгад 3-р багийн иргэн /
Ц.Нарангэрэл / Баян-Овоо сумын иргэн / тус тус байр эзэллээ.

10. “СОЁЛЫН ЦАГ” АЯН

Ард иргэдэд хүрэх соёл урлаг, соён гэгээрүүлэх ажлыг сайжруулах, соёлын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх зорилготой СОЁЛЫН ЦАГ

аяны нээлтийг Номын баяр арга хэмжээтэй давхцуулан IX/16-ний өдөр ЖТеатрт зохион байгууллаа.

IX/24. "Соёлын цаг" ТАНАЙ БАГТ-ТАНЫ ДЭРГЭД соёлын арга хэмжээг "Залуус" талбайд зохион байгуулж шинэ ном хэвлэл танилцуулах, гэрээр ном олгох, уншигчийн карт нээх, тэмцээн уралдаан, азтай оролцогч шалгаруулах арга хэмжээнүүд зохион байгуулж ажиллаа

X/28 Ханхонгор сумын иргэдэд шинэ номын танилцуулга, уншлага үйлчилгээ, соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгууллаа.

X/29. Политехникийн коллежийн оюутнуудын дунд ном хэвлэл сурталчилах, уншлага үйлчилгээг үзүүлж, соёл танин мэдэхүйн ажлууд зохион байгууллаа.

XI/06 Цогтцэций сумын 93 хүүхэд, залуучуудад 186 ширхэг ном олгож уншлага, үйлчилгээг зохион байгуулж ажилласан.

11. ШИНЭЛЭГ АЖИЛ

Говийн 10 домгийг түгээн дэлгэрүүлэх, нутаг усаараа бахархах, эх оронч үзлийг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэх зорилгоор тус но мын сангийн сан хөмрөгт байдаг газар усны домог хүүрнэх “Говийн арван домог” номыг цахим хэлбэрт оруулж mongolmedleg.org сайтад байршуулан нийтийн хүртээл болголоо.

Мөн Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөрийн хүрээнд уг 10 домгийг ХЖТеатрын уран бүтээлчдээр уншуулж, Алтанговь телевиз дүрсжүүлэн видео хэлбэрт оруулж аймгийн Өмнөговь хуудсаар дамжуулан түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгууллаа. Цахимд байршсан уг 10 видеог 590453 хүн үзэж сонирхсон байна.

Видеог DVD болгон бичүүлж сумдын соёлын төвүүд, Музей, ХЖТеатр зэрэг байгууллагуудад тус бүр 2-5 ширхэгийг хүлээлгэн өглөө.

12.ДҮГНЭЛТ

Давуу тал ба боломж:

Тус номын сангийн хувьд 2020 онд Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан шинэ номын сангийн зураг төсвийн ажилд номын сангийн орчин, нөхцөлд тавигдах шаардлага, өнөөгийн уншигчдын хэрэгцээнд нийцүүлсэн зургийн даалгаварыг гарган өгч улмаар шинэ номын сангийн эскиз зураг батлагдаж, зураг төсвийн ажил дуусах шатандаа явж байна.

Хөгжлийн ирээдүй-Оюунлаг залуучууд, Хүүхэд хөгжлийн түлхүүр зэрэг аймгийн дэд хөтөлбөрүүдэд холбогдож хүүхэд, залуучуудын ном уншлага, соёлын түвшинг дээшлүүлэх соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгууллаа.

Орон нутгаас 2020 онд хөтөлбөрүүдтэй уялдуулж нийт 14,529,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнд:

1. Хөгжлийн ирээдүй-Оюунлаг залуучууд хөтөлбөрийн хүрээнд 5,0 сая төгрөг /2,500,000 төгрөгийн ном, 2,500,000 төгрөг Номын хэлэлцүүлэг/
2. Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөр/3,0сая/
3. Хүүхэд хөгжлийн түлхүүр /Говийн 10 домог уралдаан/ 945,0мянга
4. Үндэсний бичиг үсгийн баяр /300,0 мянга/
5. Соёлын цаг, Номын баяр /979,0 мянга/
6. Автоматжуулалтын программыг 3 жилээр сунгаж, тогтмол хэвлэлийн модулиар өргөтгөх асуудлыг шийдвэрлэв /5,250 мянга/

Цаг үеийн нөхцөл байдал олон нийтэд үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй байсан хэдий ч цахимд суурилсан танин мэдэхүйн ажлууд, мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулан ард иргэдийг соён гэгээрүүлэх үүргээ биелүүлж ажиллаа.

Сул тал, бэрхшээл

3-р сарын 11-ний өдрөөс 6-р сарын 25 хүртэл, 11-р сарын 12-ны өдрөөс хойш нийтэд үйлчлэхгүй, дотооддоо сан хөмрөгийн тооллого, номын ариутгал, цахим мэдээлэл лавлагааг олон нийтэд хүргэн ажилласнаас танхим, болон зөөврийн үйлчилгээний тоон үзүүлэлт өнгөрсөн онуудтай харьцуулахад харьцангуй доогуур гарч байна.

Номын сангийн орчны газар гэж байхгүй, гурван талаас барилгууд баригдаад үйлчлүүлэгчид номын санруу орж үйлчлүүлэхэд бэрхшээлтэй болсон. Баруун талд олгосон





газрыг эзэмшигч нь хашаалж барилгын ажлын эхлэл тавьсан. Уг ажлыг хийх явцдаа ачааны машин номын сангийн үүдний цементэн талбай дээгүүр гарч явах, барилгын дуу чимээ уншлага үйлчилгээ явуулахад хүндрэлтэй болсон.

Хэрэгцээ шаардлага

Цаг үеийн нөхцөл байдал номын сангийн байнгын хэрэгцээнд ашиглах боломжтой ном хэвлэлийг ариутгах тоног төхөөрөмжтэй болох. Ингэснээр ариутгал хийсэн номыг гэрээр олгох, гэр бүл, хамт олонд зориулсан хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх боломж бий болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДАРГА А.ОДОНЧИМЭГ

МУСГЗ, ЯРУУ НАЙРАГЧ Г. МЭНД-ООЁОГИЙН НЭРЭМЖИТ СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ХОЁР. ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ БА ТОВЧ АГУУЛГА

2.1. Номын сангийн алсын хараа, зорилго, зорилт

Алсын хараа:

Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг аймаг орон нутгийн төвшинд хэрэгжүүлэхэд номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн уншигчдад бие даан суралцах, өндөр боловсрол эзэмших, номын санг иргэдийн мэдээллийн төв болгон хөгжүүлэхэд оршино.

Зорилго:

Мэдлэг дээдэлсэн мээдээллийн эрин зуунд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг өсөн нэмэгдүүлж, иргэдэд цаг хугацаа, орон зай хамааралгүйгээр хэрэгцээт мэдээллийг номын сангийн үйл ажиллаганы дагуу, мэргэжлийн түвшинд хүргэдэг нээлттэй мэдээллийн төв байхад оршино.

Зорилт:

Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглан мэдээллийн чөлөөт урсгалыг өргөжүүлэн хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Номын баяжилтыг нэмэгдүүлэх, үндсэн данс бүртгэл, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах

Нийгмийн зорилтот бүлгүүдэд хүрч үйлчлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх

2.2. Номын сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодит байдлын үнэлгээ, тулгарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зам

Иргэдэд ном, хэвлэл мэдээллээр үйлчлэх, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг номын сангийн үйлчилгээнд хамруулах, Номын санд биеэр ирж чадахгүй байгаа өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өргөнөөр хамруулах, нийт ард иргэдийн дунд ном унших хөдөлгөөн өрнүүлэх, номыг бүтээлчээр унших арга зүйг түгээх, уншигчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие даан суралцахад туслах, хөгжихөд туслах зорилгоор үйл ажиллагаагаа төлөвлөн явуулж ирсэн.

Дэлхий нийтэд тархсан COVID-19 улмаас хөл хориог 2020 оны 01 сарын 27-наас 06 сарын –22-ны өдөр, 11 сарын 12-наас 12 сарын 11-ний өдрийн хугацаанд тогтоосон тул коронавирусын халдвараас сэргийлж, уншлага үйлчилгээ, ном олголт энэ хугацаанд танхимаар хийгдээгүй учраас уншигч, ирэгсэд, ном олголтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүрээг өргөжүүлэхэд анхаарч, “Соёлын цаг” хөтөлбөрийн хүрээнд байгууллага, иргэн, ЕБС-ийн сурагчдыг картжуулах аяныг зохион байгуулж, зөөврийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж ирсэн.

Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж цахимаар ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан гаргаж, үйл ажиллагаагаа цахимаар явуулах зэргээр шинэ нөхцөл байдлаар ажиллаж ирсэн.

Үйлчилгээний хүрээ, зохион байгуулалт, чанар хүртээмжийн талаар (номын сангийн сан хөмрөг, үйлчилгээ, каталог зохион байгуулалт, лавлагаа номзүйн үйлчилгээ, номын сангийн автоматжуулалт, аргазүйн үйл ажиллагаа,

2.3. хүний нөөцийг чадавхижуулах, захиргаа удирдлага зохион байгуулалтын ажил, бусад, дүгнэлт)



Номын сангийн сан хөмрөг:

Фондын сан хөмрөгийг ном болон тогтмол хэвлэл, хэвлэмэл бус бүтээгдэхүүнээр бүрдүүлж, уншигчдын эрэлт хэрэгцээт ном, нутгийн зохиолчдын уран бүтээл, хүүхдэд зориулсан уран бүтээл зэргийг худалдан авч, фондоо баяжуулдаг бөгөөд нийт 48814 ш номын фондтой.

2020 онд: Төсвөөр 3966550 төгрөгний 147 нэр төрлийн 234 ширхэг ном

Хандиваар 1114200 төгрөгний 51 нэр төрлийн 72 ширхэг нийт 5080750 төгрөгний 306 ном шинээр ирсэн бөгөөд мөн Монгол Улсын Ерөнхий сайд У. Хүрэлсүхийн санаачилсан "Соён гэгээрүүлэх аян"-ыг дэмжин "ДАС" ихэр сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй GANGAR_NM4RE -2019 01Distribution _NL төслийн хүрээнд Монгол Улсын нийтийн номын сангийн 376 салбарт "Монгол ардын баатарлаг тууль" номыг үнэ төлбөргүй тараахтай холбогдуулж, 12 сумын соёлын төвийн номын сангуудад тус бүр 5 ш нийт 65 ш номыг хандиваар ирсэн.

Үйлчилгээ:

Байгууллагын үйл ажиллагаа болон тэмдэглэлт өдрүүд, шинэ номын мэдээлэл, цаг үеийн байдалтай холбоотой мэдээ мэдээллийг МУСГЗ Г. Мэнд-Ооёогийн нэрэмжит Аймгийн Нийтийн номын сан page хуудас, https://aimaglibrary.wordpress.com/блог, https://www.facebook.com Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан нүүр хуудсаар тогтмол сурталчилж, шуурхай хүргэн ажиллаж ирсэн.

Байнгын уншигч-1289

Ирэгсэд-3073

Бүх олгосон ном-5027 байна.

“COVID-19” халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор өрөө, танхимуудын ариутгал халдваргүйтэлийг тогтмол хийж, ДЭМБ, ЗГ-ын болон УОК, ЭМЯ-ны шийдвэр, заавар зөвлөмж, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврыг даган үйл ажиллагаагаа явуулж, коронавируст халдвартай холбоотой бүхий л цаг үеийн мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлгийг хүргэж, цахим номын сан, цахим номын уншлага, цахим хичээлүүд зэрэг бүхий л мэдээллийг тогтмол хүргэн сурталчилсан бөгөөд байгууллагын цахим хуудсанд 135576 сэтгэгдэл оруулж, давхардсан тоогоор 269351 хүн тандалт хийсэн байна.















Каталог зохион байгуулалт :

Lib4U номын сангийн цогц программ хангамжийн мэдээллийн баазад нийтдээ 17500 нэр төрлийн нийтдээ 41607 ном байршсан.

Лавлагаа ном зүйн үйлчилгээ:

Уншлага үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч үйлчилгээндээ “Үүлэн технологи” нэвтрүүлэн ажиллаж, номын сангийн Lib4U программ хангамжийн мэдээллийн бааз онлайн орчинд ажиллаж, үйлчилгээг цахим хэлбэрээр явуулж хэвшсэн.

Номын сангийн автоматжуулалт



Шинээр баркод хэвлэгч захиалан үйлчилгээндээ нэвтрүүлэн, 1000 гаруй номонд шинээр баркод нааж гарган үйлчилгээнд оруулаад байна.

Сүхбаатар аймгийн 12 сумдын Монбиблио программын нэгдсэн тайлан, каталогийн мэдээ, мэдээллийн нөөцийг шинээр авч нөөцөлсөн.

Аргазүйн үйл ажиллагаа

Байгууллагын захирлын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/03 тоот тушаалаар арга зүйчээр Т. Чандманийг томилж, арга зүйн ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, номын сангийн дэргэдэх мэргэжлийн зөвлөл байгуулах, ерөнхий данс буюу нэгбүрчилсэн бүртгэлийг шинэчлэх төлөвлөгөө гаргаж ажиллах, Үндэсний номын сангаас ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх, номын ангиллыг ББК ангилал болгож солих зэрэг ажлуудыг төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үндэсний номын сангаас ирсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарч, 2020 оны төлөвлөгөө болон арга зүйн ажлын төлөвлөгөөнд тусган, Үндэсний номын сангийн арга зүйч Б. Сарандэлгэрээс заавар зөвлөгөө тогтмол авч ажилласан.

Хүний нөөцийг чадавхижуулах



Хүний нөөцийг чадавхижуулахад анхаарч, байгууллагын хүний нөөцийн стратеги төлөвлөлт болон 2020 оны хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж, хэрэгцээтэй боловсон хүчнээр орон тоог нэмэгдүүлэн нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүний нөөцийн төлөвлөгөөнд ажилтан, албан хаагчдыг мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх сургалт, цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тусгаж, ажилчдын хүүхдийн төрсөн өдрөөр цалинтай чөлөөг эцэг, эхэд олгох, үр дүнгийн гэрээний үр дүнг үндэслэн урамшууллыг сар бүр олгох, /6187.408 төгрөг / эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах, коронавирусийн үед богиносгосон цагаар болон зайнаас гэрээр ажиллуулах зэргээр хэрэгжилтийг ханган ажиллаж ирсэн.

Захиргаа удирдлага зохион байгуулалтын ажил

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 тоот тушаалын 3 дугаар хавсралтын шинэчилсэн загварын дагуу боловсруулан хийж ажилласнаас гадна шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, бэлэн байдлын үеийн тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийт ажилтан, албан хаагч нарт Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, БСШУС-ын Сайдын 2020 оны “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” А/43 тоот тушаал, БСШУСЯ-ны ТНБД-ын 2020 оны 02 дугаар сарын 07-ны “Ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах тухай 2/748 тоот албан бичиг, 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/588, аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” А/601, 2020 оны 11 сарын 18-ны өдрийн “Хэвийн богиносгосон, зайнаас ажиллах жагсаалт баталх тухай А/603, Зарим байгууллагын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх тухай 2020.12.08-ны өдрийн А/649 тоот захирамжууд, аймгийн Засаг даргын 2020 оны “Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, ажил эрчимжүүлэх тухай 01, 2020 оны 11 дүгээр сарын 13-ны “Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай А/06 тоот албан даалгавруудыг тус тус танилцуулж, ажлын чиглэл гарган ажилласан. Үүнд:

“Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зарим арга хэмжээ авах тухай” байгууллагын захирлын 2020 оны 02 дугаар сарын 05-ын өдрийн А/01, 2020 оны 11 сарын 12-ны өдрийн А/ 27, 2020 оны 12 сарын 01-ний өдрийн А/31 тоот тушаалын дагуу ажлын тусгай горимд шилжүүлэн, зайнаас гэрээр ажиллуулан, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлааг сайжруулах чиглэлээр ажилласан.

Байгууллагын цахим хуудсаар болон өрөө, танхим бүрт анхааруулга сэрэмжийн талаар мэдээлэл өгч сурталчилж, үйлчилгээний танхимуудад ариутгал халдваргүйтэлийг тогтмол хийж, ажилтан, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор хоолны мөнгө олгох, аарц чацаргана, витаминаар үйлчлэх, амны хаалт олгох, ариутгалын бодисоор ханган ажилласнаас гадна АЗДТГ-т өөрсдийн оёсон 120 ш амны хаалтыг 100.0 төгрөгний хамт, мөн БСУГ-аас гаргасан уриалгад нэгдэж, 35.0 төгрөг нийт 135.0 төгрөг хандивлаж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээ тайланг аймгийн ЗДТГ, ЭМГ, БСУГ тогтмол гарган өгч ажилласан.

Аймгийн засаг даргын 2020 оны А/263 тоот захирамжийн дагуу “Хамгаалагдсан хүүхэд-



Хариуцлагатай аав ээж” ажиллагааны дагуу төлөвлөгөө гарган ажиллаж, нийт 100 ширхэг амны хаалтыг оёж, 80 ширхэг витамины хамт амны хаалтгүй хүүхэдтэйгээ зорчин яваа жолооч,тоглоомын талбай болон гадуур яваа амны хаалтгүй хүүхдүүдэд тараан өгч Covid 19 халдварт өвчнөөс сэргийлэх зөвлөмжийг өгч ажилласан.

ГУРАВ. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

3.1. Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт, байрлуулалт, эргэлтийн байдал

Байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд, уншигчдаас санал асуулга авч, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангаж ажиллах, үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, нэмэгдүүлэхэд анхаарч, дүн шинжилгээ хийж ажиллах, номын санчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчил дутагдлыг дор бүр нь засах арга хэмжээ авах, номын сан дахь сонин, сэтгүүл, үнэт ховор ном, цахим номыг бүртгэлжүүлэн, данс бүртгэлтэй болох, нэгдсэн тоог гаргах, Үндэсний номын сангаас ирсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, нийтийн уншлагын танхим болон хүүхдийн танхимын номын санч өөрчлөгдсөнтэй холбогдуулан номын тооллого хийж, акт үйлдэн, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах, хугацаатай үүрэг өгч ажиллах, шинэ хууль тогтоомж, эрх зүйн актын талаарх мэдээ, мэдээллийг хүргэж ажиллах зэрэг ажлуудыг төлөвлөн, хэрэгжилтийг хананган ажиллаж ирсэн.



Брайл ном, сонсдог ном CD аудио хуурцагнуудаа бүртгэлжүүлж, брайль номын данс нээж, нийт 400 номыг дансжуулсан.

3.2. Номын сангийн сан хөмрөгт үнэлэлт, дүгнэлт хийж судалгаа хийсэн байдал

Номын сангийн сан хөмрөгийн данс бүртгэл, хадгалалт хамгаалалтыг цэгцлэх, сайжруулах зорилгоор “Номын сангийн ерөнхий данс буюу нэг бүрчилсэн бүртгэл шинэчлэх ажлын төлөвлөгөө” гаргаж, данс шинэчлэх ажлыг эхлүүлж, одоо ашиглаж байгаа данс бүртгэлийг үзэж нягтлан шалгалт хийх, ахмад номын санчдаас мэргэжлийн зөвлөгөө авч ажиллах, дансны хуулалтанд тогтмол хяналт тавьж, шаардлага хангасан тохиолдолд дараагийн данс хуулах ажлыг эхлүүлэх, шинээр хуулсан данс бүрийг тухай бүр нь хүлээн авч, тухайн ном байгаа байхгүйд нягтлан шалгалт хийж баталгаажуулах, бэлэн болсон дансан дахь номыг цахим каталогитой тулгалт хийх ажлыг зохион байгуулах, зөрчлийг арилган баталгаажуулж, номын нэгдсэн дүн мэдээг гаргах зэрэг ажлуудыг тусган ажиллаж байна.





3.3. Номын сангийн тооллого, хадгалалт хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар

Номын сангийн сан хөмрөгт ном хэвлэлийн тооллогыг тогтоосон хугацаанд номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журмын дагуу хийж ирсэн.

Нийтийн уншлагын танхим болон хүүхдийн танхимын номонд ажил хүлээлцэхтэй холбогдуулж, тооллого хийж, электрон каталогит ороогүй орхигдсон болон баркодны зөрчилтэй, баркод наагаагүй номыг наах зэрэг гарсан зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгч ажиллаж байна. Тооллогын үеэр бүх номонд ариутгал халдваргүйтэл хийж ажилласан. Нийтийн уншлагын танхимын тоологдоогүй 409 номноос 275 номонд бар код нааж, шинээр 69 катологт оруулсан бөгөөд бар кодны зөрчилтэй зассан ном 25 ш номыг засуулж, хүүхдийн танхимын 94 нэр төрлийн 106 ш ном шинээр оруулж, баркодгүй 352 ш номыг баркоджуулсан.

Мөн тогтмол хэвлэлийг улирал, он оноор нь багцлан дугаарлан, хавтаслан үдсэн.

ДӨРӨВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Уншигчдад номын сангаас үзүүлж буй үйлчилгээ болон номын сангийн үйлчилгээний инноваци, нэн шаардлагатай үйлчилгээ

Уншигчдад үйлчилгээг:
Гэрээр ном олгох танхим
Нийтийн уншлагын танхим
Хүүхдийн уншлагын танхим
Цахим мэдээллийн танхим гэсэн 4 танхимаар явуулж, Lib4U программ хангамжийг 2010 оноос эхлэн үйлчилгээндээ ашиглаж, 2019 онд ҮҮЛЭН ТЕХНОЛОГИ-ийг нэвтрүүлэн илүү хүртээмжтэй чанартай үйлчилгээг орон нутгийн иргэддээ шуурхай хүргэж ажиллаж байна.

4.2. Номын сангуудад шаардлагатай төсөл-хөтөлбөр

Хараагүй Хүмүүсийн Инноваци Хөгжлийн Төв ТББ, Канад сангаас санхүүжүүлэн ХХИХТөвөөс хэрэгжүүлж буй **"Хараааны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадваржуулах нь"** төсөл нь 2 дахь жилдээ үргэлжлэн хэрэгжиж байна.



УБ хотын Дэйзи номын сангийн мэргэжилтэн М. Цэнгэл, Оюунтүлхүүр сангийн тэргүүн Д. Оюунтүлхүүр нарын тусламжтайгаар хүүхдийн сонсдог үлгэр 2, өгүүллэг 3, роман 1, нийт 6 ширхэг сонсдог ном бэлэн болгосон.

4.3. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Иргэдийг соён гэгээрүүлэх арга хэмжээнд 6000 гаруй хүн хамрагдсан.

Дэлхийн номын өдөр:

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн гишүүн, Ган үзэгтэн шагналт, Боловсролын тэргүүний ажилтан, ахмад багш Д. Сэнгэдоржийн шинэ уран бүтээл "ХҮМҮҮН" шинэ номын нээлт, онлайн-live-уулзалтыг 04 дүгээр сарын 23-ны өдөр, мөн бүх насныхны дунд "Миний ширээний шилдэг ном" уралдааныг тус тус онлайнаар зохион байгуулан явуулсан.

"ХҮМҮҮН" шинэ номын нээлт, онлайн live-уулзалтыг 2200 хүн үзэж, 87 хүн сэтгэгдэл иргүүлсэн байна.

Миний ширээний шилдэг ном" уралдааныг тухайн хүн өөрийн уншсан хамгийн шилдэг номын талаар танилцуулж, бичлэгээ "Сүхбаатар аймаг номын сан" https://www.facebook.com/ хуудсанд байршуулахаар зохион байгуулан явуулахад нийт 18 хүн оролцсон бөгөөд:

Тэргүүн байр-т: Баяндэлгэр сумын бүрэн дунд сургуулийн 12-р ангийн сурагч Ө.Янжинлхам – 537 like

Дэд байр-т: ЕБ-ын 1-р сургуулийн 10а ангийн сурагч Г.Ундраа – 481 like

Гутгаар байр-т: Түмэнцогт сумын ЕБС -ийн 11а ангийн сурагч Х. Ганзул-391 like авч шалгарсан байна. Дэлхийн номын өдөрт зориулсан



мэдээлэл лавлагааны ажлуудыг цувралаар бэлтгэн гаргасан.

Үндэсний бичиг үсгийн баяр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, Үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, бүх нийтийн монгол бичгийн хэрэглээг дээшлүүлэх зорилгоор “Хүмүүн бичиг- Хүн бүрийн бичиг” facebook группээр дамжуулан цахим хэлбэрээр “Сайхан бичигтэн хамт олон, байгууллага, иргэн шалгаруулах уралдааныг АЗДТГ, БСУГ, НТБТ-тэй хамтран 5 сарын 5-8-ныг хүртэл зохион байгуулахад нийт 30 байгууллагын 591 төрийн албан хаагч идэвхитэй оролцсон.

“Сайхан бичигтэн хамт олон, байгууллагаар:

Тэргүүн байр: Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургууль
Дэд байр: Баруун-Урт сумын Засаг Даргын Тамгын Газар
Гутгаар байр: 4-р цэцэрлэгийн хамт олон

“Сайхан бичигтэн иргэн”-ээр :

Тэргүүн байр - Ө. Гансувд / Royal International University-Олон улсын харилцаа-3-р курсын оюутан /
Дэд байр - Б. Мөнхзул / 7-р багийн иргэн /
Гутгаар байр - З. Эрдэнэбаатар /Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн Менежмент 2-р дамжааны оюутан / нар тус тус шалгарсан.

“Монгол бичиг үсгийн гайхамшиг” уран бичлэгийн уралдааныг бүх насныхны дунд зохион байгуулахад нийт 10 гаруй бүтээл ирснээс

Насанд хүрэгсэд:

“Тэргүүн” байранд Ц. Энхбаатар / BBS телевизийн найруулагч /
“Дэд” байранд Э. Ганцэцэг / ЕБ-ын 4 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш /

Өсвөр насанд:

“Тэргүүн” байранд Үндэсний лаборатори 1дүгээр сургуулийн 12г ангийн сурагч Ө. Сайнцэцэг
“Дэд” байранд ЕБ-ын 2 дугаар сургуулийн 12б ангийн сурагч Э. Даваажав нар шалгарсан.

Номын тэмдэглэл хөтлөх уралдаан:

Гэртээ бие даан ном унших, бүтээх, хөгжих, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, уншсан номын тэмдэглэл хөтлөх, уншсан номныхоо агуулгыг зураад бүтээлчээр өөрөө өөрсдийгөө хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Номын тэмдэглэл хөтлөх” уралдаанд А.Лхагвасүрэн /1-р 10 жил /, Э. Даваасугар /1-р 10 жил/ шалгарч, гарын бэлэг, номоор шагнаж урамшуулав.

Очирбатын Дашбалбарын шүлгийг хэн уран унших вэ? уран уншлагын онлайн уралдаан:

Уг уралдааныг Тархи цэнэглэгч клубтэй хамтран зохион байгуулахад нийт 37 хүн оролцож,
Тэргүүн байранд: Баяндэлгэр сумын ЕБС-ийн сурагч Ө.Янжинлхам
Дэд байранд: Баруун-Урт сумын ЕБ-ын 2-р сургуулийн сурагч Э. Биндэръяа, Т.Сүндэрьяа
Гутгаар байранд: Баруун-Урт сумын ЕБ-ын 2-р сургуулийн сурагч Б.Урангоо
Тусгай байранд Түмэнцогт сумын ЕБС-ийн сурагч Б.Оргилмаа нар шалгарсан.

"Монголын Нууц Товчоонд нэвтрэхүй" цуврал нэвтрүүлэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9.1, 12. 12, МУ-ын Ерөнхийлөгчийн 2004 оны 02 сарын 18-ны өдрийн "Монголын Нууц товчоо"-г эрхэмлэн дээдлэн тухай 23 дугаар зарлигийн дагуу “Цахим үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрээнд "Монголын Нууц Товчоонд нэвтрэхүй" цуврал нэвтрүүлгийн анхны дугаарыг онлайн хэлбэрээр хүргэхэд 1000 гаруй хүн харж, тандалт хийсэн байна. Уг хэлэлцүүлэгт төрийн сангийн хэлтсийн дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Барчидгүнсэн, 2-р БДС-ийн түүх, нийгмийн багш С. Мандахтуяа нар оролцсон.

"Өглөөний гайхамшиг" номын яриа хэлэлцүүлэг: Өглөөний ургах нартай уралдан өөрсдийгөө хөгжүүлж яваа залуучуудад зориулан "Өглөөний гайхамшиг" номын яриа хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулан ажилласан.



"Зуны зугаатай уншлага" Сурагчдын зуны амрарлтанд зориулж, "Зуны зугаатай уншлага" 1 сарын аяныг зохион байгуулж, шинээр 36 хүүхдэд карт нээж, 276 ирэгсдэд 325 номоор үйлчилсэн.

- "Хүүхэд хөгжлийн цагаар"- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтэн Э.Насанжаргал "Цахим донтолт, цахим орчны зохистой хэрэглээ", "Харилцаа ба хандлага". мэргэжилтэн Э. Оюунзул "Найз нөхдийн харилцаа" "Сурагчийн аюулгүй байдал" сэдвүүдээр сургалт
- "Мэдээллийн цаг"-1 булангаар "Монголын нууц товчоо" номын тухай мэдээлэл, номын санд байгаа "Монголын нууц товчоо" номоор үзэсгэлэн
- "Мэдээллийн цаг"-2 булангаар "Ургийн бичиг хөтлөхийн ач тус"
- "Үлгэрийн цагаар "Манжин", "Ухаант туулай", "Улаан талгайт", "Мидас хаан" үлгэрээр театрчилсан тоглолт
- "Бүтээл сурталчлах" цагаараа Хүүхдийн зохиолч Н. Доржцэрэнгийн бүтээлээс
- "Танин мэдэхүйн цаг"-1 булангаар бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, оюун ухаан зарцуулах асуулт хариултын тэмцээн
- "Танин мэдэхүйн цаг"-2 булангаараа 3D зураг харж сурах сургалт
- "Танин мэдэхүйн аялалын цаг"-1 булангаар аймгийн төвийн хөшөө дурсгалын газраар явган аялал

- "Танин мэдэхүйн аялалын цаг"-2 булангаар "Өүлэн эх"-ийн хөшөөг үзэж, Алунгоо эхийн домгийг ярилцан, бие биендээ хүндэтгэлтэй хандах амлалт өгөн, дэлхийн улс орны төрийн далбаа болон мэдээлэл агуулсан картаар тоглож олон орны мэдлэгтэй болж, хөл бөмбөгийн талбайд тоглох зэргээр зохион байгуулсан.

Номын үзэсгэлэнг:

1. “Үлгэрийн дээжис” номын үзэсгэлэн-30 ном
2. "ШИНЭ НОМ-2020" -55 ном
3. “Хүүхдийн зохиолчдын бүтээл”-20 ном
4. “Нутгийн зохиолчдын бүтээл”-30 ном
5. “Монголын нууц товчоо”-23 ном

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар зарлигаар жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдрийг “Эх хэлний өдөр” болгон зарласантай холбогдуулж, байгууллагын ажилтан, албан хаагчид яруу найрагч О.Дашбалбар агсны “Эх хэл мину” шүлгийг цахимаар уншиж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан монгол хэлээрээ зөв ярьж, зөв бичих, язгуур соёл, өв уламжлалын талаар сурталчилсан.

"Нээлттэй хаалганы өдөр" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 05 сарын 24-ний өдрийн 97 дугаар зарлигийн дагуу "Нээлттэй хаалганы өдөр"-г Соёлын байгууллагуудын Соёлын цаг хөтөлбөрийн хүрээнд Жаахан шарга" театр, Угсаатны зүйн музейтэй хамтран Д. Сүхбаатарын талбайд 2020 оны 9 сарын 11-ний 16 цагаас байгуулж, энэ арга хэмжээнд шинэ номын болон хүүхдийн номын 50, Монголын нууц товчооны дээжээс 20 гаруй ном, үнэт ховор номын үзэсгэлэн 6, нутгийн зохиолчдын худалдаа 25 нийт 100 гаруй номоор, монгол бичгийн уран бичвэрийн үзэсгэлэн зэргийг гаргаж, уншигч, хэрэглэгчдээс судалгаа авч ажилласан.



НОМЫН БАЯР-2020" АРГА ХЭМЖЭЭ: Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн "Номын баяр" тэмдэглэн өнгөрүүлэх 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, хүүхэд, залуучууд, ард иргэдийг өргөнөөр оролцуулсан. ажиллагаа зохион байгуулах,

ном солилцох, бэлэглэх, хандивлах, шилдэг ном шалгаруулах, номын зохиогчийг алдаршуулах, сайн уншигчийг тодруулах ажиллагаа явуулах, зохиолч уншигчдын уулзалт ярилцлага хийх, бүх нийтээр ном эрдмийг сурталчлах, номын өв санг арвижуулах, хүүхэд залуучуудын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, хэвлэл мэдээллээр сурталчлах зорилгоор **"Номын баяр-2020"** арга хэмжээ " **хязгаар үгүй-НОМ- сэтгэлгээний эрх чөлөө"** уриан дор 2020 оны 09 дүгээр сарйн 17-18-ны өдөр зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 1000 гаруй хүн оролцсон.

Номын баяр-2020" арга хэмжээнд сум, сургуулийн нийт 29 номын санчид, зохиолч, яруу найрагчид, ЕБС-ийн тэргүүний уншигч хамт олон, номын клубын сурагчид, ном борлуулагч газрууд, ахмад номын санчид, идэвхитэн уншигч нар хамрагдсан.

"НОМЫН БАЯР-2020" ӨДӨРЛӨГ

09 дүгээр 18-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд номын өдөрлөгийг зохион байгуулж, уг өдөрлөгөөр шинэ номын хямдралтай худалдаа болон уншигчийн гар дээрх номын худалдаа, нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн худалдаа, үнэт, ховор номын үзэсгэлэн, ном сурах бичгийн солилцоо, ном хандивын аян, сум, сургуулийн номын сангуудын үйл ажиллагааны танилцуулга, богино өгүүллэгийн уралдаан зэрэг арга хэмжээг өргөн дэлгэр зохион байгуулж явуулж, номын сангийн үйлчилгээний талаар уншигч, хэрэглэгчдээс судалгаа авч ажилласан.

БОГИНО ӨГҮҮЛЛЭГИЙН НААДАМ”

“Богино өгүүллэгийн уралдаан”-ыг 2 үе шаттайгаар зохион явуулж, 1-р шатны уралдааныг цахимаар явуулахад нийт 20 гаруй хүн бичлэгээ ирүүлж, 2-р шатанд ЕБС болон насанд хүрэгсдээс нийт 9 хүн өрсөлдөж,

Насанд хүрэгсдийн ангилалд:

Тэргүүн байр: Түмэнцогт сумын соёлын төвийн бүртгэл мэдээллийн ажилтан Б. Долгормаа

Дэд байр: Асгат сумын ЕБС-ийн дуу хөгжмийн багш Отгончимэг

Гутгаар байр: ХЖТ - ын жүжигчин Х. Очинжанцан

Сургуулийн насанд:
Тэргүүн байр:3 дугаар бүрэн дунд сургуулийн 7б ангийн сурагч А. Анужин
Дэд байр: 2 дугаар бүрэн дунд сургуулийн 6- р ангийн сурагч Ариунзаяа
Гутгаар байр: Халзан сумын ЕБС - ийн сурагч А . Хас нар тус тус шалгарсан.

“ НОМ ХАНДИВЫН АЯН”

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн санаачилсан “Соён гэгээрүүлэх аян”-ыг дэмжин “ДАС” ихэр сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй GANGAR_NM4RE -2019 01Distribution _NL төслийн хүрээнд Монгол Улсын нийтийн номын сангийн 376 салбарт “Монгол ардын баатарлаг тууль” номыг үнэ төлбөргүй тараахтай холбогдуулж, бүх сумын соёлын төвийн номын сангуудад тус бүр 5 ш нийт 65 ш номыг болон Номын баярыг угтаж зарласан "Ном хандивын аян"-д цугларсан номуудын хамт хүлээлгэн өгч, шилдэг ном хандивлагч байгууллага, иргэнийг шалгаруулав.

Сум, сургуулийн номын сангуудад ном хандивын аян өрнүүлж, **“Шилдэг ном хандивлагч”** байгууллагаар:
Аймгийн ЗДТГ
Дарьганга сумын соёлын төв
Онгон сумын ЕБС-ийн Нямдулам багштай 10б анги
Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн З. Оюунтуяа багштай 7а анги нэр тус тус шалгарсан.
“Шилдэг ном хандивлагч иргэн”- ээр :
ЕБС - ийн 1 дүгээр сургуулийн захирал Ц. Оюунжаргал
Татварын улсын байцаагч Ц. Цэнгэлмаа
ЕБ-ын 2 дугаар сургуулийн захирал С. Батчулуун нар шалгарсан.

"Номын баяр-2020" арга хэмжээний хүрээнд "Шилдэг ном", "Шилдэг уншигч"-ийг тодруулж, "Шилдэг ном-2020" шагналаар нийтлэлийн бүтээл Д. Сэнгэдоржийн "Хүмүүн" ном "Шилдэг уншигч"-аар Дөрвөлж ОНӨҮГ -н ажилтан Д. Баттүшиг нар шалгарсан.

Сум, сургуулийн номын сангуудыг сурталчлах зорилгоор номын сангийн үйл ажиллагааны талаарх "Бүтээлч танилцуулга”-тай номын санг шалгаруулахад Сүхбаатар сумын соёлын төвийн номын сан, мөн тус сумын ЕБС- ийн номын сан шалгарсан.

"Соёлыг түшиг" холбооны “**Соёлын гавъяа”** шагналаар: Баяндэлгэр сумын соёлын төвийн номын санч Г. Урнаа

“**Соёлын алдар медаль**”-иар: Уулбаян сумын соёлын төвийн номын санч П. Ганцэцэг Дарьганга сумын соёлын төвийн номын санч Л. Оюунтөгс нар тус тус шагнагдсан.

“СОЁЛЫН ЦАГ“ ХӨТӨЛБӨР:

Соёлын цаг” хөтөлбөрийн хүрээнд бүх албан байгууллага, ЕБС-ийн сурагчдыг картжуулах, зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор Аймгийн нэгдсэн эмнэлэг, Угсаатны зүйн музей, ЕБС-ын сургуулиуд, Нийгмийн даатгал, Боловсрол өргөө дотуур байр, Татварын газар, Аймгийн ЗДТГ, Биеийн тамир спортын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, БОАЖГ, Стандарт хэмжил зүй, Мэргэжлийн хяналтын газар, ХХААГ, МСҮТ, Нэгдсэн эмнэлэг, Худалдааны төвүүдэд хүрч ажиллан, энэ хугцаанд 300 гаруй хүнд карт нээн, хэрэглэгчийн судалгаа авч, зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн ажиллаж, нийт 250 хүнээс судалгаа авч, тайланг нэгтгэн БСУГ хүргүүлсэн.

"Хөндөж боломгүй хөх тавилан" номын нээлт: Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын харьяат утга зохиолын "Дөрвөн цаг" нэгдлийн гишүүн Уртнасангийн Будын "Хөндөж боломгүй хөх тавилан" номын нээлт Баруун-Урт хотод зохион байгуулагдаж, шинэ номын үзэсгэлэн худалдаа, уран бүтээлчийн хувийн архив, лавлагаа ном зүйн үзэсгэлэнгүүд гарч, 300 гаруй хүн хамрагдсан. Яруу найрагч У.Буд МЗЭ-ийн "Утга зохиолын төлөө" шагнал, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр тус тус шагнагдсан.

"Цахим ертөнцөд соёл түгээе аян: Соёлын яамнаас уриалж байгаа "Цахим ертөнцөд соёл түгээе" аянд нэгдэж, СҮХБААТАР нутгийн яруу найрагчдын уран бүтээлээс сурталчлахад АНУ, Улаанбаатар хот, Дорнод аймаг, Асгат, Түвшинширээ, Баруун-Урт сум гэх зэрэг олон газраас өөрсдийн уран бүтээлээс илгээж, сарын аяны хугацаанд олон нийтэд сурталчлан таниулж, 20 гаруй уран бүтээлчид оролцож, цахимаар нийтдээ / people viems/ 69934 хүний хандалт авсан.

“Цахим ертөнцөд соёл түгээе” аянд бичлэг илгээсэн СҮХБААТАР НУТГИЙН яруу найрагчдаас...



4.4. Ном уншилтыг сайжруулах. Уншлагын төвүүдийг зохион байгуулах, үйл ажиллагааг нь зохицуулах ажил хийсэн эсэх

“Энх өглөө” номтой уулзалтыг зохион байгуулж, “Тархи цэнэлэгч” клубын Б.Ундрал, 2 дугаар цэцэрлэгийн багш С.Анхтуяа оролцож, мөн уг клубын тэргүүн, ЕБ-ын 3-р сургуулийн 12б ангийн сурагч С. Мөнх-Эрдэнэ “Автуус ба амьдрал” номыг байгууллагын нүүр хуудсаар дамжулан танилцуулсан.

Номын сангийн дэргэдэх "Оюуны хөтөч" клубын ахлагч ЕБ-ын 2 дугаар сургуулийн 7в ангийн сурагч Э. Биндэръяа Гэрэлцолмон багштай 2в ангийн хүүхдүүдэд "Сургамжтай усаар байлдсан" үлгэрээр чанга уншлага, номын сангийн үйлчилгээ болон номын тухай яриа таниулга, клубын гишүүн ЕБ-ын 2-р сургуулийн 7в ангийн Ө. Дөлгөөн Сонинцэцэг багштай 4а ангид "Модон шувуу " үлгэрийг цахим хэлбэрээр сонсгож хэлэлцүүлэг зохион байгуулахад 60 гаруй хүүхэд хамрагдсан.

Цахим үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд шинэ номын мэдээллүүд болон Л.Сарантуяагийн “Зүчи хаан” түүхэн роман, Луи Замперминий амьдрал, бодит түүхээс сэдэвлэн бичсэн “Мятаршгүй” ном, монгол ардын үлгэр “Могжоохон даагатай жогжоохон хүү” үлгэрийг сурталчилсан.

4.5. Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал

Түмэнцогт, Халзан, Уулбаян, Онгон, Наран Сүхбаатар сумын соёлын төв, Түвшинширээ, Асгат сумын ЕБС-ийн номын сангуудад нийт 300 гаруй номоор хүргэж ажилласан байна.

4.6. Зөөврийн номын үйлчилгээг: Зөөврийн номын сангийн үйлчилгээг давхардсан тоогоор 700 гаруй хүнд, 1300 гаруй номоор үйлчилсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд /сонсдог ном/, 2-р БДС-ийн номын сан, Улаан загалмайн нийгэмлэг, Баруун-Урт сум 2. 9-р цэцэрлэг, Цайрт ХХК, нэгдсэн эмнэлэг, ЕБС 3-р сургууль, Угсаатны зүйн музей, 2-р цэцэрлэг, Эхэн ус эмнэлэг, Дээж худалдааны төв, Эрхэт цайны газар, Аймгийн ЭМГ-ын мэргэжилтэн Энхсайхан, ГБХЗХГ-ын

мэргэжилтэн Энхбат, Насанжаргал, Уртцагаан ХХК-ы ажилчин Сувдаа зэрэг хүмүүст давхардсан тоогоор 700 гаруй хүнд, 1300 гаруй номоор үйлчилсэн байна.

4.7. **Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал**

COVID-19 улмаас хөл хорио тогтоосонтой холбогдуулан эцэг эхээр дамжуулан хүүхдэд гэрээр ном олгож үйлчилгээг 20 гаруй хүнд олгож 100 гаруй ном олгож үйлчилсэн байна.

"Номын нөхөрлөлийн холбоо" байгуулан номтой нөхөрлүүлэх, хамт олноороо цагийг бүтээлч өнгөрөөх, уншсан номын тэмдэглэл хөтлүүлэх зорилго тавин 4-р БДС-ийн Нацагням багштай 6б, 1-р БДС-ийн Аззаяа багштай 8б, 3-р БДС-ийн Мөнхзул багштай 5в анги нар хамрагдсан.

Найзтайгаа уншъя" уншлагаар ЕБ-ын 3-р сургуулийн сурагчид "Өглөөний гайхамшиг" номын талаар ярилцлага зэргийг зохион явуулсан.

4.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал

2010 оноос харааны бэрхшээлтэй иргэдтэй, 2019 оноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн бөгөөд тэдний бүтээлч байдлыг дэмжих,

орчин үеийн тоног төхөөрөмжийг ашиглан хэвлэлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ном унших боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж ажиллаж ирсэн. Мөн эрх зүйн хөтчийн хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр халамжийн хэлтэс, Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн нар нийгмийн даатгал, халамж болон тэтгэмж тэтгэврийн хуулийн шинэчилсэн найруулгын талаарх мэдээ мэдээллийг иргэддээ сурталчилж, мэдээлсэн.

Хөгжлийн бэрхэшэлтэй иргэд өдөр тутам уншлага үйлчилгээнд хамрагддаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхдэд гэрээр нь зөөврийн номын үйлчилгээг хүргэсэн.

Эрх зүйн хөтөч сургалтын хүрээнд МХГ-ын хүнс чанар, стандарт хяналтын улсын байцаагч Т.Амарбат, Эрүүл ахуй, халдвар хамгаалалтын улсын байцаагч Э. Мөнхнаран, Хөдөлмөр нийгэм, хамгааллын улсын байцаагч Г.Гэрэлцацрал, Нийгмийн даатгалын хэлтсийн ХШДАТасгийн дарга Ч. Наранзул, тэтгэвэр хариуцсан байцаагч Б. Энхтуяа нар ХБ-тэй иргэдэд мэдээлэл өгсөн.



COVID19 халдварт цар тахлын хүрээнд Улаан загалмайн хороонд “Нэг өдрийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнд амны хаалт, витамин өгч, энэ цар цахлын үед амны хаалт хэрхэн зүүж хэрэглэх талаар мэдээлэл өгсөн.

Дэлхийн цагаан таягтны өдрийг угтан ЕБС, насанд хүрэгсдийн дунд “Харааны бэрхшээлтэй иргэн миний бодлоор” эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулахад 80 гаруй хүн хамрагдсан.



2-р багийн хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон эмэгтэй М. Батцэцэгт хүнсний зүйл, хувцас зэрэг эд зүйлсийг 100.0 төгрөгний хамт өгсөн.

4.9. Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн эсэх

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд болон хяналт шинжилгээ, үнэлгээний ажилд хийгдээгүй, дутуу явж байгаа, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг гарган өгч, холбогдох хүмүүст нь хариуцуулан өгсөн.

ТАВ. ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн үйл ажиллагаанд лавлагаа номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар:

Номын сангийн бүтэц орон тоог Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/159 тоот захирамжаар шинэчлэн батлуулж, ном зүйчийн орон тоотой болон ажиллаж, Сүхбаатар аймгийн нутгийн зохиолчдын ном зүйн бүртгэлийг хэвлүүлэн гаргах, уншигчдад лавлагаа, мэдээллийн үйлчилгээг тогтмол хүргэх, орон нутгийнхаа ном судар, гар бичмэл, бичиг соёлыг эрэн сурвалжлан, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.



5.1. Ганцаарчилсан хэрэглэгч болон үйлчлүүлэгч байгууллага, хамт олныг мэдээлэл-номзүйн үйлчилгээгээр хангасан байдал

Номын сангийн үндсэн программ хангамж болох Lib4U программ дээр үйлчилгээний танхимуудыг үйл ажиллагааг цахимаар хянан ажиллаж, үйл ажиллагааг цахимаар явуулж хэвшсэн.

5.2. Хэрэглэгчийг мэдээллийн соёлтой болгоход чиглэгдсэн ажлууд хийсэн эсэх

Сонин, сэтгүүлийн өгүүллийн улсын нэгдсэн сан “Зотеро” программд аймгийн тогтмол хэвлэл болох “Сүхбаатарын өнгө” сонины 2020 оны 11 сар хүртэлх дугааруудын 100 гаруй мэдээллийг шивж оруулсан бөгөөд ном сэлбэн засагч Н. Баярчимэгт уг программыг зааж сурган, хүлээлгэж өгсөн.

ЗУРГАА. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Орон нутаг судлах цогц төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар хийсэн ажил

6.2. Орон нутгийн картын сан, номзүйн бүртгэл эрхлэн гаргасан эсэх





“Сүхбаатар нутгийн зохиолч, уран бүтээлчдийн намтар ном зүй”-г сэтгүүлч Г. Сүхээгээр уран бүтээлчдийн намтрыг хянуулж, номзүйн бичилтийг Хотын номын сангийн номзүйч Түвшинтогтохоор хянуулахаар өгөөд байгаа бөгөөд номын эх бэлтгэл дуусч 2 дахь шатанд шилжсэн.

ДОЛОО. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1. Номын санд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, технологийн үйл ажиллагааг хэрэглэгчдэд хүргэхэд чиглэгдсэн ажлуудын талаар:

- 2020 оны Аймгийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Номын сангийн цахим үйлчилгээнд 19 сая төгрөгний техникийн шинэчлэл хийгдэж аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн А/14 тоот тушаалаар томилогдсон комисс хүлээн авсан. / Аймгийн Засаг даргын тамгын газраас зарласны дагуу уг тендэрт "Нэкстдистрибьюшн" ХХК шалгарсан /

Техникийн шинэчлэл хийгдсэнтэй холбогдуулж, телефон интернэтийг шилэн кабель руу шилжүүлж, интернэт хурдыг нэмэгдүүлсэн.

НАЙМ. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1. Номын санчдад аргазүйн зөвлөгөөг амаар болон биечлэн хүргэсэн байдал

Үндэсний номын сангаас гаргасан номын сангийн бичгийн тайлан боловсруулах загварын дагуу нийт номын сангуудад заавар зөөвлөгөө, номын сангийн статистик мэдээ тайлангийн тайлагналт шинэчлэгдсэнтэй холбогдуулж, Дарьганга,Уулбаян, Түмэнцогт, Баяндэлгэр сумын номын санчдад зөвлөгөөг амаар, "Номбибло" программын талаарх сургалтыг сумдын соёлын төвийн номын санчдад тус тус хүргэсэн.

8.2. Номын санд томилолтоор явж туршлага судалсан, аргазүйн туслалцаа үзүүлсэн болон дүн шинжилгээ хийсэн байдал (тоо, сэдэв, үр дүн).

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг номын санчдын нэгдсэн спортын наадам Төв аймгийн Зуун мод хотод зохион байгуулагдаж, сум, сургуулийн номын санчдын хамтарсан баг амжилттай оролцож, ширээний теннисийн эрэгтэй төрөлд мөнгөн медаль, дартсын төрөлд багаараа мөнгөн медаль хүртсэн.

Сүхбаатар сумын соёлын төвийн номын санд очиж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

8.5. Номын санчдад зориулсан сургалт семинар зохион байгуулсан байдал.

“НОМЫН САНЧДЫН НЭГДСЭН СУРГАЛТ”

2020 оны 09 дүгээр сарын 17-ны **“Номын баяр-2020”** арга хэмжээний хүрээнд номын санчдын нэгдсэн сургалтыг зохион байгуулж, СУИС-ийн харьяа Соёлын боловсролын дээд сургуулийн багш Т. Хайдав, Хүүхдийн төв номын сангийн хэлтсийн дарга Г. Дарьсүрэн. Арга зүйч Л. Батболор нар уригдан ирж оролцож, “Цахим номын сангийн үйлчилгээ”, “ЕБС-ийн номын сангийн үйл ажиллагаа ба орчин үе”, “Хүүхдийн ном унших дадлыг хэвшүүлэх нь”, “Хүүхдийн Төв номын сангийн соёл танин мэдэхүйн ажлууд”, “Хүүхдийн уншлаганд эцэг эхийн оролцоо” Monbiblo цахим үйлчилгээг идэвхижүүлэх нь зэрэг сэдвээр сургалтыг явуулж, сум, сургуулийн нийт 29 номын санчид оролцсон.





"Mongolian library update-2020" Номын санч.мэдээллийн ажилтнуудын улсын YII зөвлөгөөнд арга зүйч Т. Чандмань, номын санч Р.

Цолмонтуяа, Улбаян сумын номын санч П. Ганцэцэг нар оролцож, чуулганы талаарх мэдээллийг нийт ажилтан, албан хаагчдад өгсөн.

Удирдлагын академээс зохион байгуулсан “Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт хийх арга зүй” сургалтанд арга зүйч Т. Чандмань хамрагдаж, байгууллагын байгууллагын ажилтан, албан хаагчдад дотоод сургалтыг цахим мэдээлэл бэлтгэн танилцуулсан.

“Архив, албан хэрэг хөтлөлтийг байгууллага хэрхэн бэлтгэх арга зүй” сэдэвт 1 сарын сургалтанд бичиг хэрэг, архивын ажилтан А. Оюунтуяа хамрагдаж, мэргэжлийн үнэмлэхтэй болсон.

Хүүхэд залуучууд гэр бүл, хөгжлийн газраас зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдэвт сургалтанд нийт ажилтан, албан хаагчид хамрагдсан.

ЕС. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

9.1. Номын сангийн хүний нөөцийн өнөөгийн байдал, хангалт (Номын сангийн орон тооны ажилтны тоо, номын санчийн тоо, мэргэжлийн боловсон хүчний тоо /бүрдэлт/-ийг судалгаанд үндэслэж гаргасан байдал)

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн С/30 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS5742:2019” жагсаалтыг үндэслэн номын сангийн бүтэц орон тоог Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/159 тоот захирамжаар шинэчлэн батлуулж, арга зүйч, ном зүйч, сүлжээний инженер, программист, ном сэлбэн засагч, бичиг хэргийн ажилтан, нярвын орон тоог нэмэгдүүлэн Захирал 1, арга зүйч 1, сүлжээний инженер – 1, ном зүйч-1, номын санч, мэдээллийн ажилтан -4, ном сулбэн засагч-1, нярав-1, бичиг хэргийн ажилтан -1, үйлчилгээний ажилтан-1 гэсэн 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

9.2**.** Хүний нөөцийг чадавхижуулсан байдал (сургалт, семинар, урамшуулал)

2020 оны 06 сарын 03-ны өдөр ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ (ЖДШ⁺) цахим сургалтанд Захирал Х. Мөнгөн-Өлзий, “Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх" сэдэвт онлайн сургалт хэлэлцүүлэгт номын санч В. Энхтуяа тус тус хамрагдсан.

Үндэсний номын сангаас 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан номын сангийн ангилагч, каталогч нарт зориулсан онлайн сургалтанд нийт албан хаагчид болон сум, сургуулийн номын санчид хамрагдсан.

"ОРЧИН ҮЕИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА УНШИГЧИЙН ХЭРЭГЦЭЭ" сэдвийн хүрээнд Зохиолч, уншигч, номын санчдын дунд "Орчин үеийн номын сангийн үйлчилгээ ба уншигчийн хэрэгцээ" хэлэлцүүлгийг зохион байгуулж, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч Ц. Оюундэлгэр, ахмад номын санч М. Дэнсмаа, идэвхитэн уншигч Мөнхжаргал нар уригдан оролцож, сум, сургуулийн бүх номын санч нар хамрагдсан.

Д. Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын Нийтийн Төв номын сангийн 40 жилийн ойн арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан онол практикийн хуралд оролцов.

Байгууллагын нийт албан хаагчид угийн бичигтэй болгох зорилт тавин ажиллаж, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, улирлын ажлын үзүүлэлт болгон дүгнэсэн бөгөөд Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоол "Угийн бичг хөтлөх журам"-ын дагуу байгууллагын ажиллагсдад угийн бичиг хөтлөх талаар заавар өгч, нийт ажилчдыг хөтлүүлэх ажлыг хийсэн. Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн " Уралдааны болзол батлах тухай" А/85 тоот захирамж "Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалъя" угийн бичгийн хөтлөлтийн уралдаанд тайлагналт гаргаж өгсөн.

10. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Төсвийн тухай шинэ хуулийг мөрдөж ажиллан, байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтод тулгуурлан төсвийг дунд хугацаагаар төлөвлөн, төсөв болон тодотгосон төсвийн сар, улирлын хуваарийн дагуу үйл ажиллагаагаа явуулсны үр дүнд 2019 онд 92,005,900 төгрөгний санхүүжилт авч, өр авлагагүй ажилласан.

2020 онд 16 сая төгрөгний санхүүжилттай ажиллаж байна.

Байгууллагын тамга, улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчилж, тамга солиулж, 2019 оны байгууллагын баримт бичигт нягтлан шалгалт хийж цэгцлэн, дотоод товъёог, баримт ашиглалт, баталгааны хуудас үйлдэх, үдэж хавтаслах, хаяглах зэрэг ажлуудыг хийсэн.



11. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА: Байгууллагын 2020 оны "Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө"-г шинэчлэн гаргаж, эрчим



хүчний байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14 тоот албан бичиг хүргүүлж, мэргэжлийн хүн авчирч шалгуулан дүн шинжилгээ хийлгэж, цахилгааны утас залгуур, унтраалгыг солих, шинээр хийлгэх зэрэг дотоод бүх шаардлагатай арга хэмжээг авч ажиллан 600,0 төгрөгний эд материал зарцуулсан.

Байгууллагын 2020 оны ХАБЭА-н төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт ажиллагсад болон ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт 11 дүгээр сарын 11-ний өдөр хамруулсан.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар 5.10 дугаар сарын 2 дахь Бямба гариг" Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-өөр 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр өөрийн эзэмшил газар 4,5 дугаар тойргийн зам дагуу тарьсан модоо арчлан тордож, цэвэрлэгээ хийж ажилласан.

Аймгийн БОАЖГ-аас зарласан “Хандлагаа өөрчилж “Хамтдаа эрүүл цэвэрхэн орчинг бүрдүүлцгээе аянд хамрагдаж, ХЖТ-ын зүүн талын өөрийн хариуцсан талбайн хог хаягдлыг 03. 26-ны өдөр, Баруун-Урт сум болон БОАЖГ-аас зарласан хог цэвэрлэгээнд тогтмол оролцож, гаднах хог хаягдал, цэвэрлэгээг хийж, хогийн цэг дээр хаях арга хэмжээ авч ажилласан.

"Шинэ номын тойм"-оо цахим хэлбэрээр цувралаар хүргэн ажиллаж, цахим үйлчилгээг үр дүнтэй ашиглаж байгаа талаар МОНЦАМЭ агентлагийн хуудсаар дамжуулан сурталчлав.

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ЗАХИРАЛ Х. МӨНГӨН-ӨЛЗИЙ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрхэм зорилго:

Номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номын санг мэдээллийн төв болгон хөгжүүлэх нь бидний эрхэм зорилго юм.

Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 1948 онд 267 номтойгоор одоогийн Алтанбулаг суманд байгуулагдаж үндэс сууриа тавьжээ. 1961 оноос Сүхбаатар суманд Сэлэнгэ аймгийн Төв номын сан, 2009 оноос Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан болон өргөжиж 30000 гаруй номтойгоор Захиргаа аж ахуй, Арга зүй мэдээллийн танхим, Гэрээр ном олгох, тогтмол хэвлэлийн уншлагын танхим, Хүүхдийн уншлагийн танхим, Гадаад уншлагын танхим, Номын сангийн фонд, лавлагаа мэдээллийн тасаг гэсэн бүтэц зохион байгуулалттай нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.2014 оноос Зөөврийн номын сангийн үйлчилгээг шинээр нэвтрүүлж алслагдсан баг болон албан байгууллагуудад хүрч үйлчилж байна. Нийтийн номын сан нь жилд дунджаар 2700 гаруй уншигчийг шинээр бүртгэн авч давхардсан тоогоор 16000 гаруй ард иргэдэд 21000 гаруй номоор үйлчилгээ үзүүлж байна. Мөн Сэлэнгэ аймгийн Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд Соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион явуулж байна. Үүнд Үндэсний бичиг үсгийн баяр, Эрдмийн баяр, Номын баяр, Дээлтэй монгол хөтөлбөр, Кофет уншлага, Үлгэрээр хүмүүжье, Чихэртэй уншлага зэрэг олон төрлийн ажлуудыг зохион байгуулж байна.

Номын сангийн албан ёсны имейл хаяг: selengenomiinsan@gmail.com

Байгууллагын утасны дугаар: 7036-2169

Номын сангийн захирал: С.Шинэчимэг.

2. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж буй номын сангуудад харъяалал үл харгалзан мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, уншлага үйлчилгээний чанар, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх, хүүхэд залуучуудыг номонд дурлуулах, номын соёлыг түгээх, номын сангийн үйлчилгээнд орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх, цаг үетэйгээ хөл нийлүүлэн ажиллахыг эрмэлзэн олон төрлийн арга хэмжээг шинээр болон уламжлал болгон зохион байгуулж, хөтөлбөр төлөвлөгөөг гаргаж ажиллаа.

Номын санчдыг хөгжүүлэх иргэдийн орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангасан, хөгжиж буй номын санчдыг ажиллуулах тэднийг дэмжин ажилдаа идэвх санаачлагатай хандах, бүтээлч сэтгэлгээтэй номын санчийг төлөвшүүлэх шат дараалсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Номын сангийн орчны стандартыг бүрдүүлэх уншигчдад ном унших таатай орчныг бүрдүүлэн ажиллах,дотоод засвар үйлчилгээг хийж, уншигчдын ширээ сандалыг тогтмол засварлаж, номын санг үер усны аюулаас хамгаалах зорилгоор явган замыг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

Номын сангийн төсвийг зөв зохистой зарцуулах өр авлага үүсгэхгүй авилга ашиг сонирхолын зөрчлийг гаргахгүй төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан,төлөвлөн

зохион байгуулж, төсвийн тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж, шилэн дансыг тогтмол хөтлөн ажиллаж байна.

Жендерийн хуулийн дагуу ажлын байрны аливаа дарамт үүсгэхгүй, ажиллагсдад ажиллах таатай орчныг бүрдүүлэн ажиллахын зэрэгцээ, аливаа хүчихийлэлийг зогсоох,нийгмийн хариуцлагын хүрээнд гэр бүл хүүхдийн хүчирхийлэлийн эсрэг арга хэмжээнд нэгдэн идэвхтэй оролцож ирсэн.

2020 онд дэлхий дахинд цар тахал Корона вирусын халдвар дэгдсэнтэй холбоотой номын сангийн үйл ажиллагаанд илүү их цахим хэрэглээг нэмэгдүүлэх, гэрээсээ ажиллах горимд шилжих, түргэн шуурхай зохион байгуулалтанд шилжих, номын сангийн орчин дотоод цэвэрлэгээ ариутгалыг тогтмол хийж сар бүрийн 25-ны өдөр их цэвэрлэгээ зохион байгуулж өдөр тутмын ариутгал цэвэрлэгээг хийж түүнд тогтмол хяналт тавих ажлыг зохион байгуулж ирлээ.

Аймгийн Онцгой комиссын өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж, эргүүл жижүүр хийх, ажлын байрыг тусгай зориулалтаар ашиглах, ажилчдыг дайчлах ажлуудыг зохион байгуулж ажиллаа. Шинээр үүссэн нөхцөл байдлын улмаас цахим орчинд номын сангийн ажлыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах арга аргачлалыг боловсруулан ажиллаж байна.

3. ФОНД БҮРДҮҮЛЭЛТ БОЛОН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Цаасан Каталогыг шинээр зохион байгуулах ажлын хүрээнд фондын үсэг дараалллын 6000 гаран номонд соронзон ялтас байрлуулан фондын номыг цаасан каталогт бүрэн оруулж каталогжуулан ажиллаа . Жил бүрийн 9-р сард улс орон даяар “Номын баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Нийтийн номын сан нь “Номын баяр-2020”, “Хязгаар үгүй ном сэтгэлгээний эрх чөлөө” гэсэн уриан доор амжилттай зохион байгууллаа. Ажлын хүрээнд Шилдэг айл өрхийн номын санг шалгаруулах болон номын сангийн идэвхитэн уншигчдаа шагнаж урамшууллах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Соёлын цаг арга хэмжээний хүрээнд фондноос хуучин Монгол бичиг ,түүх ,танин мэдэхүйн нийт 120 гаруй номоор үзэсгэлэн гаргаж ном хэвлэлээ сурталчилан иргэдэд үйлчиллээ.

Фондоос уншлагын танхим, гэрээр ном олгох тасагт уншигчдын хэрэгцээт ном, хэвлэлийг тогтмол олгож ном хэвлэлийн буцалтанд хяналт тавьж байна. Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор урагдаж гэмтсэн 50 ширхэг номонд сэлбэн засалт хийн ажиллав.

Фондын номнуудыг цаасан каталогт оруулж байгаатай холбогдуулан номын тавиуруудыг ариутгалын хлорамины 2%-ийн уусмалыг бэлтгэн тавиур болон номыг арчиж, ариутган чийгтэй цэвэрлэгээг хийж номнуудаа шинжлэх ухаан,төрөл ангиар нь ангилж тавиурт буцаан байрлууллаа. Ном хэвлэлийг хуурайшилтаас хамгаалах зорилгоор агаар чийгшүүлэгчийг байнга ажиллуулж байна.

д/д	Ном олголт	Тоо,ширхэг
1	Гэрээр ном олгох тасаг	120
2	Явуулын номын санч	141
3	Ном солилцоо /Шаамар соёлын төв /	6

Сан хөмрөгийн мэдээллийн төрөл	Тоо ширхэг	Үнэ
Сан хөмрөг нийт	43607	69,728,655 төгрөг
Хэвлэмэл ном	37913	67,303,283 төгрөг
Сонин, сэтгүүл	5646	2,335,100төгрөг
Цахим хэвлэл	65	329,411төгрөг

4. КАТАЛОГИ, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн номзүйн ажлыг хэрэгжүүлэх, уншигч хэрэглэгчдэд төрөл бүрийн номзүйн лавлагаа мэдээллийг өгөх, католог шинээр зохион байгуулах, шинээр ирсэн болон хандиваар ирсэн ном хэвлэлүүдийг данслан, техник ажиллагаа хийн танхимуудад хуваарилах ажлыг хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Жилийн эцсийн байдлаар шинээр 226 ширхэг 3,582,250 төгрөгний ном худалдан авч фондоо баяжуулсан. Үүнээс:

Худалдаагаар 109 ширхэг 2.534.700 төгрөг, Хандиваар 117 ширхэг 1,047,550 төгрөгний номыг дахин үнэлэх журмын дагуу үнэлэн авч нэгбүрчилсэн бүртгэлд бүртгээд байна.

Номын санчдын татгалзлын дэвтэрт дүн шинжилгээ хийж нөхөн бүрдүүлэх шаардлагатай ном хэвлэлийн талаар улирал бүр удирдлагад танилцуулан ажиллаа.

Ээлжит бус тооллогоор дутсан номуудыг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулж нийт 45 ширхэг номыг алдагдсан номыг нөхөн төлүүлэх журмын дагуу номыг номоор нь буюу нөхөн бүрдүүлэх шаардлагатай номуудаар төлүүлэн ажиллав.

Төлөвлөгөөт болон тэмдэглэлт баяруудыг тохиолдуулан:

2020 онд шинээр ирсэн ном хэвлэлүүдийг сурталчлах ажлын хүрээнд “Шинэ номын мэдээ” болон сэдэвчилсэн мэдээллүүдийг бэлтгэн уншигчдад сурталчлан ажиллаж байна.

2020 оны 1-4-р улиралд номын сангийн каталогийн картыг шинэчлэх, үсэг дараалал болон төрөл ангийн картыг шинээр зохион байгуулах ажлын хэсгийг гаргаж тусгай төлөвлөгөөний дагуу ажиллаа.

Үүнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Фонд болон танхимуудаас номуудыг шинжлэх ухааны ангилалаар нь ялган, номын сангийн ерөнхий данстай тулган нэгтгэж каталогийн карт бичихэд бэлэн болгох
- Ном тус бүрийг программаас шүүж, каталогийн картыг номзүйн бичилтээр бичиж хэвлэх
- Карт бүрийн ард дансны дугаарыг бичиж, нэмэлт тэмдэглэлүүдийг хийх
- Картыг төрөл анги болон үсэг дарааллийн ангилаар ялган шоголд байрлуулах зэрэг ажлыг зохион байгуулж номын сангийн номуудыг 100% каталогжуулан ажиллаа.

Mongolian Library update - 2020 номын санч мэдээллийн ажилтнуудын улсын VII –р зөвлөгөөнд оролцож дараах сургалтуудад хамрагдаж, мэргэжил нэгт номын санчдаас туршлага судалж, цаашид хэрэгжүүлэх ажлаа төлөвлөн ажилдаа хэрэгжүүлэн ажиллаа.

- Номын сангийн салбарын эрхзүйн орчин, шинэчлэл
- Номын сангийн үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх нь
- Шинэ нөхцөлд дасан зохицох нь
- Номын сангийн арга зүйн ажлын өнөөгийн байдал, хүртээмж чанар
- Оюуны өмчийн бүтээлийг хуулбарлахаас урьдчилан сэргийлэх нь

Мөн 6 сэдвийн хүрээнд панел хэлэлцүүлэг зохион байгуулж номын санчид өөрсдийн сонголтоор хуваагдан оролцож, номын сангийн үйл ажиллагаа зохион байгуулах хүрээнд тулгамдаж буй асуудал, мэргэжлийн үнэлэмж, мэдээллийн технологи, сургалт арга зүй , бүтээлч санаачлагийн талаар ярилцаж санал бодлоо тусган нийт номын санчдын саналыг боловсруулж, цаашид сэдвийн хүрээнд хэрхэн хамтарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх зэрэг өгөөжтэй хэлэлцүүлэг зохион байгуулагдсан.

Хөл хорионы үеэр 3-6 сарын хугацаанд долоо хоногт 3 удаа 8-р баг Буурын голын хэсгээр эргүүлд гарч, иргэд болон аж ахуй нэгж байгууллагуудад халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллах талаар тараах материал, заавар зөвлөгөө өгөн ажилласан.

Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн гишүүнээр сонгогдон Дэлхийн зөн олон улсын байгууллага болон Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан “Байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийг чадавхжуулах сургалт”-нд хамрагдаж цаашид зөвлөлийн хүрээнд төлөвлөгөө гарган хэрхэн ажиллах талаар мэдээлэл олж авлаа.

5. ҮЙЛЧИЛГЭЭ

Уншигчдийн хүрээг тэлэх, ном олголтын хүртээмж нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, соёл олон нийтийн ажлыг тогтмол явуулах зорилго тавин ажиллаа.

УНШЛАГА

ҮЙЛЧИЛГЭЭ:

2020 оны жилийн эцэст 597шинэ уншигч, 3650 ирэгсдэд 12965 ширхэг ном хэвлэлээр үйлчиллээ. Уншигчдад өдөр тутмын тогтмол хэвлэл болон шинэ мэдээ мэдээллээр үйлчилж байна.

Номын сангийн өдөр тутмын бүртгэл, сонин сэтгүүлийн бүртгэлүүдийг стандартын дагуу бүртгэж, өгөгдсөн номзүй мэдээг 185 хэрэглэгчдэд лавлагаа өгч, номын татгалзлын дэвтэрт 16 номын санал бүртгэлээ.

Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3.2.6-д заасны дагуу ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор, урагдаж гэмтсэн 400 ширхэг номыг сэлбэн засаж үйлчилсэн.

Өдөр тутмын бүртгэл, өгөгдсөн номзүйн бүртгэл, номын татгалзлын бүртгэл, үндсэн фондтой харилцах бүртгэл, сонин сэтгүүлийн бүртгэл, ээлж хүлээлцэх дэвтэр, ном сэлбэн засалтын дэвтэр гэсэн бүртгэлүүдийг цаг тухайд нь бүртгэж ажилласан

Номын хугацаа хэтэрсэн уншигчидтай холбогдох мөн гэрээр явж хугацаа хэтэрсэн номыг буцаан татаж авсан.

Номын сангийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн уншлагыг нэмэгдүүлж номын сангийн үйлчилгээг илүү хялбар авахад туслах үүднээс Сонсголын бэрхшээлтэй иргэдтэй бичгэн хэлбэрээр харилцаж, номын хайлтыг зурган, бичгэн хэлбэрээр мэдээлэл өгч ажиллалаа. Номын сангаар хөдөлгөөний болон бусад байнга ирж чадахгүй иргэдэд номын унших хугацааг илүү урт хугацаагаар олгож номын лавлагааг утсаар олгов. Нийт 11 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилсэн ба үүнээс 4 нь сонсголын 7 хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд давтамжтай үйлчилсэн. Хараагүй иргэдэд зориулсан барлэль номыг судалж байна.

Уншигчдад үйлчлэхдээ хоорондын зай барих, амны хаалт зүүж үйлчилж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байсан.

Каталогийн ажлын шинэчлэлийн хүрээнд иргэд уншичдаас гэрээр олгосон номыг татан оруулах, каталогт шивэхэд бэлтгэж ажилласан.

Засаг даргын тамгийн газрын номын санг шинэчлэх хүрээнд номыг ангилах, номонд техник ажиллагаа хийх, дансанд бичих гэхчлэн номын сангийн стандарт журмын дагуу ажиллаж номын санг хүлээлгэн өгсөн.

Номын сангийн сан хөмрөгт буй номыг сурталчлах, хоёр хэлээр харьцуулан унших аргыг сурагчдад сонсгох мэдрүүлэх, таниулах зорилгоор Англи хэлний Анхаа багштай хамтран уншигч 2-р сургууль 6/б/анги Т.Мишээл,4-р сургууль 6/б/ анги Н.Номин –Эрдэнэ сурагчдад хүүхэд багачуудын сайн мэдэх “Улаан малгайт” үлгэрийг уншиж сонирхууллаа.

Цахим орчинд Соёл түгээе Би хариуцлагатай иргэн аянд нэгдэж Хүүхэд багачуудад зориулсан Сургамжит өгүүллэгүүдийг цуврал хэлбэрээр оруулсан. Спорт сургуулийн Монгол хэл уран зохиолын багш Э.Хулан , сурагчдад номын сангийн шинэ уншигчийн карт, сэлбэн засалт, номонд текник ажиллагаа хийх, номын мэдээ гаргах зэргээр заавар зөвөлгөө өгөв.

Гадаад монгол уран зохиолын ном, Шинжлэх ухааны номнуудын ялгагчийг солин шинэчилсэн.

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ:

Дэлхий нийтээр халдварлаж буй Covid-19 цар тахлын хүрээнд Монгол улсын засгийн газар, Эрүүл мэндийн яам, Улсын онцгой комиссоос төрийн байгууллагуудыг гэрээр ажиллахыг үүрэг болгосны үндсэн дээр ажилаа тасралтгүй үргэлжлүүлэхийн тулд иргэд олон нийтийн дунд тэмдэглэлт ойн баярууд болон уламжлалт ажлуудаа цахимаар зохион байгуулахаар болсон.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан **“Үлгэрч багачууд”** онлайн уралдааныг зохион байгуулж нийт 13 хүүхэд багачууд оролцож СӨБ-ын ангилалд Тэргүүн байр 7-р цэцэрлэгийн ахлах бүлгийн сурагч А.Чингүүн , Сургуулийн насны ангилалд Сайхан сумын ЕБС-ын 1-р сургуулийн сурагчид Э.Ирээдүй, Б.Азжаргал, “Шилдэг өгүүлэгч”-ээр Сүхбаатар сумын 1-р сургуулийн 2г ангийн сурагч Д.Дүүрэнжаргал нар амжилттай оролцлоо. Мөн оролцсон хүүхэд тус бүрт гарын бэлэг гардуулан өглөө.

Үндэсний бичиг үсгийн баярыг **тохиолдуулан “Үндэсний бичиг үсэг тусгаар** тогтнолын баталгаа”сэдэвт онлайн уралдааныг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6-12-р ангийн сурагчид болон насанд хүрэгчдийн ангилалаар зохион байгуулсан. Үүнд:

- 6-9-р ангийн төрөлд – Тэргүүн байранд “Зөв цэвэр бичигтэн”-ээр ЕБ-ын 2-р сургуулийн 7а ангийн сурагч Г.Номинзул
- 10-12-р ангийн төрөлд- Тэргүүн байранд “ Уран бичигтэн”-ээр ЕБ-ын 1-р сургуулийн 11а ангийн сурагч Г.Хонгорзул

- Насанд хүрэгчдийн төрөлд- “Миний нэрийн хуудас” уралдаанд 1-р сургуулийн багш Б.Уранбилэг нар амжилттай оролцлоо.

Монгол улсын Ерөнхийлөгчийн **“Номын баярын өдөр тэмдэглэх”** тухай 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Соёлын сайдын ивээл дор “Номын баяр 2020” арга хэмжээг “Хязгаар үгүй-НОМ-сэтгэлгээний эрх чөлөө” уриан дор 09 дүгээр сарын 19-ний өдөр дараах ажлуудыг зохион байгууллаа.

- ✓ Шилдэг номын сантай **байгууллага** шалгаруулах
- ✓ Шилдэг гэрийн номын сантай **айл өрх** шалгаруулах
- ✓ Шилдэг уншигч **“Нацагдорж тэмдэгтэн”** шалгаруулах
- ✓ **“Миний ширээний ном”** уншигчдын сэтгэгдэл цахимаар хүргэх
- ✓ **“Зүйр үг хэн сайн мэдэх вэ?”** уралдааныг Ерөнхий боловсролын сурагчдын дунд зохион байгуулах
- ✓ Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнгүүд зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

“Шилдэг номын сантай байгууллага”-аар Хилийн 0243-р ангийн хамт олон, **“Шилдэг айл өрхийн номын сан”**-аар Ахмад уншигч Н.Энэбиш гуайн номын сан шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд боллоо.

“Шилдэг уншигч-Д.Нацагдорж тэмдэгт”-ний болзлыг хангасан дараах сурагчдыг шагнаж урамшууллаа.

- Ерөнхий боловсролын 1-р сургуулийн Н. Одгэрэл багштай 5а ангийн сурагч Э.Энхжин
- Ерөнхий боловсролын 1-р сургуулийн Б.Уранбилэг багштай 11а ангийн сурагч С. Буянхишиг, Э. Орхонсэлэнгэ
- Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 5в ангийн сурагч Э.Оюунчимэг, 5б ангийн сурагч А.Гоомарал, 4а ангийн сурагч Б. Азжаргал
- Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 10г ангийн сурагч Э.Төгөлдөр,Ц. Лхамсүрэн
- Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 10а ангийн сурагч Д. Будсүрэн
- Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 8б ангийн сурагч Т. Бишрэлт, 12б ангийн сурагч П.Хонгорзул
- Ерөнхий боловсролын 6-р сургуулийн 3б ангийн сурагч Ө.Мөнгөнцэцэг, 8а ангийн сурагч М.Дөлгөөн,10а ангийн сурагч А. Номунбилэг

Бүх нийтийн уншлагыг идэвхжүүлэх, иргэдэд ном унших ыг уриалах, уншсан номоо бусаддаа сурталчлах зорилгоор **“Миний ширээний ном”** уншигчдын уншсан номын сэтгэгдлийг цахимаар зохион байгуулж, нийт 11 уншигчдын сэтгэгдлийг бичлэг хэлбэрээр хүлээн авч, өөрсдийн цахим хаягаар цуврал хэлбэрээр иргэдэд сурталчлан таниулж ажилласан.

Номын баярын үйл ажиллагааны үеэр хүрэлцэн ирсэн сурагчдын дунд **“Зүйр үг хэн сайн мэдэх вэ?”** уралдааныг зохион байгуулж, Тэргүүн байранд Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 5в ангийн сурагч Б.Ням-Очир, Дэд байранд Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 11а ангийн сурагч С.Буянхишиг нар авхаалж самбаа, ой тогтоолт, мэдлэг оюунаараа манлайлан оролцож шалгарсан тул өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн болон сурагчдын заавал унших номын жагсаалтаар үзэсгэлэн гаргаж нийт уншигчдад үзүүлэн таниулах арга хэлбэрээр зохион байгууллаа.

Соёлын яам, Нийслэлийн засаг даргын тамгын газартай хамтран улс орон даяар иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Соёлын цаг” аяны хүрээнд “ Номын сантай өдөр” арга хэмжээ амжилттай зохион байгуулж нийт 300 орчим иргэд, сонирхогчид хамрагдсан. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнд нийт 4 төрлийн 70 номоор үзэсгэлэн гаргаж, сурагчдын заавал унших номуудаар танилцуулга, шинэ номын мэдээ бэлтгэн иргэдэд номын сангийн үйл ажиллагааг сурталчилан ажилласан.Нийт үйлчилгээ авсан иргэдийн дундаас 10 хүнд шинэ уншигчийн карт үнэ төлбөргүй нээж урамшуулсан.

- ✓ “Зүйр үг хэн сайн мэдэх вэ?” тэмцээнд ЕБ-ын сургуулийн 3-5-р ангийн 8 сурагчид оролцож уралдаанд авхаалж самбаа, оюун ухаанаа сорин Тэргүүн байранд ЕБ-ын 2-р сургуулийн 5в ангийн сурагч Г.Энхбишрэл, Дэд байранд ЕБ-ын 2-р сургуулийн 5а ангийн сурагч Т.Бат-Оргил нар шалгарсан.
- ✓ Номын баяр 2020 нэгдсэн арга хэмжээ
- ✓ **“**Миний ширээний ном**”** уншигчдын номын сэтгэгдэл цахимаар хүргэх

Бүх нийтийн уншлагыг идэвхжүүлэх, иргэдэд ном уншихыг уриалах, уншсан номоо бусаддаа сурталчлах зорилгоор “Миний ширээний ном” уншигчдын уншсан номын сэтгэгдлийг цахимаар зохион байгуулж, нийт 11 уншигчдын сэтгэгдлийг бичлэг хэлбэрээр хүлээн авч, өөрсдийн цахим хаягаар цуврал хэлбэрээр иргэдэд сурталчлан таниулж ажилласан.

- ✓ Цахимаар бага болон ахлах ангийн сурагчдын заавал унших номын мэдээлэл бэлтгэн хүргэж ажиллаж байна.
- ✓ Цахимаар насанд хүрэгчдийн ном унших арга барил төлөвшүүлэхэд дэмжих зорилгоор Ном унших тухай танилцуулга мэдээлэл, сэдэвчилсэн номын мэдээ бэлтгэн ажилласан.

Номын үзэсгэлэн гаргасан тоон үзүүлэлт

д/д	Үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэнд дэлгэгдсэн номын тоо	Үзэсгэлэнд хамрагдсан сурагчид
1	Бүх зүйлийг мэдэхийг хүсч байна	20	90
2	“Уран зохиолын багш нар туслах”	18	60
3	Тив болон улс орнууд	21	50
4	Бүх мөр нь түүхээр амьсгалдаг	25	45
5	Миний хэл бол миний найз	17	75
6	Амьдралын тухай ном	22	71
7	Номтой хамт амралтаараа	24	85
8	Ид шид, домог	19	70
9	Бүх хүн мэддэг номууд	30	80
10	Номын сан-Ном-Орчин үеийн уншигч	15	89
11	Таны эрүүл мэнд таны гарт	20	65
12	Амьд байгаль	21	61
13	Бидний бахархал Чингис хаан	20	98
14	Гэр бүлийн боловсролын асуудалд	20	65

15	Хайрын тухай шүлгүүд	22	75
16	Пушкин ба түүний эрин үе	16	66
17	Толстой ба зохиолууд	18	83
18	Монгол хэл, бичиг үзэсгэлэн	21	200
19	Хамгийн дээд үнэний тухай бясалгал	18	62
20	Шинэ номын үзэсгэлэн	25	100
21	Уншигч танд уншихыг зөвлөж байна.	30	92
22	Бага болон ахлах ангийн сурагчдын заавал унших номын үзэсгэлэн	30	100
23	“Хязгаар үгүй-НОМ-сэтгэлгээний эрх чөлөө”уриан дор зохион байгуулагдах”Номын баяр 2020”арга хэмжээний хүрээнд	40	200
24	Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан “Эрдмийн баяр“ сэдэвчилсэн номын үзэсгэлэн	80	300
25	Соёлын цаг арга хэмжээ	50	100
Нийт		642	2382

Соёл олон нийтийн ажлын тоон үзүүлэлт

д/д	Соёл олон нийтийн ажлын нэр	Хамрагдсан оролцогчид		Зарцуулсан төсөв	Зохион байгуулсан огноо
		Бүртгэлтэй	Бүртгэлгүй		
1	"Үндэсний бичиг үсэг-Тусгаар тогтнолын баталгаа” онлайн уралдаан	20	40		2020.05.05-2020.05.22
	“Соёлын цаг” нэгдсэн арга хэмжээ	100	150		2020.09.23
2	“ Номын сантай өдөр” өдөрлөг	100	200		2020.09.26
3	“Зүйр үг хэн сайн мэдэх вэ?” тэмцээн	10	5	5000	2020.09.23
4	Номын баяр 2020 арга хэмжээ	40	20		2020.10.03

7	“Миний ширээний ном”	12	3	-	2020.09.11
8	“Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах	2			2020.9.18
9	Цахимаар бага болон ахлах ангийн сурагчдын заавал унших номын мэдээлэл бэлтгэн оруулах	100	300	-	2020.11.15
10	Цахимаар ном унших тухай танилцуулга мэдээлэл, сэдэвчилсэн номын мэдээ бэлтгэн оруулах	95	258	-	2020.11.16
11	Зөв амьдрах ухаан нөлөөллийн ажил	15	10	20000	2020.09
12	СӨБ-ийн хүүхдийн дунд “Чанга уншлага		65		2020.10.4 2020.10.11
13	“”Хоёр хэл”-ний уншлага	2	10		2020.11.6
		496	1061	25000	

Өөрийгөө хөгжүүлэх болон бусад ажлын хүрээнд хийгдсэн ажлууд:

Монголын үндэсний номын сангаас зохион байгуулсан “Номын сангийн ангилагч, каталогич нарт зориулсан онлайн сургалт”-нд хамрагдаж мэдээлэл, зөвлөгөө авлаа.

Төрийн албан хаагчдад зориулсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлого, төлөвлөлт сургалтанд хамрагдсан.

Арга зүйчээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч мөн 7 хоног тутам өдөр тутмын бүртгэл, өгөгдсөн номзүйн лавлагааны бүртгэл, номын татгалзыг бүртгэх дэвтэр, ном сэлбэн засах бүртгэлүүдийн мэдээ тайланг өгч ажиллалаа.

Өөрийн мэдлэг мэдээллийг дээшлүүлж, сурч хөгжихийн тулд мэргэжлийн болон шинээр хэвлэгдэн гарсан ном хэвлэлийг уншиж судлан өөрийгөө хөгжүүлэн ажиллаж байна.

“Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ” аяны хүрээнд хог хаягдлыг ариутгах асуудал, үйлчилгээнд ариутгалын бодис найруулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаа.

Нийт албан хаагчдад архив бичиг хэргийн ажилтан дараах сургалтуудыг зохион байгуулав. Үүнд:

- Галын аюулгүй байдал, цахилгаан гүйдлээс осолдогчийг салгах
- Түлэгдэлт, түлэгдэлтийн зэрэг авах арга хэмжээ
- Осолдсон хүнд анхны тусламж үзүүлэх /Зүрхний массаж хийх, зохиомол амьсгал хийх/
- Угаартахад үзүүлэх анхны тусламж
- Зүү ороох оёдол
- Харилцаа ба хандлага

Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан “Эрүүл Сэлэнгэчүүд” бүх нийтийн алхалтанд хамт олноороо оролцож, морь уралдах, Шагай няслах, шагай шүүрэх төрлүүдэд амжилттай оролцсон.

6. ХҮНИЙ НӨӨЦ

Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 7 сургууль болон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хилийн 0101, 0243-р ангийн нийт 10 номын сангийн ажилтай танилцан мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Мөн номын санчдаас санал авч тэдний мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор "Номын сангийн үйл ажиллагааг сайжруулах нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтаас номын санчдын гаргасан дүгнэлтийг танилцуулбал:

1. ЕБС-ийн номын санч нарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тогтвор суурьшилтай ажилуулах, тэдний мэдлэг чадварыг сайжруулах, давтан сургах, мэргэшүүлэх тал дээр онцгой анхааран ажиллах
2. Номын санд ном унших таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, уншигчдад үйлчлэх үйлчилгээг стандартын дагуу зохион байгуулахад байгууллагын зүгээс анхааран ажиллах
3. Номын сангаас зохиох соёл хүмүүжлийн ажлыг чанаржуулж, номын сангууд харилцан туршлага солилцож, хамтран ажиллах зэрэг дүгнэлтийг гаргаж хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгийн газар нь ажилтан албан хаагчиддаа зориулсан номын сан шинээр бий болгох хүсэлт гаргасан учраас номын сангаас мэргэжил аргазүйн туслалцаа үзүүлж, 2 өдөр 350 гаруй номыг номзүйн ангилалаар ангилж, номын сангийн стандартын дагуу бүртгэн дансалж, техник ажиллагаа хийж, тавиурт нь байрлуулан хүлээлгэн өгч ажилласан.

7. ТЕХНОЛОГИ

Мэдээллийн технологчийн ажлын хүрээнд:

ГНОТ, ХУТ-с уншигч, үйлчлүүлэгчдэд эрхлэн гаргаж буй номын үзэсгэлэнгүүд, бүх төрлийн олон нийтийн үйл ажиллагааны хэвлэлийн материалыг хэвлэн бэлтгэж номын сангийн цахим хуудсаар тогтмол сурталчлан ажиллаж байна.

Covid-19 цар тахалтай холбоотойгоор байгууллагын facebook хаяг, хуудсыг хөгжүүлэх, 5000 найз 2000 гаруй дагагчдаараа дамжуулан нийгэм олон нийтэд бүхий л төрлийн мэдээллийг цаг алдалгүй цахим хаягаараа мэдээллэн ажиллаж байна.

"Соёлын цаг", "Үндэсний бичиг үсгийн баяр" "Номын баяр" гэх мэт томоохон тэмдэглэлт өдрүүд, бүх нийтийн арга хэмжээнд байгууллагын мэдээлэл, шинэ уншигчдад зориулсан мэдээллийг шингээсэн шинэлэг дизайн бүхий брошур, картууд, өргөмжлөл, эрхийн бичиг, талархал, зураг авхуулах хүрээ, номын хавчуурга зэрэг бүх төрлийн хэвлэлийн материал бэлтгэж хэвлэх болон цахим орчинд сурталчлах, мэдээллэх ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна.

2020 онд 20 гаруй нэр төрлийн 300 гаруй брошур, карт, өргөмжлөл, тараах материал зэргийг хэвлэн бэлтгэсэн байна.

"Миний ширээний ном" аяны хүрээнд 15 уншигчдаас ярилцлага авч бичлэг боловсруулах, 3 айлаас гэрийн номын сан, 3 байгууллагын номын сангийн талаар мэдээлэл бичлэг бэлтгэж цахим хуудсаараа тухай бүрт нь мэдээллэн ажиллав.

Мэргэжлийн ажиллагсдын компьютерыг форматлаж хэрэглээний программ суулгаж хэвийн ажиллагаанд оруулав.

Нийт уншигч, иргэдийн цагийг зөв боловсон өнгөрүүлэх, цахим уншлагыг дэмжих зорилгоор "Номтой сэлфи" чэллэнжийг явууллаа.

Байгууллагын лого, хүн бүрт өөр өөр афоризмыг агуулсан фудболкыг хэвлүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлэв.

Сумдын номын сангийн хүрээнд

2020-01-10 Жавхлант сумын компьютерыг форматлаж хэрэглээний программ суулгаж номын сангийн монбиблио программыг засаж ажиллуулав.

2020-02-03 Орхонтуул сумын компьютерыг форматлаж хэрэглээний программ суулгаж номын сангийн монбиблио программыг засаж ажиллуулан нөөцийг хадгалаж авав.

2020-03-04 Орхон сумын компьютерыг форматлаж хэрэглээний программ суулгаж номын сангийн монбиблио программыг засаж ажиллуулан нөөцийг хадгалаж авав.

2020-04-17 Орхонтуул сумын компьютерын доголдолыг Teamviewer программ ашиглан засаж монбиблио программыг хэвийн ажиллагаанд оруулав.

2020-05-13 Хэрх сумын компьютерыг форматлаж хэрэглээний программ суулгаж номын сангийн монбиблио программыг засаж ажиллуулан нөөцийг хадгалаж авав.

2020-06-29 Зүүнбүрэн сумын компьютерыг форматлаж хэрэглээний программ суулгаж номын сангийн монбиблио программыг засаж ажиллуулан нөөцийг хадгалаж авав

2020-08-28 Баруунбүрэн сумын монбиблио программын доголдлыг засаж ажиллуулан нөөцийг хадгалаж авав.

2020-10-21нд арга зүйч Т.Нарандалайн зохион байгуулсан сургуулийн номын санчдыг чадавхжуулах сургалтанд номын сангийн программ хангамжийн чиглэлээр мэдээлэл хийлээ.

Байгууллагын галын аюулгүй байдлыг схем зургийг хийж гүйцэтгэв.

8. ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

№	Үзүүлэлтүүд	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт тоон үзүүлэлт
11	Фондоос авсан ном	0	0	0	201 удаа	221 удаа	231 удаа	0	0	0	412 удаа	352 удаа	0	1417 удаа
22	ГНОТ-аас авсан ном	1497 удаа	1697 удаа	1236 удаа	402 удаа	462 удаа	613 удаа	784 удаа	1215 удаа	794 удаа	1336 удаа	743 удаа	0	107349 удаа
33	ХУТ-аас авсан ном	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
44	**Нийт авсан ном**	**149**	**169**	**123**	**60**	**68**	**84**	**78**	**121**	**79**	**174**	**109**	**0**	**1214**
55	Шинэ уншигч	157	20	0	0	0	30	0	23	22	37	19	0	308
66	Иргэсэд	79	255	181	62	85	84	126	146	163	228	128	0	1537
7.7	**Нийт уншигч**	**236**	**275**	**181**	**62**	**85**	**114**	**126**	**169**	**185**	**265**	**147**	**0**	**1845**
88	Ном олголт	320	439	369	169	178	252	284	216	200	407	255	0	3089

99	Алслагдсан сум дүүргийн МСҮТ,ЕБС үйлчилсэн тоо		1	1	1	0	0	0	0	0	0	1	1	0	5
110	Алслагдсан сум дүүрэгт, Аж ахуйн нэгжид үйлчилсэн тоо		1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	2
111	Тусгай байгууламжид буй иргэдэд үйлчилсэн тоо		5	5	5	3	3	4	4	5	4	7	4	0	49
112	**Нийт үйлчилсэн сум дүүрэг албан байгууллага ЕБС-ийн тоо**		**7**	**7**	**6**	**3**	**3**	**4**	**4**	**5**	**4**	**8**	**5**	**0**	**56**
113	СОНА.	ЗБ тоо	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	1
		Охүн	0	0	0	0	0	0	0	0	20	0	0	0	20

Зөөврийн номын сан нь Номын сангийн тухай хууль, Зөөврийн номын сангийн аргачлал зэрэг хууль эрх зүйн актын хүрээнд Алслагдсан сум дүүрэг аж ахуйн нэгж иргэд , тусгай байгууламжид буй иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх, Зөөврийн номын сангийн үйлчилгээний хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэн, ажлыг төлөвлөгөөг гарган ажиллаа.

Алслагдсан сум дүүрэг,Аж ахуйн нэгж болох Бор гүвээний 5-р багт 2 удаа МСҮТ-д 5 удаа, Тусгай байгууламж болох ШШГГ, Хилийн 0101-р анги, ХЦ-ийн 0243-р анги, Ахмадын сувилалд нийт 49 удаа үйлчиллээ.

2020 онд алслагдсан сум дүүрэг,аж ахуйн нэгж байгууллагад нийт **56** удаа **308** шинэ уншигч, **1537** ирэгсдэд ,**3089** ном олгон үйлчилжээ.

ЗНСан нь 2020 онд Фондын ажилтан Б Цолмонбаатараас **7** удаа **141** ном, ГНОТ-ын номын санч Б Баасандоржоос **49** удаа **1073** ном, нийт **56** удаа **1214** ном авч хамтаран ажиллаа.

2020 онд ковид-19 цар тахалын улмаас үүссэн онцгой нөхцөл байдлын улмаас АОК-оос өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж, 8-р багийн иргэд аж ахуйн дунд эргүүлийн ажлыг нийт 15 удаа хийж гүйцэтгэлээ. Гэрээр ажиллах болон цахим орчинд ажиллах хүрээнд номын сангаас өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж ажиллалаа.

ЗНСан нь 2020.09.11-нд эрхээ хязгаарлуулсан 20 иргэнд “Эрх чөлөө” “АА” нөхөрлөлтэй хамтран зөв амьдрах ухаан нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллалаа.

ЗУРГАН ТАЙЛАН

“Үлгэрч багачууд” уралдаан

“Үндэсний бичиг үсэг тусгаар тогтнолын баталгаа” онлайн уралдаан

“Үндэсний бичиг үсэг тусгаар тогтнолын баталгаа” онлайн уралдаан

“Хязгаар үгүй ном
сэтгэлгээний эрх чөлөө” уриан доор Номын баяр 2020, “Соёлын цаг” арга хэмжээ

“Миний ширээний ном “ цахим
уншлаганд оролцсон сурагчид

Каталоги шинэчлэн зохион байгуулах ажил

СӨБ-ийн хүүхэд багачуудад номын сан,

ЕБС-ийн номын санчид болон байгууллагын номын санчдад мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Мэргэжил аргазүйн сургалт

ЗДТГ-ын номын сангийн номуудыг стандартыг дагуу бүртгэж, данслав.

Цахимаар иргэдэд номын мэдээлэл, сурталчилгаа хийн ажиллав.





Гамшгаас хамгаалах сургалт
Ном сурталчлах үйл ажиллагаа

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2019 оны 47 тоот тушаалын
8 дугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САН

Тайлан гаргасан: *Төсвийн Шууд захирагч*

Нийтийн номын сангийн захирал .... */А.Ням-Од/*

(албан тушаал) *(гарын үсэг)*

Тэмдэг ....*(огноо)*

Тайлан хянасан: *Төсвийн Ерөнхийлөн захирагч*

Аймгийн засаг дарга .... */Д.Мөнхбаатар/*

(албан тушаал) *(гарын үсэг)*

Тэмдэг .... *(огноо)*

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №1.1.Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт

Хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлж, материаллаг баазыг жигд сайжруулна.

<table>
<tr><td>№1</td><td colspan="8">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="8">Соёл урлагын байгууллагуудаас хөдөөгийн багт 2-3 удаа соёл урлагийн арга хэмжээг иргэдэд хүргэж, үйлчилгээний чанар ,хүртээмжийг сайжруулна.</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="7">БСШУСайдын зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх журам</td></tr>
<tr><td rowspan="5">ЦГүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Сар</td><td>1 / 7</td><td>2 / 8</td><td>3 / 9</td><td>4 / 10</td><td>5 / 11</td><td>6 / 12</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="7">Санхүүжилтийн эх үүсвэр, тоо хэмжээг бичнэ үү.</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="7">2019 онд алслагдсан багт 2166 иргэнд хүрч үйлчилсэн</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="7">Хүрч үйлчилсэн алслагдсан багийн иргэдийн тоо</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="7">Бүтэн жилд: 2216 хүнд хүрч үйлчилнэ</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="7">Аймгийн нийтийн номын сан нь Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг иргэдэд хүргэх зорилгоор төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Аймгийн засаг даргын тамгын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгал, Улсын бүртгэлийн хэлтэс, ШШГА, Ахмадын сувилал зэрэг 6 байгууллага Зуунмод сумын 6-н баг, Хүмүүн цогцолбор бага сургууль, Баян, Баяндэлгэр, Эрдэнэ, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр, Жаргалант сумдын нийт 1093 уншигчдад 1206 номоор хүрч үйлчилсэн. Бүх нийтийн хорио цээрийн дэглэмийг барьж төвлөрөл үүсгэхгүй үйл ажиллагаагаа хүргэснээс шалтгаалан уншигчдын тоо багасаж гарсан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="7"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="7">1093 уншигчдад 1206 номоор хүрч үйлчилсэн.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="7">70%</td></tr>
<tr><td>№2</td><td colspan="8">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="8">Нийтийн номын санг “Хүний хөгжил мэдээллийн төв ” болгоно</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="7">Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Үндсэн чиглэл"-ийн хүрээнд: Хүний хөгжил мэдээллийн төв болно</td></tr>
<tr><td rowspan="5">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Сар</td><td>1 / 7</td><td>2 / 8</td><td>3 / 9</td><td>4 / 10</td><td>5 / 11</td><td>6 / 12</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="7">Төсөл хөтөлбөр 1.196.000 сая</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="7"></td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="7"></td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="7">Хагас, бүтэн жилд: Орчин үеийн жишигт нийцсэн номын сантай болно.</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="7">Төв аймаг- БНСУлсын Пёнтек хотын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Нийтийн номын санг Солонгос улсын Пёнтек хотоос 920 сая, Орон нутгийн төсвөөс 276 сая нийт 1 тэрбум 196 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар шинэчлэл хийхээр болж зураг төслийг ДИ ЭС ЖИ ХХК хийж, гүйцэтгэгч компаниар “НУМТ ӨРГӨӨ” ХХК шалгарч засварын ажил 2020 оны 06-р сарын 12- аас эхэлж 12-р сарын байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Засвар шинэчлэлийн ажил хийгдсэнээр уншигчид ая тухтай орчинд үйлчилгээ авах орчин бүрдэж Хүний хөгжил мэдээллийн төв болох эхний үеийг амжилттай хэрэгжүүллээ.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="7">1 тэрбум 196 сая</td></tr>
</table>

	Хүрсэн түвшин	90 хувийн гүйцэтгэлтэй
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		***100%***

№3	*Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин*						
Арга хэмжээний нэр, дугаар	*Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Үндсэн чиглэл"-ийн хүрээнд: Хүний хөгжил мэдээллийн төв болно*						
	Төлөвлөлтийн уялдаа:	*Номын сангийн тухай хууль*					
Айл өрх бүрийг номын сантай болгох	*Хэрэгжих хугацаа*	*Сар*	*1 / 7*	*2 / 8*	*3 / 9*	*4 / 10*	*5 / 11*	*6 / 12*
	Шаардагдах хөрөнгө	*Үйл ажиллагааны зардлаар*					
	Суурь түвшин						
	Шалгуур үзүүлэлт	Өрхийн тоогоор					
	Хүрэх түвшин	Өрхийн номын сан"-тай айл өрхийг 20%- д хүргэнэ					
Айл өрх бүрийг номын сантай болгох, ном унших соёлд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Зуунмод сумын хэмжээнд "Өрхийн номын сан"-тай айл өрхийн судалгаа авч сурталчилан өрхийн номын сантай айл өрхийг нэмэгдүүлэх.	*Хэрэгжилт*	Ном унших соёлд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэн, айл өрх бүрийг " Гэрийн номын сан"-тай болгох, гэр бүлээр нь номтой нөхөрлүүлэх зорилгоор "Миний гэрийн номын сан" цахим уралдааныг 27 сумын хэмжээнд зохион байгуулсаны үр дүнд гэрийн номын сантай өрхийн тоо 5%-аар өсөж **19.3%-**д хүрсэн байна. 27 сумын **28910** өрхийн **5603** өрх номын сантай болсон.					
	Зарцуулсан хөрөнгө						
	Хүрсэн түвшин	Гэрийн номын сантай өрийн тоо 5 % аар өсөж 19.3%-д хүрсэн					
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		***100 %***					

Гүйцэтгэлийн зорилт № 1-1-ийн үр дүн: Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
			Өмнөх улирал	Хагас жилд		Жилийн эцэст	
				Төл.	Гүй.	Төл.	Гүй.
1.	*Хүрч үйлчилсэн алслагдсан багийн иргэдийн тоо*	Сар	*2166 иргэн*	1108	*554*	2166	1093
2.	*Орчин үеийн жишигт нийцсэн номын сантай болно.*	Сар	-	*Орчин үеийн жишигт нийцсэн номын сантай болно.*	*Орчин үеийн жишигт нийцсэн номын сантай болно.*	Орчин үеийн жишигт нийцсэн номын сантай болно.	90 хувийн гүйцэтгэлтэй байна.
3	Айл өрх бүрийг номын сантай болгох, ном унших соёлд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Зуунмод сумын хэмжээнд "Өрхийн номын сан"-тай айл өрхийн судалгаа авч сурталчилан өрхийн номын сантай айл өрхийг нэмэгдүүлэх.	тоо	14,3%	17,5%- д хүргэнэ	19%	20%-д хүргэнэ	19.3%

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №2.1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зорилт

№2.1.1	*Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин*							
Арга хэмжээний нэр, дугаар	Мэдээллийг иргэдэд цаг тухайд нь хүргэх, хэрэгцээт мэдээллийг чөлөөтэй олж авах боломжийг нэмэгдүүлэх							
	Төлөвлөлтийн уялдаа:	*Номын сангийн тухай хуулийн 3.1.1 заалт*						
Аймгийн нийтийн номын сангийн үйлчилгээг иргэд, уншигчдад түргэн шуурхай хүргэн 3840 байнгын уншигч 14090 иргэдэд 40320 ном олгон уншуулж урд оны түвшинд ажилласан байна.	*Хэрэгжих хугацаа*	*Сар*	*1 / 7*	*2 / 8*	*3 / 9*	*4 / 10*	*5 / 11*	*6 / 12*
	Шаардагдах хөрөнгө	*Үйл ажиллагааны зардлаар*						
	Суурь түвшин	**3915**-н байнгын уншигч, **14682** иргэсэд, нийт **18597** уншигчдад **40767** ном						
	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлээр						
	Хүрэх түвшин	Төлөвлөгөөг 100% биелүүлж ажиллана Байнгын уншигч **2400,** Иргэсэд **9800,** Олгож уншуулах ном **28200**						
Арга хэмжээний хэрэгжилт	*Хэрэгжилт*	2020 онд сан хөмрөгийн баяжилтыг нэмэгдүүлэх, эрэлт хэрэгцээт номыг уншигчдын хүртээл болгох үүднээс төсвөөр **2.268.600** төгрөгний **118** ширхэг ном авч фонд баяжилтаа нэмэгдүүлсэн ба хандив тусламжаар **507.500** төгрөгний **65** ширхэг ном, **372.100** төгрөгний тогтмол хэвлэл авч нийт **3.148.200** төгрөгний ном, хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулан бүртгэл тооцоонд авч, электрон каталогит оруулан уншигчын хүртээл болгож байна Бүх нийтийн хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой уншигчдын тоо эрс буурч **309** Байнгын уншигч **, 889** Иргэсэдэд , **3219 ном** олгож уншуулсан үзүүлэлттэй байна.						
	Зарцуулсан хөрөнгө	***3.148.200*** *төгрөг*						
	Хүрсэн түвшин	309 Байнгын уншигч , 889 Иргэсэдэд , 3219 ном олгож уншуулсан үзүүлэлттэй байна.						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		***70%***						

Гүйцэтгэлийн зорилт №2.2.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зорилт

Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэнд

№2.2.1	*Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин*							
“Үлгэрийн баатрууд амилсан нь”	Номын сангаас соёл олон түмний ажлыг зохион байгуулан үйлчилгээний хүрээ, хүртээмжийг сайжруулж, үйлчилгээг өргөжүүлэх.							
	Төлөвлөлтийн уялдаа:	*Номын сангийн дүрэм*						
Зуунмод сумын цэцэрлэгүүдийн дунд “Үлгэрийн	*Хэрэгжих хугацаа*	*Сар*	*1 / 7*	*2 / 8*	*3 / 9*	*4 / 10*	*5 / 11*	*6 / 12*
	Шаардагдах хөрөнгө	*Үйл ажиллагааны зардлаар*						

<table>
<tr><td rowspan="3">баатрууд амилсан нь” тэмцээнийг зохион явуулна.</td><td>Суурь түвшин</td><td colspan="7">8-н цэцэрлэгийн 40-н хүүхэд</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="7">Гүйцэтгэлээр</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="7">8-н цэцэрлэгийн 40-н хүүхэд</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="7">COVID-19 цар тахал гарсантай холбоотойгоор үйлчилгээ явагдаагүй</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="7"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="7">COVID-19 цар тахал гарсантай холбоотойгоор үйлчилгээ явагдаагүй</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="7">Үнэлэх боломжгүй</td></tr>
<tr><td rowspan="2">“Уншлагыг дэмжих аян”</td><td colspan="8">Номын сангаас соёл олон түмний ажлыг зохион байгуулан үйлчилгээний хүрээ, хүртээмжийг сайжруулж, үйлчилгээг өргөжүүлэх.</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="7">Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/683 дугаар тушаалын хавсралт</td></tr>
<tr><td rowspan="5">Номын сайн нөхөр, сургууль шалгаруулах уралдаан</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Сар</td><td>1 / 7</td><td>2 / 8</td><td>3 / 9</td><td>4 / 10</td><td>5 / 11</td><td>6 / 12</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="7">Төсөл, хөтөлбөр</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="7"></td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="7">Хамрагдсан сургуулийн тоо</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="7">20 сургуулийг хамруулна.</td></tr>
Хуульчдын өдөрт зориулсан үзэсгэлэн	25
Боловсрол соёл шинжлэх ухаан сэдэвт үзэсгэлэн	22
Соёл урлагийн ажилтны өдөрт сэдэв үзэсгэлэн	38
Маршал Ю. Цэдэнбалын төрсөн өдөрт үзэсгэлэн ....гэх мэт 90 удаагийн үзэсгэлэнд	22
Хамрагдсан иргэд	15000
Нийт номын тоо	**1533**

2020 оны жилийн эцсийн байдлаар төв номын сан нийт **15** удаа соёл, олон нийтийн ажил зохион байгуулсан байна. Үүнд:

1. Монгол Улсын ерөнхийлөгчийн ‘Номын баярын өдөр тэмдэглэх’ тухай 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Соёлын сайдын ивээл дор “Номын баяр 2020” арга хэмжээг 09 дүгээр сарын 19-өөс 10 дугаар сарын 4-ний өдрүүдэд “**Хязгаар үгүй-НОМ-сэтгэлгээний эрх чөлөө**” уриан дор зохион байгууллаа.

2020.09.03-14-ны өдрүүдэд Номын баярын үйл ажиллагааны хүрээнд 72%-ийн хямдралтай номын худалдааг “**Аз Хур”** номын их дэлгүүртэй хамтран зохион байгууллаа. Орон даяар Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу ном эрдэмийг сурталчлах , номын өв санг арвижуулах, иргэдээ соён гэгээрүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээ зохион явуулж байна .Монгол Улсын Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газраас иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх зорилгоор "Соёлын цаг" нөлөөлөлийн аяныг 2 сарын хугацаатай зарлан олон арга хэмжээ хэрэгжүүлж байгаа билээ.Энэ ажлуудын хүрээнд Аймгийн Засаг Дарга Д Батсайхан 19 сумын соёлын төвийн номын санд "**Аз хур**" номын их дэлгүүртэй гэрээ байгуулан насанд хүрэгчдэд сүүлийн үеийн шилдэг номуудыг, хүүхдэд заавал судлах чиг үүрэгтэй дэлхийн шилдэг зохиолуудыг 72 хүртэл хувийн хямдралтайгаар худалдан авч оюуны их хөрөнгө оруулалт хийлээ.

Нэг суманд 72 %-ийн хямдралаар 1 сая төгрөгийн номын хөрөнгө оруулалт хийж байгаа номын үнэ нь бусад дэлгүүрүүдэд худалдаалагдаж байгаа үнэтэй дүйцүүлбэл нэг суманд бараг 2,300,000 төгрөгийн шинэ номын хангалт хийгдэж байна гэсэн үг юм.

19 суманд газар дээр нь очиж номын баярыг хамтран зохион байгуулж шинэ номын хандив өгч ажиллаа.

1. Номын баярын нээлт 9 дүгээр сарын 19-ний Бямба гаригт 11 цагаас нийслэл, аймаг орон нутагт нэгэн зэрэг эхэллээ.Энэ үеэр номын үзэсгэлэнгүүд гарч, номын худалдааг зохион байгууллаа.

2. ХДТ-ын Драм ангитай хамтран 1 сургуулийн 1 в ангийн сурагчдын дунд “**Үлгэрийн баатрууд амилсан нь**” дүрийн тоглолт, чанга уншлагыг зохион байгууллаа.

3. 2020 оны 09 сарын 21нд **"Тренди бүсгүй"** номын хэлэлцүүлэг боллоо. Манай хэлэлцүүлгийг **"Увс тренди бүсгүй"** салбарын хамт олон хамтран зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт ирж өөрийн санал бодлоо хуваалцаж нэгээхэн цаг мөчийг бидэнтэй хамт өнгөрүүлсэн уншигч, оролцогч мундаг бүсгүйчүүддээ баярлалаа.

4. **Залуу яруу найрагч, зохиолчдын уулзалт зохион байгууллаа.**

5. "**Хадгаламж өлсөхөөс эхэлнэ**" номоор өглөөний уншлагыг өглөөний 6 цагт УПК-ийн оюутнуудын дунд зохион байгууллаа.

6. Төв номын сангийн дэргэдэх АСМТөвөөс “**Harry potter**” номоор англи хэл дээр хэлэлцүүлэг зохион байгууллаа. Harry Potter номын талаар, зохиогчийн талаар ярилцаж, Kahoot хөгжөөнт тоглоом тоглож,мөн Америкт номын баярыг хэрхэн тэмдэглэдэг талаар ярилцлаа.

7. Нийтэд соёлыг түгээх үүднээс хувийн номын сантай айл өрх, иргэн суртчилах ажлыг зохион байгууллаа. Энэ ажилд идэвх зүтгэлтэй оролцсон иргэн бол 5-р багийн өндөр настан Жана овогтой Ганболд юм. Тэрээр манай номын сангийн 2016 оны хагас жилийн тэргүүний уншигчаар шалгарч байсан. Хувийн номын сандаа 350 гаруй номын арвин цуглуулгатай.

Мөн Улсын тэргүүний 1-р цогцолбор сургуулийн 7-е ангийн сурагч Даваадоржийн Анугийн гэрийн номын санг онцоллоо. Тэрээр ном унших дуртай бага ангиасаа номтой нөхөрлөсөн.Хувийн номын сандаа 250 гаруй номтой.

8. Сум бүрт явуулын үйлчилгээг соёлын олон талт хэлбэрээр зохион байгууллаа. Үүнд:
   - Шинэ номын үзэсгэлэн гаргалаа.
   - Иргэдийн дунд “**Ном бидний анд**” сэдэв илтгэл тавилаа.

- Номын солилцоо хийж, Номын азтан шалгаруууллаа.
- Уран уншлагын уралдаан зарлаж шалгарлууллаа.
- Сум бүрт тэргүүний уншигч “Д.Нацагдорж” тэмдэгтэн шалгаруулж шагналаа .



Номын баярт
оролцогчдод баяр
хүргэе.

Номын баярт
оролцогчдод баяр
хүргэе.

ҮНДЭСНИЙ НОМЫН БААР
Соёлын
ЦАГ
ТАНАЙ АЙМАГТ - ТАНЫ ДЭРГЭД
Номын баярт
оролцогчдод баяр
хүргэе.

Номын баярт
оролцогчдод баяр
хүргэе.
ҮНДЭСНИЙ НОМЫН БААР

9. Номын сангийн фонд баяжилтанд зориулж Аймгийн Прокурорын газраас Монгол Улсад Прокурорын байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойд зориулан гаргасан номоо 10 ширхэгийг бэлэглэлээ.

10. Уншигчдын дунд сүүлийн үеийн шинэ номуудаар номын худалдаа зохион байгууллаа.

11. Ким Сү Хён “**Би “Би”-гээрээ амьдрахаар шийдсэн**” номоор Хөдөлмөрийн дээд сургуулийн 1 курсын оюутнуудын дунд шөнийн уншлагыг зохион байгууллаа. Илтгэгч нь Ганбаатарын Тэмүүлэн .

12. Хилийн цэргийн 0245-р ангийн Хилчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын үйл ажиллагаанд оролцож хөгжөөнт тэмцээн зохион байгууллаж , 2020-оны **“Тэргүүний уншигч”**-ийг шалгаруулаа. 1-р байранд: Дэд хурандаа С.Баатар, 2-р байранд ахлагч Г.Уранчимэг, Хагас жилийн уншигчаар Баярмагнай нар шалгарч Нацагдорж тэмдэг, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

13. “**Монгол ардын уламжлалт зан үйл” “Ардын уламжлалт тоглоом”**-ыг танин мэдэх,тоглож сургах зорилгоор дотуур байрны сурагчдын дунд Алаг мэлхий өрөх,Шагай

шүүрэх,бөглцөг,Хорло,Үүчүүр,Бөгж нийлүүлэх,Буга гэх мэтийн 32 төрлийн тоглоомыг зааж сургалаа.

14. Яруу найргийн "Хүрэл тулга" тэмцээнийг зохион явууллаа. Тус тэмцээнд 16 хүүхэд оролцсон.

Тэмцээнийг Нэгдүгээр шатанд: Өөрийн зохиосон шүлгээр
Хоёрдугаар шатанд: Өгөгдсөн сэдвийн дагуу 5 минутанд шүлэг бичүүлж шалгаруулсан.
1-р байр: Цогцолбор 2-р сургуулийн 10-г ангийн сурагч Н.Оюунчимэг
Өргөмжлөл 20000₮ дурсгалын зүйлээр
2-р байр: Ахлах 3-р сургуулийн 11-г ангийн сурагч Н.Баасай
Өргөмжлөл 15000₮ дурсгалын зүйлээр
3-р байр: Цогцолбор 1-р сургуулийн 10-е ангийн сурагч Б.Саруул-Уянга
Өргөмжлөл 15000₮ дурсгалын зүйлээр тус тус шагнаж урамшууллаа.

15. 7 хоног бүрийн 5 өдөр орон нутгийн САМА телевизээр шинэ номын мэдээллийг 48 удаа 240 ширхэг номыг уншигчдад тогтмол суртчилж ажиллаа.

2. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ :

- Номын сан нь 14 ажилтан албан хаагчтай бөгөөд үүнээс удирдах ажилтан 1, мэргэжлийн ажилтан 8, туслах ажилтан 5 байна.Зэрэг цолын хувьд Магистр-4, бакалавр-4 байна.
- Номын сангийн боловсон хүчнийг мэргэшүүлэх, чадваржуулах бодлогын хүрээнд Номын санч Л. Алтанцэцэг 2020 онд УЗНАДС-ийг номын сан судлалаар төгсөж мэргэшлээ.
- Мэдээллийн ажилтан Д. Нямбилэг СУИС-ийн номын сангийн ангид эчнээ суралцаж байна.
- Фондын номын санч Д. Уранчимэг 2020 оны 1-р сард сард ҮНС дээр зохион байгуулагдсан сургалтанд хамрагдсан.
- Мэргэжлийн ажилчид ҮНС –с зохион байгуулагдсан онлайн сургалтанд хамрагдлаа.
- Номын санч Л. Алтанцэцэг, Д. Уранчимэг, Н. Соёлмаа нар Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд хамрагдав.
- Арга зүйч М.Лхагважавын зохион байгуулсан "Зөв хандлага,ёс зүй"-н талаар сургалтанд мэргэжлийн ажилчид хамрагдлаа.
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч Д.Норовсамбуутай хамтран "Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин" сэдвээр сургалт хийж байгууллагын эмэгтэйчүүд хамрагдлаа
- Байгууллгаас ажилчдыг чадавхжуулахын тулд монгол бичиг, англи хэлний сургалтуудыг зохион байгууллаа

3. ТЕХНОЛОГИ

Төв номын сан нь Монголын үндэсний ДАТА төвд хүсэлт гарган албан ёсны www.library.za.gov.mnгэсэн домэйн нэр авч веб сайт ажиллуулж байна.

Номын сангийн уншигч үйлчлүүлэгчдэд ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх цахим мэдээлэл өгөх үүднээс утасгүй интернет Wi fi үйлчилгээг үзүүлж байна.

Байгууллагын ажилчид үйл ажиллагаа явуулах тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.

Байгууллагын фэйсбүүк хаяг, блог хаягаар байгууллагын үйл ажиллагаа болон шинэ номын мэдээ мэдээлэлүүдийг тогтмол сурталчилж нийтдээ 2020 онд интернет үйлчилгээний төрлөөр 8400 хүнд хүрч үйлчиллээ.

Дэлхий нийтийн үнэгүй веб байршуулах www.blogspot.com   хаяг дээр Увс аймгийн Төв номын сангийн веб болох   http://uvslibrary.blogspot.com/ хаягийг суулгаж өгсөнөөр дээрх хаягийн Article Manager булангаас харахад нийт 6505 вэбийн зочин, уншигч хэрэглэгч мэдээ, мэдээлэл авч уншсан байна.

ТӨСӨВ. ОРЛОГО, ЗАРДАЛ

Төсөв санхүүгийн талаар:

Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд санхүүгийн мэдээллийг тогтмол хүргэж, “Шилэн халаас”, “Шилэн данс” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн самбар ажиллуулж, иргэд олон нийтэд мэдээллэж байна.

Байгууллагын Вэб сайт болон www.shilendans.gov.mnшилэн дансны вэб сайтад жил, улирал, сар, тухай бүрд төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах өр авлага үүссэн шийдвэрийг байршуулан ажиллаа.

2020 онд   235.933.700 төгрөгний санхүүжилт авч төсвийн ямар нэгэн өр, авлагагүй ажиллаа. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал-59.4 % , Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл-8 % , Байр ашиглалттай холбоотой зардал-24.0 % ,Хангамж бараа материалын зардал-5,1 % , Эд хогшил, урсгал засварын зардал-1,6 %, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ -0,9% -ийг зарцууллаа.

2020 онд ирсэн Хөрөнгө оруулалт хандив:

- БСШУЯ-наас 1 ш принтер 279950₮
- Номын тавиур 2ш   232800₮
- Байгууллагуудаас ирсэн хандив бэлгийн ном 73ш   584620₮
- Хувь иргэнээс ирсэн хандив , бэлгийн ном   29 ш   222500₮

Сүүлийн 3 жил аудитын байгууллагаас ЗӨРЧИЛ-гүй санал дүгнэлт авсан

2020 онд Аудитын байгууллагын   итгэмжлэл хүлээсэн .

4.Мэдээлэл, ном зүй ,арга зүйн ажлын хүрээнд:

Байгууллагын фэйсбүүк хаяг болон ил тод байдлын самбар, уншлагын танхимуудын мэдээллийн самбарт хэрэгцээт мэдээллүүдийг тавьж, соёл олон нийтийн ажлуудыг цахим сайтад байрлуулж ажиллаа.

Улирал бүр шинэ ирсэн номын мэдээг гаргаж ном зүйн мэдээллийн самбарт болон Фэйсбүүк группт байрлууллаа.

Уншигчдад хэрэгцээт мэдээллээр нь аман болон бичгэн лавлагаа өгч ажиллаа.

2018-2019 онуудад гарсан хуулиудыг стандартын дагуу бичиж, ялгагч хийн хуулийн картын сангаа баяжууллаа. Мөн орон нутгийн холбогдолтой болон орон нутгаас төрж гаргасан зохиолчдын зохиол бүтээлээр орон нутгийн картын сангаа баяжууллаа.

2020 оны ”Увсын өнгө”, “Өглөөний сонин”-ы материалыг Zotero програмд сонгон оруулж бааз үүсгэн ҮНС-ын тогтмол хэвлэлийн мэдээллийн сангийн баазад илгээлээ.

2020 оны “**Соёлын төв чанартай үйлчилгээ**” улсын уралдаанд соёлын төвүүдээс ирсэн материалыг дүгнэх ажлыг аймгийн салбар комисстой хамтран зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Номын сангийн СУ мэдээ тайланг улирал бүр шинэчилсэн маягтын дагуу гаргаж явуулснаас гадна сумуудад шинэ маягтаар тайланг нэгтгэхэд зөвлөгөө өгч ажиллаа.

Мөн СУ мэдээ тайлан шинэчилэгдсэнтэй холбоотойгоор Фондонд байгаа тогтмол хэвлэлийг нэг бүрчилэн ангиллаа.

“**Соёлын цаг нөлөөллийн аян**”-ы хүрээнд 19 сум сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Ховд сумын соёлын төвийн номын санчийн ажлын байранд сонгон шалгаруулалт явуулах, мөн номын фондын тооллогын ажлыг зохион байгуулахад зөвлөгөө өгөх, Номын санч Жаргалын өр төлбөрийг хэрхэн барагдуулах тал дээр арга зүйн зөвлөгөө өгч сумын удирдлага болон соёлын төвийн хамт олонд дүнгийн хурал хийж нөхцөл байдал алдаа зөрчил, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулж ажиллав.

Завхан сумын номын санчийн ажлын байранд өрсөлдөх 2 иргэнд номонд техник ажиллагаа хийх номзүйн бичилтийн стандарт, Monbiblio програм, данс бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх, ном ангилах, уншигчийн бүртгэл хөтлөх талаар аргазүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Завхан, Баруунтуруун, Бөхмөрөн, Тариалан сумын номын санч нарт номыг хэрхэн тоолох, ном актлах талаар зөвлөгөө өгч ажиллаа.

Аймгийн ЗДТГ нь байгууллагын номын сантай болох зорилготой 1 сая төгрөгний ном худалдан авсан тул арга зүйн дэмжлэг үзүүлж, номын сангийн **Monbiblio** программыг суулгаж, номуудыг ангилах, техник ажиллагаа хийх, электрон катологт оруулах зэрэг ажлуудад зөвлөн туслаж ажиллаа.

2020 онд номын сангийн хэрэгцээнд авсан болон бэлэг хандиваар ирсэн 509 ширхэг номуудыг zotero програмд оруулах, шинэ номын мэдээ №1,2 гаргаж уншлагын заалуудад ашиглуулсан ба байгууллагын вэб хаяг дээр тавьж нийтэд суртчиллаа.

Номын санчид Уншигчдад хэрэгцээтэй гарын авлага 35 ширхэг хийж үйлчилгээнд ашиглуулхаас гадна 474 хүнд аман лавлагаа , 11 хүнд татгалзлал өгч ажиллаа.

Зорилтот бүлэгт хүрч үйлчилсэн үйлчилгээ:

- Мөн "Онош" эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэд , ХЦ-ын 0245-р анги, хилийн заставууд, УПК-ийн дотуур байр, УЦУОШГ,ЕБС-ын дотуур байрны сурагчид, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Халамжийн төвийн дэргэдэх асрамжийн газар,Цагдаагийн газар зэрэгт зөөврийн үйлчилгээ үзүүллээ. Нийтдээ 12 байгууллагын 164 хүнд 752 ширхэг номоор зөөвөр үйлчилгээ үзүүллээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран ажиллаж 7 хоног бүрийг Лхагва гаргийг уншлагын өдөр болгон зарлаж ажиллаа.
- Дэлхийн хараагүйчдүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Онош эмнэлэгтэй хамтран "**Хараны бэрхшээлтэй иргэдийн нийгэмд эзлэх байрь суурь**" эсээ бичлэгийн цахим уралдааныг зохион байгуулж шагнаж урамшууллаа.

Шинээр санаачилж хийсэн шинэлэг бүтээлч ажил:

1. 2020 онд Ковид цар тахал гарсантай холбоотой номын сангийн үйлчилгээг хязгаарласан тул байгууллагын санаачлагаар фондын их тооллогыг 3 сарын хугацаанд хийж , уншлагын танхимууд болон фондын номын эмх цэгцийг сайжруулах, данс бүртгэлийн зөрчлийг арилгах, ажлуудыг зохион байгуулж номын санчдаас дутагдсан 296 ширхэг 2041710 төгрөгний ном хэвлэл, 12 ш 56361 төгрөгний тогтмол хэвлэлийг нөхөн төлүүллээ.
2. Тогтмол хэвлэлийн данс 4353 ширхэг хэвлэлийг шинэчлэн хууллаа.
3. 19 сумын соёлын төвийн номын санд "**Аз хур**"номын их дэлгүүртэй гэрээ байгуулан насанд хүрэгчдэд сүүлийн үеийн шилдэг номуудыг, хүүхдэд заавал судлах чиг үүрэгтэй дэлхийн шилдэг зохиолуудыг 72 хүртэл хувийн хямдралтайгаар худалдан авч оюуны их хөрөнгө оруулалт хийлээ. Сумуудад 72 %-ийн хямдралаар 19 сая төгрөгийн номын хөрөнгө оруулалтыг аймгийн засаг даргаар ивээн тэтгүүлж ажилласан нь бусад дэлгүүрүүдэд худалдаалагдаж байгаа бодит үнэтэй дүйцүүлбэл нэг суманд **2,300,000** төгрөгийн шинэ номын хангалт хийж нийтдээ **43.000.000** төгрөгний шинэ номын хөрөнгө оруулалтыг сумуудын соёлын төвийн номын сангуудад хийлээ.

4. Орон нутгийн САМА телевизтэй гэрээ байгуулан 7 Хоног бүрийн Баасан гарагийн 18 цагт шинэ номын мэдээллийг хийж хэвшсэн бөгөөд нийтдээ 48 удаа 240 ширхэг номыг иргэдэд суртчилж ажиллаа.
5. “**Соёлын цаг-нөлөөлийн аян**”-ы хүрээнд сум бүрт явуулын үйлчилгээг соёлын олон талт хэлбэрээр зохион байгууллаа. Үүнд:
    - Шинэ номын үзэсгэлэн гаргалаа.
    - Иргэдийн дунд “**Ном бидний анд**” сэдэв илтгэл тавилаа.
    - Номын солилцоо хийж, Номын азтан шалгаруулсан.
    - Уран уншлагын уралдаан зарлаж шалгарлууллаа.
    - Сум бүрт тэргүүний уншигч “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж” тэмдэгтэн шалгаруулж шагналаа .
6. Ковид цар тахлын улмаас үйлчилгээ хязгаарласантай холбоотой манай хамт олон уншигч үйлчлүүлэгчдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэднийг идэвжүүлэх үүднээс үйлчилгээгээ таслахгүйгээр тасралтгүй Увс төв номын сан page хуудсанд мэдээ,мэдээлэл байрлуулж ажиллаа .

Цахим хуудсанд байршуулсан мэдээллийг үзвэл**:**



Сүүлийн 28 хоногт **6931** хүнд хүрсэн байна.

Байршуулсан ажлуудаас :
- Үлгэрийн ном /унших хэлбэрээр/
- Дархлаа дэмжих зөвлөмжүүд
- Гэрийн нөхцөлд уусмал бэлдэх зөвлөмж
- Цэцэрлэгийн насны хүүхдүүдэд цээжлүүлэх шүлэг
- 1-р ангийн хүүхдүүдэд зориулсан унших эх
- Монгол бичгийн хичээл цуварлаар
- IQ тестүүд
- Хүүхэдтэйгээ хамт хийх бүтээлүүд
- Номын тэмдэглэл
- Бага насны хүүхдүүдэд зориулсан “12 жил”шүлэг хамгийн их хандалт авсан.
- Хүүхдүүдэд зориулсан мэдээ мэдээллийг Аймгийн “**<u>Увс -залуу ээжүүд”</u>** групп-т share хийсэн бөгөөд энэ групп-д 11 сард хамгийн олон мэдээлэл байрлуулсан Топ фен-ээр шалгарсан.
- **“Номын тухай буу халъя**”Номын тэмдэглэлийн уралдаан /аймгийн Book lovers in UG номын групптэй хамтран/ зохион байгуулж байна.

- Сургуулийн өмнөх насныханд зориулж “**Өнхөрүүш”** үлгэрийг байршууллаа. **126** хүнд хүрсэн байна.
- Сургуулийн өмнөх насныхны хэл яриаг хөгжүүлье сэдвийн дор оньсого, түргэн хэллэг, хэл зүгшрүүлэх үгсийг цахимд байршуулсан. **78** хүнд хүрсэн байна.
- Цасны тухай дуу шүлэг, өгүүллэгүүдийг байршууллаа. Хүрсэн хүний тоо **26**

Төв номын сангийн Америкийн соёл мэдээлийн төвөөс хийгдсэн ажлууд:

Англи хэлний сургалт

Америкт төгсөгчдийн үйл ажиллагаа хөтөлбөр

Тоглоомын өдөр хөтөлбөр

Англи дууны клуб

Alimni’s activities буюу Төгсөгчдийн үйл ажиллагаа

Англи хэл дээр кино үзэх хөтөлбөр **Тоглоомын цаг**

Англи хэлний ахисан түвшний яриа790ны хичээл Д.Уянга **Дунд ангийн сурагчдад зориулсан анхан шатны хичээл**

АНУ-аас Монгол улсад суух элчин сайд Майкл Клечески Увс аймагт ажиллах үеэрээ Америкийн төвд зочилсон бөгөөд төвийн үйл ажиллагаатай танилцсан нь.

Номын баярыг угтан Harry Potter номын талаар ярилцаж,мэдээлэл солилцож,хөгжөөнт тэмцээн зохион байгуулсан.

Кино өдөр хөтөлбөрөөр

Д/д	Сар өдөр	Киноны нэр	Хамрагдсан хүний тоо
1	1/7	13 going to 30	8
2	7/10	Die Mumie	6
3	7/17	Star wars	5
4	8/9	Kindergarten Cop	6
5	8/17	Valentine’s day	6
6	8/25	Flash of jenius	6
7	9/6	Zohan	5
8	9/15	Swing Vote	7
НИЙТ		8	49

- -Англи хэлний ахисан түвшний ярианы клубт нийт давхардсан тоогоор 210
- -Англи хэлний анхан шатны сургалтанд нийт давхардсан тоогоор 52
- -Тоглоомын цаг хөтөлбөрийг нийт 12 удаа 96 сурагчийг хамруулж
- -Кино өдөр хөтөлбөрт нийт 8 удаа 49 сурагчийг хамруулсан.
- Ээжүүдийн англи хэлний сургалтанд 20 ээжийг хамруулсан.

Төв номын сангийн дэргэдэх Америкийн соёл мэдээллийн төвөөс хийгдсэн ажлуудаас:

- Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан хүний эрхийн талаар мэдээл-125 хүнд хүрсэн
- Англи хэл сурах зөвлөмж-87 хүнд хүрсэн
- Англи хэл бие даан суралцахад хэрэгтэй 10 вэб сайт-26 хүнд хүрсэн
- Цастай холбоотой англи үгс -26 хүнд хүрсэн
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан төгсөгчдийн яриа цувралын дугаар-48 хүнд хүрсэн.

.

Хийсэн онлайн ажил:

1. Увс төв номын сан page хуудсанд мэдээ,мэдээлэл байрлуулсан.Үүнд:

Үлгэрийн ном

Дархлаа дэмжих зөвлөмж

Уусмал бэлдэх

Хүүхэдтэйгээ бүтээл хийх

Монгол бичиг



Цагаан толгойн хичээл

Хүүхдэд цээжлүүлэх шүлэг

Номын тэмдэглэл







Хавсралт: зураг

Шинэ номын мэдээ, үзэсгэлэнгүүд:

Ном сэлбэн засалт:





Хэвлэсэн католог:








Номын тооллого

- Хилийн цэргийн 0245-р ангийн Хилчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын үйл ажиллагаанд оролцож хөгжөөнт тэмцээн зохион байгууллаж , 2020-оны **“Тэргүүний уншигч”-**ийг шалгаруууллаа.

“**Монгол ардын уламжлалт зан үйл”** сэдэвтэй дотуур байрны уншигч хүүхдүүдийн дунд “**Ардын уламжлалт тоглоом”-**ыг танин мэдэх,тоглож сургах зорилгоор доорх ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.





Яруу найргийн “Хүрэл тулга” тэмцээнийг зохион явууллаа.

- УПК-ын оюутан,багш ажилчдын дунд “Ном унших аян” зохион явууллаа.

ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2020.12.18

Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтэнд анхааран Аймгийн Засаг Даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллав.

2019 оны эхнээс байгууллагын ажлын төлөвлөгөөг жилээр гаргаж зорилго зорилтууд, хийгдэх ажлын талаар ярилцан нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллав.

Нийтийн номын сан нь 2018-2020 оны Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Оюунтүлхүүр” дэд хөтөлбөр, “Цахим номын сан” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Манай байгууллага нь 2019 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаараа шалгарч улсын хэмжээний шилдэг номын сангийн шилдгээр шалгарч МҮНС-н нэрэмжит “Ном-Цом”-ийн эзэд боллоо.

Ховд аймгийн Нийтийн номын сан 2020 онд 18 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт 5 тасаг танхимаар уншлага үйлчилгээг хүргэж ажиллаж байна.

Статистик үзүүлэлт:

2020 оны статистик тоон мэдээллийг төлөвлөгөөтэй харьцуулбал:







Байгууллагаас зохион байгуулж буй соёл олон нийтийн ажил болон хийгдэж буй арга хэмжээ, мэдээлэл сурталчилгааг Фейсбүүк хуудсанд тогтмол байршуулан баяжуулан ажиллаж байна. Фейсбүүк хуудасны LIKE 8000 аас 9117 болж өсөж лайкны тоогоороо тэргүүлэн шинэ содон мэдээллээр хангаж байна.



Шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд нь www.shilendans.gov.mn сайтад шивж оруулж тайланг улирлаар цаг тухайд нь илгээсэн.

Байгууллагын админаар захирал Т.Эрдэнэтуяа, хэрэглэгчээр Нягтлан бодогч О.Чанцалмаа Мэдээллийн ажилтан Д.Нямгэрэл нарыг томилон цаг тухай бүрд нь мэдээллийг тогтмол шивж оруулж ажилласан.

Байгууллагын 2020 оны Ирсэн бичиг, Явуулсан бичиг, Захиралын /А,Б/ тушаал, ажилтнуудын тайлан

, үр дүнгийн гэрээ, хурлын тэмдэглэл, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг архивын баримт бичгийг хавтаслаж, товъёог үйлдэж, баталгааны хуудас хийж архивлав.

.

I. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. **АЙМГИЙН ОЮУНТҮЛХҮҮР ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД**:

Аймгийн Оюунтүлхүүр дэд хөтөлбөрийн 2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105 дугаар зарлигийн дагуу Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэх, Монгол бичгийн түүх, бичлэгийн төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх, дэлгэрүүлэх, уралдаанд оролцогчдод урам зориг өгөх, бүтээлийг сурталчилах зорилгоор Үндэсний бичиг үсгийн баярыг 2020 оны 05 сарын 05-19-ны өдрүүдэд онлайнаар зохион байгуулж явуулах, удирдамж, тусгай хөтөлбөр гарган ажиллаа.

Аяны хүрээнд уншигчдын дунд “Монгол бичиг-Миний бичиг” эссэ бичлэг, “Монгол ардын үлгэрийг хэн сайн ярих вэ?” ур чадварын, “Монгол бичиг-Яруу найрагт” шүлгийн уралдаануудыг цахимаар зохион байгуулж, эссэ бичгийн уралдаанд амжилттай оролцсон Лицэй ахлах сургуулийн 11-б ангийн сурагч О.Цолмон, үлгэрийн ур чадварын уралдаанд 3-р ахлах сургуулийн 1-б ангийн сурагч Б.Бат-Ирээдүй нар шалгарч шагналаа гардан авлаа. Мөн байгууллагын ажилтнуудын дунд “Каллиграф бичлэг”-ийн сургалтыг зохион байгуулж явуулсан. Уншлагын танхимын номын санч нарын цахим үзэсгэлэнд гаргасан сэдэвчилсэн номын танилцуулгыг сурталчиллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигийн дагуу Номын баярын



үйл ажиллагааг удирдамж, хөтөлбөр гаргаж, зохион байгуулж явууллаа. Хөтөлбөрийн дагуу Монголын шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж тэмдэгтэний болзол хангасан сум сургуулийн 32 сурагчийг шагнаж урамшууллаа. Мөн сум сургуулийн номын санчдад “Номын сангийн үйл ажиллагаа онол арга зүй”-н 8 цагийн сургалтыг зохион байгуулж Батламж олгов. Уншигчдын дунд бүх тасаг танхимууд “Бүтээлч уншлага” зохион байгуулж, шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.



“Бүтээлч уншлага” зохион байгуулж явууллаа. Номын баярыг тохиолдуулан “Номч багш нар” сэдэвт бүтээлч уншлагыг Жаргалант сумын 14-р цэцэрлэгийн хамт олны ажлын байранд нь очиж, карт нээж, номоор үйлчилгээ үзүүллээ. Нийт 27 албан хаагчид хамрагдсан байна.

Намрын уншлага намрын улиралтай холбоотой ном уншиж, ярилцаж, тухайн сэдвийн дагуу өнгө дүрслэл буулгаж ярилцлаа. Мод навчны өнгө ялган хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэн ажиллав.

“Монголын түүх соёл” сэдэвт сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.



Шинэ номын мэдээлэл бичиж сурталчилав.



Монгол Улсын Засгийн Газрын санаачилгаар Соёлын яам, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл урлагийн газраас зохион байгуулж буй “Соёлын цаг нөлөөллийн аян” улс орон даяар зохион байгуулж буй уг арга хэмжээнд тусгай хөтөлбөр гарган оролцож байна. Тус аяны хүрээнд АЖ Чулууны нэрэмжит Алтан гадас одонт ХДТ, Орон нутгийг судлах Музейн хамт олонтой хамтарч алслагдсан баг хороонд очиж, иргэдийн дунд Нээлттэй өдөрлөг зохион байгуулж явууллаа. Энэ үеэр иргэдээс соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар судалгаа авч ажиллаа.

1.Намарзан төв

2. Баруун бүс төв захын хаан банк

3. 1-р цэцэрлэг ойр орчмын гэр хорооллын айлууд

4.3Х 123-р анги

5.Аймгийн төв талбай

6. Алтан бумба ахмадын сувилал

Гэрээр ном олгох тасгийн шинэ номын баяжилт хийж ирсэн номоороо үзэсгэлэн гаргаж иргэдээс ирсэн номын захиалгыг тухай бүрт нь фондоос авч уншигчдадаа хүргэж ажиллалаа

Аяны хүрээнд ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын дунд “Дараагийн хуудас ТВ” нэвтрүүлгийг зохион байгуулж явууллаа. Ирээдүйн Нобелийн шагналт зохиолч болох зорилготой сурагчид Төрийн шагналт зохиолч Д.Төрбатын Алтан ургийн хэлхээ зохиолоор дараагийн хуудасыг үргэлжлүүлэн бичлээ.

2.3 “ШУВУУН СААРАЛ” БОГИНО ӨГҮҮЛЛЭГИЙН НААДАМ

Аймгийн “Оюун түлхүүр” дэд хөтөлбөрийн хүрээнд “Шувуун саарал” богино өгүүллэгийн наадам / 1-4-р анги, 5-8-р анги, 9-12-р анги, насанд хүрэгчид / гэсэн ангилалаар амжилттай зохион явууллаа. Монголын шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч их зохиолч Д.Нацагдоржийн уран бүтээлийг ард иргэд, хүүхэд багачууд, оюутан залууст сурталчилах, сурагчдын сэтгэлгээг идэвхжүүлэх, эх хэлний зөв хэрэглээг хэвшүүлэх, тэдний хэл яриаг зүгшрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх үүднээс зохион явуулж буй энэ удаагийн шувуун сааарал богино өгүүллэгийн уран уншлагын наадамд төвийн болон хөдөө орон нутгаас нийт 110 гаруй хүн оролцлоо. Тус арга хэмжээний үеэр нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, тасаг танхимуудын үйл ажиллгааг танилцуулж, аймгийн 16 сум, Жаргалант сумын ЕБС-ийн 7 –н сургуулийн сурагчид, эцэг эхчүүд, багш нар, оюутан залуус, албан хаагч нар нийт 260 гаруй хүнд номын сангийн үйл ажиллагаагаа сурталчилж ажиллаа.

Тэргүүн байранд Буянт сумын 9а ангийн сурагч Ц.Номин-эрдэнэ "Мэнгэ"
Дэд байр Дарви сумын 9б ангийн сурагч Ж.Буян-эрдэнэ "Би эр хүн"
Гутгаар байр Буянт сумын 7а ангийн сурагч А.Мөнхцэцэг "Хэрүүлчийн дамжаа"
Тусгай байр Проресс 7б ангийн сурагч Н.Номин
Тусгай байр Үенч сумын 9б ангийн сурагч Б.Хүслэн
Тусгай байр 1-р сургуулийн 9г ангийн сурагч О.Маралжингоо "Багын явдал" өгүүллэгээр шалгарлаа.

“ГАН ҮЗЭГ” яруу найраг, **“ШУВУУН СААРАЛ”** богино өгүүллэгийн наадмын хамгийн олон хандалт авч шалгарсан Гранпри шагналын эзэд тодорлоо. "ШУВУУН СААРАЛ-2020" богино өгүүллэгийн уран уншлагын наадмын ГРАНПРИ Буянт сумын ЕБС 9а ангийн сурагч Ц.Номин-эрдэнэ "ГАН ҮЗЭГ-2020" яруу найргийн наадмын ГРАНПРИ Дарви сумын ЕБС 6а ангийн сурагч А.Цолмон.





“ГАН ҮЗЭГ ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ 2020”

Тэргүүн байранд 1-р сургуулийн 8б ангийн сурагч Ундрах "Би"
Дэд байр Алтай сумын 8а ангийн сурагч Д.Туяацэцэг "Бохирдол"

Гутгаар байр Мөнгөнтуул "Ээждээ"
Тусгай байр ЦАЦ сургуулийн 8б ангийн сурагч П.Ануужин "Цолмон-д зориулав"…

2.УГИЙН БИЧГИЙН СУРГАЛТ:

“ХОВД “УГИЙН БИЧИГ- УРГИЙН ХЭЛХЭЭ” хөдөлгөөнийг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийтийн номын сан, Сумдын соёлын төв 2020 оны 05 дугаар сарын 10-наас 2020 оны 12 дугаар сарын 15-ны хооронд зохион явуулахаар Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан эрт дээр үеэс уламжлагдан ирсэн угийн бичгийг өрх бүр хөтөлж хэвших, ахмад үе нь үлгэрлэн хөтлүүлэх, ураг төрөл дотроосоо гэрлэх, үерхэхийн хор уршгийг ойлгуулан, цус ойртолтоос хамгаалах, Угийн бичиг хөтлөх арга зүйд сургах, гарын авлага хэвлүүлэн сургалтын арга хэмжээг зохион байгуулах. Уг арга хэмжээний хүрээнд хөдөлгөөн өрнүүлэх хугацаанд цахим хичээл болон угийн бичгийг олон нийтийн ТВ нэвтрүүлгээр иргэдэд мэдээллийг өгч, “Угийн бичиг- Ургийн хэлхээ” facebook фэйж хуудсыг идэвхтэй ажиллуулан, сумдын соёлын төвөөр дамжуулан орон нутгийн иргэдийг угийн бичиг хөтлөх арга зүйд сургах ажлыг зохион байгуулж, угийн бичиг хөтөлсөн өрх, иргэдийг тоог нэмэгдүүлнэ. Энэхүү ажлын хүрээнд Ховд гэр бүлийн радио 104.0 "Угийн бичиг" хөтлөхийн ач холбогдлын талаар нэвтрүүлэг хийж 7 хоногийн 3 удаагийн давтамжтай явуулан ажиллаа. Тус хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан “Шилдэг угийн бичиг шалгаруулах уралдаан”-ы эхний шатанд оролцож, шалгарсан Жаргалант сумын Наран багийн иргэн Б.Гомбожавын шагналыг аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ч.Уранчимэг гардуулан өглөө.

Ховд аймгийн нийтийн номын сан, Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран, байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд “Цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, угийн бичгийн үндсэн ойлголт” сургалтанд хамрагдлаа. Аймгийн эцэг эхийн зөвлөлийн 60 хүн хамрагдлаа.

Уенч сумын соёлын төвтэй хамтран Уенч сумын төрийн албан хаагчдын дунд 4 удаагийн сургалтаар 100 гаруй хүн "Цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, угийн бичгийн үндсэн ойлголт" сургалт хийв. Үүнд: ЗДТГ, ЭМТ, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль.

НИЙТИЙН НОМЫН САН - фэйж дээр уншигчддаа тавьж үзүүлж байна.





Let`s talk about America" цуврал лекц бүрийг American Corner нүүр хуудсанд байршуулж мэдээлэлээ хүргэж байна.

“Covid 9” цар тахал гарсантай холбогдуулан Соёлын яамнаас уриалж буй “Цахим орчинд соёл түгээе” аяны хүрээнд Гэрээр олгох тасгаас шинэ ирсэн номнуудаа 7 хоног бүр сурталчилан таниулж Нийтийн номын сангийн page хуудсанд байршуулж ажиллаж байна.





НОМЫН САНГААС “НОМТОЙ ХАМТ” хөдөлгөөн өрнүүлэн ажиллаж байна.







Орон нутгийн сонинг Зотеро программд Ховдын толь 2012-2016 он, Ховдын мэдээ 2008, 2009, 2016, 2017, 2020 оны 89 дугаар болон нийт 3625 дугаарыг шивж оруулаа.

5. НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР, ИРГЭДИЙН ӨДӨР

Аймгийн Нийтийн номын сангаас зохион явуулж буй "Цахим уншлагад нэгдэцгээе” сэдэвт номын аяны хүрээнд Иргэдийн өдрийг Буянт гол дээр зохион байгуулж,

байгууллагын уншлага үйлчилгээг танилцуулж, мэдээлэл өгч ажиллаа. Тус арга

хэмжээний хүрээнд тасаг танхимууд номын үзэсгэлэн гаргаж үйл ажиллагаагаа сурталчиллаа. Дугуйтай аялалыг зохион байгуулж дархлаагаа дэмжин дасгал хөдөлгөөн хийж буй иргэдэд нүүдлийн номын сангаар үйлчиллээ.

Бүтээлч орон зай хөтөлбөрийг зохион байгуулж номын санчид, номын богц оёлоо.

"Зуны зугаатай уншлага" нээлттэй хаалганы өдрийг тасаг танхимууд хамтран зохион байгуулж зуслангийн айлуудад үйлчилгээ үзүүллээ. Бяцхан уншигчид номоо уншиж, хоорондоо таавар таалцаж, уншсан номынхоо тухай харилцан ярилцаж, зуны зугаатай нэг өдрийг бидэнтэй хамт өнгөрөөлөө

НЭЭЛТТЭЙ ХААЛГА-2020

ЕБС-ийн 7 сургууль дээр очиж "Нээлттэй хаалга"-ны өдөр өдөрлөгийг зохион байгуулж явууллаа. **2300** хүнд мэдээлэл өгөв.

Ховд аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны ажилчдад болон хараагүй бэрхшээлтэй иргэдэд зориулсан Баррайль номын танилцуулга хийж, үзэсгэлэн гаргалаа. Америкийн төвөөс тус төвийн хүүхдүүдэд зурагт ном, тоглоом зэргийг бэлэглэлээ.

Ховд Их сургуулийн оюутны 1, 2-р байранд үйл ажиллагаагаа сурталчиллаа.

Оюутнуудын дунд АХА тэмцээн зохион явуулж эхний 4-н байрыг шагнаж урамшууллаа. Мөн хөгжөөнт тоглоом тоглуулав. Нээлттэй хаалганы өдөр нийт 210 хүүхэд хамрагдлаа.

Номын баярыг тохиолдуулан “Номч багш нар” сэдэвт бүтээлч уншлагыг Жаргалант сумын 14,7-р цэцэрлэгийн хамт олны ажлын байранд нь очиж, карт нээж, номоор үйлчиллээ. Нийт 56 албан хаагчид, бэлтгэл, ахлах бүлгийн 84 хүүхэд хамрагдсан байна.

6.“УХААН ДАЛАЙ НОМООС ЭХТЭЙ” АЯН

Дэлхийн номын баярыг угтаж цахимаар уншигчдын дунд ном уншлагын аяныг удирдамж, тусгай хөтөлбөр гаргаж ажиллаа. Аяны хүрээнд ЕБС-ийн дунд ангийн сурагчдад зориулан Их мэдэх танхимаас Үлгэрийн хаан гэгдэх Данийн нэрт зохиолч, яруу найрагч Ханс Кристиан Андерсений дэлхийн шилдэг зохиол болох “Чүдэнз худалдагч охин”

Их мэдэх танхимаас Үлгэрийн хаан гэгдэх Данийн нэрт зохиолч, яруу найрагч Ханс Кристиан Андерсений дэлхийн шилдэг зохиол болох “Чүдэнз худалдагч охин”

зохиолыг цахимаар танилцуулж, Дэлхийн сонгодог шилмэл 50 боть зохиолоор цахим үзэсгэлэн гаргаж сурталчиллаа. Ахлах ангийн сурагчдад Уншлагын их танхимаас

ЭЕШ-нд

бэлтгэгчдэд зориулсан тестийн номын танилцуулга, Францын алдарт зохиолч Жюль Верний намтар уран бүтээл болон алдарт зохиолуудын товч танилцуулга, Насанд хүрэгсэдийн танхимаас “Монголын түүх соёлоос суралцъя” сэдэвт номын үзэсгэлэн гаргаж, уншиж судлах номыг цувралаар танилцууллаа. Насанд хүрэгсэд болон нийт иргэдийн дунд “Өв уламжлалаа дээдлэе” гэрийн номын сантай иргэнийг шалгаруулах уралдаан зарлаж, шилдэг гэрийн номын санг цахимаар сурталчилж үзэгч уншигчдаас хамгийн их лайк хандалт авсан номын санг шилдэгээр шалгаруулах ажил явагдаж байна.

Номын санд шинээр ирсэн номын мэдээллийг гаргаж, Дэлхийн түүх соёлын агуулгыг харуулсан бяцхан ном хийж цувралаар танилцуулж, Зотеро програмд аймаг орон нутгийн



Ховдын мэдээ сонин 2008-2020 он, Ховдын толь сонин 2013-2020 он хүртэлх дугааруудыг шивж оруулсан.

Урилгын унглага:

Цаст алтай сургуулийн Цэрэндолгор багштай 5а анги Цаст алтай сургуулийн Сарантунгалаг багштай 6г ангийнхан урилгаар ирж ном уншиж уншсан номынхоо талаар номын санчид ярьж өгч уншсан номын тэмдэглэл хөтөллөө.


Бидний үеэс тэс өөр
Бичиж ярих нь хэлэмгий доломгой
Сурч мэдэх нь бас шаламгай болж
Сурагч та нарт ухаалаг үе ирнээ
* * *
Цөм үед хөгжиж буй
Энхрий бяцхан үрс минь
Эх дэлхийг таньж мэдэх
Их ирээдүй нь ээж та нар шүү
3б Сувд-Эрдэнийн ээж Отгонпүрэв
2020 оны 11-29 нд


Орчин үеийн сурагч
Орчин үеийн сурагч нь
Олон талын авьяастай
Өвсгөө самбаа нь дэндсэн
Онцгой төрсөн хүүхдүүд
Нүд шууд нь гялалзсан
Нүүрэмгий сэргэлэн жаалууд
Нэвтрүүлэг рекламыг хашраана
Нэмэлт витаминаар бомбогдуулъя
Угаас ухаантай үрсээ
Утас интернэт ухуулна
Удаан суулгамааргүй байна
Урлах нартай уралдан босгоно
Үнэхээр судлуулах хэрэгтэй байна

Цахимаар 12-р жилийн 1-р сургуулийн Энхжаргал багштай 3б ангийн эцэг эх, сурагчдын дунд тэмцээн явууллаа. Эцэг эхийн дунд "Орчин үеийн сурагч" 8 мөрт шүлгийн уралдаан, сурагчдын дунд "Миний цахим хичээл" зохион бичлэгийн уралдааныг тус тус зохион явуулахад сурагч Сувд-Эрдэнийн зохион бичлэг, түүний ээж Отгонпүрэв, Сурагч Насан-Учралын ээж Амартүвшин нарын 8 мөрт шүлгүүд хамгийн их хандалт авч түрүүлсэн байна.



Тоглоомын хөтөлбөр:
Америкийн төвд 5-р ангийн сурагчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй хөгжилтэй байдлаар, өнгөрөөж сонирхолтой тоглоом тоглуууллаа.

Цаст алтай сургуулийн Цэрэндолгор багштай 5а ангийн хүүхдүүд Талархалын захидлын уралдаан зохион байгуулав.





7.ШИНЭ НОМЫН НЭЭЛТ БОЛОВ.

Зохиолч, яруу найрагч Ц.Жагирзүсэмийн "Ховд" шүлгийн түүвэр шинэ номын нээлтийг Уншлагын их танхимд 2020 оны 05 сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

8.ҮЛГЭРИЙН ЦАГ АРГА ХЭМЖЭЭ

Цэцэрлэгийн болон бага насны хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, үлгэр сонсох, үлгэрийн үйл явдлыг ойлгох, төсөөлөн бодох, сэтгэх чадварыг дээшлүүлэх, хэл ярианы зөв хэрэглээг хэвшүүлэх, хэл яриаг зүгшрүүлэх зорилгоор гадаадын болон монгол ардын үлгэрээр цахим мэдээлэл хийж ажиллаа.





АМЕРИКИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бүтээлч орон зайн төвд 2 үндсэн хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд үүний нэг нь Оёдлын сургалт буюу хуучин хувцсаа сэргээн засварлах, загварчлах нөгөө нь ахлах ангийн сурагчдын дунд Инженерийн анхан сургалт юм.

Цар тахлын улмаас тус сургалт явагдахгүй байна. Оёдлын сургалтыг Политехникийн оёдлын багш Д.Цэнгэл хариуцан явуулж, гэрийн ажилтай эмэгтэйчүүд болон тус сургуулийн оюутнуудад зүймэл урлал, өөдсөөр дэр хийх, хуучин хувцсаа сэргээн засварлав.

Номын санчид өөр өөрсдийн мөрөөдлийн самбараа хийж танилцууллаа.

Англи хэл дээр “Дүрэмт хувцас өмсөх хэрэгтэй юу? хэрэггүй юу?” гэсэн сэдвийн дор мэтгэлцээн зохион байгуулж явууллаа. Нийтдээ 4 баг оролцлоо.

2020 онд Америкийн төвд Ардуно ба инженерийн анхан шатны сургалт

Англи дууны клуб байгуулагдлаа

Даваа гариг бүр бага ангийн сурагчдад зориулсан Тоглоомын тойрог хөтөлбөр явагдаж байна.

АНУ-ын FLEX буюу Ирээдүйн Манлайлагчдын солилцооны хөтөлбөрийн танилцуулгыг Улаанбаатар хотоос сургагч багш Дөлгөөн хүрэлцэн ирж хийв.

Оёдлын сургалт:

Багийн ажил хичээлээр Хулганы дэгээ тоглоом,
Том асуулт зэрэг хичээлийг орж хүүхдүүдийн багаар ажиллах чадварыг нэмэгдүүллээ.

Аксес хөтөлбөр:

Аксес хөтөлбөрийн сурагчид үзсэн киноныхоо талаар ярилцаж эерэг эсрэг дүрийн талаар хоорондоо мэтгэлцээн зохион байгууллаа.

Мужуудын танилцуулга:

5-р ангийнхан америкийн төвд зочилж, үйл ажиллагаа болон ном сэтгүүл кино тоглоомтой танилцлаа. Америкийн 50 мужийн танилцуулга хийлээ.

Англи хэлний багш нарын сургалт:

Англи хэлний багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулж байна. Сургалтыг Ховд их сургуулийн англи хэлний багш Лхамзаяа Шүрэнцэцэг нар удирдан явуулж байна.

Инженерийн сургалт:

Оюутанд үйлчлэх өдөр:

Ховд их сургуулийн оюутны 1-р байранд АХА тэмцээнийг зохион байгуулж явууллаа.

Halloween party

1-4-р ангийн Үл мэдэх танхимаас шалгарсан ном.

Ерөнхий Боловсролын 7 сургуулийн 1-4-р ангийн нийт 60 гаруй бүлгийн 1900 гаруй бяцхан уншигчдын дундаас Прогресс сургуулийн $4^{б}$ ангийн сурагч Мөнх-Очир овогтой Мөнх-



Оргил 50 ном уншиж шилдэг уншигчаар шалгарч байна. Мөн тэргүүний уншигч анги хамт олноор 3-р сургуулийн Б.Тодгэрэл багштай $4^{в}$ анги, Прогресс сургуулийн Д.Ганцацрал багштай $4^{б}$ анги, Цаст-Алтай цогцолбор сургуулийн $3^{б}$ анги, 6-р сургуулийн Сайнжаргал багштай $4^{г}$ ангиуд шалгарсан байна.

Их мэдэх танхимын 2020 оны аваргууд:



Ухаан далай номоос эхтэй ном **89** удаа, Д.Нацагдоржийн Шилдэг бүтээлүүд **101** удаа уншигдаж тус тус аварга номоор шалгарлаа.

Аварга уншигчаар Прогресс сургуулийн 5б ангийн сурагч Ц.Энх-тайван, **Аварга уншигч анги хамт олноор** ЦАЦ сургуулийн Цэрэндолгор багштай 5а анги, ЦАЦ сургуулийн П.Сарантунгалаг багштай 6г анги тус тус шалгарлаа.

Идэвхтэн уншигч анги хамт олноор ЦАЦ сургуулийн Ц.Туул багштай 7б анги 7-р сургуулийн Соёлмаа багштай 5в анги тус тус шалгарлаа. Уншлагын их танхимын 2020 оны тэргүүний уншигч сурагчаар Прогресс сургуулийн 12б ангийн сурагч А.Хулангоо, 1-р сургуулийн 12а ангийн сурагч П.Бат-Эрдэнэ тус тус шалгарсан байна.

2020 оны аварга номоор Элсэлтийн ерөнхий шалгалтын даалгаврын эмхэтгэл 2006-2016 Биологи 126 удаа, Oxford 114 удаа, Тунгалаг тамир роман 1,2-р дэвтэр 98 удаа тус тус уншигдаж аварга номоор шалгарлаа.







Эрдэм шинжилгээ чөлөөт уншлагын танхимаас шилдэг номоор Л.Сарантуяа “Тэнгэрийн таалал” 30 удаа, Ц.Оюунгэрэл “Миний ажлын НОУ- ХАУ”

38 удаа, Ц.Оюунгэрэл “ Ногоон нүдэн лам” 75 удаа уншигдаж тус тус шалгарлаа. Тэргүүний уншигчаар Т.Цагаан эмч нийт 36 зохиол уншиж шалгарлаа.

III. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020 оны 1-р улиралд фондын болон бүх тасаг танхимын номын ээлжит тооллогыг хийж дуусгалаа





Жил бүр фонд баяжилтыг нийтийн номын санд 5 сая, сум бүрт 0.5 сая төгрөгөөр худалдан авалт хийх / 3 жилээр тооцсон/: Нийтийн номын сан 2018 онд Оюунтүлхүүр хөтөлбөрт тусгагдсан төсөвийн 7614850 төгрөгний 689 ширхэг ном бүрдүүлэлт хийв. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 398 ширхэг ном, 94 ширхэг сэтгүүл, гарын авлага эмхэтгэл авч бүрдүүлэлт хийв. Үүнээс 389 ширхэг номыг 5407928 төгрөгөөр худалдаж авч фонд баяжилт хийгдсэн байна.

БСШУЯ-с болон Дас ихэр сангаас ирсэн бэлгийн ном хэвлэлийг хүлээн авч сумуудын номын сангийн сан хөмрөгт баяжилт хийв.

Жил бүр уламжлал болгон зохион явагддаг Монголын номын санчдын спортын наадам Төв аймагт 5-н төрлөөр зохион байгуулагдаж Манай баг Теннис төрөлд алтан медаль, эмэгтэй гар бөмбөг мөнгөн медаль, холимог гар бөмбөг тусгай байранд шалгарч амжилттай оролцлоо.
“Хоггүй хот”аяны хүрээнд байгууллагын гадаад орчныг 7 хоног бүрийн 4 дэх өдөр хамт олноороо гадна орчноо цэвэрлэх, мод, зүлэг тарих ажилд оролцов.

Үр дүн: 2020 онд тавьсан зорилго зорилтуудыг 100 хувийн амжилттай хэрэгжүүлж, алслагдсан баг хороо болох Баруун бүсийн төв барааны зах, Их буян зах худалдаа, Арван мянгатын айл өрхүүд, Зэвсэгт хүчний 123-р анги, Ахмадын Цагаан уул сувиллын газар, Зуслангийн айлууд, Малчны хороолол зэрэгт оршин суух ард иргэдэд болон цахим орчинд Соёлын Яамны уриалга, Цахим уншлага, Номтой хамт хөдөлгөөн зэргийг уриалан Соёлын биет бус өвийг сурталчилан ажилласнаар үйл ажиллагаанд хамрагдаж, бидний үйлчилгээг авсан уншигчдын тоо 10000-р нэмэгдсэн нь их ач холбогдолтой боллоо.

Цаашид анхаарах арга хэмжээ:

1. Уншигчдын хүсэлт шаардлагын дагуу ном авч фонд баяжилт хийхэд төсөв хүрэхгүй хүндрэлтэй байгааг анхааран үзэх.
2. Цахим орчинд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд өндөр хурдны интернэт, өндөр үзүүлттэй компьютер, тоног төхөөрөмж нэн тэргүүний шаардлага үүсч байна. Иймд бидний энэхүү хүсэлтийг анхааралдаа авч асуудлыг шийдэж өгнө гэдэгт гүнээ итгэж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРАЛ Т.ЭРДЭНЭТУЯА

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2019 оны 47 тоот тушаалын
9 дүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн Д.Сүрэнжавын нэрэмжит Хөвсгөл аймгийн Нийтийн номын сан

Тайланг баталгаажуулсан: Төсвийн Шууд захирагч

Нийтийн номын сангийн захирал: ..../Э.Даваачулуун/

(албан тушаал) *(гарын үсэг)*

Тэмдэг *2020.12.14*

(огноо)

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга ..../С.Нарантуяа/

2020 оны .... дүгээр сарын ....ний өдөр

1.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
1	Ерөнхийлөгчийн зарлиг ➢ Үндэсний бичиг үсгийн баяр ➢ Хөвсгөл нуур ➢ Номын баяр 2020 ➢ Баатарлаг туульсаа түгээн дэлгэрүүлэх	4	4
2	Соёлын баримтат өв хөтөлбөр ➢ Хөгжсөн Хөвсгөл 2016-2030 хөтөлбөр	1	1
3	Үндэсний хөтөлбөр ➢ Соёлын баримтат өвийг хамгаалах ➢ Соёлын биет бус өвийг хамгаалах ➢ Чулуун соёлын өв	3	3
4	“Соёлын цаг-нөлөөллийн арга хэмжээ	1	3
5	Ахмад настны хөгжил хамгаалал	1	1
6	“Зүтгэл, итгэл, санаачлага” нэрэлсэн жил	37	37
	Нийт		7

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЭЭ

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

1.1 Төлөвөлтийн уялдаа: Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2012 оны 158 дугаар зарлиг, 2019 оны 1-дүгээр сарын 29-ны 13 дугаар зарлиг

№	**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин**	
	Гүйцэтгэлийн зорилт: Хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, баатарлаг туулсаа уншигч ирэгсэддэд түгээн дэлгэрүүлэх сурталчилах	
Арга хэмжээний нэр, дугаар	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2012 оны 158 дугаар зарлиг, 2019 оны 1-дүгээр сарын 29-ны 13 дугаар зарлиг

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	➢ Үндэсний бичиг үсгийн баяр ➢ Хөвсгөл нуур ➢ “Номын баяр 2020” арга хэмжээ ➢ Жангар тууль залах ёслол	Хэрэгжих хугацаа	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
		Шаардагдах хөрөнгө	Улсын төсөв, хандив тусламжаар											
		Хариуцах нэгж	Нийт албан хаагчдид											
		Суурь түвшин												
		Шалгуур үзүүлэлт	Холбогдох дүрэм журам стандартын дагуу											
		Хүрэх түвшин	“Номын баяр 2020” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах											
Арга хэмжээний хэрэгжилт	➢ Үндэсний бичиг үсгийн баяр ➢ Хөвсгөл нуур ➢ “Номын баяр 2020” арга хэмжээ ➢ Жангар тууль залах ёслол	Хэрэгжилт	Номын баярын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: • Номын баярын нээлт • Шинэ номын худалдаа • Та авч болно өгч болно ном солилцоо • Хөвсгөл аймгийн 99 гайхамшиг шинэ номын нээлт • Жангар ном залах ёслол • Уран зургийн үзэсгэлэн • Хөвсгөл аймгийн ган үзэгтэнүүд номын үзэсгэлэн • Ахлах ангийн сурагчдад жангар “цахим хичээл” “Би номын сантайгаа сэлфи” фото зургийн уралдаан цахим орчинд											
		Зарцуулсан хөрөнгө	1.230.000											
		Хүрсэн түвшин	Нийт 9 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 220000 орчим иргэд уншигчдад хүрч үйлчиллээ.											

1.2 Төлөвлөлтийн уялдаа: Засгийн газрын “Соёлын баримтат өв” хөтөлбөр, Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн хүрээнд

Стратеги *төлөвлөгөөний хавсралтын дугаар, зорилтын дугаар*

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

	Гүйцэтгэлийн зорилт: Соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үнэт өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж өвлүүлэн хөгжүүлж соёлын бүтээлч үйлдвэрлэл бий болгоно.		
Арга хэмжээний нэр, дугаар		Төлөвлөлтийн уялдаа:	Соёлын талаар төрөөс баримталж буй бодлого, аймгийн засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, номын сангийн хууль тогтоомж, стандартыг мөрдөх
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	1.1.1 Шинээр авсан ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг электрон мэдээллийн санд оруулах, хадгалж хамгаалах	Хэрэгжих хугацаа	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12
		Шаардагдах хөрөнгө	Улсын төсвөөр
		Хариуцах нэгж	Лавлагаа мэдээлэл, арга зүй уншлага үйлчилгээний нэгж
		Суурь түвшин	
		Шалгуур үзүүлэлт	Холбогдох дүрэм журам стандартын дагуу
		Хүрэх түвшин	3-р улиралд Шинэ номын үзэсгэлэн 4 удаа гаргаж уншигчдад үйлчлэх
Арга хэмжээний хэрэгжилт	1.1.1 Шинээр авсан ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг электрон мэдээллийн санд оруулах, хадгалж хамгаалах	Хэрэгжилт	Уншигчдын эрэлт хэрэгцээний дагуу бүртгэсэн татгалзлын дэвтэр, хэвлэлийн газрын каталог зэргээс үндэслэн 533500 төгрөгийн 62ш ном захиалага хийн худалдан авч, 224500 төгрөгийн 25 ш номыг хандив тусламжаар авч, 170000 төгрөгийн 8 төрлийн хэвлэл захиалж нийт 933000 төгрөгийн 95 ширхэг ном, хэвлэлээр фонд баяжилт хийгдэв.
		Зарцуулсан хөрөнгө	
		Хүрсэн түвшин	Шинэ номын үзэсгэлэнг 4 удаа гаргаж нийт 1877 шинэ уншигч, 5230 иргэдэд үйлчиллээ.

1.3 Төлөвөлтийн уялдаа: Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан номын сан хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

№	**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин**

<table>
<tr><td colspan="2" rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="13">Гүйцэтгэлийн зорилт:
➢ Соёлын баримтат өвийн үндэсний хэмжээний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, баримтат өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах, сурталчлах
➢ Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа монгол угсаатны олон бүлгийн соёлын биет бус өвийг олж илрүүлэх, судлах, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэхэд
➢ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин байгаа түүх, соёл, шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой хадны зураг, бичээс, буган чулуун хөшөө, хүн чулуун хөшөө, тамга тэмдэг, бичээс бүхий хөшөө, амьтны дүрст чулуун дурсгал, зураг, тамга бүхий хавтан чулуун дурсгалууд зэрэг чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах, судалж шинжлэх, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлан таниулах, зохистой ашиглах замаар чулуун соёлын өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, хамгаалах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="12">➢ Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 238 дугаар тогтоол
➢ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 68 дугаар
тогтоол
➢ Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын13-ны 69 дүгээр тогтоол</td></tr>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td rowspan="6">➢ Соёлын баримтат өвийг хамгаалах
➢ Соёлын биет бус өвийг хамгаалах
➢ Чулуун соёлын өв</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td><td>8</td><td>9</td><td>10</td><td>11</td><td>12</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="12">Улсын төсөв, хандив</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="12">Номын санчид</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="12"></td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="12">Холбогдох дүрэм журам стандартын дагуу</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="12">Иргэдэд соёлын үйлчилгээг тогтвортой хүргэх</td></tr>
<tr><td>Арга хэмжээни</td><td>➢ Соёлын баримтат өвийг хамгаалах</td><td>Хэрэгжилт</td><td colspan="12">Соёлын баримтат өвийг аймгийн хэмжээнд бүртгэн баталгаажуулж, нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай болгох зорилтын хүрээнд Аймгийн</td></tr>
</table>

